



МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2025

Монголбанкны Ерөнхийлөгч
С.Наранцогт



Өмнөх үг

Эрхэм уншигч Танд Монголбанкны 2025 оны “Жилийн тайлан” хүрэх өдрийн мэндийг дэвшүүлье!

Энэхүү тайланд Монгол Улсын 2025 оны эдийн засаг, санхүүгийн салбарын үзүүлэлтийн тойм, Монголбанкнаас хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны тухай мөн Төв банкны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах юм.

Монгол Улс 2025 онд нийгэм, эдийн засаг, гадаад орчны тодорхой бус байдал, экспортын гол нэрийн түүхий эдийн үнийн хэлбэлзэл, үйлчилгээний салбарын идэвхжил саарсан зэрэг олон сорилттой тулгарсан хэдий ч макро-санхүүгийн суурь үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой хадгалагдлаа. Төлбөрийн тэнцэл эерэг дүнтэй байж, гадаад валютын нөөц нэмэгдэн, санхүүгийн зуучлал хэвийн үргэлжилж, бодит секторуудын үзүүлэлтүүд тогтвортой байснаар эдийн засгийн идэвхжил хадгалагдсан нь бодлогын зохистой хариу арга хэмжээний үр дүн байв.

Монголбанк хуулиар ногдсон үндсэн зорилтуудаа биелүүлж, үнийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад бодлогын арга хэрэгслүүдээ ашиглав.

Инфляц 2025 оны эхний хагаст зорилтын дээд интервалыг давж нэмэгдсэн боловч мөнгөний бодлогыг макро зохистой бодлогын арга хэмжээтэй хослуулан хэрэгжүүлснээр оны эцэст 7.5% болж саармагжлаа.

Банкны системийн чанаргүй зээлийн хувь хэмжээ тайлант хугацаанд харьцангуй бага түвшинд хадгалагдаж, зээлийн өсөлт тогтвортой байж, банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд бүрэн хангагдав. Төв банкны зүгээс банкны зохицуулалтын орчныг улам боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг бэхжүүлэх, системийн эрсдэлийг бууруулах, төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангахыг зорьж ажиллав. Түүнчлэн, Төв банк зах зээл дэх хүлээлтийг тогтвортой байлгах, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхийг эрмэлзэн олон нийттэй харилцахдаа ил тод, ойлгомжтой бодлогыг чухалчилж, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмрээ орууллаа.


Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт – төгрөгийг гүйлгээнд гаргасан 100 жилийн түүхэн ой 2025 онд тохиосны зэрэгцээ Монголбанкны Ерөнхийлөгч, Мөнгөний бодлогын хорооны хараат бус гишүүд болон Хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн шинээр томилогдсон онцлог жил тохиов. Цаашид

Төв банк нь бодлого, үйл ажиллагааны реформ хийх дунд хугацааны стратегийг тодорхойлж, бодлого боловсруулалт, шийдвэр гаргалт болон институцийн засаглал, төв банкны ил тод, хараат бус байдал, хяналтын тогтолцоо, хариуцлагыг сайжруулахыг зорьж байна.

Монголбанкны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг олон улсын түнш байгууллагууд болон УИХ, бодлого тодорхойлогчид, санхүүгийн зах зээлийн хамтран зүтгэгчиддээ талархал илэрхийлье. Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал хувь нэмэр оруулах үнийн тогтвортой байдал, санхүүгийн системийн найдвартай үйл ажиллагааг хангахын төлөө Монголбанк тууштай ажиллах болно.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ  С.НАРАНЦОГТ

МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ



ГАРЧИГ

1.ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХЫН ТОЙМ	9
1.1 Бодит сектор	9
1.2 Гадаад сектор	12
1.3 Мөнгө, санхүүгийн сектор	19
1.4 Улсын төсөв	25
2. ТӨВ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	29
2.1 Мөнгөний бодлогын зорилт, хэрэгжилт	29
2.2 Монголбанкны зах зээлийн үйл ажиллагаа	32
2.3 Санхүүгийн тогтвортой байдал	39
2.4 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага	52
2.5 Үнэт металл худалдан авах үйл ажиллагаа	54
2.6 Монгол Улсын Үндэсний төлбөрийн систем	55
2.7 Мөнгөн тэмдэгтийн үйл ажиллагаа	60
2.8 Засгийн газрын санхүүгийн зуучлал	63
2.9 Төв банкны судалгаа, статистик	64
2.10 Төв банкны олон нийттэй харилцах харилцаа	65
2.11 Гадаад харилцаа	67
2.12 Эрдэнэсийн сан, Мөнгөн тэмдэгтийн танхим	72
2.13 Иргэд, олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэг олгох	73
3.ТӨВ БАНКНЫ ЗАСАГЛАЛ, БҮТЭЦ, БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА	77
3.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц	77
3.2 Дотоод аудит	78
3.3 Эрсдэлийн удирдлага	79
3.4 Мэдээллийн технологи	82
3.5 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	82
3.6 Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн	91
3.7 Зээлийн мэдээллийн сан	92
3.8 Банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлт	95
4.АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	99

1.1. БОДИТ СЕКТОР


Үйлдвэрлэл

Эдийн засаг урьдчилсан гүйцэтгэлээр 2025 онд 6.8 хувиар¹ өслөө. Үүнд хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын идэвхжил гол нөлөөг үзүүлэв (Зураг 1.1).


Цаг агаарын нөхцөл таатай байсан нь хөдөө аж ахуйн салбар 33.2 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 2.9 нэгж хувийг дангаараа бүрдүүлсэн байна. Хэдийгээр тариалалт болон ургац хураалт буурч, газар тариалангийн салбар агшсан боловч 2 жил дараалсан зудын дараах суурь үеийн нөлөөгөөр мал аж ахуйн салбар эрчтэй сэргэж, хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг бүрдүүллээ.

Оюу толгойн далд уурхайн олборлолт эрчимжиж, зэсийн баяжмалын хэмжээ нэмэгдсэн нь уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэв. Үүний зэрэгцээ аж үйлдвэр болон барилгын салбарын идэвхжил тайлант онд өндөр байж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Салбарын бүтцээр авч үзвэл 1) хөнгөн болон мах боловсруулах үйлдвэрлэл нь боловсруулах салбарын; 2) шинээр ашиглалтад орсон Бөөрөлжүүтийн цахилгаан станц нь эрчим хүчний салбарын; 3) орон сууц болон төмөр замын барилга угсралт нь барилгын салбарын өсөлтөд гол нөлөө үзүүлсэн байна. Харин өмнөх хоёр жилийн турш 10 гаруй хувиар тэлж байсан үйлчилгээний салбарын өсөлт 2025 онд саарлаа.

Зураг 1.1 ДНБ-ий өсөлт, үйлдвэрлэлийн аргаар



Зураг 1.2 ДНБ-ий өсөлт, эцсийн ашиглалтын аргаар



Эх сурвалж: УСХ

Эцсийн ашиглалт

Нийт эрэлт урьдчилсан гүйцэтгэлээр 2025 онд 6.9 хувиар тэлж, үүнд өрхийн хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал (хөрөнгө оруулалт), экспортын өсөлт голлон нөлөөллөө (Зураг 1.2). Өрхийн хэрэглээ тайлант онд 9.2 хувиар тэлж, нийт эрэлтийн өсөлтийн 6.6 нэгж хувийг дангаараа тайлбарлаж байна. Харин 2 жил дараалан эрчтэй өссөн өрхийн бодит орлого² тайлант онд дунджаар 5.4 хувиар өссөн

¹ 2015 оны зэрэгцүүлэх үнээр

² Өрхийн нэрлэсэн орлогыг ХҮИ-р засварлан бодит орлого болгон илэрхийлэв.

нь хэрэглээний өсөлтөөс доогуур үзүүлэлт байв. Мөн төрийн байгууллагын хэрэглээ буурснаар нийт эрэлтэд 1.3 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлжээ.


Хөрөнгийн нийт хуримтлал тайлант онд 7.2 хувиар буурч, нийт эрэлтийн өсөлтөд 3.6 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн байна. Тодруулбал, тайлант онд барилга байгууламж, биологийн өсөж үрждэг хөрөнгө эрчтэй нэмэгдсэн боловч нүүрсний экспорт эрчимжиж, бараа материал, бүтээгдэхүүний үлдэгдэл багассанаар материаллаг эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл огцом буурч, хөрөнгийн нийт хуримтлал агшив.

Цэвэр экспорт 2025 онд нийт өсөлтөд 5.1 нэгж хувийн эерэг нөлөөг үзүүллээ. Нүүрсний экспортын биет хэмжээ тайлант хугацаанд 8 орчим хувь, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 35 орчим хувиар өссөнөөр бараа, үйлчилгээний экспортын бүлэг нийт эрэлтэд 4.0 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлжээ. Харин хэрэглээ, хөрөнгө оруулалтын импорт тайлант онд буурсантай холбоотойгоор нийт эрэлтэд 1.1 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв.

Инфляц

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцыг 6 +/-2 нэгж хувийн интервалд, 2027 оноос 5 +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахаар тусгасан. Инфляц 2025 он гарснаар эрчимжиж, зорилтын дээд интервалыг давсан ч мөнгө, санхүүгийн бодлогын төлөв хатуурсан, импортын хүнснээс бусад барааны үнэ тогтворжсон, эрчим хүчний үнийн өөрчлөлтөөс үүдэлтэй инфляцын шууд нөлөө арилсан зэргээс шалтгаалан оны эцэст 7.5 хувьд хүрч, зорилтот интервал руу буурлаа.

Зураг 1.3 Улсын инфляц жил, сараар



Хүснэгт 1.1 Инфляцын задаргаа

Бүлэг	Жилийн инфляц	Жилийн инфляцад эзлэх нэгж хувь
12 сар		
Импортын бараа	4.3%	2.0%
Импортын бараа /хүнсний бус/	3.4%	1.2%
Импортын хүнс	8.0%	0.5%
Шатахуун	4.9%	0.3%
Дотоодын бараа, үйлчилгээ	10.3%	5.5%
Махнаас бусад дотоодын хүнс	9.6%	1.1%
Мах, махан бүтээгдэхүүн	16.4%	1.3%
Үйлчилгээ	9.9%	1.7%
Төрийн зохируулалттай	9.0%	0.7%
Бусад дотоодын бараа	7.4%	0.6%
Нийт		7.5%

Эх сурвалж: Монголбанк, УСХ

2025 оны 12 дугаар сарын инфляцад голлон нөлөөлсөн хүчин зүйлсийг авч үзвэл (Хүснэгт 1.1):

- **Импортын хүнсний бус барааны** бүлгийн үнэ жилийн 3.4 хувиар өсөж, инфляцын 1.2 нэгж хувийг бүрдүүллээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2 дахин буурсан үзүүлэлт юм. Үүнд, 1) БНХАУ дефляцтай байсан, 2) тээврийн саатал харьцангуй буурсан, 3) төгрөгийн ханш сүүлийн улирлуудад тогтворжсон зэрэг нөлөөлөв.
- **Импортын хүнсний барааны** үнийн өсөлт жилийн 8.0 хувь хүрч эрчимжлээ. Уг бүлгийн үнийн өсөлт 2024 оноос 2025 оны дунд үе хүртэл дунджаар жилийн 3.0 хувь орчим байсан ч оны сүүлийн хагаст эрчимжсэн. Үүнд олон улсад хүнсний үнэ өндөр байсан, рублийн ханш чангарсан зэрэг нь нөлөөлж байна.

- **Төрийн зохицуулалттай үйлчилгээний** үнэ оны эцэст жилийн 9.0 хувиар өсөж, инфляцын 0.7 нэгж хувийг бүрдүүллээ. Уг бүлгийн үнэ 2024 оны 11 дүгээр сард өрхийн цахилгааны тариф нэмэгдсэнтэй холбоотойгоор өндөр түвшинд хадгалагдаж, инфляцыг 1.9 нэгж хувиар нэмэгдүүлээд байв. 2025 оны 11 дүгээр сараас харин суурь үеийн нөлөө арилан, нийт инфляцад үзүүлэх нөлөө буурчээ.
- **Дотоодын мах, махан бүтээгдэхүүний** үнэ жилийн 16.4 хувиар өсөж инфляцын 1.3 нэгж хувийг бүрдүүлж байна. Махны нийлүүлэлт нэмэгддэг зун, намрын сард үнэ төдийлөн буурах бус харин өндөр өсөлттэй байв.
- **Махнаас бусад хүнсний** барааны үнэ жилийн 9.6 хувиар өсөж, инфляцын 1.1 нэгж хувийг бүрдүүлэв. 2025 онд тариалангийн гол бүс нутгуудаар ургац ихээр алдаж, хүнсний ногоо, тэр дундаа төмсний үнэ огцом өсөв.
- **Үйлчилгээний** үнэ жилийн 9.9 хувиар нэмэгдэж, инфляцын 1.7 нэгж хувийг бүрдүүллээ. Оны эхний хагаст орон сууц, нийтийн хоол, үс засалт зэрэг дэд бүлгийн үнэ эрчимтэй өссөн хэдий ч оны сүүлийн хагаст эдгээр дэд бүлгийн үнийн өсөлт харьцангуй саарч, үйлчилгээний инфляц алгуур буурч байна.

Ажил эрхлэлт


Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2025 онд³ өмнөх оны орчимд 2 сая 353 мянга байв. Бүрэлдэхүүн хэсгүүдээр авч үзвэл, ажиллах хүчний тоо өмнөх оноос 22.8 мянгаар буюу 1.6 хувиар өсөж, 1 сая 463.9 мянгад хүрсэн нь ажиллагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой юм. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо 22.8 мянгаар буюу 2.5 хувиар буурч, 888.9 мянга болсон байна. Ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 8.4 орчим мянгаар буурч, 77 мянга болсноор ажилгүйдлийн түвшин 5.3 хувьд хүрч, өмнөх оноос 0.7 нэгж хувиар буурлаа. Улмаар ажиллах хүчний оролцооны түвшин 2025 онд 1.0 нэгж хувиар өсөж, 62.2 хувьд хүрэв (Зураг 1.4).

Зураг 1.4 Ажиллах хүчний оролцооны түвшин



Эх сурвалж: УСХ

Зураг 1.5 Ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: УСХ

3 Жилийн тоо гараагүй байгаа тул 2025 оны мэдээллийг 4 улирлын гүйцэтгэлийн дунджаар авав.

Улсын хэмжээнд нийт ажиллагсдын тоог эдийн засгийн салбаруудаар авч үзвэл 2025 онд 433 мянга (31.2 хувь) үйлчилгээний салбарт, 364 мянга (26.2 хувь) хөдөө аж ахуйн салбарт, 177 мянга (22.5 хувь) худалдааны салбарт, 145 мянга буюу 10.4 хувь нь боловсруулах салбарт тус тус ажиллаж байна. Нийт ажиллагсдын тоо 2025 онд өмнөх оноос 31.2 мянгаар буюу 2.3 хувиар өсөж, 1 сая 387 мянгад хүрсэн бөгөөд өсөлтөд хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах болон барилгын салбарт ажиллагсдын тоо өссөн нь нөлөөлжээ (Зураг 1.6). Гэтэл худалдааны салбарт ажиллагсдын тоо өмнөх оноос 6.7 хувиар буюу 13 мянган хүнээр буурсан бол үйлчилгээний салбарт ажиллагсдын тоо 3.5 хувиар буюу 16 орчим мянган хүнээр тус тус буурав.

Зураг 1.6 Ажилчдын тооны жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр




Эх сурвалж: УСХ

1.2. ГАДААД СЕКТОР

Түүхий эдийн үнэ

Тайлант онд экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, алтны үнэ түүхэн дээд түвшинд хүрсэн бол нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны үнэ өмнөх оноос буурлаа (Зураг 1.7).

Зураг 1.7 Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн индекс, 2020=100



Эх сурвалж: Блумберг, Монголбанк

Алтны үнэ 2025 онд өмнөх оноос 44.9 хувиар өсөж, жилийн дунджаар унц тутамд 3,485 ам.долларт хүрэв. Геополитикийн эрсдэл өндөр хэвээр хадгалагдсан, томоохон эдийн засагтай орнуудын төв банкнууд бодлогын хүүгээ бууруулсан, ам.долларын ханш суларсан, дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал өндөр байсан нь алтны үнэ жилийн турш өсөхөд нөлөөлөв.

Зэсийн үнэ тайлант онд дунджаар тонн тутамдаа 10,074 ам.долларт хүрч, өмнөх оноос 8.7 хувиар өсөв. Зэсийн томоохон уурхайнуудад гарсан осол болон ажилчдын эсэргүүцлийн улмаас зэсийн нийлүүлэлт жилийн турш тасалдсан нь үнэ үнэ өсөхөд нөлөөлсөн байна. Хэдийгээр АНУ-ын тарифын бодлоготой холбоотой тодорхой бус байдлын нөлөөгөөр зэсийн эрэлт оны эхний хагаст огцом савласан ч наймдугаар сараас тогтворжлоо.

Чулуун нүүрсний дундаж үнэ жилийн 36.6 хувиар буурав. Оны эхний хагаст БНХАУ-ын дотоодын нүүрсний олборлолт өндөр байсан нь үнэ хурдтай буурахад нөлөөлсөн бөгөөд энэ хандлага оны хоёрдугаар хагаст төдийлөн сэргэсэнгүй. БНХАУ-ын үл хөдлөхийн салбараас бусад салбарт гангийн эрэлт харьцангуй өндөр байсан нь тус улсын дотоодын нүүрсний үнэ оны сүүлийн хагаст өссөн боловч энэхүү өсөлт манай улсын экспортын үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэнгүй.

Төмрийн хүдрийн үнэ тайлант онд дунджаар тонн тутамд 97 ам.долларт хүрч, өмнөх оноос 5.8 хувиар буурав. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямралаас үүдэлтэй төмрийн хүдрийн үнэ хурдтай буурах төлөвтэй байсан ч гол нийлүүлэгч орнуудад нийлүүлэлтийн доголдол үүсэж, БНХАУ-ын эрэлт өндөр байлаа. Үүнээс шалтгаалан үнийн бууралт хүлээлтээс бага байв.

Түүхий нефтийн үнэ тайлант онд дунджаар баррель тутамд 68 ам.долларт хүрч, өмнөх оноос 15.1 хувиар буурав. ОПЕК-ийн орнууд болон бусад олборлогчдын нийлүүлэлт өндөр байсан нь үнэ буурахад нөлөөлөв. Үүний зэрэгцээ тарифын бодлогын тодорхой бус байдлын улмаас газрын тосны эрэлт харьцангуй сул байв.

Төлбөрийн тэнцэл


Тайлант оны урьдчилсан гүйцэтгэлээр урсгал ба хөрөнгийн данс 2,064 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 3,321 сая ам.долларын ашигтай гарснаар төлбөрийн тэнцэл 1,034 сая ам.долларын ашигтай гарав.

Зураг 1.8 Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл



*урьдчилсан


Зураг 1.9 Урсгал ба хөрөнгийн дансны бүтэц




Эх сурвалж: Монголбанк

Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2024 онд 2,314 сая ам.долларын алдагдалтай байсан бол тайлант онд 2,064 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал 250 сая ам.доллаароор буурсан бөгөөд үүнд барааны дансны ашгийн өсөлт голлон нөлөөлжээ.

Зураг 1.10 Санхүүгийн дансны бүтэц



Зураг 1.11 Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц



*урьдчилсан

Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцэл 2025 онд 3,321 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд өнгөрсөн оны гүйцэтгэлээс 9 сая ам.доллаароор буурсан дүнтэй байна.

Барааны гадаад худалдаа⁴

Монгол Улсын барааны дансны тэнцэл 2025 онд 4,389 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оноос 5 хувь буюу 221 сая ам.доллаароор өсөв. Үүнд, импорт 3 хувиар буюу 303 сая ам.доллаароор, экспорт 1 хувиар буюу 82 сая ам.доллаароор тус тус буурснаар, гадаад худалдааны нийт эргэлт өмнөх оноос 1 хувиар буюу 384 сая ам.доллаароор буурсан байна.

Хүснэгт 1.2 Барааны гадаад худалдаа, сая ам.доллар

Төрөл	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт (25 [*] /24 [*])	
						Дүн	Хувь
Эргэлт	16,087	21,243	24,437	27,398	27,014	-384	-1%
Экспорт	9,241	12,539	15,187	15,783	15,701	-82	-1%
Импорт	6,845	8,704	9,250	11,615	11,312	-303	-3%
Тэнцэл	2,396	3,834	5,937	4,169	4,389	221	5%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Экспорт: Тайлант онд нийт уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өмнөх оноос 1 хувиар буюу 96 сая ам.доллаароор буурсан байна. Үүнд чулуун нүүрсний экспорт өмнөх оноос 2,955 сая ам.доллаароор буурсан нь голлон нөлөөлсөн бол зэсийн баяжмалын экспорт 2,490 сая ам.доллаароор, төмрийн хүдрийн экспорт 37 сая ам.доллаароор, мөнгөжөөгүй алтны экспорт 342 сая ам.доллаароор тус тус өсөж, нүүрсний орлогын тасалдлыг нөхөв..

4 ГЕГ-ын “Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл”-д үндэслэсэн тоон мэдээлэл бөгөөд аргачлалын ялгаатай байдлаас шалтгаалан Төлбөрийн тэнцлийн статистикаас зөрүүтэй болно.

Мал аж ахуйн гаралтай экспорт өмнөх оноос 9 хувиар буюу 48 сая ам.доллаароор өссөн бол газар тариалангийн экспорт 5 хувиар буюу 4 сая ам.доллаароор, аж үйлдвэрлэлийн экспорт 6 хувиар буюу 32 сая ам.доллаароор буурав. Экспорт 2025 онд өнгөрсөн оноос 1 хувиар буюу 82 сая ам.доллаароор буурахад үнийн өөрчлөлтөөс шалтгаалсан бууралт 1,861 сая ам.доллар, харин тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан нэмэгдэл 1,779 сая ам.доллар байжээ.

Хүснэгт 1.3. Экспорт, голлох ангиллаар, сая ам.доллар

Төрөл	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт (25'/24')	
						Дүн	%
Уул уурхай	8,520	11,663	13,873	14,653	14,557	-96	-1%
Зэсийн хүдэр, баяжмал	2,900	2,735	2,626	3,319	5,809	2,490	75%
<i>Мян.тонн</i>	1,283	1,453	1,525	1,695	2,283	587	35%
Чулуун нүүрс	2,759	6,496	8,764	8,535	5,580	-2,955	-35%
<i>Мян.тонн</i>	15,688	31,694	66,706	79,518	83,946	4,429	6%
Төмрийн хүдэр, баяжмал	952	391	445	598	634	37	6%
<i>Мян.тонн</i>	7,106	4,732	5,713	7,511	8,803	1,292	17%
Мөнгөжөөгүй алт	1,005	1,127	738	899	1,241	342	38%
<i>Кг</i>	17,250	19,660	11,734	11,645	10,790	-855	-7%
Бусад	905	914	1,300	1,302	1,293	-9	-1%
Уул уурхайн бус	721	876	1,314	1,130	1,144	14	1%
Нийт дүн	9,241	12,539	15,187	15,783	15,701	-82	-1%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Импорт: Тайлант онд импорт өмнөх оноос 3 хувиар буюу 303 сая ам.доллаароор буурахад дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв. Үүнд:

- Хэрэглээний барааны импорт өмнөх оноос 27 сая ам.доллаароор буурсан нь гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тавилга, автомашин, түүний сэлбэг хэрэгсэл, гутал, хувцас, цүнхний импорт 114 сая ам.доллаароор,
- Хөрөнгө оруулалтын шинж чанартай барааны импорт 5 хувиар буюу 261 сая ам.доллаароор буурсан нь машин, механик тоног төхөөрөмж, эд ангийн импорт 10 хувиар, хөрөнгө оруулалтын бусад барааны импорт 9 хувиар,
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 2 хувиар буюу 44 сая ам.доллаароор тус тус буурсантай холбоотой байв.

Хүснэгт 1.4. Импорт, голлох ангиллаар, сая ам.доллар

Төрөл	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт (25'/24')	
						Дүн	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	2,184	2,686	2,691	3,546	3,519	-27	-1%
Түргэн эдэлгээтэй	1,315	1,501	1,363	1,605	1,692	86	5%
Удаан эдэлгээтэй	869	1,185	1,329	1,941	1,827	-114	-6%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	2,757	3,308	3,820	4,957	4,696	261	-5%
Машин, тоног төхөөрөмж, эд анги	1,768	1,987	2,411	3,273	2,940	-332	-10%
Барилгын материал	727	1,002	1,100	1,288	1,397	108	8%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	262	318	309	396	359	-37	-9%
Аж үйлдвэрлэлийн орц	762	966	852	933	960	27	3%
Нефтийн бүтээгдэхүүн	1,132	1,724	1,869	2,162	2,118	-44	-2%
Дизель түлш	590	960	1,110	1,296	1,337	41	3%

Мян.тонн	989	982	1,347	1,641	1,825	183	11%
АИ-92, АИ-95	353	535	509	639	601	-38	-6%
Мян.тонн	514	648	708	892	839	-53	-6%
А-80	38	26	14	4	0.18	-4	-96%
Мян.тонн	59	33	22	6	0.25	-5	-96%
Бусад нефтийн бүтээгдэхүүн	151	203	236	223	180	-43	-19%
Мян.тонн	202	170	226	181	147	-35	-19%
Бусад	11	21	18	17	19	2	14%
Нийт дүн	6,845	8,704	9,250	11,615	11,312	-303	-3%


Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Үйлчилгээний гадаад худалдаа

Үйлчилгээний дансны алдагдал тайлант онд 2,855 сая ам.долларт хүрсэн бөгөөд өмнөх оноос 16 хувиар буюу 462 сая ам.доллараар буурав. Үйлчилгээний дансны алдагдал буурахад тайлант онд уул уурхайн экспорттой холбоотой техникийн болон тээвэрлэлтийн үйлчилгээний зардлын бууралт голлон нөлөөлжээ.


Гадаадад аялсан иргэдийн тоо өмнөх жилүүдээс өссөн бөгөөд үүнд иргэдийн орлого, нислэгийн шинэ чиглэлүүд, тийзийн үнийн бууралт, аяллын компаниудын төлбөрийн уян хатан нөхцөл, зарим орны визний чөлөөлөлт, сурагчдын өвлийн амралт зэрэг олон хүчин зүйлс нөлөөлөв. .

Зураг 1.12 Үйлчилгээний экспорт



*урьдчилсан

Зураг 1.13 Үйлчилгээний импорт



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1.5. Үйлчилгээний гадаад худалдаа, сая ам.доллар

Үйлчилгээний гадаад худалдааны дансны нэр төрөл	2019	2020	2021	2022	2023	2024	2025*	Өөрчлөлт (25'/24')	
								Дүн	%
1. Тээвэр	-594	-212	-167	-763	-740	-801	-479	321	-40%
2. Аялал жуулчлал	-412	-521	-722	-745	-734	-954	-1,004	-50	5%
3. Барилга, барилгын ажил үйлчилгээ	-107	-97	-118	-60	-97	-180	-53	127	-71%
4. Даатгал болон тэтгэврийн үйлчилгээ	-23	-21	-24	-23	-33	-40	-36	4	-10%
5. Санхүүгийн үйлчилгээ	-207	-145	-151	-149	-178	-216	-236	-20	9%
6. Оюуны өмч ашиглах эрхийн төлбөр	-25	-23	-30	-32	-30	-27	-43	-16	59%
7. Харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээ	-55	-70	-97	-75	-102	-133	-146	-13	10%
8. Бизнесийн бусад үйлчилгээ	-546	-343	-363	-487	-659	-941	-856	85	-9%
9. Бусад үйлчилгээ	-23	-18	-4	-22	-20	-25	0	24	-98%

Нийт үйлчилгээ	-1,992	-1,450	-1,675	-2,355	-2,592	-3,317	-2,855	462	-14%
-----------------------	---------------	---------------	---------------	---------------	---------------	---------------	---------------	------------	-------------

*урьдчилсан

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2025 онд урьдчилсан гүйцэтгэлээр -45,905 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 5 хувь буюу 2,066 сая ам.доллаароор өсөв.

Хүснэгт 1.6 Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц, сая ам.доллар

А. ГАДААД АКТИВ	12,718	Б. ГАДААД ПАССИВ	58,623
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	1,175	1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	35,997
2. Багцын хөрөнгө оруулалт	637	2. Багцын хөрөнгө оруулалт	4,874
3. Санхүүгийн дериватив	7	3. Санхүүгийн дериватив	13
4. Бусад хөрөнгө оруулалт	3,895	4. Бусад хөрөнгө оруулалт	17,739
5. Нөөц актив	7,005		
		В. ПОЗИЦ	-45,905

Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсаас гадагш хийсэн нийт хөрөнгө оруулалтын дүн буюу гадаад актив 12,718 сая ам.долларт хүрсэн бөгөөд үүний 55 хувийг гадаад валютын улсын нөөц, 31 хувийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9 хувийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 5 хувийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсад орсон нийт хөрөнгө оруулалтын дүн буюу гадаад пассив 58,623 сая ам.долларт хүрч, үүний 61 хувийг шууд хөрөнгө оруулалтын пассив, 30 хувийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 8 хувийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын позицгийн жилийн өөрчлөлтийг харвал, шууд хөрөнгө оруулалтын богино позиц 2,066 сая ам.доллаароор, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 2,468 сая ам.доллаароор, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 65 сая ам.доллар тус тус буурчээ. Гадаад валютын улсын нөөц 1,495 сая ам.доллаароор өсөж, тайлант онд 7,005 сая ам.долларт хүрэв.

Хүснэгт 1.7 Гадаад хөрөнгө оруулалтын позицгийн өөрчлөлт, сая ам.доллар


Үзүүлэлтүүд	2021	2022	2023	2024	2025*	Өөрчлөлт (25/24')	
						Дүн	%
Шууд хөрөнгө оруулалтын позиц	-25,457	-27,614	-29,673	-32,355	-34,823	-2,468	8%
Багцын хөрөнгө оруулалтын позиц	-4,143	-2,992	-2,217	-3,201	-4,238	-1,036	32%
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн позиц	11	0	0	-13	-6	7	-56%
Бусад хөрөнгө оруулалтын позиц	-14,510	-14,729	-14,598	-13,780	-13,845	-65	0%
Гадаад валютын улсын нөөц	4,366	3,400	4,921	5,510	7,005	1,495	27%
Нийт позиц	-39,733	-41,936	-41,567	-43,839	-45,905	-2,066	5%

*урьдчилсан


Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл (пассив) 35,997 сая ам.долларт хүрсэн бөгөөд 50 хувь буюу 18,114 сая ам.доллар нь толгой компаниасаа авсан зээл, үлдсэн 50 хувь буюу 17,884 сая ам.доллар нь хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт байна.

Зураг 1.14 Монгол Улсад орсон ШХО-ын үлдэгдэл улсаар сая ам.доллар, нийт дүнд эзлэх хувь



Зураг 1.15 Монгол Улсад орсон ШХО-ын үлдэгдэл салбараар сая ам.доллар, нийт дүнд эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь ангилбал, Нидерланд 44 хувь, БНХАУ 16 хувь, Сингапур 8 хувь, Их Британи 7 хувь, Хонг-Конг 4 хувь, Люксембург 4 хувийг нь тус тус бүрдүүлэв. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал, уул уурхайн салбарт шууд хөрөнгө оруулалтын 75%, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 6 хувь, санхүү даатгалын салбарт 5 хувь, үйлчилгээний бусад салбарт 3 хувь, барилгын салбарт 2% нь оржээ.


Монгол Улсаас гадагш хийсэн багцын хөрөнгө оруулалтын үлдэгдэл (актив) 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 637 сая ам.долларт хүрэв. Хөрөнгө оруулсан улсаар нь ангилбал, Хонг Конг улсад 19 хувь, АНУ-д 19 хувь, Сингапур улсад 15 хувь, Герман улсад 7 хувь, Австрали улсад 4 хувийн хөрөнгө оруулалтыг тус тус хийжээ.

Монгол Улсад орсон багцын хөрөнгө оруулалтын үлдэгдэл (пассив) 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 4,874 сая ам.долларт хүрчээ. Хөрөнгө оруулалтыг улсаар нь харвал нийт багцын хөрөнгө оруулалтын 20 хувь нь Сингапур, 9 хувь нь АНУ-аас, 7 хувь нь Их Британи, 6 хувь нь Хонг Конг, 4 хувь нь Люксембург, 4 хувь нь Швейцарь улсаас тус тус нийлүүлэгджээ.

Зураг 1.16 Багцын хөрөнгө оруулалтын актив сая ам.доллар, нийт дүнд эзлэх хувь



Зураг 1.17 Багцын хөрөнгө оруулалтын актив сая ам.доллар, нийт дүнд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

Гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 40,460 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 8 хувь буюу 3,223 сая ам.доллаар өсөв. Өрийн бүтцийг институцийн салбараар авч үзвэл:

- Монгол Улсын Засгийн газрын гадаад улсаас авсан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, өрийн бичгийн үлдэгдэл 4 хувь буюу 351 сая ам.доллаар өссөн.
- Төв банкны гадаад өрийн үлдэгдэл 1 сая ам.доллаар буурсан.
- Хувийн салбарын гадаад өрийн үлдэгдэл арилжааны зээл болон хөрөнгө оруулагчийн зээлийн өсөлтөөс шалтгаалан 9 хувь буюу 2,873 сая ам.доллаар өссөн байна.

Хүснэгт 1.8 Монгол Улсын нийт гадаад өр, сая ам.доллар

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт (25/24*)	
						Дүн	%
НИЙТ ГАДААД ӨР	33,806	33,345	34,569	37,237	40,460	3,223	8%
Засгийн газар	8,454	8,012	8,105	8,397	8,748	351	4%
Засгийн газрын гадаад өр/ДНБ (%)	55%	51%	39%	36%	35%	-1%	-3%
Төв банк	2,610	2,179	1,785	1,086	1,085	-1	0%
Хадгаламжийн байгууллага	1,627	1,533	1,733	2,602	4,022	1,420	35%
Богино хугацаат	361	224	235	211	502	291	58%
Урт хугацаат	1,265	1,308	1,498	2,391	3,520	1,129	32%
Бусад сектор	8,843	8,436	7,866	7,898	8,492	594	7%
Богино хугацаат	812	1,622	1,678	1,818	2,104	287	14%
Урт хугацаат	8,030	6,814	6,188	6,080	6,387	307	5%
Хөрөнгө оруулагчаас авсан зээл	12,272	13,185	15,081	17,254	18,114	859	5%

*урьдчилсан

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

** ОУ-ын аргачлалаар Хөгжлийн банкныг бусад секторт оруулсан.

Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2021 онд 55 хувь байсан бол тасралтгүй буурсаар 2025 онд ДНБ-ний өсөлтөөс шалтгаалан 35%-д хүрч, буурлаа.

1.3 МӨНГӨ, САНХҮҮГИЙН СЕКТОР

Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө⁵) 2022 оны сүүлээс өсөлт үзүүлсээр, 2024 оны хоёрдугаар улиралд жилийн өсөлт нь 29.1 хувьд хүрсэн. Улмаар, 2025 оны хоёрдугаар улиралд жилийн өсөлт нь саарч, 4.2 хувь болсон ч цаашид аажмаар сэргэж, 2025 оны эцэст 10.6 хувиар нэмэгдэн 47.1 их наяд төгрөгт хүрлээ.

5 M2=M1+бусад хадгаламж

Хүснэгт 1.9 Мөнгөний нийлүүлэлт, их наяд төгрөгөөр

	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт	
	ХП	ХП	ХП	ХП	ХП	Дүн	Хувь
Мөнгө (M2)	27.9	29.7	36.8	42.6	47.1	4.5	10.6%
Мөнгө (M1)	6.5	7.2	9.9	11.7	11.2	-0.5	-3.9%
Төгрөгийн харилцах	5.7	6.4	8.9	10.7	10.2	-0.5	-4.5%
Хад.байгууллагаас гадуурх мөнгө	0.8	0.8	0.9	1.0	1.0	0.0	2.1%
Бусад хадгаламж	21.4	22.5	27.0	30.9	35.8	5.0	16.1%
Төгрөгийн хадгаламж	15.0	12.6	17.1	22.0	26.0	4.0	18.3%
Гадаад валютын хадгаламж	4.0	4.9	5.0	4.9	5.7	0.9	18.2%
Гадаад валютын харилцах	2.3	4.9	4.9	4.0	4.1	0.1	1.8%

Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.18 Мөнгөний нийлүүлэлт, эх үүсвэр талаас



Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд төгрөгийн хадгаламжийн өсөлт голлон нөлөөлж, жилийн өсөлтийн 9.4 нэгжийг бүрдүүлсэн байна. Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 4.0 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 26.0 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүний 82.8 хувь буюу 21.6 их наяд төгрөг нь иргэдийн хадгаламж байна.

Харин төгрөгийн харилцах 4.5 хувиар буюу 0.5 их наяд төгрөгөөр буурч, мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтөд -1.1 нэгжийн сөрөг нөлөө үзүүлжээ.


Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1.10 Мөнгөний нийлүүлэлт, байршуулалт талаас, их наяд төгрөгөөр

	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт	
	ХП	ХП	ХП	ХП	ХП	Дүн	Хувь
Мөнгө (M2)	27.9	29.7	36.8	42.6	47.1	4.5	10.6%
Гадаад цэвэр актив	3.8	2.5	9.0	8.7	8.7	0.0	-0.1%
Засгийн газрын цэвэр зээл	-1.1	-2.3	-4.3	-7.1	-7.3	-0.2	3.2%
Дотоод авлага	25.1	29.4	32.2	40.9	45.7	4.8	11.6%
Иргэдээс авах авлага	10.6	11.8	15.6	22.2	26.3	4.0	18.1%
Аж ахуйн нэгжээс авах авлага	14.5	17.6	16.6	18.7	19.4	0.7	3.9%

Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.19 Мөнгөний нийлүүлэлт, байршуулалт талаас



Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалтаар нь авч үзвэл, гадаад цэвэр актив (ГЦА) 2023 оны эцэст жилийн өсөлтөд 21.8 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлж байсан бол уг нөлөө буурсаар 2025 оны эцэст -0.02 нэгж хувь болж саарсан байна.


Дотоод цэвэр актив (ДЦА)-ын хувьд иргэд болон аж ахуйн нэгжээс авах авлага нь мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 11.2 нэгж хувийг тайлбарлаж, үүнээс иргэдээс авах авлага дийлэнх буюу 9.5 нэгж хувийн эерэг нөлөөг үзүүлжээ. Харин засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) 0.5 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлжээ.

Эх сурвалж: Монголбанк


Банкны салбарын зээлийн өсөлт 2023, 2024 онуудад эрчимжсэн бол 2025 оноос саарч, оны эцэст 19.0 хувь болж буурсан байна. Зээлийн өсөлтийг зориулалтаар нь авч үзвэл, худалдааны зээл 2025 оны эцэст 30.8 хувиар өсөж, нийт зээлийн өсөлтийн 5.4 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Мөн хэрэглээний болон хадгаламж барьцаалсан зээл (4.3 нэгж хувь), ипотекийн зээл (2.3 нэгж хувь) нийт зээлийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ.

Зураг 1.20 Банкнудын зээлийн үлдэгдэл, салбарын ангиллаар

Жилийн өсөлтийн бүрэлдэхүүн




Бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Банкуудын ногоон зээл

Зураг 1.21 Банкуудын ногоон зээлийн үлдэгдэл




Банкуудын ногоон зээлийн багц 2025 оны эцэст өмнөх оны мөн үеэс 72.5 хувиар буюу 981.3 тэрбум төгрөгөөр өсөж, 2.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд банкны салбарын нийт зээлийн 5.3 хувийг бүрдүүлж байна.

Ногоон таксономийн ангиллаар нийт ногоон зээлийн 61.1 хувь нь эрчим хүчний хэмнэлтийн салбарт, 15.3 хувь нь тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлалын салбарт, 9.4 хувь нь сэргээгдэх эрчим хүчний салбарт тус тус ногдож байна.

Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.22 Банкуудын ногоон зээл, таксономийн ангиллаар



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн салбар


Монгол Улсын санхүүгийн салбарт 2025 оны жилийн эцсийн байдлаар арилжааны 12 банк, 575 банк бус санхүүгийн байгууллага, 176 хадгаламж зээлийн хоршоо, 22 даатгалын компани, 63 даатгалын зуучлагч компани, 29 даатгалын хохирол үнэлэгч компани, 1,143 даатгалын төлөөлөгч, 52 үнэт цаасны компани үйл ажиллагаа явуулж байна. Банкнаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд тэлж буй боловч банкны салбар санхүүгийн зах зээлийн 80 гаруй хувийг бүрдүүлсэн хэвээр байна.

Банкны салбар

Банкны салбар тайлант оны эцсийн байдлаар 16,672 ажилтан, 1,397 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт хадгаламжийн дансны тоо 3.8 сая, харилцах дансны тоо 9.4 сая, зээлдэгчдийн дансны тоо 2.4 саяд тус тус хүрчээ.

Банкны салбарын нийт актив өмнөх оноос 19.9 хувиар буюу 14.2 их наяд төгрөгөөр өсөж, 85.4 их наяд төгрөгт хүрэв. Банкнаас иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээл нийт активын 51.8 хувийг бүрдүүлж, өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар буюу 7.0 их наяд төгрөгөөр өсөж, 43.8 их наяд төгрөгт хүрэв. Гэсэн хэдий ч зээлийн өсөлт өмнөх онтой харьцуулахад 16.5 нэгж хувиар саарсан нь иргэдийн зээлийн өсөлт удааширсантай холбоотой байна.

Зураг 1.23 Банкуудын зээл




Эх сурвалж: Монголбанк

Тайлант оны эцсийн байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 5.1 хувь нь чанаргүй, 3.4 хувь нь анхаарал хандуулах зээл байна. Боловсруулах үйлдвэрлэл (12.7%), барилга (11.3%), уул уурхайн салбарын (8.6%) чанаргүй зээлийн хувь банкны системийн дунджаас өндөр байгаа болчанаргүй зээлийн хувь хэмжээ худалдааны салбарт 3.0 хувь, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт 1.5 хувьтай байгаа нь харьцангуй бага үзүүлэлттэй байна.

Банкнүүд харилцах, хадгаламжийн үлдэгдэл 2025 оны эцсийн байдлаар нийт пассивын 59.6 хувийг бүрдүүлж, өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өсөж, 45.9 их наяд төгрөгт хүрлээ. Харилцах, хадгаламжийн өсөлт өмнөх онтой харьцуулахад 4.9 нэгж хувиар буурсан байна. Тодруулбал, хадгаламж өмнөх оноос 18.3 хувиар өсөж, 31.6 их наяд төгрөгт хүрсэн болхадгаламжийн жилийн өсөлт өмнөх оноос 3.2 нэгж хувиар саарчээ. Үүнд иргэдийн төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлт өмнөх оноос буурсан нь нөлөөллөө. Мөн харилцах өмнөх оноос 2.8 хувиар буюу 409.6 тэрбум төгрөгөөр буурч, 14.3 их наяд төгрөгт хүрсэн нь төрийн байгууллагуудын төгрөгийн харилцах дансны үлдэгдэл буурснаар тайлбарлагдаж байна.

Зураг 1.24 Банкуудын харилцах, хадгаламж




Эх сурвалж: Монголбанк

Тайлант онд банкнуудын өөрийн хөрөнгө өмнөх оноос 15.2 хувиар буюу 1.1 их наяд төгрөгөөр өсөж, 8.5 их наяд төгрөгт хүрэв. Банкнуудын ашиг 1.6 их наяд төгрөгт хүрсэн ба активын өгөөж 1.9 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 19.0 хувьд хүрсэн байна.


Банкны салбарын нийт орлогын 79.6 хувь нь хүүний орлого, 7.7 хувь нь шимтгэлийн орлого, 12.6 хувь нь бусад орлого байв. Хүүний орлогын 76.8 хувийг зээлийн хүүнээс, 15.6 хувийг үнэт цаасны хүүнээс олжээ. Харин банкнуудын нийт зардлын 63.1 хувь нь хүүний, 4.8 хувь нь эрсдэлийн сангийн, 32.0 хувь нь бусад зардал байна. Хүүний зардлыг авч үзвэл, 58.9 хувь нь хадгаламжид төлсөн хүүний, 12.1 хувь нь зээлийн хүүд зарцуулжээ.

Зураг 1.25 Өөрийн хөрөнгийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.26 Орлого, зарлагын бүтэц



Банкнаас бусад санхүүгийн салбар

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын нийт актив тайлант онд 9.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 27.4 хувиар өсөв. ББСБ-ын зээлийн багц өмнөх оны мөн үеэс 25.5 хувиар буюу 1.5 их наяд төгрөгөөр өсөж, 7.2 их наяд төгрөгт хүрэв. ББСБ-ын зээлийн үлдэгдлийн 4.4 хувь нь анхаарал хандуулах,

8.4 хувь нь чанаргүй зээлийн ангилалд багтаж байгаа бөгөөд зээлийн үлдэгдлийн 88.5 хувь нь иргэнд, 11.5 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл байна. 2025 онд 15.1 их наяд төгрөгийн зээл олгож, 13.7 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгджээ. Тайлант онд ББСБ-ууд 2.7 их наяд төгрөгийн орлого олж, 1.8 их наяд төгрөгийн зардал гарган, 946.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын нийт актив 2025 оны эцэст 379.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 6.2 хувиар өсөв. Зээлийн үлдэгдэл 12.4 хувиар өсөж, 290.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд зээлийн чанарын хувьд 5.0 хувь нь анхаарал хандуулах, 3.0 хувь нь чанаргүй зээл байна. ХЗХ-дын хадгаламж өмнөх оноос 5.1 хувиар өсөж, 261.2 тэрбум төгрөг болов. Тайлант онд 86.7 тэрбум төгрөгийн орлого олж, 44.3 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 17.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос 0.2 нэгж хувиар буурч, 19.4 хувьд хүрлээ.

Даатгалын салбарт 2025 оны эцэст ердийн даатгалын 18, урт хугацаат даатгалын 3, давхар даатгалын 1 компани буюу нийт 22 даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын компаниудын нийт активын хэмжээ 771.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өсжээ. Даатгалын нийт хураамжийн орлого 584.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 33.1 хувь буюу 193.7 тэрбум төгрөгийг даатгалын нөхөн төлбөрт олгосон байна. Даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 119.8 хувиар нэмэгдэж, 56.0 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт хөрөнгийн өгөөж 3.5 нэгж хувиар өсөж, 7.1 хувьд, өөрийн хөрөнгийн өгөөж 9.8 нэгж хувиар өсөж, 19.6 хувьд хүрэв.

Үнэт цаасны компаниудын нийт хөрөнгө тайлант онд өмнөх оноос 42.0 хувиар буурч, 2025 оны эцэст 273.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант хугацаанд орлого 37.5 тэрбум төгрөгөөр, зарлага 21.7 тэрбум төгрөгөөр өсөж, 44.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллав. 2025 онд 1.3 их наяд төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх оноос 16.7 хувиар буурчээ. Үүний 28.3 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 24.6 хувийг компанийн бонд, 21.8 хувийг хувьцаа, 14.3 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 11.0 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна.

Дээрхээс гадна Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК (МИК ОССК), Монгол Улсын Хөгжлийн банк зэрэг байгууллагыг бусад санхүүгийн байгууллага гэх ангилалд оруулдаг. МИК ОССК нь охин компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас буюу ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ) гаргах зорилгоор үүсгэн байгуулагдсан. Энэ оны байдлаар 39 тусгай зориулалтын компаниудаас (ТЗК) бүрдэж байна. МИК ОССК-ын гаргасан ИЗББ 2025 оны эцсийн байдлаар 5.4 их наяд төгрөг бөгөөд банкнудаас 81.7 мянган зээлдэгчийн 5.3 их наяд төгрөгийн зээлийн багцыг шилжүүлэн авчээ. Хөгжлийн банкны актив жилийн 35.9 хувиар нэмэгдэж, 2025 оны эцэст 3.2 их наяд төгрөг болов. Тайлант онд Хөгжлийн банк олон улсын хөрөнгийн зах зээлд 500.0 сая ам.долларын “Хөгжлийн банк 2028” бондыг гаргасан.

1.4 МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30.1 их наяд төгрөг, нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 31.3 их наяд төгрөгт хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 1.3 хувьтай тэнцүү алдагдалтай байв (Хүснэгт 1.11).

Хүснэгт 1.11 Төсвийн үндсэн үзүүлэлтүүд


их наяд төгрөг	2024		2025	
	Гүй.	Тод.	Урьд.Гүй.	Өөрчлөлтийн хувь
Нийт орлого	31.4	32.5	32.6	3.8
Сангуудын орлого	1.8	2.3	2.3	27.8
Тэнцвэржүүлсэн орлого	29.6	30.2	30.1	1.7
Татварын орлого	27.4	28.3	27.1	-1.1
Татварын бус орлого	2.2	1.9	3.0	36.4
Нийт зардал	30.4	31.6	31.3	3.0
Анхдагч зардал	29.2	30.5	29.7	1.7
Хүүний зардал	1.2	1.2	1.6	33.3
Нийт тэнцэл	1.0	1.8	1.3	-
ДНБ-д эзлэх хувь	1.3	2.0	1.3	-
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-0.8	-1.4	-1.2	-
ДНБ-д эзлэх хувь	1.0	1.5	1.2	-
Анхдагч тэнцэл	-0.4	-0.2	2.9	-
ДНБ-д эзлэх хувь	0.5	0.2	2.8	-

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 онд өмнөх оноос 468 тэрбум төгрөгөөр өндөр төвлөрөв. Үүнд нийгмийн даатгалын шимтгэл 924 тэрбум төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татвар 359 тэрбум төгрөгөөр, хувь хүний орлогын албан татвар 323 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв. Харин ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) 1.2 их наяд төгрөгөөр, аж ахуй нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) 732 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ (Зураг 1.27).

Зураг 1.27 Төсвийн орлогын бүтэц




Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зардал

Төсвийн зардал 2025 онд өмнөх оноос 3.0 хувиар буюу 923 тэрбум төгрөгөөр өндөр байв (Хүснэгт 1.11). Тодруулбал, урсгал зардал 2.1 их наяд төгрөгөөр нэмэгдсэний 859 тэрбум төгрөг нь цалингийн зардал, 754 тэрбум төгрөг нь тэтгэврийн зардал байна. Өөрөөр хэлбэл, төсвийн зардлын өсөлтийг цалин, тэтгэврийн зардал голлон бүрдүүлжээ. Ийнхүү сүүлийн жилүүдэд цалин, нийгмийн халамжийн зардал огцом нэмэгдсэн нь төсөвт ихээхэн ачаалал үүсгэж байна. Хөрөнгийн зардал харин өмнөх оноос 833 тэрбум төгрөгөөр буурсан нь барилга байгууламжийн зардал өмнөх оноос буурсантай холбоотой (Зураг 1.28).

Зураг 1.28 Төсвийн зардлын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн алдагдал, өр төлөхөд ашигласан эх үүсвэр

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 онд 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байна. Мөн 3.3 их наяд төгрөгийн зээл, үнэт цаасны төлбөрийг төлсөн байна. Ийнхүү төсвийн санхүүжилтийн шаардлагыг шинээр гаргасан 2.1 их наяд төгрөгийн гадаад бонд, 613 тэрбум төгрөгийн дотоод бонд болон 1.5 их наяд төгрөгийн гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлжээ (Хүснэгт 1.12).

Хүснэгт 1.12 Санхүүжилтийн шаардлага болон эх үүсвэр бүрдүүлсэн байдал

Их наяд төгрөг	2024	2025	Өөрчлөлт
	Гүй.	Урьд.Гүй.	
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	0.8	4.5	1.6
Харилцах болон хадгаламжийн данс	-1.2	0.7	-0.1
ЗГ-ийн бонд	1.2	2.7	1.9
Шинээр гаргах	2.2	2.7	-1.3
Үндсэн төлбөр	-1.0	0.0	3.2
ЗГ-ийн зээл	0.8	1.0	-2.2
Шинээр гаргах	2.0	1.5	0.0
Үндсэн төлбөр	-1.2	0.5	-2.2


Эх сурвалж: Сангийн яам

2.1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТ, ХЭРЭГЖИЛТ

Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжин, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор инфляцыг дунд хугацаанд 5 хувь (+/-2 нэгж хувийн интервал)-ийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд 2026 онд инфляцын зорилт болох голч 6 хувийг 2027 оноос 5 хувь болгон бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляц 2025 оны 12 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 7.5 хувь, Улаанбаатар хотод 7.6 хувьд хүрч, зорилтот интервалд хүрэв. Тайлант оны эхний хагаст гадаад валютын орох урсгал саарч, төлбөрийн тэнцэлд учрах дарамт нэмэгдсэнээр импортын барааны үнээр дамжин инфляц эрчимжив. Мөн дотоод орчинд төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ өссөн нь инфляц төв банкны зорилтоос өндөр байхад нөлөөллөө. Улмаар Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ) ээлжит шийдвэрүүдээр инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах зорилгоор мөнгөний бодлогыг хатуу төлөвт хадгалав. 2025 оны сүүлийн саруудад цахилгааны үнийн өсөлтийн суурь үеийн нөлөө арилсан, худалдааны гол түнш орон БНХАУ-ын инфляц буурч, нам түвшинд хадгалагдсан, мөн суудлын автомашины үнэ харьцангуй хямдарсан зэргээс шалтгаалж, инфляц төв банкны зорилтот түвшин рүү хүрлээ.

Зураг 2.1 Жилийн инфляц (Улс, Улаанбаатар)



Эх сурвалж: УСХ

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ) инфляцыг зорилтот түвшний орчимд тогтворжуулах зорилгоор 2025 оны 1 дүгээр сарын ээлжит бус хурлаар мөнгөний бодлогын төлөвийг хатууруулж, банкнуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг тус бүр 2 нэгж хувиар нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан. Түүнчлэн, 2025 оны 1 дүгээр улирлын ээлжит хуралдаанаар төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн дам нөлөө үргэлжлэн нэмэгдэхээс сэргийлж, бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэв. Тайлант оны үлдсэн хугацаанд МБХ бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Жилийн инфляц 2025 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 9.6 хувьд хүрч, төв банкны зорилтын дээд хязгаарыг давав. Үүнд, цахилгааны үнийн өсөлт, цалингийн өсөлтийг дагасан үйлчилгээ, түрээсийн үнийн өсөлт голлон нөлөөлөв. байна. Эрэлтийн болон зардлын шалтгаантай үнийн дарамт хүлээлгдэж байснаас нэмэгдсэн, нийтийн тээвэр, бусад төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ өссөн зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр инфляцын төсөөлөл өмнөхөөс нэмэгдэж, инфляц төв банкны зорилтот түвшнээс өндөр хэвээр хадгалагдан, 2026 оны дундаас зорилтын интервалд тогтворжих хүлээлттэй байв.

Иймд, МБХ хүлээлтээр дамжин үнийн өсөлт эрчимжих, цахилгааны үнийн өсөлтийн дам нөлөө инфляцыг эрчимжүүлэх эрсдэлээс сэргийлэх зорилгоор бодлогын хүүг 2025 оны 3 дугаар сард 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 12 хувьд хүргэхээр шийдвэрлэв.

Инфляц алгуур саарч, 2025 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 8.3 хувьд хүрэв. Үүнд, мах, гурил зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болон импортын барааны үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлөв. Хэдийгээр инфляцын төсөөлөл өмнөхөөс буурч, хүлээлтээс эрт саарах хандлага ажиглагдаж эхэлсэн ч нийтийн тээвэр, цахилгаан зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн нөлөөгөөр инфляц 2025 оны туршид төв банкны зорилтоос өндөр байх хүлээлттэй байв. Иймд, МБХ гадаад, дотоод орчны нөхцөл байдал, эрсдэл, инфляцын цаашдын төлөвийг харгалзан 2025 оны 2-р улирлын хурлаар бодлогын хүүг хэвээр хадгалахаар шийдвэрлэв.


Жилийн инфляц 2025 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 8.8 хувьтай гарав. Үүнд, мах, хүнсний ногоо, гурилын үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж, хүнсний инфляц нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Инфляц алгуур буурч, 2026 онд зорилтот интервалд орох хүлээлттэй байсан боловч цаг агаармуудах, улмаар дотоодын хүнсний инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байв. Мөн Засгийн газраас хэрэгжүүлэх томоохон төслүүдийн санхүүжилт, экспортын орлого болон валютын ханшийн төлөв зэрэг нь инфляцыг өдөөж болзошгүй байлаа. Ийнхүү МБХ эдийн засгийн гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан бодлогын хүүг 2025 оны 3-р улирлын хурлаар хэвээр хадгалахаар шийдвэрлэв.

Инфляц тайлант оны 12 дугаар сард улсын хэмжээнд 7.5 хувьд хүрч саарлаа. Ийнхүү инфляц 12 сарын дараа төв банкны зорилтот интервалд оров. Үүнд, төрийн цахилгааны үнэ өссөн суурь үеийн нөлөө арилсан, суудлын автомашины үнэ буурсан нь нөлөөлөв. Гэвч 2026 оны 1 дүгээр сараас эмч, багш нарын цалин өсөхөөр байгаа нь инфляцын дарамтыг нэмэгдүүлж, улмаар инфляцын төсөөллийг өсгөсөн байна. Түүнчлэн, гадаад орчинд тодорхой бус байдал өндөр үед экспортын орлого болон валютын ханшийн төлөв өөрчлөгдөх, цаг агаар болон нийлүүлэлтээс шалтгаалсан үнэ өсөх тохиолдолд инфляц эрчимжих эрсдэлтэй байв. Ийнхүү МБХ эдийн засгийн гадаад, дотоод орчны төлөв байдал, эрсдэлийг харгалзан бодлогын хүүг 2025 оны 4-р улирлын хурлаар хэвээр хадгалахаар шийдвэрлэв. Энэхүү шийдвэр нь инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд тогтворжуулах, эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилттой нийцтэй болно.

Мөнгөний зах, хүүний түвшин


Банкнудын зээл олгох эсхүл хадгаламж татах шийдвэр нь банк хоорондын зах дахь санхүүгийн хэрэгслүүдийн хүүгээс хамаарч байдаг. Иймд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн тусламжтай банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалахыг зорьдог(Зураг 1).

Зураг 2.2 Мөнгөний бодлогын шилжих механизм



МБХ-ны шийдвэрээр бодлогын хүүг тайлант онд 2 нэгж хувиар өсгөж, 12 нэгж хувьд хүргэсний үр дүнд 2025 онд банк хоорондын захын сарын жигнэсэн дундаж хүү өмнөх онтой харьцуулахад 2.11 нэгж хувиар өсөж, 12.03 хувьд хүрэв. Мөн банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүгийн бодлогын хүүгээс хазайх хазайлт 0.03 нэгж хувь болж, өмнөх оноос 0.11 нэгж хувиар өссөн байна. (Зураг 2.3).

Зураг 2.3 Банк хоорондын захын хүү



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш


Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны эцэст 3,556.81 төгрөгт хүрч, оны эхнээс 4.0 хувиар суларлаа (Зураг 2.4). Монголбанк богино хугацааны валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүү, ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад оролцдог. Тайлант хугацааны төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн өдрийн дундаж абсолют хэлбэлзэл 0.03 хувь байсан бөгөөд нийт хугацааны 68 хувьд нь өдөрт 0%; +0.1% хувийн интервалд хэлбэлзжээ (Зураг 2.5). Тухайлбал, өдрийн дээд түвшин 0.40 хувиар буюу 13.98 төгрөгөөр суларч, 0.14 хувиар буюу 5.05 төгрөгөөр чангарсан байна.

Зураг 2.4 Төгрөгийн ам.доллартой харьцах Монголбанкнаас зарласан хаалтын ханшийн хэлбэлзэл



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.5 Төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн өдрийн хэлбэлзлийн давтамж



Эх сурвалж: Монголбанк

2.2 МОНГОЛБАНКНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


2.2.1 Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа

Төв банкны үнэт цаас

Нээлттэй захын үйл ажиллагаа буюу төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү болон нөөцийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм. Монголбанк 2025 онд 28 хоногтой ТБҮЦ-ыг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй хэлбэрээр долоо хоногийн Даваа гараг бүр арилжаалав. Богино хугацаат буюу 28 хоногтой ТБҮЦ-ны хүү нь бодлогын хүүтэй тэнцүү бөгөөд банк хоорондын захын хөтөч хүүгийн үүргийг гүйцэтгэж, системийн илүүдэл нөөцийг татах, банкнуудын богино хугацааны нөөцийг удирдахад чухал үүрэгтэй байдаг.

ТБҮЦ-ны нийт үлдэгдэл тайлант оны эхэн үеэс 4.6 хувиар буюу 534.0 тэрбум төгрөгөөр буурч, 2025 оны эцэст 11,029.0 тэрбум төгрөгт хүрэв. Үүнд оны эхнээс алтны худалдан авалтаар 4,347.7 тэрбум төгрөг, урт хугацаат своп арилжаагаар 6,041.2 тэрбум төгрөгийг тус тус нийлүүлж, Монголбанкны спот арилжаагаар 8,215.1 тэрбум төгрөг, Засгийн газрын цэвэр зээлийн өөрчлөлтөөр 1,671.3 тэрбум төгрөг, урт хугацаат репо арилжааны эргэн төлөлтөөр 195.5 тэрбум төгрөг татсан нь голлон нөлөөлсөн бөгөөд тус хугацаанд ЗБН-ийн шаардлага 1,469.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 2.6 Төв банкны үнэт цаасны үлдэгдэл /тэрбум.төг/



Эх сурвалж: Монголбанк

Репо арилжаа

Төв банкны репо арилжаа нь нээлттэй зах зээлийн хэрэгслийн нэг бөгөөд Монголбанкнаас банкны эзэмшиж буй үнэт цаасыг хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэй худалдан авах замаар банкны системд нөөц нийлүүлэх хэрэгсэл юм.

Банк хоорондын зах дээрх богино хугацааны нөөцийн хэлбэлзлийг бууруулах, богино хугацаатай хүүг удирдах зорилгоор нөөц нийлүүлэх шаардлагатай үед Төв банк нөөцийн таамаглалд үндэслэн репо арилжаа зарладаг. Монголбанкнаас 2015 оноос хойш нэг долоо хоногтой репо арилжаа зохион байгуулаагүй байна.

Урт хугацаат репо арилжаа

Тайлант онд Монголбанкнаас урт хугацаатай репо арилжаагаар банканд олгосон санхүүжилтээс 150.1 тэрбум төгрөг хуваарийн дагуу эргэн төлөгдөж, 2025 оны эцсийн байдлаар банкуудад олгосон эх үүсвэрийн хэмжээ 54.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Харин банкнууд 2025 онд ААН, иргэдэд 282 тэрбум төгрөгийн зээлийг олгосноор нийт олгосон зээлийн хэмжээ 1,484.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2020-2025 оны хооронд нийт 68,654 ажлын байрыг хадгалж, 5,642 ажлын байрыг шинээр бий болгожээ.

Хэвийн зээлийг үнэт цаасжуулах ажлын хүрээнд “ҮЦСК актив нэг ТЗК” нь 40.5 тэрбум төгрөг (бондын төлөлт хуваарийн дагуу эргэн төлөгдөж дууссан бөгөөд татан буугдах үйл ажиллагаа эхэлсэн), “ҮЦСК актив хоёр ТЗК” нь 160.4 тэрбум төгрөг, “ҮЦСК актив гурав ТЗК” нь 82.9 тэрбум, “ҮЦСК актив дөрөв ТЗК” нь 83.0, “ҮЦСК актив тав ТЗК” нь 65.6 тэрбум төгрөг, “ҮЦСК актив зургаа ТЗК” нь 24.2 тэрбум төгрөгийн үнэт цаасыг тус тус гаргав.

2.2.2 Төв банкны байнгын хэрэгслүүд

Монголбанк нь банкны системийн түр зуурын шинжтэй илүүдэл нөөцийг шингээх, шаардлагатай тохиолдолд нөөц татах, нийлүүлэх замаар банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүгийн хэлбэлзлийг бууруулах зорилгоор байнгын хэрэгслүүдийг ашигладаг. Байнгын хэрэгсэлд нөөцийг татах буюу овернаит хадгаламж, нөөцийг нийлүүлэх буюу репо санхүүжилтийн хэрэгсэл багтана. Мөн Монголбанк хүүгийн нэгдсэн бодлогын хүрээнд репо санхүүжилтийн хүү нь төв банкны хүүгийн коридорын дээд хязгаар, овернаит хадгаламжийн хүү нь төв банкны хүүгийн коридорын доод хязгаар болж, банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүгийн хэлбэлзлийг хязгаарладаг.

Тайлант онд Монголбанк нийт 456 удаагийн хэлцлээр, өдөрт дунджаар 314.0 тэрбум төгрөгийн овернаит хадгаламжийг 9.67 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр банкнуудаас татсан бол нийт 93 удаагийн хэлцлээр, өдөрт дунджаар 343.5 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг 13.76 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр банкнуудад олгожээ (Зураг 2.7).

Зураг 2.7 Байнгын санхүүжилтийн тухайн сард хийгдсэн нийт хэлцлийн тоо болон тухайн сарын нэг хэлцлийн дундаж хэмжээ




Эх сурвалж: Монголбанк

2.2.3 Заавал байлгах нөөцийн шаардлага

Банкны төгрөгийн татан төвлөрүүлсэн эх үүсвэрт тооцох заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг МБХ-ны 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар 2 нэгж хувиар нэмэгдүүлж 13 хувь болгон өсгөв. Ингэснээр банкны системийн төгрөгийн ЗБН-ийн хэмжээ 2025 оны эцэст 5,271.81 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1,528.41 тэрбум төгрөгөөр буюу 40.83 хувиар нэмэгджээ. Мөн тус хурлаар санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлж, эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор гадаад валютын ЗБН-ийн хувь хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 18 хувь болгон өсгөв. Ингэснээр банкны системийн валютын ЗБН-ийн хэмжээ 2025 оны эцэст 2,157.87 тэрбум төгрөгөөр тогтоогдсон бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 484.33 тэрбум төгрөгөөр буюу 28.94 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 2.8 Төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлага, түүний хангалт



Эх сурвалж: Монголбанк

2.2.4 Бусад санхүүжилт

Өдрийн зээл

Монголбанкнаас төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор банканд олгодог хүүгүй, барьцаатай, нэг өдрийн хугацаатай зээл бөгөөд тухайн өдөрт багтан эргэн төлөгдөх нөхцөлтэй. Тайлант онд Монголбанк нийт 8 удаагийн өдрийн зээлийн хэлцэл байгуулсан бөгөөд нэг хэлцлийн дундаж хэмжээ 29.3 тэрбум төгрөг байна.

Барьцаат зээл


Монголбанк эцсийн зээлдүүлэгчийн үүргийн хүрээнд банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны тушаалаар батлагдсан «Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журам»-ын дагуу 2024 онд нийт 189.0 тэрбум төгрөгийн барьцаат зээлийг олгож, бүгд эргэн төлөгдөв. 2025 онд Монголбанкнаас барьцаат зээл олгоогүй байна.

Ипотекийн санхүүжилт

Монголбанк Засгийн газартай хамтран 2013 оноос “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн гол зорилго нь бага болондундаж орлоготой өрхийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, орон нутгаас нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг саармагжуулахад оршиж байна.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Монголбанк, Засгийн газар, Хуримтлалын сан болон арилжааны банкуудын эх үүсвэрээр нийт 10.5 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийг 142.6 мянган өрхөд олгосон байна (Зураг 2.9).

Зураг 2.9 Ипотекийн зээл олголт



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын Их Хурлын 2023 оны “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 99 дүгээр тогтоолоор орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэл, хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангах, зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, мөн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл болон орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах бодлого баримтлахыг Монголбанканд даалгасан болно.

Уг тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2025 онд нийт 1.3 их наяд төгрөгийн зээлийг 9,894 өрхөд олгосон бөгөөд үүнээс 33 хувь буюу 420.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг орон нутагт олгож, бүс нутгийн хүртээмжийг ханган ажиллалав.

Мөн Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Үндэсний баялгийн сангийн тухай хууль” батлагдаж, Засгийн газрын 2025 оны 288 дугаар “Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын дагуу “Хуримтлалын сан”-д 2025 онд төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулав. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3 дугаар заалтын дагуу Монголбанк 2025 онд “Хуримтлалын сан”-гийн эх үүсвэрээс 554.0 тэрбум төгрөгийг орон сууцны ипотекийн зээлд зориулж, 4350 өрхөд олгосон байна.

Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондын санхүүжилт

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын 2.6-д заасны дагуу НОСК ХК-ийн хэрэгжүүлсэн “Түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөр” нь цар тахлын эрсдэлтэй нөхцөлд ажилласан төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдад зориулсан онцгой нөхцөлтэй хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор НОСК ХК-иас үүсгэн байгуулсан “Тусгай зориулалтын компани”-ийн гаргасан 150 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг нэрлэсэн үнээр худалдан авах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020., 2022 оны тушаалыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд баталсан юм. Эдгээр тушаалын дагуу 2020 онд 34.4 тэрбум, 2021 онд 65.6 тэрбум, 2022 онд 50 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг тус тус худалдан авч, хөтөлбөрийг санхүүжүүлэн, нийт 1,573 төрийн албан хаагчийн орон сууцаар хангасан байна. Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондын эргэн төлөлт хэвийн үргэлжилжбайгаа бөгөөд 2025 онд нийт 10.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөгдөж, оны эцсийн байдлаар 112.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.2.5 Монголбанкны валютын захын оролцоо

Спот захын арилжаа

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцож байна. 2025 оны 4 сар хүртэл улирлын чанартай импортын өсөлт, нүүрсний үнийн бууралт зэргээс шалтгаалан гадаад валютын орлого буурч, улмаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамттай байв. Гэвч 5 дугаар сараас оны сүүл рүү уул уурхайн экспорт сэргэн, эдийн засгийн нөхцөл байдал тогтворжсноор ам.долларын төгрөгтэй харьцах ханш огцом хэлбэлзээгүй юм.

Зураг 2.10 Монголбанкны валютын захын спот арилжааны цэвэр дүн 2015-2025 он




Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас 2025 онд нийт 100 удаа гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, дуудлага худалдаа болон цахим талбараар дамжуулан 6,802.7 сая ам.доллар нийлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 4.0 хувиар буюу 261.0 сая ам.доллаароор өсөв.

Үүний зэрэгцээ Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга нарын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 03/3/А-5 дугаар хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс тайлант хугацаанд нийт 4,454.4 сая ам.доллар, банк болон Сангийн яамнаас 165.1 сая ам.доллар тус тус худалдан авснаар нийт 4,619.5 сая ам.долларыг валютын дотоод захаас татав. Мөн Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-т заасны дагуу Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх хүрээнд цэвэр дүнгээр 784.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний валютын хөрвүүлгийг хийж гүйцэтгэв.

Зураг 2.11 Монголбанкны валютын захын спот арилжааны задаргаа



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Монголбанк банкнуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэл, спот захын дарамтыг бууруулах, дотоодын зах зээл дэх долларжилтыг бууруулах, бодит эдийн засгийг дэмжих зорилгоор банкнуудтай богино хугацааны санхүүгийн үүсмэл хэрэгслийг 2010 оноос, урт хугацаат своп хэлцлийг 2014 оноос тус тус байгуулж байна. Урт хугацаат своп хэлцлийг эдийн

засгийн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр шинэчлэн ашиглаж ирсэн бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн тушаалаар урт хугацаат своп хэлцлийн хүүний нөхцөлд өөрчлөлт оруулж, ногоон санхүүжилтийн нэмэлт хүүг 0.5 хувиас 1 хувь болгон нэмэгдүүлээд байна.

Зураг 2.12 Банкнуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлийн хэмжээ(сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

Урт хугацаат своп хэлцлийн журмын дагуу банкнуудын нэгээс дээш жилийн хугацаатай гадаад зах зээлээс татсан эх үүсвэрээр УХСХ байгуулж, 2025 онд нийт 1,946.2 сая ам.долларын дүнтэй бодит бус урт хугацаат своп хэлцлийг банкнуудтай байгуулсан бол нийт 587.4 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийн хугацаа дуусаж, төлбөр тооцоог гүйцэтгэв.Улмаар урт хугацаат своп хэлцлийн үлдэгдэл 1,358.8 сая ам.доллаароор нэмэгдэж, 3,684.0 сая ам.долларт хүрч, тайлант онд богино хугацаат своп, форвард хэлцэл шинээр байгуулаагүй болно.

Гадаад валютын хадгаламж

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны тушаалаар баталсан “Дотоодын банкнаас Монголбанканд гадаад валютын хадгаламж байршуулах журам” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны тушаалын дагуу гадаад валютын хадгаламжийн хүүгийн хувь хэмжээ нь Олон улсын төлбөр тооцооны банк (ОУТГБ)-ны харгалзах хугацаанд санал болгож буй хугацаат хадгаламжийн өгөөжтэй тэнцүү нөхцөлтэйгөөр банкнууд Монголбанканд гадаад валютын хадгаламжийг 7 хоногоос 3 хүртэлх сарын хугацаатай байршуулдаг. Банкнуудын Төв банк дахь ам.долларын хадгаламжийн үлдэгдэл 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 783.04 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 533.04 сая ам.доллаароор өсжээ (Зураг 2.13).

Зураг 2.13 Банкнуудын Төв банк дахь ам.долларын хадгаламжийн үлдэгдэл, сараар




Эх сурвалж: Монголбанк

2.2.6 Банк хоорондын захын арилжаа

Монголбанкнаас банк хоорондын захын тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллаж байгаа бөгөөд сарын дундаж арилжааны хэмжээ 2025 онд 1,775.5 тэрбум төгрөг болж, өмнөх жилээс 62.2 тэрбум төгрөгөөр буюу 3 хувиар буурав.

Тодруулбал, банк хоорондын захын сарын дундаж үнэт цаасны шууд арилжааны хэмжээ 2025 онд 738.3 тэрбум төгрөг болж, өмнөх жилээс 116.3 тэрбум төгрөгөөр буурсан бол репо арилжаа 658.4 тэрбум төгрөг болж, 39.2 тэрбум төгрөгөөр, овернайт зээлийн хэмжээ 162.0 тэрбум төгрөг болж, 14.5 тэрбум төгрөгөөр, банк хоорондын хадгаламжийн хэмжээ өөрчлөлтгүй буюу 0.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Мөн сарын дундаж арилжааны тоо тайлант онд 56 болж, өмнөх жилийн дунджаас 10-аар бага байв. Банк хоорондын захын хэлцлийн сарын дундаж хугацаа харин төдийлөн өөрчлөлтгүй буюу 9.1 хоног болж, өмнөх оноос 1.1 хоногоор буурчээ (Зураг 2.14).

Зураг 2.14 Банк хоорондын захын төгрөгийн арилжаа, арилжааны төрлөөр



Эх сурвалж: Монголбанк

2.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Макро зохистой бодлого

Монголбанк нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2025 онд Монголбанкнаас банкны салбарын зээлийн өсөлт, өрхийн өрийн дарамт, санхүүгийн мөчлөг дагасан эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн бодлогын тодорхой шийдвэрүүдийг үе шаттайгаар гаргав.

Банкны салбарын зээлийн өсөлт өндөр түвшинд хадгалагдаж, дотоод эрэлтийг өдөөх, цаашлаад санхүүгийн салбарт мөчлөг дагасан эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 1 дүгээр сарын ээлжит бус хурлаар банкуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тус бүр 2 нэгж хувиар нэмэгдүүлэн, харгалзан 13 хувь болон 18 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 1 дүгээр улирлын ээлжит хурлын шийдвэрээр банкны салбарын хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс үүдэлтэй эмзэг байдлыг бууруулах, санхүүгийн системд үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор банкнаас иргэнд шинээр олгох болон нөхцөл өөрчлөх хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 55 хувиас 50 хувь болгон бууруулж, 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс мөрдөж эхлэв. Энэхүү бодлогын шийдвэр нь иргэний хэрэглээний зээлийн хэт өсөлт, өрхийн өрийн дарамтыг бууруулахад эерэг нөлөө үзүүлж, санхүүгийн

салбарт системийн эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх ач холбогдолтой юм.

Түүнчлэн, тэтгэврийн зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, тэтгэврийн зээлдэгчийн санхүүгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, нийгмийн баталгааг хангах хүрээнд тэтгэврийн зээлтэй холбоотой бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ. Үүнд, банкнаас шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд, зээлийн сарын төлбөр төлсний дараа үлдэх орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс доошгүй байх зохицуулалт болон тэтгэврийн зээлийг бусад хэрэглээний зээлтэй адил зохицуулалттай байхаар буюу өр, орлогын харьцааг 50 хувиас хэтрүүлэхгүй байхаар 2025 оны 3 болон 6 дугаар сард шийдвэрлэв. Гэвч зээл авах боломжийг нь хязгаарлаж, хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байгаа талаар зарим иргэнээс ирүүлсэн гомдол, Улсын Их Хурлын байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, УИХ-ын гишүүдээс Монголбанканд ирүүлсэн хүсэлтийг харгалзан үзэж, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар банкнаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлтэй холбоотой дээрх шийдвэрүүдийг хүчингүй болгож, хуучин нөхцөлд нь хэвээр үлдээв.

Мөн тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, нөхцөлийг сайжруулах зорилгоор Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 4-р улирлын ээлжит хурлаар цогц шийдвэрийг гаргав. Үүнд, тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн үлдэгдэлтэй гэнцэхүйц хэмжээний эх үүсвэрийг банкны заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох, тус зээлийн нийт хугацааг 36 сараас ихгүй байхаар нэг удаа сунгаж, зээлийн сарын төлбөрийн дарамтыг бууруулсан тохиолдолд уг активыг бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүйгээр, эцсийн ангиллыг хэвээр хадгалах болон тэтгэврийн зээлд тогтоосон 150 хувийн эрсдэлийн жингийн хэмжээг 100 хувь болгон бууруулах зэрэг шийдвэр багтана.

Банк болон банкны бус санхүүгийн салбарын харилцан хамаарлын эрсдэлийг бууруулах, банк, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн тушаалаар арилжааны банкнаас ББСБ, ХЗХ, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэгч зэрэг этгээдэд зээл болон бусад хэлбэрээр санхүүжилт олгохгүй, тэдгээрээс аливаа актив хөрөнгө худалдан авахгүй байх, олгосон санхүүжилтийн хугацааг сунгахгүйгээр эргүүлэн төлүүлэх зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлдэг болов. Энэхүү бодлого нь нэг талаас зохицуулалттай салбараас олгож буй хэрэглээний зээлийн бодлогын нөлөөлөл сулрахаас сэргийлэх, нөгөөтээгүүр макро-санхүүгийн сөрөг шокийн үед салбар хооронд эрсдэл халдварлах сувгийг хаах ач холбогдолтой юм.


Монголбанкны МБХ санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн макро зохистой бодлогын шийдвэр гаргах зорилгоор тусгайлан хуралдах тогтолцоонд шилжиж, анхны хурлаа 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. Системийн эрсдэл, санхүүгийн тогтвортой байдалд чиглэсэн макро зохистой бодлогын хүрээнд жилд хоёр удаа ээлжит товлолоор хуралдах тогтолцоонд шилжсэн нь институцийн чадавхыг бэхжүүлэх ач холбогдолтой юм. Тус хуралдаанаар макро зохистой бодлогын хэрэгжилтийг хянан хэлэлцэж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын арга хэрэгслийг өөрчлөхгүй хадгалахаар шийдвэрлэв.

Монголбанкнаас иргэний хэрэглээний зээлийн өсөлтийг зохистой түвшинд хадгалах, өрхийн өрийн дарамтыг бууруулах болон банкны системд эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор банкнаас олгох хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа (ӨОХ) болон хугацааны хязгаарлалт тогтоон 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлж байна. Үүний нөлөөгөөр 2018 оны эцэст 36.2 хувьд хүрсэн банкны салбарын нийт зээлд эзлэх хэрэглээний зээлийн хувь хэмжээ 2019 оноос эхлэн буурч, 2025 оны эцэст 29.7 хувь болж буураад байна (Зураг 2.15). Мөн банкнаас шинээр олгосон хэрэглээний зээлийн хугацаа богиносж, хэрэглээний зээлтэй иргэдийн өр, орлогын харьцаа бууран, хязгаарлалтаас доогуур түвшинд хадгалагдаж байна.


Мөн эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн болон банкны салбараас олгох хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлахад Монголбанкнаас хэрэгжүүлж буй макро зохистой бодлогыг чангаруулав.

Ингэснээр хэрэглээний зээлийн өсөлт саарч, бизнесийн зээлийн өсөлт сэргэх хандлагатай буюу 2025 оны эцсээр банкны салбарын нийт зээлийн хэмжээ жилийн 19.0 хувиар өссөний 4.3 нэгж хувийг хэрэглээний зээлийн өсөлт бүрдүүлж байна (Зураг 2.16).

Зураг 2.15 Банкны салбарын нийт зээлд хэрэглээний зээлийн эзлэх хувь



Зураг 2.16 Банкны салбарын нийт зээлийн жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Монголбанк

Банкны хяналт шалгалтын бодлогыг боловсронгуй болгох ажлын хүрээнд

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны А-223 дугаар тушаалаар “Банкны салбарын дунд хугацааны шинэтгэлийн хөтөлбөр”-ийн зорилт 2-т тусгасан банкны хяналт шалгалтын тогтолцоонд эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуулав. Тус ажлын хэсэг нь “Банкны хяналт, шалгалтын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэх, хяналт, шалгалттай холбоотой журам, зааврыг шинэчлэн боловсруулах, банкны эрсдэлийн үнэлгээний нэгдсэн систем нэвтрүүлэх” үүрэгтэй юм.

Түүнчлэн Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Казакстан улс дахь ССАМТАС төвөөс техник туслалцаа авч, зөвлөхтэй хамтран одоогийн хяналт шалгалттай холбоотой журам болон зааврыг шинэчлэх ажлын хүрээнд зөвлөгөө авах, хянан шалгагчдыг чадавхжуулж, сургалтад хамруулах боломжоор хангаж, дэмжлэг үзүүлэн ажиллав.

Тус ажлын хэсгээс Монгол Улсын Банкны тухай хууль, тогтоомж, журам, заавар болонолон улсад хэрэгжүүлсэн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын туршлагыг судалж, банкны хяналт шалгалтын үйл ажиллагааны суурь зарчим болох “Банканд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаанд баримтлах бодлогын баримт бичиг” болон шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөг тус тус боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн тушаалаар батлуулав.


Бодлогын баримт бичгийн үндсэн зорилго нь Монголбанкнаас хэрэгжүүлж буй зайны болон газар дээрх хяналт шалгалт, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хяналт шалгалт, банкны засаглал, тогтворжуулах төлөвлөгөөний үнэлгээ зэрэг арга хэмжээний уялдааг хангах, банкны хяналт шалгалтыг гүйцэтгэл болон эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх, хяналт шалгалтад баримтлах зарчим, аргачлал болон эрсдэлийн үнэлгээний чиглэлийг нарийвчлан тодорхойлох, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд оршино. Банканд хяналт шалгалт хийх үйл ажиллагааг дараах байдлаар сайжруулахаар дараах зорьж байна:

- Банкны эрсдэл өндөртэй үйл ажиллагаанд хяналт шалгалтын нөөцийг зохистой хуваарилж, хяналт шалгалтыг үр дүнтэй, оновчтой үр дүнд хүрэхэд чиглүүлэх;

- Газар дээрх хяналт шалгалтын хугацааг багасгаж, үр дүнг нэмэгдүүлэх буюу зөвхөн эрсдэлтэй банкны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг төвлөрүүлж, эрсдэл багатай банкнуудад хяналт шалгалтын дарамтыг бууруулах;
- Банк тус бүрийн үйл ажиллагааны шинж чанар, санхүүгийн нөхцөл байдал, эрсдэлийн удирдлагын чадвар, хандлага болон банкны систем дэх ач холбогдлыг харгалзан үнэлж, дүгнэх, хянан шалгагч өөрийн мэдлэг, туршлага, логик сэтгэмжийг ашиглан хяналт шалгалтыг зөв, оновчтой хэрэгжүүлэх;
- Олон улсын сайн туршлагатай нийцүүлж зайны хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулж, зайны хяналт шалгалтын үйл ажиллагааг Монголбанкны голлох хяналт шалгалтын хэрэгсэл болгон өөрчлөх;
- Банкны хянан шалгагч цогц мэдээллээр хангагдах, хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сантай болох.

Цаашид Банкны хяналт шалгалтын тогтолцоонд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зохицуулалтуудыг амжилттай нэвтрүүлэхээр ОУВС-гийн техник туслалцааны хүрээнд 2025-2028 онд дараах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.

Зураг 2.17 Шилжилтийн үеийн төлөвлөгөө (2025-2028)



Эх сурвалж: Монголбанк

“Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”-ыг шинэчилж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 594 дүгээр тушаалаар “Банкны зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг анх баталсан болно Тус журмыг Банкны тухай хууль болон Компанийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдтэй нийцүүлэн 2014, 2018 болон 2022 онд шинэчлэн найруулж, банкнуудын зохистой засаглалын зарчимд хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, сүүлийн 20 гаруй жил мөрдөн ажиллаж байна.

Үүний үр дүнд банкуудын засаглалын зарчим аажмаар хэвшиж, салбарын нийтлэг стандарт болон тогтов. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн засаглалын кодекс”-ийн 2025 оны тайланд системийн нөлөө бүхий 5 банк нь нийт 113 нээлттэй хувьцаат компаниас засаглалын үзүүлэлтээр тэргүүлж, эхний 10-т багтаж байна.

Одоогийн мөрдөгдөж буй журам нь Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага

(OECD)-ын засаглалын зарчимд суурилсан боловч, банкны зохистой засаглалыг үнэлэх үнэлгээний аргачлалд тусгагдсан асуумжуудын агуулга хэт ерөнхий, ач холбогдол багатай болон эрсдэлд суурилсан хяналт шалгалттай бүрэн нийцээгүй тул эдгээрийн шалтгааны улмаас тус журмыг шинэчлэн найруулах шаардлага үүсээд буй юм.

Иймд “Банкны салбарын дунд хугацааны шинэтгэлийн хөтөлбөр”-ийн зорилт 2-т тусгасан банкны хяналт шалгалтын тогтолцоонд эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэх хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А-143 дугаар тушаалаар баталсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”-ыг Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос баталсан зохистой засаглалын зарчимтай нийцүүлэн шинэчлэн найруулж, журмын төслийг Монголбанкны цахим хуудсанд байршуулж, олон нийт болон нийт банкнаас саналыг авч ажиллав. Тэдгээрээс ирүүлсэн саналтай танилцан, холбогдох судалгааг хийж, журмын төслийг дахин шинэчлэн найруулж байна. Энэхүү шинэчилсэн журмын төсөл нь банкны эрсдэлийн удирдлагын оролцогч талууд болох төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо, гүйцэтгэх удирдлага, эрсдэл хариуцсан захирал болон түүний нэгж, комплаенс, дотоод аудит болон зохицуулагч байгууллага хоорондын эрсдэлийн мэдээлэл солилцох үр нөлөөтэй тогтолцоог бий болгох, эрсдэлийг үнэлэх, удирдах, бууруулах үйл ажиллагаа сайжруулах, зохистой засаглалын үнэлгээг бодит нөхцөлд нийцүүлэх, эрсдэлийн талаарх мэдээллийг ил тод тайлагнах тогтолцоог бүрдүүлснээрээ онцлог болох.

Банкнүүдын зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлж байна.

Монголбанкнаас банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын улсын жишиг, зарчимд нийцүүлэх хүрээнд “Базел стандартын Бүлэг 2”-ын өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP, ILAAP), хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-уудыг 2023 оноос үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд тайлант онд банкнууд ICAAP, ILAAP-ын туршилтын тайланг холбогдох журмын төслийн дагуу 3 дахь жилдээ бэлтгэн Монголбанканд ирүүлж байна. Эдгээр тайланд Монголбанкнаас холбогдох журмын төслийн дагуу SREP үнэлгээ болон хоёр дахь шатны чанарын баталгаажуулалтыг хийж гүйцэтгэн үр дүнг банкнуудад танилцуулах уулзалтыг зохион байгуулав. Тус уулзалтаар банкнуудад тулгарч буй эрсдэлийн удирдлагын дутагдал, цашид анхаарах зүйлс, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн болно.

“Базел стандартын Бүлэг 2”-ыг манай улсын банкны хяналт шалгалтын журам, заавар, зохицуулалтын арга хэрэгслүүдэд нэвтрүүлэх ажлын хүрээнд “Банкны дотоод өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг үнэлэх үйл явц (ICAAP, ILAAP)-ын журам”-ын төслийг 2025 оны 2-р улиралд “Захиргааны ерөнхий хууль”-ийн дагуу олон нийтэд танилцуулах, сонсох ажиллагааг зохион байгуулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн тушаалын хавсралтаар батлав. Улмаар тус журмыг “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэл”-д бүртгүүлэхээр ажиллаж байна.


Тогтвортой, ногоон санхүүжилтийн хүрээнд “Монголын санхүүгийн байгууллагуудад зориулсан уур амьсгалын нөлөөллийн тайлагналын удирдамж” (Удирдамж)-ийг батлуулав.

Монголбанкнаас Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP) -той “Төв банкиг ногооруулах бэлэн байдалд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС S1, S2) -д нийцүүлэн санхүүгийн салбарт зориулсан удирдамжийг боловсруулж, нээлтийн үйл ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр банк санхүүгийн салбарын удирдлагууд болон холбогдох ажилтнуудыг оролцуулан зохион байгуулав. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн А-180 дугаар тушаалаар удирдамжийг батлан Монголбанкны цахим хуудсанд нийтлэв.

Тус удирдамжийг банкнуудын тайлагналд нэвтрүүлснээр Монгол Улсын санхүүгийн салбарт ил тод, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал алхам болсон бөгөөд хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талын итгэлийг нэмэгдүүлэх, уур амьсгалын нөлөөллийг ил тод тайлагнах үйл явцыг эрчимжүүлэх, олон улсад Монгол Улсын санхүүгийн салбарын нэр хүндийн эрсдэл болон ногоон угаалт (green washing)-ын эрсдэлийг бууруулах, банк, санхүүгийн салбарын уур амьсгалын нөлөөллийн тайлагналын тухай ойлголтын ялгаатай байдлыг арилгах зэрэг нөхцөл бүрдсэн буй.

Удирдамжид банкнууд тайлагнах явцдаа суралцах буюу СТОУС S1, S2 стандартыг бүрэн нэвтрүүлэхэд шаардлагатай өгөгдөл мэдээллийг цуглуулах, дотооддоо мөрдөх тайлагналын арга аргачлалыг боловсруулах, ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, зохицуулагч байгууллагын тайлангийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх үе шаттай замын зургийг тусгав. Энэ хүрээнд нийт банк, санхүүгийн байгууллагаас 2032 оноос уур амьсгалын нөлөөллийн СТОУС S1, S2 стандартын дагуу бүрэн хэмжээнд тайлагнадаг болно.

Зураг 2.18 СТОУС S1, S2 стандартыг хэрэгжүүлэх замын зураг (2025-2032)



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын орчныг бүрдүүлэх нь

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг “Алсын хараа 2050”-д хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон, олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлэхээр тусгаж, банк, санхүүгийн тогтолцоог хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих бодлогод нийцүүлэн шинэчилж, хөрөнгө оруулалт, зээлийн таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн үйлчилгээг технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилан хөгжүүлэх үйл ажиллагааг 2021-2030 онд хэрэгжүүлэхээр заасан. Энэ хүрээнд гадаадын банк, түүний салбарын эрх зүйн зохицуулалтын орчин сайжирч байгаатай холбогдуулан Монголбанк банканд хяналт тавих зохицуулалтыг нарийвчлан төрөлжүүлэх, санхүүгийн салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих шаардлага тулгарч байна. Иймд Монголбанк нь 2025 онд гадаадын банк, гадаадын хөрөнгө оруулагч нарт дотоодын санхүүгийн салбарт нэвтрэх, хөрөнгө оруулах боломжийг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай бодлого, зохицуулалтын механизмыг бий болгоход анхаарч ажиллав.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн тушаалаар “Гадаадын банкны салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журам”-ыг баталснаар гадаадын банкны салбар Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэв.

Монголбанкнаас гадаадын банкны хянан шалгах эрх бүхий байгууллагуудтай хийсэн харилцан ойлголцлын санамж бичгүүд нь хоёр байгууллагын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох хүрээнд

байв. Иймд Монгол улсад салбараа нээх хүсэлт ирүүлсэн гадаадын банкны харьяа улсын хянан шалгах эрх бүхий байгууллагатай хос хяналтын тогтолцоонд суурилсан хамтарсан хяналт шалгалт хэрэгжүүлэх нөхцөлийг тодорхойлж, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байх шаардлага үүссэн тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн тушаалаар үлгэрчилсэн харилцан ойлголцлын санамж бичгийн загварыг боловсруулан батласан буй. Тус санамж бичигт хоёр орны зохицуулагч байгууллагын Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх гадаадын банкны салбарын хяналт шалгалтын хамрах хүрээг нарийвчлан тодорхойлж, мэдээлэл солилцох арга хэрэгсэл, мэдээллийн нууцлалыг хангах харилцааг тусгаж, харьяа улсын болон хүлээн авагч улсын хянан шалгах эрх бүхий байгууллагын чиг үүргийг тодорхойлов.

Мөн Монгол Улсад гадаадын банкиг охин компани хэлбэрээр дотоодын зах зээлд нэвтрэх болон гадаадын банк, гадаад улсын банкны салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд тавих нэмэлт шаардлага, хяналт шалгалтын зохицуулалтыг тодорхой болгох зорилгоор гадаадын банкиг хянан зохицуулах харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, гадаадын банкиг хуулийн этгээдийн хэлбэрээр үүсгэн байгуулагдахыг дэмжих үзэл баримтлал бүхий “Банкны тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

“Банкны хадгаламжийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөлийг тогтоох журам”-ыг батлав

Монгол Улсын банкны салбарын эх үүсвэрийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлд дээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч нарт өргөн хүрээнд уян хатан, дундын зуучлал багатай хөрөнгө оруулалтын сонголтыг бий болгож, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, эх үүсвэрийн зардлыг бууруулах зорилгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлтээр 191 дүгээр зүйл, Банкнаас үнэт цаасны зах зээлд гаргасан хадгаламжийн сертификат арилжих зүйлийг боловсруулж, хууль тогтоогчид уламжлав. Уг зүйлээр Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй банк хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах, зах зээлд арилжахаар гаргасан хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнахтай холбогдох журмыг зохицуулагч байгууллагууд хамтран батлах зэрэг зохицуулалтыг хуульд нэмж тусгасан бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан юм.

Дээрх хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсгийг үндэслэн “Банкны хадгаламжийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөлийг тогтоох журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А-263 дугаар тушаалаар батлуулан, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны актаар бүртгүүлэв. Энэхүү зохицуулалтын хүрээнд Монголбанкнаас хадгаламжийн үйл ажиллагааны зөвшөөрөл авсан банкны эрхлэх мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг нөхцөл, шаардлагыг тодорхойлж өгсөн буй. Мөн хадгаламжийн сертификатыг илүү уян хатан санхүүгийн хэрэгсэл болгох, ингэснээр санхүүгийн зах зээлд банкны эх үүсвэрийн бүтцийг оновчтой болгох, актив пассивын хугацааны эрсдэлийг бууруулах, эх үүсвэрийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх, банкны эх үүсвэр бий болгохтой холбоотой захиргаа хүний нөөцийн зардлыг багасгах, банк хоорондын чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зэрэг ач холбогдолтой юм.

Банкны салбарт СТОУС 9 стандартыг хэрэгжүүлэх тухай

Монголбанкнаас банкны салбарт санхүүгийн тайлагналын олон улсын есдүгээр стандарт буюу СТОУС 9 стандартыг хэрэгжүүлэх ажлыг Азийн Хөгжлийн Банк болон Олон Улсын Валютын Сангийн техник тусалцааны хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр дараах чиглэлээр хэрэгжүүлж байна:

1. СТОУС 9 стандартын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, банкнуудын бэлэн байдлыг судлах;

2. СТОУС 9 стандартын талаарх сургалт зохион байгуулах, мэдлэг олгох, чадавхжуулах;
3. Холбогдох журам, зааврын төслийг боловсруулах.

Монголбанкнаас олон улсын сайн туршлагад үндэслэн түгээмэл тулгамддаг асуудлыг шийдвэрлэх, шилжилтийн үеийн богино хугацааны арга хэмжээг, үр дүнтэй хэрэгжүүлэх, Монголбанкны дотоод чадавхыг бусад улс оронтой нийцүүлж, санхүүгийн тогтвортой байдалд хэт дарамт учруулахгүйгээр шилжилт хийх үүднээс шилжилтийн үеийн төлөвлөгөөг батлан, шаардлагатай арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2025 онд Монголбанкны хянан шалгагч нарыг чадавхжуулах, салбарын оролцогч талуудтай мэдээлэл солилцох уулзалтуудыг зохион байгуулах, олон улсын байгууллагын зөвлөмж, судалгааны үр дүнд үндэслэн СТОУС 9 стандартыг хэрэгжүүлэх зарчмыг тодорхойлох, зохицуулагч байгууллагын суурь шаардлагыг тогтоох ажлыг тус тус гүйцэтгэв.

Монголбанкнаас банкны хэмжээнд дагаж мөрддөг, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг СТОУС 9 стандартад нийцүүлсэн бөгөөд төслийг батлуулахаар ажиллаж байна. Түүнчлэн, Монголбанкнаас банканд СТОУС 9 стандартыг хэрхэн хэрэгжүүлэх, “Нягтлан бодох бүртгэлийн журам” болон “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын хоорондын уялдаа, мөн банканд стандартыг хэрэгжүүлэх суурь зарчмыг зохицуулагч байгууллагаас тодорхойлох зорилгоор “Банканд СТОУС 9 стандартыг хэрэгжүүлэх аргачлал”-ын төслийг боловсруул.

Банкны системд нөлөө бүхий банкнийг тогтоон, холбогдох аргачлалд өөрчлөлт оруулав

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-104 дүгээр тушаалаар баталсан “Банкны системд нөлөө бүхий банкнийг тогтоох аргачлал”-д “Энэ аргачлалын 3.1-д заасны дагуу Монголбанкны банкны бодлого, зохицуулалт чиг үүрэг бүхий газар нь банкны нөлөө бүхий байдлын оноог банк тус бүрээр жилд нэгээс доошгүй удаа тооцоолно” болон “Энэ аргачлалыг Монголбанкны банкны бодлого, зохицуулалтын чиг үүрэг бүхий газар жилд нэгээс доошгүй удаа хянаж, шаардлагатай тохиолдолд аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг боловсруулж шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу Монголбанкнаас банкны нөлөө бүхий байдлын оноог тооцоолсон болно.

Аргачлалд 500 болон түүнээс дээш оноо авсан банкнийг банкны системд нөлөө бүхий банк гэж тогтооно гэж заасны дагуу 2025 оны байдлаар Хаан, Голomt, Худалдаа хөгжлийн, Төрийн, Хас зэрэг банк босго оноог хангасан тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А-105 дугаар тушаалаар баталсан “Банкны системд нөлөө бүхий банк”-ны жагсаалтыг хэвээр үлдээв.

Түүнчлэн, “Банкны системд нөлөө бүхий банкнийг тогтоох аргачлал”-д банкны системд нөлөө бүхий банк нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй байх болон нөлөө бүхий байдлын босго оноог хангах доод хугацааг тодорхойлсон аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А-277 дугаар тушаалыг батлан, мөрдөж байна.

Банкны салбарын зохицуулалттай холбоотой хэрэгжүүлсэн бусад ажил

Үндэсний эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө, банкны салбарт үзүүлэх үр дагавар, төрийн хөгжлийн баримт бичигт тусгагдсан болохыг тус тус харгалзан Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх зориулалт бүхий бондын худалдан авалтыг дэмжих үүднээс Монголбанкнаас тус бондын эрсдэлийн жинг бууруулах, түргэн борлогдох активт тооцох, Төв банкны санхүүжилтийн барьцаа хөрөнгийн жагсаалтад оруулах түр зохицуулалтыг 2025 оны 12 дугаар 01-ний өдөр хийсэн. Тус түр зохицуулалтын хүчин төгөлдөр хугацаа 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болох юм.

Түүнчлэн, дотоодын мөнгөний захын хэрэгслүүдийг төрөлжүүлэх, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг түргэн борлогдох активын төвлөрлийг бууруулах замаар бэхжүүлэх зорилготой аймгийн үнэт

цаасны эрсдэлийн жинг 20 хувиар тогтоож, тус үнэт цаасыг түргэн борлогдох активт тооцох боломжийг судлан ажиллаж байна.

Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд

Банкны тухай хуулийн 62, 63 дугаар зүйл болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-155 дугаар тушаалаар баталсан “Банкны тогтворжуулалтын сангийн журам”-ын дагуу Монголбанк 2022 оноос “Банкны тогтворжуулалтын сан”-г бүрдүүлэх болсон юм. Тус санг бүрдүүлснээр банкны системд нөлөө бүхий банк (БСНББ)-нд бүтцийн өөрчлөлт хийхэд шаардагдах санхүүжилтийг бий болгох чухал ач холбогдолтой. Тиймээс банкны салбарын тогтвортой байдлыг хангах, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн хууль ёсны эрхийг хамгаалах үүднээс банкны салбарын нөлөө бүхий банкнаас тогтворжуулалтын санд төлөх жилийн хураамжийн хэмжээг банкны эрсдэлийн түвшнээс хамааруулан тооцох зарчмыг тодорхойлж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А-184 дүгээр тушаалаар “Банкны тогтворжуулалтын сангийн жилийн хураамжийг тооцох аргачлал”-ыг баталсан. Тус санд 2025 оны байдлаар 57.8 тэрбум төгрөг хуримтлагдсан байна.

Хүндрэлийн үеийн бэлэн байдлыг хангах, банкныг түргэн шуурхай тогтворжуулах боломжийг бүрдүүлэх үүднээс Банкны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны тушаалаар баталсан “Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журам”-ын дагуу Монголбанк жил бүр банкнуудаас “Банкийг тогтворжуулах төлөвлөгөө”-г банкны ТУЗ-өөр баталгаажуулснаар хүлээн авч, үнэлдэг. Тус төлөвлөгөөний зорилго нь банк аливаа хүндрэлтэй нөхцөлд өөрийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, төлбөрийн чадвар (өөрийн хөрөнгө) болон хөрвөх чадвар (төлбөр түргэн гүйцэтгэх чадвар)-ын зохистой түвшинд хүргэх юм. Монголбанк энэхүү цогц арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжихүйц байдал, хүндрэлийн үеийн тогтворжих чадварыг үнэлж, холбогдох зөвлөмжийг жил бүр тухайн банканд хүргүүлэн ажиллаж байна.

Банкны тухай хуулийн 68 дугаар зүйл болон “Банкийг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх, банкны эрх хүлээн авагч томилох, дуусгавар болгох журам”-ын дагуу албадан татан буулгах арга хэмжээ явуулж буй Зоос банк ХК, Хадгаламж банк ХХК, Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчийн үйл ажиллагаанд Монголбанкнаас хяналт тавин ажиллаж байна. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор Монголбанк өөрийн цахим хуудсанд банкны эрх хүлээн авагчдын Банкны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэг, 73 дугаар зүйлийн дагуу чанаргүй активыг эргэн төлүүлж, хөрөнгө худалдан борлуулсан орлогоос нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн хангаж байгаа мэдээллийг сар бүр шинэчлэн байршуулж байна.

Албадлагын арга хэмжээг түргэн шуурхай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх, төрөөс гарах зардлыг багасгах зарчмын хүрээнд, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Банкны тухай хуулийн 53 дугаар зүйлийн дагуу хэвийн үйл ажиллагаагаа сэргээх чадваргүй БСНББ-нд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Монголбанк “Банкны системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа, үйлчилгээг тодорхойлох заавар”, банканд авах бүтцийн өөрчлөлт хийх арга хэмжээний үндэслэл, түүнд ашиглагдах хэрэгсэл, сонгох дараалал, дуусгавар болгох нөхцөл, санхүүжилтийн эх үүсвэр, Монголбанкны нэгжүүдийн чиг үүрэг, оролцоо, олон нийттэй харилцах стратеги, бусад этгээдтэй хамтран хийх ажиллагааг нарийвчлан тодорхойлсон бодлогын суурь баримт бичгийг 2025 онд боловсруулсан. Энэ дагуу банканд авах албадлага, хямралын үеийн бэлтгэл, хариу арга хэмжээний зохицуулалтыг цогц бөгөөд олон улсын сайн туршлагатай нийцүүлэхээр ажиллаж байна.

Банкны хяналт шалгалттай холбоотой зохион байгуулсан сургалт, уулзалт

“Банкны зохистой засаглалын хяналт шалгалт” сургалт: ОУВС-гийн зөвлөх болон Гүрж улсын Төв банкны засаглал хариуцсан захирал нар 2025 оны 2 дугаар сарын 17-19-ний нд “Банкны зохистой засаглалын хяналт шалгалт” сэдвээр сургалт хийлээ. Сургалтын үеэр банкны зохистой засаглалын

үндсэн зарчим, удирдлагын бүтцийн үр ашигтай байдал, ГУЗ-ийн хараат бус байдал ба үүрэг хариуцлага, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохион байгуулалт, хяналт шалгалтын хүрээнд засаглалын үнэлгээ хийх аргачлал, түүнчлэн олон улсын туршлага (ОУВС ба Гүржийн Төв банкны жишээгээр) зэрэг сэдвийг хамрав.

Зайны хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах уулзалт, семинар: Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд 2025 оны 10 дугаар сард ОУВС-гийн зөвлөх болон тус сангийн богино хугацааны зөвлөхүүд болох Армени улсын Төв банкны Эрсдэлийн шинжилгээний газрын захирал Манех Харутюнян болон Хяналт шалгалтын стратеги, хөгжлийн хэлтсийн захирал Анна Егиазарян нар Монголбанкны зайны болон газар дээрх хяналт шалгалтын үйл ажиллагаатай танилцаж, цаашид 2026 оноос мөрдлөг болгон ажиллах “Зайны хяналт шалгалтын аргачлал”-ын эрсдэлийн үнэлгээний загвар, тайлангуудад зөвлөгөө өгөх зорилготой уулзалт, семинарыг холбогдох ажилтнуудтай хамтран зохион байгуулав.

“СТОУС 9 стандартын хяналт шалгалт” сургалт, семинар: Монголбанкнаас техник туслалцааны хөтөлбөрийн хүрээнд Олон Улсын Валютын Сан болон Азийн Хөгжлийн Банкны зөвлөхүүд СТОУС 9 стандартын хүрээнд хянан шалгагч нарт зориулсан сургалтуудыг 2025 оны 4 дүгээр сар, 2025 оны 6 дугаар сар болон 2025 оны 10 дугаар саруудад зохион байгуулсан.

Сургалтуудаар СТОУС 9 стандартын үндсэн ойлголтыг өгөх, хянан шалгагч нарын чадавхыг дээшлүүлэх, СТОУС 9 стандартын тогтолцоо, хэрэгжилтийг хянан шалгахад анхаарах асуудлуудыг тодорхойлох, жишиг асуумжуудыг танилцуулсан.


Банкны хяналт шалгалтын чиглэлээр ССАМТАС төвд сургалт зохион байгуулав:

Монгол Улс ОУВС-гийн Казакстан улс дахь ССАМТАС төвийн гишүүн орон бөгөөд ССАМТАС төвөөс зохион байгуулдаг сургалт, семинарт оролцох, гишүүн орнуудтай туршлага солилцох, мөн техникийн туслалцаа авах боломжбүрдүүлсэн юм. Монголбанк банкны салбарын дунд хугацааны шинэтгэлийн хөтөлбөрийн зорилт 2-т тусгасан банкны хяналт шалгалтын тогтолцоонд эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд дээрх төвөөс техник туслалцаа авч, хамтран ажиллаж байна. Техник туслалцааны хөтөлбөрийн хүрээнд болон ССАМТАС төвөөс зарласан, банкны хяналт шалгалтын чиглэлийн “Зохистой засаглал”, “Суурь зарчмууд болон СТОУС 9 стандарт”, “Холбоотой талын ажил гүйлгээ”, “Хяналт шалгалтын зарчим – дугуй ширээний уулзалт”, “Эрсдэлд суурилсан хяналт шалгалт” сургалтад Монголбанкны хянан шалгагч нар идэвхтэй оролцож, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн зэрэгцээ, гишүүн орнуудын туршлагатай танилцаж, өөрийн улсын зохицуулалтын талаар мэдээлэл, туршлага солилцсон байна.

Банкны үйл ажиллагаанд хяналт тавих

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны чиглэлийн дагуу банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах зорилгоор 2025 онд Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудын хэрэгжилтэд газар дээрх ба зайны хяналт шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэв.

Зураг 2.19 Банканд хийх хяналт шалгалтын цар хүрээ



Эх сурвалж: Монголбанк

Банкны үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн газар дээрх хяналт шалгалт

Банкнүүдын үйл ажиллагаанд 2026 онд хийж гүйцэтгэх эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөг Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулав. Банкнүүдын өндөр эрсдэлтэй үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг төвлөрүүлэн 2025 онд иж бүрэн шалгалтыг 3 банканд, хэсэгчилсэн шалгалтыг 7 банканд, Монголбанкны бусад нэгжтэй хамтран бүх банканд сэдэвчилсэн хяналт шалгалтыг тус тус хийж гүйцэтгэв.

Банкны үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн зайны хяналт шалгалт

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банканд зайнаас хяналт тавих аргачлал”-ын дагуу арилжааны банкнүүдын улирал бүрийн ерөнхий мэдээлэл, балансын бүтэц, (CAELS) буюу өөрийн хөрөнгийн хүрэлцээ, активын чанар, ашигт ажиллагаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, зах зээлийн эрсдэлийн үзүүлэлтэд гарсан өөрчлөлт, үүсэж болзошгүй эрсдэл, цаашид авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй тусгаж үнэлгээ, дүгнэлт өгсөн тайлан болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банканд өгөгдсөн үүргийн биелэлт, банкуудын чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайланг хянасан “Зайны хяналтын дүгнэлт”-ийг улирал бүр боловсруулан танилцуулж ажиллав.

Банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгсэл, үнэлгээний аргачлалыг олон улсын зарчимд нийцүүлэх арга хэмжээний хүрээнд Базел стандартын Бүлэг 2-т тусгагдсан шаардлагууд болон “Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал” (SREP)-ыг нэвтрүүлж, арилжааны банкуудын 2024 оны банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP), хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ын тайланг үнэлж, үнэлгээний үр дүнг 2025 оны 11 дүгээр сард банкуудын удирдлагад танилцуулав.

Банкнүүдын сар бүрийн санхүүгийн тайлан мэдээ болон бусад тайланг Банкны тухай хуультогтоомжийн хүрээнд зайны хяналтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг хууль тогтоомжийн дагуу арилгуулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлсэн болно. Зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд банкуудад албан бичгээр сануулах, үүрэг даалгавар өгөх, улсын байцаагчийн мэдэгдлээр хугацаатай үүрэг өгч, зөрчил илэрсэн тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулж ажиллав.

Мөн Монголбанкны Хяналт шалгалтын газарт хандан ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын гишүүд болон хянан шалгах түр хорооны ажлын хэсэг, бусад төрийн байгууллага болон банкнаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянаж шийдвэрлэх, холбогдох мэдээллийг бэлтгэн хүргүүлж ажиллав.

Хууль, журам, эрх зүйн орчны шинэчлэлт

Монголбанкнаас банкны салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааг олон улсын шилдэг туршлага, эрсдэлд суурилсан хяналтын зарчимд нийцүүлэх зорилгоор газар дээрх хяналт шалгалтын аргачлалыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүллээ. Шинэчилсэн аргачлал нь банкны үйл ажиллагаанд тулгарч буй эрсдэлийг системтэйгээр үнэлэх, эрт үед илрүүлэх, түүнд тохирсон хяналтын арга хэмжээг цаг тухайд нь авах боломжийг бүрдүүлж байна.

Мөн тус шинэчлэлийн хүрээнд банк бүрийн эрсдэлийн түвшин, дотоод хяналтын чанар, эрсдэлийг бууруулах чадавхыг нэгдсэн аргачлалаар үнэлэх тогтолцоо бүрдэж, хяналт шалгалтын нөөцийг эрсдэлийн түвшин өндөр чиглэлд төвлөрүүлэн илүү үр ашигтай, оновчтой ашиглах нөхцөл бүрдэж, банкны системийн тогтвортой байдлыг хадгалах, үүсэж болзошгүй аливаа эрсдэлийг урьдчилан илрүүлэх, банкнуудын эрсдэлийн удирдлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхээс гадна хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх институцийн суурь бэхэжнэ.

Мөн банкны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Банкны тухай хуулийг шинэчлэх төсөлд, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог хууль, эрх зүйн зохицуулалттай уялдуулах санал, дүгнэлт боловсруулав.

Банкны мөнгө угаах, санхүүгийн терроризмын үйл ажиллагаанд хяналт тавих

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, холбогдох бусад эрх зүйн актын хүрээнд банк хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хуулийн хэрэгжилтийг хангуулах, банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (МУТС/ҮОХЗДС)-тэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн хэрэгжүүлэв.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалт нь банкнуудын МУТС-тэй тэмцэх бүтэц зохион байгуулалт, бодлого журам, харилцагчийг таньж мэдэх, гүйлгээнд тусгайлсан хяналт тавих, бэлэн мөнгөний, гадаад төлбөр тооцоо болон виртуал хөрөнгийн гүйлгээг мэдээлэх, эцсийн өмчлөгчийг тодорхойлох, сэжигтэй гүйлгээг мэдээлэхтэй холбоотой хийгдэж буй үйл ажиллагаа болон корреспондент банкны үйл ажиллагаа зэрэг чиглэлүүдийг хамарсан болно.

Банкны МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн газар дээрх хяналт шалгалт

Хяналт шалгалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх хэлтсээс 2025 онд банкнуудын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан аргачлалын дагуу 8 банканд газар дээрх иж бүрэн болон хэсэгчилсэн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу банкнуудын бэлэн валютын арилжааны зориулалт, хэмжээ, ханш, бэлэн валютын орлого, зарлага, зарласан ханш болон цахимаар хийсэн арилжааны ханшийн зөрүү, сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлсэн эсэх болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа нь холбогдох хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэх, гадаад валютын дуудлага худалдаанаас худалдан авсан валютыг банк захиалгын дагуу худалдсан эсэх зэрэг үйл ажиллагааг хамруулан сэдэвчилсэн хяналт шалгалтыг Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газартай хамтран хийж гүйцэтгэлээ.

Банкны МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн зайны хяналт шалгалт

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох журмын дагуу банкнуудаас ирүүлсэн мэдээлэлд тулгуулан банк бүрийн МУТС эрсдэлийн үнэлгээг хийж, газар дээрх хяналт шалгалтын чиг хандлагыг тодорхойлсон.

“Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-ын дагуу 12 банканд зайны хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Банкнаас сар, улирлаар ирүүлсэн тайлан, мэдээ, эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн банкны тайлант хугацааны бизнесийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэл, хяналтын тогтолцоо, банкнуудын МУТС/ҮОХЗДС үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлж, нэгдсэн үнэлгээг боловсруулав.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний хэрэгжилтийг банкнууд хангаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Хууль, журам, эрх зүйн орчны шинэчлэлт

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь цахим орчинд харилцагчийг таньж мэдэх, цахимаар харилцагчийг бүртгэх боломжтой болсон юм. Дээрх хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор улс орнуудын сайн туршлагад үндэслэн “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын “Харилцагчийг таньж мэдэх” бүлэгт цахимаар харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны зохицуулалтыг оруулахаар холбогдох төслийг боловсрууллаа.

МУТС-тэй тэмцэх Үндэсний хөтөлбөр, түүний хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр” буюу “Үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу хэрэгжүүлэх шаардлагатай Монголбанк болон банкны салбарын ажлуудыг хийж гүйцэтгэн, тухай бүр тайлагнаж байна.

Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/171 дүгээр тушаалын дагуу Банкны салбарын эмзэг байдлыг үнэлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Банкны салбарын эмзэг байдлыг үнэлэх ажлын хүрээнд банк тус бүрээс шаардлагатай мэдээллийг гаргуулан авч, Дэлхийн Банкны аргачлалын дагуу үнэлэн, тайланг боловсруулан хүргүүлсэн.

Мөн Үндэсний эрсдэлийн үнэлгээний дэд ажлын хэсэг болох Модуль 2 буюу Үндэсний эмзэг байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, Модуль 8 буюу Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийх, Модуль 9 буюу Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ хийх, Модуль 10 буюу Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэгт ажиллалаа.

Монгол Улсад татварын зорилгоор харилцан мэдээлэл солилцох ажиллагаа олон улсын стандартын дагуу хэрэгжиж байгаа эсэхэд “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага”-аас хийх үнэлгээний ажилд бэлтгэж, үнэлгээ боловсруулах, хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд тавих, үнэлгээний тайлан боловсруулах, хамгаалах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллан, банкны салбартай холбоотой асуудалд санал боловсруулж хүргүүлсэн болно.

Банканд зөвшөөрөл олгох хүрээнд: Банкны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн баталсан журмуудын хүрээнд зөвшөөрөл олгохтой холбоотой чиг үүргийг хэрэгжүүлэв.

Зөвшөөрлийн алба нь 2025 онд ирүүлсэн зөвшөөрлийн хүсэлт, холбогдох баримт бичгийг хянаж дараах байдлаар шийдвэрлэв. Үүнд:

Олгосон зөвшөөрөл:


- Үйл ажиллагааны энгийн 4 зөвшөөрөл;
- Банк шинээр хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай 11 зөвшөөрөл;
- Ногдол ашиг хуваарилах 8 зөвшөөрөл;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлага томилох тухай 26 мэдэгдэл;
- Гадаад валютын тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлах тухай 19 зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Харин банк болон хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 12 зөвшөөрлийн хүсэлт, холбогдох баримт бичгүүд хууль, журмын шаардлага хангаагүй тул зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

2.4 ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Монголбанк нь Төв банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийн гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар болон найдвартай байдлыг хангах, дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмын дагуу нөөцийн удирдлагыг хэрэгжүүлдэг. ГВУН-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь олон улсын жишигт нийцсэн, оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон давхар хяналтын тогтолцоог бий болгоход чиглэсэн байдаг. Мөн нөөцийн статистикийн нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлан ГВУН-ийн хэмжээг ОУВС-гийн “Мэдээлэл түгээх тусгай стандарт”-ын дагуу сар бүр боловсруулж, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлж байна.

Зураг 2.20 Төв банкнуудын бодлогын хүү, хувиар



Эх сурвалж: Блүүмберг


2025 онд дэлхийн томоохон эдийн засаг бүхий улс орнуудын хооронд улс төр болон геополитикийн тодорхой бус байдал үргэлжилсэн хэвээр байв. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп 2025 оны 4 дүгээр сард гадаад худалдааны түнш орнуудад тариф тогтоох шийдвэр гаргасан нь олон улсын зах зээлд шок үүсгэж, түүхий эдийн үнийн савлагаа нэмэгдэх, бусад улс орнууд хариу татварын арга хэмжээ авах нөхцөлд хүргэв. Тэргүүлэх Төв банкнууд нь мөнгөний бодлогын үндсэн зорилт болох инфляцын түвшин ба зах зээлд үүсээд буй тодорхой бус нөхцөл байдлыг анхааралтай ажиглан, мөнгөний бодлогоо 2025 онд аажмаар зөөлрүүллээ. Дээрх зах зээлийн орчинд нөөцийн валютуудын мөнгөний бодлогын төлөв, дохио, түүнийг тойрсон тодорхой бус байдал болон эрсдэлийг үнэлж, харилцагчийн болон төлбөр тооцооны эрсдэлийг хамгийн бага байлгах зарчмаар хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хэрэгслүүдийг тус тус сонгон ГВУН-ийн удирдлагыг гүйцэтгэв.

Тухайлбал, АНУ, Англи, Япон, Герман, Франц, Льюксембург зэрэг орны Төв банк; олон улсын банк, санхүүгийн байгууллага; зээлжих зэрэглэл өндөртэй гадаадын банк, санхүүгийн байгууллагуудад харилцах, хугацаат хадгаламж, богино болон урт хугацаат үнэт цаас хэлбэрээр байршууллаа. Мөн хөрөнгө оруулалтын таатай орчныг ашиглан урт хугацаат хөрөнгө оруулалтын багцын хэмжээг аажмаар нэмэгдүүлж, АНУ-ын ЗГҮЦ, олон улсын банк, санхүүгийн байгууллагын үнэт цаасанд хөрөнгө оруулах замаар бенчмарк өгөөжийг давуулсан гүйцэтгэлтэй удирдав.

Монголбанк нь 2025 онд ГВУН-ийг нэмэгдүүлэх зорилгоор, холбогдох хуулийн хүрээнд дотоодын иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 16.3 тн үнэт металл худалдан авч, мөнгөжүүлэх үйл ажиллагааг эрхлэн, багцын удирдлагыг олон улсын зах зээл дээр хэрэгжүүллээ. Алтны ханш нь 2025 онд Ойрх Дорнод болон ОХУ-Украины дайн, геополитикийн хурцадмал байдал, ам.долларын бодит өгөөжийн бууралт, АНУ ба худалдааны түнш орнуудын хувьд үүссэн гадаад худалдаа болон тарифын зөрчилдөөн зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр тогтвортой өсөлттэй байв. Мөнгөжсөн алтны багцын арилжааг олон улсын зах зээл дээрх макро эдийн засгийн тоон үзүүлэлт, тэдгээрийн хүлээлт, харьцуулсан гүйцэтгэл, хөрөнгө оруулагчдын хандлага, хүлээлт, геополитикийн нөхцөл байдал, ХНБ-ны бодлогын төсөөлөл, дотоодын зах зээлээс худалдан авах алтны хэмжээ зэрэг мэдээлэлд үндэслэн эрсдэлийн хязгаарлалтуудын хүрээнд бодит ашгийг нэмэгдүүлэх зарчмаар гүйцэтгэв.

Монголбанк нь Монгол Улсын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах, Төв банкны хүүгийн зардлыг бууруулах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор дотоодын зах зээлээс худалдан авч мөнгөжүүлсэн алтны эх үүсвэрийг ашиглан Хятадын Ардын Банктай байгуулсан “Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцэл”-ийн ерөнхий гэрээний хүрээнд 2011-2016 оны хооронд ашигласан нийт дүнгээс 6.0 тэрбум юанийн төлөлтийг 2023-2024 онд хийж гүйцэтгэсэн. Улмаар своп хэлцлийн ашиглалтын үлдэгдэл 2025 оны эцсийн байдлаар 6.0 тэрбум юань байна. Тус гэрээг анх байгуулснаас хойших хугацаанд Монгол Улс, БНХАУ-ын хоорондын гадаад худалдааны эргэлт 2.9 дахин, банкны системээр дамжин хийгдсэн юанийн гүйлгээний хэмжээ 3.4 дахин өссөн нь хоёр орны гадаад худалдаа, санхүүгийн салбарын уялдаа, интеграцчилал гүнзгийрснийг илтгэж байгаа бөгөөд энэ нь “Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн ерөнхий гэрээ”-ний хэрэгцээ, ач холбогдол улам бүр нэмэгдсэнийг тодотгож байна.

Зураг 2.21 Гадаад валютын улсын нөөц ба импортын хэрэгцээг хангах түвшин



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын улсын нөөц 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар түүхэн дээд түвшин болох 7,005.3 сая ам.долларт хүрч, оны эхнээс 27.1 хувиар буюу 1,495.5 сая ам.доллараар нэмэгдлээ. Энэхүү үзүүлэлт нь:

- Валютын төлбөртэй бараа болон үйлчилгээний импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр тооцвол 5.4 сар буюу 23.3 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшин,
- Валютын төлбөртэй барааны импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр тооцвол 7.8 сарын буюу 33.4 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинг тус тус хангаж байна.

Энэ нь олон улсын жишиг түвшин болох импортын 3.0 сарын хэрэгцээг хангах боловч Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үзэл баримтлалд “ГВУН нь үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй байх” гэж зааснаас доогуур түвшинд хэвээр байна.

Монголбанк нь ГВУН-ийн удирдлагын хүрээнд харилцагч дэлхийн тэргүүлэх банк, санхүүгийн байгууллагуудаар дамжуулан арилжааны банкны корреспондент банкны харилцаанд дэмжлэг үзүүлэх бодлого баримталж ажилладаг. Шууд клирингийн дансны төрөлжилтийг нэмэгдүүлэх, нэг банкнаас хараат бус байдлыг бууруулж хил дамнасан төлбөр тооцооны дэд бүтцийг сайжруулах, олон улсын санхүүгийн системд нэвтрэх гарцыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 2025 онд АНУ болон Их Британийн нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүллээ.

Ам.долларын урт хугацаат хөрөнгө оруулалтын багцын удирдлагыг идэвхжүүлэх, нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжүүлэх, мөн ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын жишигт нийцүүлэхэд шаардлагатай бэлтгэлийг хангах, өгөөж – эрсдэлийн тооцооллыг кастодиан банкны тайлангаар баталгаажуулах, засаглал, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор Глобал кастодиан банканд данс нээх ажлыг зохион байгуулсан. Улмаар 2025 онд үйлчилгээний цар хүрээ, туршлага, төлбөр тооцооны дэд бүтэц, олон улсын санхүүгийн систем дэх ач холбогдлын түвшин зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн JP Morgan банкны үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцооны (Global custodian) үйлчилгээг авч Глобал кастодианы чиглэлээр хамтран ажиллаж байна.

2.5 ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголбанк нь Төв банкны тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль бусад журмын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын зах зээлээс үнэт металлыг Лондоны металлын биржийн үнээр худалдан авч, гадаадад цэвэршүүлдэг. 2025 онд 16.3 тонн үнэт металл худалдан авч, мөнгөжүүлэн гадаад валютын улсын нөөцийг 1 тэрбум 313 сая ам.доллаар нэмэгдүүлэв.

Тайлант онд Монголбанк нь үнэт металлын сорьцын шинжилгээний хувийн хэвшлийн шинэ лабораторитой гэрээ байгуулан хамтран ажиллаж эхэлсэн. Ингэснээр өмнө нь үнэт металлын сорьцыг зөвхөн улсын лабораториор тогтоолгодог байснаас үүдэлтэй, ачаалал буурч, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн. Мөн алт олборлогч аж ахуйн нэгж, иргэнд үзүүлэх үнэт металлын сорьц тогтоох үйлчилгээг шуурхай болгож, алт худалдан авалтын үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.

Монголбанк Дэлхийн алтны зөвлөлийн хуралд оролцож, Колумб, Эквадор, Филиппин улсын Төв банкнын хамтаар “Лондоны зарчмууд” багц зарчимд гарын үсэг зурав. Ингэснээр үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрээс Монгол Улсаас хариуцлагатай олборлолтын дор олборлосон алтыг олон улсын томоохон үнэт эдлэл хийдэг үйлдвэрүүдэд нийлүүлэх төслийн саналыг тавиад байна. 2025 онд Монголбанк, Швейцарын “Хариуцлагатай Алтны Холбоо” /Swiss Better Gold Association/ болон “Аргор” /Argor Heraeus SA/ алт цэвэршүүлэх үйлдвэртэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж төслийг эхлүүлэв. Тус төсөлд Монгол Улсын жижиг дунд алт олборлогч таван аж ахуйн нэгжийг хамруулаад байна.

Зураг 2.22 Монголбанкны худалдан авсан үнэт металл



Эх сурвалж: Монголбанк

2.6 МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх зорилгын хүрээнд “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага, хэрэгжилтийн өгөөжийг үнэлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А-139 дүгээр тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь хуулийн бүлэг, заалт бүрийн хэрэгжилтийн талаар хэлэлцэж, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай заалтуудыг тодорхойлж, үнэлгээ өгч байна.

Монголбанк нь үндэсний төлбөрийн ₮ картыг EMV технологийн чип стандарт руу шилжүүлэх ажлыг 2022 онд эхлүүлж, бодлогын төдийгүй үйл ажиллагааны түвшинд олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг ажлыг шат дараатай хийж гүйцэтгэлээ. Үүний үр дүнд зах зээл дэх нийт ₮ картыг чип технологи руу 2025 онд амжилттай шилжүүлж дууссан. Ингэснээр ₮ картын нууцлал, аюулгүй байдлыг олон улсын жишигт хүргэснээр биет карт дээрх картын дугаар, эзэмшигчийн овог, нэр зэрэг мэдээллийг хэвлэх шаардлагагүй болсон юм. Иймд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А-48 дугаар тушаалаар “Үндэсний төлбөрийн ₮ картын загвар, лого, холограм”-ийн загварыг шинэчлэн баталж, ₮ карт дээр хэвлэх мэдээллийн шаардлагыг хялбаршууллаа.

EMV технологийг нэвтрүүлсний давуу тал нь карт эзэмшигчийн мэдээллийг хамгаалах, картыг хуулбарлах, хулгайн болон залилангийн гүйлгээ хийх эрсдэлээс хамгаалахын зэрэгцээ зайнаас уншуулж, төлбөр тооцоогоо гүйцэтгэх боломжийг бий болгосон явдал юм. Нөгөө талаас карт эзэмшигчид өдөр тутмын нийтийн тээвэр, авто зогсоол, замын төлбөр зэрэг бага дүнтэй гүйлгээг энгийн, хялбараар гүйцэтгэх давуу талыг бий болгоод байна.

Монгол Улс нь ОХУ-аас импортоор авдаг нэн шаардлагатай стратегийн бараа, бүтээгдэхүүн буюу бензин, шатахуун, цахилгаан эрчим хүчний төлбөрийг 2024 оны 12 дугаар сараас эхлэн АНУ-ын Сангийн яамны дэргэдэх Гадаад хөрөнгийн хяналтын алба (OFAC)-аас олгосон лицензийн хүрээнд шатахуун эрчим хүчний төлбөрийг дамжуулж байгаа бөгөөд тус зөвшөөрлийн хүчинтэй хугацаа 2027 оны 01 дүгээр сар хүртэл сунгагдсан. ОХУ-аас 2025 онд нийт 201.6 сая ам.долларын 4.5 мянган ширхэг гүйлгээ хүлээн авсан бол 1.9 тэрбум ам.долларын 6.0 мянган ширхэг гүйлгээг тус улс руу шилжүүлээд байна. Илгээсэн гүйлгээг төрлөөр нь авч үзвэл нийт гүйлгээний дүнгийн 66.2% буюу 1.3 тэрбум ам.долларыг нефтийн бүтээгдэхүүн, 13.5% буюу 265.3 сая ам.долларыг түргэн эдэлгээтэй хэрэглээний бараа, 2.8%

буюу 54.9 сая ам.долларыг аж үйлдвэрийн бүтээгдэхүүний орц, 2.6% буюу 50 сая ам.долларыг хүнсний бараа бүтээгдэхүүн, түүхий эд, үлдсэн 14.9%-ийг бусад гүйлгээ тус тус эзэлж байна.

“Төв банк (Монголбанк)-ны тухай хууль”-д зааснаар Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А-242 дугаар тушаалыг баталж, бүх иргэд, аж ахуйн нэгжийн дансны хуучин дугаарлалтыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс ашиглахыг зогсоон олон улсын дансны нэгдсэн дугаарлалтад бүрэн шилжүүлэхээр төлбөрийн системийн нийт оролцогчидтой хамтран ажиллалаа. Монголбанкнаас дансны нэгдсэн дугаарлалт (IBAN)-ын зааврыг боловсруулж, Монгол Улсын бүх дансны дугаарыг улсын код, хяналтын орон, банкны болон дансны дугаар (харилцагчийн үндсэн дансны дугаарт өөрчлөлт орохгүй) гэсэн бүтэцтэй, нийт 20 орноор уртасгав. IBAN дансны дугаарлалтад шилжсэнээр олон улсын гүйлгээ өмнөхөөс хурдан, найдвартай дамжих, гүйлгээ буцаагдах эрсдэлээс сэргийлэхийн зэрэгцээ тухайн данс аль банкны данс вэ гэдгийг мэдэх боломжтой болов.

Төлбөрийн системийн бодлого, зохицуулалтын хүрээнд оролцогч хоорондын их дүнтэй гүйлгээний банксүлжээ системд мөрдөж ажилладаг “Их дүнтэй төлбөрийн системийн дүрэм”-ийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А-229 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 7400 дугаартайгаар бүртгүүлэв. Тус дүрмийг шинэчлэн баталснаар Банксүлжээ системээр дамжих гүйлгээний цахим мэдээний бүтцийг шинэчилсэн, мөн, оролцогчдоос ирүүлсэн холбогдох саналыг дүрэмд тусгасан.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А-247 дугаар тушаалаар “Автомат клиринг хаус системийн дүрэм”-д нэхэмжлэлийн гүйлгээг дамжуулах зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан нь төлбөрийн системийн зохицуулалтын орчныг сайжруулах чухал ажлын нэг болсон юм. Төлбөрийн систем, технологийн газрын Үндэсний цахим гүйлгээний төв нь нэхэмжлэлийн гүйлгээг шинээр нэвтрүүлэх хүрээнд банкуудтай программ хангамжийн туршилтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Монголбанкнаас “Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн ээлжит хурал”-ыг банк, төлбөрийн системийн оролцогч финтекүүд, төрийн байгууллага болон хууль зүйн фирмийн төлөөллийн 140 гаруй оролцогчийн бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 10 дугаар сард зохион байгууллаа. Төлбөрийн системд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэхийг дэмжих зорилгын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл”-д Стейблкойнийг төлбөрийн хэрэгсэл болгох боломжийг судлах ажлыг тусгасан. Иймд Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн хурлаар Монголбанк болон оролцогчдын зүгээс дэлхийн нийгээр санхүүгийн зах зээлд шинээр нэвтрүүлэхээр зорьж буй стэйблкойнийг манай улсад нэвтрүүлэх боломж, хууль, эрх зүйн уялдаа, олон улсын туршлагын талаар танилцуулж, дугуй ширээний өргөн хэлэлцүүлэг өрнүүлэв.

Монголбанкнаас 2024 онд “Apple pay” үйлчилгээг банкуудтай хамтран амжилттай хэрэгжүүлснээр дараа дараагийн шинэ, шинэлэг төлбөрийн үйлчилгээг нэвтрүүлэх суурь тавигдсан. Улмаар, 2025 оны 11 дүгээр сард “Google pay” үйлчилгээг нэвтрүүлэв. Энэ нь олон улсын стандартад нийцсэн технологийн дэвшилд суурилсан, энгийн, хялбар төлбөр тооцоог дотооддоо болон олон улсад гүйцэтгэх чухал алхам болсон. Түүнчлэн, манай улсад ирэх гадаад улсын иргэд, жуулчид “Apple pay”, “Google pay”-ээр төлбөр тооцоогоо түргэн шуурхай, найдвартай гүйцэтгэх нөхцөл бүрдэж, нэлээдгүй хөрөнгө оруулалтыг татах боломжтой болоод байна.

Монголбанк “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль”-ийн 10.1-т заасны дагуу 2025 онд нийт 18 зөвшөөрлийн хүсэлт хүлээн авсан. Зөвшөөрөл авахаар ирүүлсэн баримт бичгийг судал дараах байдлаар шийдвэрлэлээ.

Олгосон зөвшөөрөл:

- **Төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрөл:** 2 финтек компанийн хүсэлтийг хянан үзээд: 1 финтек компанид төлбөрийн карт хүлээн авах зөвшөөрлийг хугацаагүй сунгаж, 1 финтек компанийн төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрлийг хууль, журмын шаардлага хангаагүй тул олгохоос татгалзсан;
- **Төлбөрийн карт хүлээн авах зөвшөөрөл:** 2 финтек компанид төлбөрийн карт хүлээн авах зөвшөөрлийг шинээр олгож, 1 финтек компанид төлбөрийн карт хүлээн авах зөвшөөрлийг хууль, журмын шаардлага хангаагүй тул олгохоос татгалзсан;
- **Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл:** 2 финтек компанид аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл шинээр олгож, хуулийн хугацаанд 1 банкны зөвшөөрлийг судалж байна;
- **Төлбөр тооцооны төлөөлөгчийн эрх олгох зөвшөөрөл:** 2 банканд төлбөр тооцооны төлөөлөгчийн эрхийг шинээр олгож, 1 банканд зөвшөөрлийг хугацаагүй сунгасан;
- **Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх зөвшөөрөл:** 2 финтек компанид мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх зөвшөөрлийг шинээр олгосон;
- **Цахим мөнгө гаргах зөвшөөрөл:** 2 финтек компанид цахим мөнгө гаргах зөвшөөрөл шинээр олгож, 1 финтек компанид зөвшөөрлийг хугацаагүй сунгасан бол 1 финтек компанийн зөвшөөрлийг хууль, журмын шаардлага хангаагүй тул сунгахаас татгалзсан. Мөн хуулийн хугацаанд 1 финтек компанийн зөвшөөрлийг судалж байна.

Монголбанк нь оператор болон оролцогчийн эрх зүйн баримт, мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар цуглуулж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Газар дээр хийсэн шалгалтын үр дүнг системийн найдвартай, үр ашигтай байдлын үнэлгээнд ашигладаг. Төлбөрийн системийн оролцогчдыг хамруулсан газар дээрх шалгалтыг 2025 онд дараах байдлаар хийж гүйцэтгэсэн. Үүнд:


- Төв банкны хариуцсан төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт (Банксүлжээ систем, ҮЦГТ-ийн бага болон картын клирингийн систем);
- Бусад төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт (ХХБ-ны картын клирингийн систем);
- Төлбөрийн системийн оролцогчийн үйл ажиллагааны шалгалт (банкуудын иж бүрэн шалгалт);
- Цахим мөнгөний үйл ажиллагааны иж бүрэн шалгалт.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллалаа.

Зайнаас тавих хяналт нь төлбөрийн хэрэгсэл, цахим мөнгө, мөнгө шилжүүлэх үйлчилгээ, төлбөрийн шилжүүлэг, мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үйлчилгээний чиг хандлагыг тодорхойлох, хэвийн бус үзэгдэл, үйл ажиллагааг илрүүлэх, үйлчилгээний тасралтгүй байдал, ерөнхий чанарыг үнэлэхэд чиглэдэг.

Их дүнтэй, бага дүнтэй бодит цагийн болон багц гүйлгээний төлбөрийн системийн оролцогч хооронд 2025 онд хийгдсэн гүйлгээний нийт тоо, дүнг өмнөх онтой харьцуулбал гүйлгээний тоо 18.3 хувиар өсөж, гүйлгээний дүн 2.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Төлбөрийн системийн оролцогч хоорондын 2023-2025 оны байдлаар их, бага дүнтэй гүйлгээний тоон үзүүлэлтийг Хүснэгт 2.1, өсөлт бууралтыг Зураг 2.23-д үзүүлэв.

Зураг 2.23 Төлбөрийн системийн оролцогч хоорондын гүйлгээ 2023-2025 оны гүйлгээний тоо, дүн (сая ширхэг, их наяд төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 2.1 Банк хоорондын 2023-2025 оны гүйлгээний тоо, дүн (мянган ширхэг, их наяд төгрөг)

Он/Улирал	2023		2024		2025		2024/2025 өөрчлөлт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо %	Дүн %
I улирал	57,108.87	130.57	85,560.34	250.22	114,775.33	254.22	34.1%	1.6%
ACH	7,372.60	1.33	11,221.61	2.29	11,408.15	2.77	1.7%	21.0%
RTP	49,267.49	11.38	73,780.51	15.88	102,685.52	21.53	39.2%	35.6%
RTGS	468.78	117.86	558.22	232.05	681.66	229.92	22.1%	-0.9%
II улирал	70,282.32	172.16	106,789.52	272.38	124,693.58	256.06	16.8%	-6.0%
ACH	7,219.86	1.73	11,078.31	3.23	11,117.39	3.02	0.4%	-6.6%
RTP	62,429.00	14.05	94,941.33	20.56	112,725.79	23.50	18.7%	14.3%
RTGS	633.46	156.38	769.88	248.59	850.41	229.54	10.5%	-7.7%
III улирал	74,471.21	199.54	105,544.71	263.53	120,736.02	298.35	14.4%	13.2%
ACH	7,946.19	1.88	7,442.07	1.98	7,480.27	2.18	0.5%	9.9%
RTP	65,916.65	14.83	97,306.13	21.55	112,399.20	24.27	15.5%	12.6%
RTGS	608.36	182.83	796.51	240.00	856.55	271.90	7.5%	13.3%
IV улирал	82,478.60	239.21	119,755.50	289.03	133,960.62	244.47	11.9%	-15.4%
ACH	7,599.92	2.17	11,102.39	2.73	7,922.75	2.54	-28.6%	-6.7%
RTP	74,214.74	16.42	107,803.06	23.14	125,111.88	25.95	16.1%	12.1%
RTGS	663.95	220.61	850.05	263.16	925.99	215.98	8.9%	-17.9%
Нийт	284,341.00	741.48	417,650.07	1,075.17	494,165.56	1,053.10	18.3%	-2.1%
ACH	30,138.6	7.1	40,844.4	10.2	37,928.6	10.5	-7.1%	2.7%
Эзлэх хувь	10.6%	1.0%	9.8%	1.0%	7.7%	1.0%	-21.5%	4.9%
RTP	251,827.9	56.7	373,831.0	81.1	452,922.4	95.2	21.2%	17.4%
Эзлэх хувь	88.6%	7.6%	89.5%	7.5%	91.7%	9.0%	2.4%	19.9%
RTGS	2,374.5	677.7	2,974.7	983.8	3,314.6	947.3	11.4%	-3.7%
Эзлэх хувь	0.8%	91.4%	0.7%	91.5%	0.7%	90.0%	-5.8%	-1.7%

RTP – Бага дүнтэй төлбөрийн систем (бодит цагийн гүйлгээ)

ACH - Бага дүнтэй төлбөрийн систем (багцын гүйлгээ)

RTGS – Банкүлжээ буюу их дүнтэй төлбөрийн систем

Төлбөрийн карт гаргах зөвшөөрөл бүхий байгууллагууд Үндэсний ₮ карт болон олон улсын Виза, Мастеркарт, Юнионпэй, Американ экспресс, Жэй Си Би зэрэг брэндийн картуудыг гаргаж байна. Энэ оны IV улирлын байдлаар нийт төлбөрийн картын 48.3 хувийг Үндэсний төлбөрийн брэнд ₮ карт дангаар эзэлж байна.

Хүснэгт 2.2 Төлбөрийн картын болон төхөөрөмжийн тоо 2023-2025 он

№	Үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он	2025/2024 өөрчлөлт (%)
1	Картын хэрэглээ (мянган ширхэг)				
1.1	Картын тоо	4,286.2	4,578.2	5,815.0	27.0%
1.2	Идэвхитэй ашиглагдаж буй картын тоо	2,244.9	2,357.6	2,540.4	7.8%
2	Картын төрөл (мянган ширхэг)				
2.1	₮ карт	2,049.7	2,109.0	2,811.5	33.3%
2.2	Виза	1,056.9	1,282.5	1,615.6	26.0%
2.3	Мастеркарт	105.5	199.7	420.0	110.3%
2.4	ЮнионПэй	1,061.4	969.5	943.7	-2.7%
2.5	Амекс	12.5	17.5	24.3	39.0%
2.6	ЖейСиБи	0.1	0.0	0.0	-94.4%
3	Төхөөрөмжийн төрөл [1]				
3.1	CDM	15	8	1	-87.5%
3.2	CRM	1,958	2,055	2,030	-1.2%
3.3	АТМ	719	603	461	-23.5%
3.4	КИОСК (пос-той)	1,274	1,285	1,462	13.8%
3.5	МПОС	185	238	125	-47.5%
3.6	ПОБ	3,141	3,118	2,998	-3.8%
3.7	ПОС	121,955	169,448	186,503	10.1%
3.8	Цахим худалдаа	9,831	11,075	3,926	-64.6%
3.9	Бусад	-	-	-	0.0%

Хүснэгт 2.2-оос үзэхэд тайлант онд төлбөрийн картын тоог 2024 онтой харьцуулахад 27.0 хувиар, идэвхтэй ашиглагдаж буй картын тоо 7.8 хувиар тус тус өссөн байна. Төхөөрөмжийн хувьд ПОС төхөөрөмжийн тоо өмнөх оноос 10.1 хувиар өссөн бол CDM, АТМ, МПОС төхөөрөмжүүд буурсан байна.

Хүснэгт 2.3 Төлбөрийн картын гүйлгээний тайлан төхөөрөмжийн төрлөөр 2023-2025 он (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№	Төхөөрөмж		2023 он	2024 он	2025 он	2025/2024 өөрчлөлт /%/
1	ПОС	Тоо	640,835.9	677,905.3	690,571.3	1.9%
		Дүн	18,007.9	19,611.1	20,494.0	4.5%
2	МПОС	Тоо	9.7	17.6	10.9	-37.9%
		Дүн	0.3	0.5	0.4	-14.4%
3	ПОБ	Тоо	1,345.4	532.7	336.7	-36.8%
		Дүн	229.0	171.3	98.4	-42.6%
4	АТМ/CRM/CDM	Тоо	810,023.8	829,213.2	823,014.4	-0.7%
		Дүн	93,310.7	90,857.8	82,191.9	-9.5%
5	Цахим худалдаа	Тоо	9,699.1	15,610.7	19,661.0	25.9%
		Дүн	465.3	635.7	975.6	53.5%
6	КИОСК (пос-той)	Тоо	4,880.0	5,180.4	4,751.3	-8.3%
		Дүн	12,976.2	19,002.9	22,758.5	19.8%
	Нийт	Тоо	1,466,793.9	1,528,459.7	1,538,345.6	0.6%
		Дүн	124,989.4	130,279.3	126,518.8	-2.9%

Гүйлгээний үзүүлэлтийн хувьд тайлант онд ПОС төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо хамгийн өндөр буюу 690.5 сая ширхэг байна. Харин гүйлгээний дүнгийн хувьд АТМ, CRM, CDM төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээний дүн хамгийн их буюу 82.1 их наяд төгрөгийн үзүүлэлттэй байгааг Хүснэгт 2.3-т зааснаар харж болно.

2.7 МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголбанк Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрхийн хүрээнд мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах, гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн зохистой бүтцийг хангах, мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, түүний нөөцийг бий болгох, хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлох, гэмтэж муудсаныг солих, устгах үйл ажиллагааг эрхлэн зохион байгуулдаг.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өөрчлөлт


Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ 2025 оны эцсийн байдлаар мөнгөн дүнгээр 1.24 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 хувь буюу 22.2 тэрбум төгрөгөөр өссөн бол тоо ширхэгийн хувьд өмнөх оноос 3.1 хувь буюу 18.2 сая ширхгээр нэмэгдэж, 608.5 сая ширхэгт хүрсэн байна.

Хүснэгт 2.4 Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө


№	Мөнгөн дэвсгэрт	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)		Тоо ширхэг (сая ширхгээр)	
		2024	2025	2024	2025
1	1 төгрөг	34.8	35.7	34.8	35.7
2	5 төгрөг	157.3	161.2	31.5	32.2
3	10 төгрөг	1,212.0	1,255.7	121.2	125.6
4	20 төгрөг	1,988.5	2,057.6	99.4	102.9
5	50 төгрөг	4,480.8	4,701.0	89.7	94.0
6	100 төгрөг	8,495.8	8,830.6	85.0	88.3
7	200 төгрөг	38.8	42.5	0.2	0.2
8	500 төгрөг	10,317.5	11,056.3	20.7	22.1
9	1000 төгрөг	26,754.7	25,806.1	26.8	25.8
10	5000 төгрөг	75,488.6	74,470.3	15.1	14.9
11	10000 төгрөг	231,151.2	218,754.1	23.1	21.9
12	20000 төгрөг	862,058.7	897,178.7	43.1	44.9
	Нийт	1,222,178.7	1,244,350.0	590.6	608.5

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний бүтцийг мөнгөн дүнгээр нь авч үзвэл нэрлэсэн дүн өндөртэй мөнгөн дэвсгэрт дийлэнх хэсгийг бүрдүүлдэг. Тодруулбал, 2025 онд 5,000, 10,000 болон 20,000 төгрөгийн дэвсгэрт мөнгөн дүнгийн 95.7 хувийг, үүнээс 72.1 хувийг 20,000 төгрөгийн дэвсгэрт дангаараа бүрдүүлж байна.

Зураг 2.24 Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний дэвсгэртийн бүтэц, мөнгөн дүнгээр



Зураг 2.25 Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний дэвсгэртийн бүтэц, тоо ширхгээр




Эх сурвалж: Монголбанк

Харин бэлэн мөнгөний бүтцийг тоо ширхгээр авч үзвэл дийлэнх буюу 78.7 хувийг 1 төгрөгөөс 100 төгрөгийн мөнгөн дэвсгэрт эзэлж, үлдсэн 21.3 хувийг 500 төгрөгөөс 20,000 төгрөгийн мөнгөн дэвсгэрт бүрдүүлж байна. Тоо ширхэгийн олонх буюу 20.6 хувийг 10 төгрөгийн дэвсгэрт, 16.9 хувийг 20 төгрөг, 15.5 хувийг 50 төгрөг, 14.5 хувийг 100 төгрөг тус тус эзэлж нийлбэр дүнгээр эдгээр дөрвөн дэвсгэрт 67.5 хувийг бүрдүүлж байна.


Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний тоо, дүнгийн өөрчлөлт 2019 он хүртэл тодорхой хэлбэлзэл хөдөлгөөнтэй харагдаж байсан бол 2020 оноос харьцангуй тогтворжиж, үнийн дүн 2020-2025 онд дунджаар 5.7 хувиар, тоо ширхэг 4.3 хувиар тус тус өссөн байна.

Зураг 2.26 Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний дэвсгэртийн бүтэц, тэрбум төгрөг, нийт үнийн дүнгийн өсөлт/бууралт




Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.27 Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний дэвсгэргийн бүтэц, сая ширхэг, нийт тоо ширхэгийн өсөлт/бууралт



Сүүлийн 10 жилийн хугацаанд (2015-2025 онд) гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний дүн дунджаар 4.3 хувь, тоо ширхэг дунджаар 5.8 хувийн өсөлттэй байв.

Орчин цагийн үндэсний мөнгөн тэмдэгтийг “ТӨГРӨГ” нэртэйгээр гүйлгээнд гаргасны 100-н жилийн ой энэ онд тохиолоо



Ардын Засгийн газар 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Монголын Худалдаа бааж үйлдвэрийн банкныг байгуулж, улмаар эдийн засгийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэн, 1925 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн түүхэн тогтоолоор Худалдаа бааж үйлдвэрийн банканд үндэсний мөнгөн тэмдэгтийг “ТӨГРӨГ” нэртэйгээр гүйлгээнд гаргах онц эрхийг олгож байжээ.

Монгол Улсад орчин цагийн үндэсний мөнгөн тэмдэгт ТӨГРӨГ-ийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ой 2025 оны 12 дугаарын 09 нд тохиолоо. Энэхүү түүхэн өдөрт зориулж, “ДУРСГАЛЫН 100,000 ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТ”, мөн “Монгол Шуудан” ХК-тай хамтран “ТӨГРӨГ-100 ЖИЛ” марк хийж, Монголбанкны цахим хуудас (www.mongolbank.mn/tog100)-аар дамжуулан мөнгө цуглуулагчид болон сонирхогчдод зориулан худалдаанд гаргаад байна.

Шинэ дурсгалын мөнгөн дэвсгэртийн загварын зохиомж, хамгаалалтын элемент:



Дурсгалын 100,000 төгрөгийн дэвсгэртийн нүүрэн талыг Их Монгол Улсыг байгуулсан эзэн Чингис хааны бэлгэдэлд зориулсан бол ар талыг Ардын хувьсгалын бэлгэдэлд зориулж, түүнийг удирдсан удирдагчид болон өнөөгийн Монгол орны газрын зургийг зохиомжлон оруулсан.

Түүнчлэн дэвсгэртийн хоёр талд морьт баатар болон морины эскиз зургийг дүрсэлсэн бөгөөд үүгээр Их Монгол Улс болон тусгаар тогтносон орчин үеийн Монгол Улс байгуулагдсан хоёр түүхэн үйл явдалд монголчууд морийг эрхэмлэн дээдэлж ирсэн соёл, уламжлал, түүхэн утга бэлгэдлийг илэрхийлэхийг зорьжээ. Уг зохиомжийг орчин үеийн зураг дүрслэлтэй хослуулан бүтээсэн байна.

Монголбанк мөнгөн дэвсгэртийг хуурамчаар үйлдэхээс сэргийлж, шинээр хэвлэж буй мөнгөн тэмдэгтийн хамгаалалтын таних тэмдгийг тогтмол сайжруулж ирсэн. Түүнчлэн шинээр гаргаж байгаа дурсгалын дэвсгэртэд орчин үеийн дэвшилтэд технологид суурилсан хамгаалалтын элементүүдийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллаж байна. Монголбанк мөнгөн тэмдэгтийг тоолж, ялгах үйл ажиллагааг сайжруулан шинэчлэх ажлын хүрээнд дэлхийн улс орнуудын төв банкнуудын бэлэн мөнгөний төвийн үйл ажиллагаандаа ашиглаж буй сүүлийн үеийн дэвшилтэд технологи бүхий автомат системийн талаарх судалгаа хийв., Үүний үр дүнд 20 жилийн дараа мөнгөн тэмдэгт тоолж, ялгах орчин үеийн үр ашигтай, өндөр бүтээмжтэй хагас болон бүрэн үйлдэлт тоологч машин мөн бүрэн автомат устгалын машиныг үйл ажиллагаандаа цогцоор нь нэвтрүүлээд байна.

Ингэснээр бодитоор хүний гар ажиллагааг бодитоор бууруулж, мөнгөн тэмдэгтийн ялгалт, устгалын үйл ажиллагааг хялбаршуулан сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн.

2.8 ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ

Засгийн газрын санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөнгөний бодлогын арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор 2012-2017 оны хооронд Засгийн газар Монголбанкаар дамжуулан Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ыг анхдагч зах зээлд гарган арилжаалсан бөгөөд тус үнэт цаас нь 2024 онд бүрэн төлөгдөж дууссан. ЗГҮЦ нь санхүүгийн зах зээл дэх эрсдэл хамгийн багатай, найдвартай хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд хүүгийн орлого нь албан татвараас чөлөөлөгддөг онцлогтой. Цаашлаад ЗГҮЦ-ны тогтмол арилжаа нь эрсдэлгүй хүүгийн түвшинг тогтоох, өгөөжийн муруйг бүрдүүлэх, мөнгөний бодлогын дам нөлөөг тодорхойлох, хоёрдогч зах зээлийн идэвхийг нэмэгдүүлэх зэргээр санхүүгийн зах зээлийн хөгжилд сайн нөлөө үзүүлдэг.

Улмаар Монгол Улсын Засгийн газар 2025 оноос эхлэн ЗГҮЦ олон нийтэд нээлттэй хэлбэрээр дахин гаргаж, арилжаалж эхлээд байна. Засгийн газрын дотоодын үнэт цаасны арилжааны хүрээнд тайлант онд нийт 389.6 тэрбум төгрөгийн үнэт цаас авах санал ирснээс хуваарийн дагуу нийт 32 удаагийн арилжаагаар 150.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалаад байна (Зураг 2.28).

Зураг 2.28 ЗГҮЦ-ын үлдэгдэл, хугацаагаар тэрбум.₮



2.9 ТӨВ БАНКНЫ СУДАЛГАА, СТАТИСТИК

Монголбанк бодлогын шийдвэрт дэмжлэг болохуйц эдийн засаг, санхүүгийн салбарын судалгааны ажлуудыг тогтмол гүйцэтгэдэг бөгөөд дараах үндсэн чиг үүргийг баримтлан ажилладаг. Үүнд:

- Монголбанкны бодлого боловсруулах, мөнгөний бодлогын оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор бодлогын суурь судалгаа болон эмпирик судалгааг хөгжүүлэх;
- Макро, микро эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүүгийн салбарын эмпирик судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх, судалгааны үр дүнд үндэслэсэн бодлогын зөвлөмжүүд боловсруулах, үр дүнг удирдлагад тайлагнах, олон нийтэд мэдээлэх;
- Эдийн засгийн төлөв, хүлээлтийн түүвэр судалгаануудыг гүйцэтгэх, үр дүнг удирдлагад тайлагнах, олон нийтэд мэдээлэх;
- Судалгааны ажлуудыг хэвлэн нийтлүүлэх, илтгэл хэлбэрээр хурал, зөвлөгөөнд танилцуулах, зөвлөмж байдлаар холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
- Судалгааны чиглэлээр гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

Монголбанкнаас тайлант онд “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн хүрээнд болон төв банкны үйл ажиллагааг дэмжих чиглэлд дараах сэдвээр эмпирик болон түүвэр судалгааны ажлуудыг боловсруулж, дотоодын болон олон улсын сэтгүүлүүдэд нийтлүүлээ.

Олон улсын сэтгүүлд:

- “The macroeconomic effects of exchange rate movements in a commodity-exporting developing economy”. *International Economics* 177(2024) 100475;
- “Public debt and growth in Asian developing economies: Evidence of non-linearity and geographical heterogeneity”. *Eurasian Economic Review Volume 24*(2024) 421-452;

“Money-Output Revisited: Time-Varying Granger Causality Evidence from Forty-Three Countries”. *Open Economics Review* (2024) зэрэг Мөн Швейцарын холбооны улсын эдийн засгийн газраас хэрэгжүүлдэг Төв банкнуудын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр (БСС)-ийн хүрээнд “Distress prediction and stress testing of non-financial firms: Case of Mongolia”, “Market distance and household income: Quasi-experimental evidence from Mongolia” судалгааны ажлуудыг гүйцэтгэлээ.

Эдгээрээс гадна инфляц, төсвийн бодлого, банкны салбарын шинэчлэл зэрэг сэдвийн хүрээнд макро эдийн засаг, макро бодлого, санхүүгийн салбарын 6 судалгааны ажил, уур амьсгалын өөрчлөлт, нээлттэй банкны талаарх 3 бодлогын судалгаа, их өгөгдөл ашигласан 2 судалгааны ажлыг гүйцэтгэн дотооддоо хэвлүүлэв. Түүнчлэн “Банкны зээлийн төлөвийн судалгаа”, “Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөлөл”, “Худалдан авалтын менежерийн индекс (PMI)”, “Иргэдийн инфляцын хүлээлтийн

түүвэр судалгаа”, “Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа” болон “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын түүвэр судалгаа” зэрэг түүвэр судалгааг боловсруулж, олон нийтэд хүргэлээ.

2.10 ТӨВ БАНКНЫ ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

Төв банкны бодлогын ил тод байдал нь мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн оролцогчдын хүлээлтийг удирдах, төв банканд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлснээр хараат бус байдлыг бэхжүүлэх зэрэг ач холбогдолтой. Иймд төв банк өөрийн үйл ажиллагаа, эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын шийдвэрийн үндэслэл, зорилгыг олон нийтэд нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлж байна.

Тайлант онд олон нийттэй харилцах хүрээнд мэдээллийн ил тод, мэргэжлийн үг хэллэгээр бус энгийн ойлгомжтой байдлаар сайжруулах, мэдээлэл түгээх сувгийн хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллав.

Дээрх хүрээнд хэвлэлийн хурал, ярилцлага, цаг үеийн мэдээ, мэдээллийг цахим хуудаст шуурхай байршуулах, Монголбанкны албан ёсны нийгмийн сүлжээний сувгуудаар түгээх, ингэхдээ мэдээллийг тухайн талбарын онцлогт нийцтэй (богино геел, инфографик, фото болон постер мэдээлэл) хэлбэрээр түгээж ажиллалаа.

Монголбанкнаас мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх сувгууд нь:

1. Хэвлэлийн хурал,
2. Цаг үеийн мэдээ, мэдээлэл,
3. Тайлан, статистик мэдээ,
4. Ярилцлага,
5. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа,
6. Чөлөөт уулзалт, хэлэлцүүлэг,
7. Олон нийтийн цахим сүлжээний сувгууд,
8. Хэвлэл, мэдээллийн байгууллагууд зэрэг болно.

Дээрх сувгаар хүргэсэн мэдээ, мэдээллийн тухай танилцуулбал,

1. Монголбанкны хэвлэлийн хурал

2025 онд нийт 9 удаагийн хэвлэлийн хурлыг зохион байгуулав. Үүнд мөнгөний бодлогын хорооны ээлжит болон ээлжит бус хурлын шийдвэр танилцуулах хэвлэлийн хурал 5 удаа, цаг үеийн асуудлаарх хэвлэлийн хурал 4 удаа зохион байгуулж, дээрх хэвлэлийн хуралд давхардсан тоогоор 30 гаруй хэвлэл, мэдээллийн байгууллагад оролцож, мэдээллийг цаг тухайд нь олон нийтэд хүргэв.

2. Цаг үеийн мэдээлэл

Тайланд онд Монголбанкны цахим хуудаст 160 мэдээ, мэдээлэл байршуулав. Үүнд цаг үеийн шинжтэй хурал, хэлэлцүүлгийн мэдээнээс гадна сар тутам дахь алт худалдан авалт, гадаад валютын албан нөөц, инфляцын үзүүлэлт, өдөр тутмын валютын ханш болон алт худалдан авахханшийн мэдээлэл зэрэг багтаж байна. Мөн статистик мэдээлэл, Монголбанкны судалгаа зэргийг хуваарийн дагуу цахим хуудаст байршуулж, олон нийтэд нээлттэй хүргэж ажиллав.

3. Тайлан, мэдээлэл, статистикийг цахим хуудаст байршуулах

Монголбанк инфляцын хүлээлтийг удирдах зорилгоор улирал бүр олон нийтэд тайлагнадаг. Инфляцын тайлангийн агуулгыг өргөжүүлэн II улирлаас эхлэн “Мөнгөний бодлогын тайлан” хэлбэрээр гаргаж,

Монголбанкны цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд түгээв.

Тайлант хугацаанд “Мөнгөний бодлогын тайлан”-гийн 6, 9, 12 дугаар сарын дугаарыг цахим хуудаснаа нийтэлж, олон нийтийн сүлжээний цахим сувгуудаар түгээв. Ингэхдээ тайланг татаж авах линкийг хуваалцах, мөн тайлан дахь голлох агуулгуудаар цуврал рийл (богино хэмжээний видео контент) бэлтгэж, цахим сувгуудаар түгээсэн байна.

Тогтмол хэвлэгддэг тайлангуудаас гадна цаг үеийн шинжтэй макро эдийн засгийн судалгаа, статистик тоон мэдээллүүдийг Монголбанкны цахим хуудаст хуваарийн дагуу нийтэлж, олон нийтэд хүргэлээ.

4. Ярилцлага

Цаг үеийн асуудлаар Монголбанкны газар, нэгжийн удирдлагуудаас хэвлэл, мэдээлэлд нийт 34 удаа ярилцлага, тодруулга өгч, Төв банкны бодлого, үйл ажиллагааг олон нийтэд тайлбарлан таниулж, мэдээлэл хүргэж ажиллалаа. Үүнд, гадаад валютын албан нөөц, эдийн засгийн төлөв байдал, ипотекийн санхүүжилт, эдийн засгийн гадаад нөхцөл байдал, түүний нөлөөлөл, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах Үндсэн чиглэлийн төсөл, Төгрөгийн 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх зэрэг сэдвийг хамруулав.

5. Ивент, үйл ажиллагаа

Монголбанкнаас жил бүр олон нийтийг хамарсан томоохон хурал, хэлэлцүүлэг, үйл ажиллагаа зохион байгуулах, түүгээр дамжуулан илтгэл, танилцуулгыг олон нийтэд хүргэж ажилладаг. Энэ нь тодорхой эдийн засгийн асуудлаар Төв банкны тайлан, мэдээлэл, судалгааны үр дүнг олон нийтэд хүргэх, улмаар Төв банк эдийн засгийн цаашдын төсөөлөл, бодлого шийдвэрийг тайлбарлах, хүртээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. 2025 онд Монголбанк олон нийтийг хамарсан томоохон гурван үйл ажиллагааг хэрэгжүүлж, ажиллав.

- *Үндэсний мөнгөн тэмдэгт – Төгрөгийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ой*
- *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн хэлэлцүүлэг*
- *Олон улсын өндөр түвшний хурал, хэлэлцүүлэг*

6. Чөлөөт уулзалт, хэлэлцүүлэг

Монголбанкны бодлого, үйл ажиллагааны талаарх ойлголтыг сэтгүүлч, хэвлэл, мэдээллийн байгууллагуудад хүргэх, тайлбарлах зорилгоор сэтгүүлч, редакцуудтай чөлөөт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулдаг ба тайлант улиралд цаг үеийн асуудлаар чөлөөт уулзалт (2025.08.23) зохион байгууллаа. Тус сэтгүүлчдийн сургалтыг “Мөнгөний бодлогын тайлан” сэдвийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд тайланг хэрхэн боловсруулдаг, ямар мэдээллийг агуулдаг, өмнө нь гаргаж байсан Инфляцын тайлангаас ямар ялгаатай, хэвлэл, мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид хэрхэн ашиглах зэрэг сэдвээр өргөн хүрээний мэдээллийг өглөө.

Сургалтад Монголбанкны Ерөнхийлөгч болон холбогдох газрын захирлууд оролцож, сэтгүүлчдийн асуултад нээлттэй хариулав. Чөлөөт уулзалтад 30 гаруй хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцов.

7. Олон нийтийн цахим сүлжээний сувгууд

Монголбанкны албан ёсны цахим сүлжээ болох Facebook, Twitter, Instagram, Youtube сувгуудыг тогтмол хөгжүүлсэн бөгөөд . нийт 197 мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээний сувгуудаар дамжуулан хүргэв (Хүснэгт 2.5).

Хүснэгт 2.5 Олон нийтийн цахим сүлжээний сувгуудаар мэдээлэл хүргэсэн байдал /2025 он/

Мэдээлэл түгээх хэлбэр	Мэдээллийн линк, фото	Facebook, Twitter, Instagram, Youtube		
		Инфографик, постер	Богино хэмжээний видео контент, рийл	Шууд дамжуулалт
Давтамж	88	72	33	4

8. Өдөр тутмын сонин, цахим сайтуудтай хамтран ажиллах, мэдээллийг түгээх

Монголбанкны Хэвлэл мэдээллийн алба нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 6.34.1 дүгээр зүйлд заасны дагуу мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгслүүдэд гарсан өөрчлөлтийг тухай бүр, мөн мөнгө, зээл, санхүүгийн зах зээлийн байдлын талаарх мэдээллийг улирал тутам олон нийтэд мэдээлдэг. Түүнчлэн мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа, арга хэрэгслүүдийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, цаг үеийн мэдээ, мэдээлэл, иргэдийг зөв, бодитой мэдээллээр хангахад чиглэсэн ярилцлага, нийтлэл, мэдээ мэдээллийг олон нийтэд тогтмол түгээн ажилласан болно. Үүнтэй холбогдуулан Монголбанкнаас түгээж буй мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж, оны эхний хагаст 38, а, сүүлийн хагас жилд 35 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг дүгнэн ажилласан байна.

Ингэснээр 2025 онд Монголбанкны бодлого, үйл ажиллагаатай холбоотой нийт 29 мэдээ, мэдээлэл, ярилцлагыг өдөр тутмын сонин болон цахим сайтуудад нийтлүүлж, мэдээ, мэдээллийн хүртээмжийг дээшлүүлж ажиллав. Үүнд:

- Жилийн эцэст уламжлал болгон гаргадаг “Төв банкны онцлох 20 ажил”
- Төгрөгийн ханшийн хэлбэлзлийн шалтгааны талаарх тайлбар
- Монголбанкны Хяналтын зөвлөлийн хурлын мэдээ
- Монголбанкны Ерөнхийлөгчийн ярилцлага
- Монгол Улсын банкны салбарын өрсөлдөх чадварын судалгааны тайлангийн хураангуй
- Мөнгөний бодлогын хэрэгжилт, түүний үр дүнтэй байдлын талаарх холбогдох газрын захирлын ярилцлага,
- “Дэлхийн хуримтлалын өдөр” нэгдсэн арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллүүд зэрэг болно.

2.11 ГАДААД ХАРИЛЦАА

Монголбанкны гадаад харилцааны бодлого нь орчин үеийн Төв банкны хөгжлийн чиг хандлагад нийцсэн, судалгаа болон эрсдэлд суурилсан бодлогыг нутагшуулах, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, банк, финтекийн хөгжилтэй уялдуулан урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхэд чиглэж байна.

Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагаа**АЗИ:**

Монголбанкны Ерөнхийлөгч Япон Улсын Токио хотноо зохион байгуулагдсан ОУВС, ЛСА-ийн хамтарсан бүс нутгийн хуралд урилгаар оролцож, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогын талаар илтгэл тавив. Тус хурлын үеэр гамшгийн эрсдэлийн санхүүжилт, төсвийн бодлогын хамтын ажиллагааны талаар бүс нутгийн орнуудын туршлага судлах боломж бүрдэв.

Мөн ОУВС, JICA, Японы Төв банк, БНСУ-ын хөрөнгө удирдлагын байгууллагын удирдлагуудтай албан уулзалт хийж, санхүүгийн тогтвортой байдлын чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцов.

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч БНХАУ-ын Шэньжэнь хотноо болсон Tsinghua PBCSF Дэлхийн санхүүгийн форумд урилгаар оролцож, хөгжиж буй зах зээлийн өрийн хямрал болон Монгол Улсын өрийн удирдлагын шинэчлэлийн талаар илтгэл тавив. Форумын үеэр олон улсын мөнгөн тэмдэгтийн тогтолцоо, дэлхийн худалдаа, санхүүгийн засаглалын асуудлаар хэлэлцэж, Монгол Улсын гадаад өрийн бүтэц, ил тод байдлыг бэхжүүлсэн туршлагыг танилцууллаа. Мөн тус арга хэмжээний хүрээнд төв банкууд, олон улсын байгууллагын төлөөлөлтэй уулзаж, санхүүгийн зохицуулалт, өрийн удирдлага болон бодлогын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцов.

Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Азийн Санхүүгийн 18 дугаар форум (AFF)-д оролцов. Тус форум 2025 оны 1 дүгээр сарын 13-14-нд Хонконг хотноо “Дараагийн өсөлтийн хөдөлгүүрийг идэвхжүүлэх нь” сэдвийн дор болж, бодлогын хэлэлцүүлгийг Хонконгийн Төв банкны Ерөнхийлөгч Eddie Yue удирдав. Хэлэлцүүлгээр инфляц, мөнгөний бодлогын өөрчлөлт болон дэлхийн эдийн засгийн тодорхойгүй нөхцөл дэх өсөлтийн чиг хандлагын талаар хэлэлцэв.

Манай улсаас тус форумд Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв, 2024 оны УИХ-ын сонгуулийн дараах бодлогын чиглэл болон мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар байр сууриа илэрхийлж, олон улсын бодлого боловсруулагчидтай санал солилцлоо. Энэхүү оролцоо нь Монголбанкны гадаад харилцаа, бодлогын түвшний хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ач холбогдолтой болов.

Монгол Улс болон БНСУ дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойд зориулсан хамтын ажиллагааны олон улсын бага хурал 2025 оны 4 дүгээр сарын 15-нд өрнөж, Монголбанкны Ерөнхийлөгч хүндэт зочноор оролцож, хоёр улсын эдийн засгийн тасралтгүй өргөжсөн түншлэлийн тухай энэ үеэр болсон яриандаа дурдсан юм. Хурлын үеэр худалдаа, эдийн засгийн өнөөгийн нөхцөл, түүнийг хөгжүүлэх боломжийн талаар г хэлэлцэж, санхүүгийн салбарын хамтын ажиллагааг бататгах чиглэлүүдийг тодорхойлов. Монголбанк ба БНСУ-ын Төв банкны хамтын ажиллагааны KPP хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд мэдлэг солилцоо, чадавх бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлэн дэмжиж буйг онцолж байв. .

Зүүн Өмнөд Азийн Төв банкнуудын сургалт, судалгааны төв (SEACEN)-ийн Хүний нөөцийн 7 дугаар бага хурал болон 45 дугаар Хүний нөөцийн захирлуудын уулзалтыг Монголбанк Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав. Төв банкнуудын хүний нөөцийн чадавхыг дэмжих, дижитал шилжилтийн эрин үед шаардлагатай ур чадварын шинэ хэрэгцээг тодорхойлох, ирээдүйн ажиллах хүчний бүтцэд төв банкнууд хэрхэн манлайллын үүрэг гүйцэтгэх талаар гишүүн орнууд өргөн хүрээнд хэлэлцэв.

Үндсэн хоёр хэлэлцүүлэг, дөрвөн салбар хуралдааны хүрээнд “Хүний нөөц 2030: Ажлын ирээдүйг төлөвшүүлэх стратеги — дижитал шилжилтийн үе дэх төв банкны ажиллах хүчний хөгжил” сэдвийн дор туршлага солилцож, хүний нөөцийн бодлогын шинэ чиглэлүүдийг нэгдсэн ойлголт, зөвлөмж болгон боловсруулав.

Монгол Улс SEACEN-ийн хүний нөөцийн бодлогын бүс нутгийн хэмжээний энэхүү хэлэлцүүлгийг эх орондоо зохион байгуулснаар төв банкнуудын олон улсын хамтын ажиллагаанд манлайллаа бэхжүүлээ.

“Нийлүүлэлтийн саатал болон худалдааны шоктой үе дэх дэлхийн эдийн засаг: Мөнгөний бодлогын үр нөлөө” сэдэвт олон улсын өндөр түвшний хурлыг Улаанбаатар хотноо 2025 оны 6 дугаар сард амжилттай зохион байгуулав. Тус хурал нь Дэлхийн нийтийн эдийн засагт нэгэн зэрэг тулгамдаж буй шок, тодорхойгүй байдал нэмэгдэж буй нөхцөлд бодлогын шинэ хандлага, хамтын шийдлийг эрэлхийлэх стратегийн ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Цар тахлын дараах сэргэлт, уур амьсгалын өөрчлөлт, амьжиргааны өртгийн өсөлт, геополитикийн хурцадмал байдал зэрэг олон талт сорилт нь улс орнуудын мөнгөний бодлого, төсвийн бодлого, бүтцийн реформын үр нөлөөг дахин үнэлэх, зохицуулалтыг шинэ

нөхцөлд нийцүүлэх шаардлагыг дэлхий нийтээр хурцаар тавьж байна.

Ийм нөхцөлд Монгол Улсад өндөр түвшний олон улсын бодлогын хэлэлцүүлгийг зохион байгуулсан нь Монголбанкны олон улс дахь нэр хүндийг бэхжүүлж, Монгол Улсыг бүс нутгийн эдийн засгийн бодлогын хэлэлцүүлгийн төв болгон таниулж, бодлогын шинэ санаачилга, судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг эрэлхийлсэн чухал үйл явдал боллоо.

Бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллагын төлөөллүүд Монголд цугларснаар дэлхийн эдийн засгийн бодлогод тулгарч буй шок, шинэ эрсдэлийн талаарх ойлголт гүнзгийрч, цаашдын бодлогын түншлэл, хамтын ажиллагааны суурь бэхжив.

Азийн хөгжлийн банкны Ерөнхийлөгч нарын зөвлөлийн 58 дахь удаагийн жилийн уулзалт 2026 оны 5 дугаар сард Милан хотноо зохион байгуулагдаж, Монголбанкны төлөөлөл оролцов.

Уулзалтад 5000 гаруй төлөөлөгч оролцож, Ази, Номхон далайн бүс нутгийн тогтвортой, тэсвэртэй хөгжлийг дэмжих дөрвөн тэргүүлэх чиглэлийг хэлэлцэв. Үүнд: хүнсний тогтолцооны шилжилтэд 2030 он хүртэл 40 тэрбум ам.долларын санхүүжилт олгох, дижитал технологи болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эрчим хүчний системийн шинэчлэл (ASEAN Power Grid-д дэмжлэг үзүүлэх 10 тэрбум ам.долларын бэлэн байдлыг хангах), мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, дэд бүтцийг бэхжүүлэх хөрөнгө оруулалтыг гүнзгийрүүлэх асуудлыг онцлов.

Түүнчлэн цахим дэд бүтэц, хиймэл оюун ухаан, ногоон санхүүжилт, үйлдвэрлэлийн сүлжээ, цахим худалдаа, хүний нөөцийн ур чадварын хөгжил зэрэг чиглэлээр өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнөв.

Уулзалтын үеэр Монголбанкны төлөөлөл АХБ-ны удирдлагуудтай хоёр талын уулзалт хийж, эрчим хүч болон дэд бүтцийн санхүүжилт, хувийн хэвшлийн оролцоо, Төр-хувийн хэвшлийн түншлэл (PPP)-ийн хэрэгжилт, боловсрол болон нийгмийн салбарын санхүүжилтийн талаар санал солилцов.

ЕВРОП:

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны 2025 оны жилийн уулзалтад Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал, Санхүүгийн зах зээлийн газрын захирал, Лондон дахь төлөөлөгч болон Удирдлага, төлөвлөлтийн газрын албан тушаалтнууд оролцов. Тус уулзалтаар ЕСБХБ-ны өсөлтийн шинэ үе шат, Сахарын өмнөд бүс, Ирак руу үйл ажиллагаагаа тэлэх болон Стратегийн капиталын цар хүрээг шинэчлэн батлах ажлуудын талаар хэлэлцлээ.

Олон Улсын Төлбөр Тооцооны Банкны 2025 оны 95 дахь удаагийн жилийн уулзалтад Монголбанкны Ерөнхийлөгч, Лондон дахь төлөөлөгч нар гишүүн төв банкнууд, бусад төв банкнуудын Ерөнхийлөгчид болон бусад зочдын хамт оролцож, хөгжиж буй эдийн засгийн дугуй ширээний уулзалт, зохицуулагч байгууллагуудын шийдэл зэрэг асуудлаар санал солилцож, мөн ОУТТБ-ны жилийн санхүүгийн тайланг дүгнэлээ.

Мөн ОУТТБ-ны дэргэдэх Санхүүгийн тогтвортой байдлын хүрээлэн (FSI) болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-аас Швейцарын Холбооны Улсын Базель хотноо зохион байгуулагдсан Санхүүгийн тогтвортой байдлын хүрээлэн ба Үнэт цаасны хорооны 20 жилийн ойн хуралд Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зах зээлийн газрын захирал, Санхүү, бүртгэлийн газрын захирал, Лондон дахь төлөөлөгч нар оролцож банк, үнэт цаасны зах зээлийн чиг хандлага, хөндөгдөж буй сорилт, хамтын зохицуулалтын ач холбогдлын талаар хэлэлцлээ.

Швейцарын Эдийн засгийн яамнаас санхүүжүүлдэг Төв банкуудад зориулсан хоёр талын тусламж, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн 2025 оны жилийн хуралд Монголбанкны Ерөнхийлөгч “Худалдаа ба санхүүгийн хуваагдал” сэдэвт панел хэлэлцүүлэгт илтгэгчээр оролцов.

Английн Төв банкнаас жил бүр зохион байгуулдаг Мөнгөний бодлогын хуралд Монголбанкны Ерөнхийлөгч, Лондон дахь төлөөлөгч нар оролцож, Британийн Алтны стандарт, төсөөллийн үнэлгээ, загварчлал, эдийн засгийн тодорхой бус байдлыг олон нийтэд мэдэгдэх, Мөнгөний бодлогын стратеги зэрэг чухал сэдвүүдээр илтгэл, хэлэлцүүлэгт санал солилцлоо.

АНУ:

ОУВС болон Дэлхийн Банкнаас жил бүр хамтран зохион байгуулдаг Хаврын уулзалт болон жилийн уулзалтад Монголбанкны Ерөнхийлөгч оролцлоо. Тус уулзалтуудын гол цөм нь Дэлхийн Банк, ОУВС-гийн Хөгжлийн Хороо, ОУВС-гийн Олон Улсын Валют Санхүүгийн Хорооны хуралдаанууд бөгөөд тус байгууллагуудын ажлын ахиц дэвшлийг хэлэлцдэг. Энэ удаагийн жилийн чуулга уулзалтад бусад улс орны төв банкуудын Ерөнхийлөгч, сангийн сайд, бизнесийн салбарын төлөөлөгчид, парламентын гишүүд, иргэний нийгмийн байгууллагууд оролцож, дэлхий дахины санхүү, эдийн засгийн нөхцөл байдлын талаар хэлэлцлээ.

ОХУ:

Дорнын эдийн засгийн чуулгын Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Владивосток хотноо 2025 оны 9 дүгээр сарын 03-06-нд зохион байгуулагдсан “Энх тайван ба хөгжил цэцэглэлтийн төлөөх хамтын ажиллагаа” сэдэвт уулзалтад Монгол Улсын Ерөнхий Сайд Г.Занданшатарын албан айлчлалын бүрэлдэхүүнд багтан Монголбанкийг төлөөлж, Дэд Ерөнхийлөгч оролцлоо. Чуулга уулзалтын үеэр Дэд Ерөнхийлөгч ОХУ-ын Төв банкны Дэд Ерөнхийлөгч А.С.Гузнов нар хоёр талт уулзалт хийсэн бөгөөд Ерөнхий Сайд Г.Занданшатарын албан айлчлалын бүрэлдэхүүний хамтаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинд бараалхав.

Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага (ШХАБ)-ын гишүүн болон ажиглагч орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлдөх хуралдаанд Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Москва хотноо 2025 оны 11 дүгээр сарын 17-19-нд Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарын албан айлчлалын бүрэлдэхүүний хамтаар Монголбанкны төлөөлөл оролцсон билээ. Тус хуралдаанаар ОХУ болон Монгол Улс хоорондох өргөжин тэлж буй гадаад худалдааны төлбөр тооцоог цаашид найдвартай, хэвийн үргэлжлүүлэх, нэн чухал стратегийн бараа бүтээгдэхүүн болох шатахуун, эрчим хүчний төлбөр тооцоог тасалдуулахгүй байхад төлбөрийн нөөц хувилбар, төлөвлөгөө гаргах талаар ОХУ-тай яриа хэлэлцээр хийхэд оршив.

Монголбанк, Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Төв банктай жил бүр дугуй ширээний уулзалтыг хоёр оронд ээлжлэн зохион байгуулж ирсэн уламжлалтай бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 17-нд Улаанбаатар хотноо 7 дахь удаагийн дугуй ширээний уулзалтыг амжилттай зохион байгууллаа. Уулзалтад хоёр талын Төв банкны удирдлагууд, холбогдох газар, нэгжийн төлөөлөл болон хоёр улсын арилжааны банкуудын төлөөлөл оролцов. Уулзалтын үеэр хил дамнасан төлбөр тооцоо, банк хоорондын хамтын ажиллагаа, корреспондент харилцаа, валютын своп хэлэлцээрийн боломж болон институцийн чадавхыг бэхжүүлэх асуудлуудыг хэлэлцэв.

Энэхүү уулзалт нь хоёр улсын санхүүгийн салбарын хамтын ажиллагааг өнөөгийн олон улсын нөхцөл байдалд нийцүүлэн үргэлжлүүлэх, эрчим хүч болон худалдааны төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх боломжит шийдлүүдийг эрэлхийлэх, төв банкуудын бодлогын түвшний харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа. Уулзалтын хүрээнд төлбөр тооцооны илүү найдвартай сувгуудыг судлах, корреспондент банкны харилцааг хөгжүүлэх, хамтарсан судалгаа болон боловсон хүчний солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр санал солилцсон нь стратегийн ач холбогдолтой үйл явдал болов.

Хамтын ажиллагаа

Хэлэлцүүлгийн хүрээнд валютын своп хэлэлцээрийн хэрэгжилт, юаниар хийсэн гадаад төлбөр тооцооны өсөлт, CIPS систем дэх оролцоо, хил дамнасан QR кодын төлбөр тооцооны ахиц зэрэг бодит үр дүнг тэмдэглэж, үндэсний валютаар хийх төлбөр тооцоог өргөжүүлэх нь валютын ханшийн эрсдэлийг бууруулж, хил дамнасан санхүүгийн урсгалыг тогтвортой дэмжих ач холбогдолтойг онцлов. Мөн цаашид техникийн түвшний хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, туршлага судлах чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэхээр талууд санал нэгдэв.

Хоёр талын хамтын ажиллагааг бататгах, бэхжүүлэх хүрээнд Монголбанк, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сантай хамтран ажиллах санамж бичиг /2025.08.25/ байгууллаа. Санамж бичгийн хүрээнд талууд Монгол Улсын санхүүгийн салбарыг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр чадавхжуулах, барилгын салбарын санхүүжилтийг дэмжих сангийн загварыг Монголд нутагшуулах чиглэлээр хамтран ажиллах юм. Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг нь Монгол Улсын санхүүгийн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлд дасан зохицох, тогтвортой хөгжлийн санхүүжилтийг өргөн хүрээнд нэвтрүүлэх стратегийн чухал алхам боллоо.

World's Best Bank Award Ceremony 2025

ОУВС, Дэлхийн банкны жилийн уулзалт 10 дугаар сарын 14-18-нд АНУ-ын Вашингтон хотноо болж, Монголбанкны Ерөнхийлөгч тэргүүтэй удирдлагууд оролцов. Энэ үеэр олон улсад нэр хүндтэй “Global Finance” сэтгүүлийн зүгээс 2025 оны “Central Banker Report Cards” тайлангаар шилдэгт багтсан Төв банкны тэргүүнүүдэд үнэлгээний батламжийг гардуулан өглөө. Монголбанкны Ерөнхийлөгч тус тайлангаар “А-” үнэлгээ авч, дэлхийн шилдэг төв банкны удирдлагуудын нэгээр шалгарсан бөгөөд энэ үеэр батламжаа мөн гардаж авав.

Монголбанкны Ерөнхийлөгч “А-” үнэлгээ авсан нь Монгол Улсын мөнгөний бодлого, инфляцын бууруулалт, банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ олон улсад эергээр үнэлэгдэж буйг бататгасан онцгой үйл явдал юм.

“Дэлхийн эдийн засаг: Мөнгөний бодлогын үр нөлөө” сэдэвт олон улсын өндөр түвшний хурал

Монголбанк, Бреттон Вүүдсийн дахин зохион бүтээх хороо (Reinventing Bretton Woods Committee) хамтран “Нийлүүлэлтийн саатал болон худалдааны шоктой үе дэх дэлхийн эдийн засаг: Мөнгөний бодлогын үр нөлөө” сэдэвт олон улсын хурлыг 2025 оны 6 дугаар сарын 19-21-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Дэлхийн хүндэт профессорууд, бодлого боловсруулагчид хурал цугларч мөнгөний бодлого, санхүүгийн салбарын зохицуулалт, санхүүгийн системийг ногооруулах, Төв банкны цахим мөнгөний талаар дэлгэрэнгүй хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хурлыг нээж, Монголбанкны Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ “Нийлүүлэлтийн гаралтай шокууд нь эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж, бодлого боловсруулагчдад сорилт болж байна. Энэ үед Төв банкнууд мөнгөний бодлогын үр дүнтэй байдлыг дээшлүүлэхийн тулд уламжлалт үүрэг оролцоогоо эргэн харах, тоон болон чанарын мэдээллийг сайжруулах, тооцоолол, дүн шинжилгээний арга техникийг боловсронгуй болгох, мөнгө-сангийн бодлогын уялдааг бэхжүүлж ажиллах шаардлагатай байна. Мөн Олон улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх нь бүс нутгийн болон дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чухал юм” хэмээн онцоллоо.

Дэлхийн эдийн засагт цар тахал, уур амьсгалын өөрчлөлт, амьжиргааны өртгийн өсөлт, геополитикийн хурцадмал байдал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалсан хүндрэлүүд сүүлийн жилүүдэд зэрэгцэн тохиож, шинэ сорилтууд тулгарсаар байна. Энэ нөхцөл байдал нь мөнгөний болон төсвийн бодлогын чиг баримжаа, харилцан уялдааг дахин эргэж харах, тогтвортой байдлыг хангах шинэ гарц, шийдлийг эрэлхийлэх шаардлагыг үүсгэж байгаа билээ. Дэлхий нийтэд тулгараад буй энэхүү нийтлэг сорилтуудын талаар өндөр түвшний хэлэлцүүлгийг өрнүүлэх гол талбар болохын хувьд энэ удаагийн хурлаар дараах

сэдвийг онцоллоо. Үүнд, дэлхий нийтийг хамарсан шокийн үе дэх эдийн засгийн нөхцөл байдал, нийлүүлэлтийн шокод үзүүлэх мөнгөний бодлогын арга хэмжээ, Төв банкны оролцоонд гарч буй өөрчлөлтүүд, нийлүүлэлтийн шокод үзүүлэх төсвийн бодлогын арга хэмжээ, хиймэл оюун ухаан, дижиталчлал болон ногоон шилжилтийн макро эдийн засаг дахь үр дагавар, дэлхийн эдийн засгийн хуваагдлын үед хэрэгжүүлэх эдийн засаг, санхүүгийн зохицуулалтын бодлого, арга замууд сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлээ.

Монголбанк, Бреттон Вүүдсийн дахин зохион бүтээх хорооны хамтран зохион байгуулж буй олон улсын өндөр түвшний энэхүү хэлэлцүүлэгт 15 орны 20 гаруй зочин төлөөлөгчид оролцож байна. Тодруулбал, ОУВС-ийн Төсвийн бодлого хариуцсан зөвлөх Митали Дас, Бреттон Вүүдсийн дахин зохион бүтээх хорооны гүйцэтгэх захирал Марк Узан, Солонгосын Хөгжлийн институтийн ерөнхийлөгч Дон Чул Чо, Чехийн Төв банкны Ерөнхийлөгч асан Мирослав Сингер, ОУВС-ийн Монгол дахь Суурин төлөөлөгч Тигран Погосиан, АХБ-ны Бүс нутгийн хамгийн ажиллагаа, интеграцийн хэлтсийн захирал Жон Ву Канг зэрэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагууд, судалгаа, хөгжлийн институтийн эрдэмтэн, судлаач нар оролцож байгаа юм. Түүнчлэн Монгол Улсын холбогдох яамд, арилжааны банкны удирдлагууд, дотоодын зохицуулагч байгууллагууд, судлаачдын төлөөлөл зэрэг өргөн хүрээг хамарч байна.

Энэхүү өндөр түвшний хурал нь “Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж бэхэжсэний 100 жилийн ой”-г тохиолдуулан 2024 онд зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын амжилтад тулгуурлан, дэлхийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, эрдэмтэн судлаачид, санхүүгийн тэргүүлэх мэргэжилтнүүдийг нэг дор урин цуглуулж, дэлхийн эдийн засагт тулгарсаар буй сорилтууд, тэдгээрийг даван туулах бодлогын зохистой арга хэмжээ, тэр дундаа мөнгөний бодлогын хүрээнд гарч буй сорилтын талаар хэлэлцүүлэх үндсэн зорилготой юм.

2.12 ЭРДЭНЭСИЙН САН

1.Эрдэнэсийн сангийн сан хөмрөг болон үзмэрийн танхимын үйл ажиллагаа:

Улсын банк Улсын эрдэнэсийг татан төвлөрүүлэх үүрэг бүхий нэгжийг 1983 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн (Одоогоор Засгийн газрын) 101 дүгээр тогтоолоор “Үнэт зүйлс, эрдэнэсийн улсын фонд” нэртэйгээр тусгаарлан байгуулсан түүхтэй. Улсын Эрдэнэсийн фонд байгуулагдсанаар Монгол Улсын түүх соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг Улсын санд төвлөрүүлэн хадгалж, хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсад банкны тогтолцоо үүсэж бэхэжсэний 80 жилийн тэмдэглэлт ойг тохиолдуулан 2004 онд Эрдэнэсийн санд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг дэглэн олон нийтэд нээлттэйгээр үзүүлэн, таниулах зорилгоор Эрдэнэсийн сангийн үзмэрийн 2 танхимыг байгуулсан. Мөн 2021 онд Олон улсын төв банкнуудын жишгээр Монгол Улсын төлбөрийн хэрэгслийн түүхийг харуулсан Эрдэнэсийн сангийн дэргэдэх Мөнгөн тэмдэгтийн танхимыг нээж Монголбанкны Эрдэнэсийн санд хадгалагдаж буй эртний зоос, Монгол Улсад төлбөр, тооцооны үүрэг гүйцэтгэж байсан эд зүйлс, цаасан болон зоосон мөнгөн тэмдэгт, дурсгалын зоосоор дамжуулан Монгол Улсын төлбөрийн хэрэгслийн хөгжлийн түүхийг харуулах зорилготой юм.

Монгол Улсад үндэсний мөнгөн тэмдэгт “Төгрөг” гүйлгээнд гаргасны 100 жилийн ойг тохиолдуулан тайлант онд Мөнгөн тэмдэгтийн танхимын дэргэд шинэ танхимыг тохижуулж дэглэсэн бөгөөд 2025 онд Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Хэл, зохиолын хүрээлэнтэй хамтран “Монголбанк - 100” баримтын эмхэтгэл II боть, “Монгол Улсын төлбөрийн хэрэгслийн бичвэр” бүтээлүүдийг олны хүртээл болгосон. Улмаар тайлант онд Эрдэнэсийн сангийн үзмэрийн танхимуудыг 8500 орчим иргэнд үзүүлж, танилцууллаа.

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “Эрдэнэсийн сангийн жилийн орлого, зарлагын хэмжээ болон гүйцэтгэлийн тайланг батлах;” гэж заасны дагуу 2025 оны төсвийн гүйцэтгэл, 2026 оны төсвийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн батлуулав. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д “Монголбанк жил бүр Эрдэнэсийн санд тооллого явуулж, тайланг Улсын Их Хуралд танилцуулна” гэсний дагуу 2025 оны жилийн эцсийн сан хөмрөгийн тооллогын ажлыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан ажлын хэсэг гүйцэтгэж тооллогын тайланг УИХ-д хүргүүлж, танилцуулав.

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэх агентлагийн Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын нэгдсэн тооллого”-д хамрагдаж, Эрдэнэсийн сангийн сан хөмрөгд бүртгэлтэй эд зүйлсийг бүртгэн баталгаажуулж ажиллав.

2. Дурсгалын зоосны үйл ажиллагаа:

Монголбанк нь Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “үнэт болон бусад металлуар хийсэн дурсгалын зоос гаргах” гэж заасны дагуу Койн Инвест Траст компанитай “Зоос үйлдвэрлэх ерөнхий гэрээ”-г байгуулан хамтран ажиллаж байна.

Монголбанк нь Лихтенштейны Вант улсын Койн Инвест Траст компанитай 1996 оноос хойш зоос үйлдвэрлүүлэх ерөнхий гэрээ байгуулан 28 жил хамтран ажиллаж байна. Койн Инвест Траст компани нь Монголбанкны зөвшөөрлөөр Монголбанкны нэр, бэлгэдэлтэйгээр “Монголын амьд байгаль”, “Монголын ургамал, ан амьтан”, “Монголын түүх соёл”, “Билгийн тооллын зоос, олимп болон алдартай хүмүүс”, “Хэлбэр ба онцлог хийц” сэдвийн хүрээнд зоос цутгуулан Олон Улсын зах зээлд гаргах, Олон Улсын үзэсгэлэнд оролцох зэрэг үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.

Дурсгалын зоосыг хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан орчин үеийн чиг хандлага, хөгжлийг харуулсан smartminting 4.1 болон шинэлэг загвараар үйлдвэрлүүлэн олон нийтэд тухайн сэдвийг сурталчлан таниулж байна.

Тайлант онд орчин цагийн “Төгрөг”-ийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ойг тохиолдуулан “Нэг төгрөг” дурсгалын зоосыг 1 унцын хэмжээтэйгээр алт, мөнгөн төрлөөр, 1925 оны “100 Төгрөг” 3 граммын алтан ялтсан дэвсгэрт, 2020 оноос эхлэн гаргасан 12 жилийн цуврал дурсгалын зоосны үргэлжлэл “Морь жил” дурсгалын зоос, Голомт банкны 30 жилийн ойг тохиолдуулан 1 унцын мөнгөн зоос, алтан ялтсан 1 граммын дэвсгэрт, Иргэний нисэхийн ерөнхий газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсад нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан “Нисэх хүчин 100 жил” 1 унцын дурсгалын зоос, Монгол Улсын Зам, тээврийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Автотээвэр 100 жил” 1 унцын алтадсан мөнгөн дурсгалын зоос, Анхдугаар Богд Өндөр Гэгээн Занабазарын мэлмий гийсний 390 жилийн ойг тохиолдуулан “Занабазар 390” 2 унцын дурсгалын мөнгөн зоосыг бэлэг дурсгал, цуглуулгын зорилгоор зоос цуглуулагч, иргэдэд худалдаалж байна.

2.13 ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ МЭДЛЭГ ОЛГОХ

Төв банк/Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7¹ дахь заалт, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн 3.3² болон 3.4³ дэх заалтын дагуу Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан “Иргэдийн эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх

¹ 7/банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

² 3.3.Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлж, Төв Банкны бодлого, үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэж ажиллана.

³ 3.4.Олон нийтийн санхүү, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлнэ.

стратеги” болон “Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратеги 2024-2030”-ийн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Үүнд:

“Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратеги 2024-2030”-ийн хүрээнд:

- УИХ-ын даргын санаачилгаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Хадгаламжийн даатгалын корпорац (ХДК), Боловсролын ерөнхий газар (БЕГ)-тай хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох “Level-Up” хөтөлбөрийг 2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүллээ. “Level-Up” хөтөлбөрт Улаанбаатар хотын 6 дүүргийн ерөнхий боловсролын 80 сургууль болон Орхон, Булган, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан аймаг дахь ерөнхий боловсролын сургуулийн нийт 149 сургагч багшийг бэлтгэж, 5,033 ахлах ангийн сурагчийг хамруулсан байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2024 онд сургагч багш нарыг бэлтгэн, албан ёсны нээлтийн арга хэмжээ тус тус зохион байгуулав. Мөн Монголын Мэтгэлцээний Нэгдсэн танхим, Монголын Карл Попперын Мэтгэлцээний Нийгэмлэгтэй хамтран сурагчдын илтгэл, мэтгэлцээний ур чадварыг нээн хөгжүүлж, тэдний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, олон ургалч үзэл, ялгаатай үнэт зүйл, санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, шүүмжит сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор Говь-Алтай, Ховд, Увс, Завхан, Орхон, Булган аймагт 2025 оны 3, 4 сард амжилттай зохион байгуулж, нийт 237 оролцогч, 88 дасгалжуулагч багш, 27 мэтгэлцээний клуб хамтран ажиллалаа.
- Монголбанкнаас Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага (OECD)-ын санаачилгаар олон улсад хэрэгжүүлдэг “Дэлхийн мөнгөний долоо хоног–2025” аяныг 13 дахь жилдээ Монгол Улсад амжилттай хэрэгжүүллээ. Монголбанк, орон нутгийн төр захиргааны байгууллагын удирдлагууд, орон нутгийн иргэдийн төлөөлөл болон нийт 300 орчим хүүхэд, залуусыг хамруулсан нээлтийн арга хэмжээг Хөвсгөл аймгийн Мөрөн хотод 2025 оны 3 дугаар сарын 22-ны өдөр хийж, хаалтын үйл ажиллагааг Өмнөговь аймгийн Даланзадгад хотод 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Харин аяны хүрээнд санхүүгийн суурь мэдлэг олгох сургалт, мэдээллийг нийт 193,800 хүүхэд, залууст хүргэсэн бол нөлөөлийн арга хэмжээг давхардсан тоогоор нийт 3.7 сая иргэнд хүргэсэн байна.
- Орчин цагийн үндэсний мөнгөн тэмдэгт “Төгрөг”-ийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ойтой холбогдуулан төгрөгийн үнэ цэнийг таниулах зорилгоор Монголбанкнаас ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд эсээ бичлэгийн уралдаан, 1-5 дугаар ангийн сурагчдын дунд гар зургийн уралдааныг тус тус зохион байгуулан шалгаруулж, батламж гардуулав.
- Иргэдийн санхүү, эдийн засгийн мэдлэгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн арилжааны банкны ажилтан, Төрийн банкны төв албаны болон салбар, нэгжийн ажилтан болон Ерөнхий боловсролын Medle цахим сургуулийн багш, Level-Up хөтөлбөрийн ЕБС-ийн багш нар болох нийт 298 “сургагч багш”-ийг бэлтгэн, батламж олгов. Түүнчлэн ерөнхий боловсролын Medle цахим сургуулийн багш нарыг чадавхжуулж, тэдгээр багш нар 1,173 сурагчдад “Бизнес судлал” хичээл орсон байна.
- Монголбанк, ХДК, БЕГ, Монголын банкны холбоо (МБХ), банкнууд, “Жэй Си Ай Прогресс” байгууллага болон “Банкс маркетплейс” ХХК хамтран “Дэлхийн хуримтлалын өдөр-2025” аяныг “Хуримтлалаар мөрөөдлөө бүтээе” уриан дор улсын хэмжээнд зохион байгууллаа. Аян 2025 оны 10 дугаар сарын 10- 31-ний өдөр зохион байгуулагдсан бөгөөд Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбарууд банкнуудтай хамтран тухайн аймаг, сумдыг хамарсан олон талт арга хэмжээг санаачлан амжилттай зохион байгуулав. Аяны хүрээнд 1,027,806 иргэнд хүрч, 43,650 иргэнд сургалт орсон байна. “Дэлхийн хуримтлалын өдөр-2025” аяны үр дүнг дүгнэн, хаалтын арга хэмжээг 2025 оны аравдугаар сарын 31-ний өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулж, хуримтлал, хадгаламжийн ач холбогдлын талаар илтгэл тавьж, оролцогчдын дунд хуримтлалын талаарх мэдлэг шалгах уралдаан зохион байгууллаа.

- Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэрэгжүүлж буй “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Олон нийтийн эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх заалтыг тусган батлуулав.

“Иргэдийн эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратеги”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд:

- Монголбанк, Санхүү эдийн засгийн их сургууль, Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь бичиг”-ийг шинэчлэн боловсруулан олны хүртээл болгож, улмаар www.etoli.mn цахим хуудсыг ашиглалтад орууллаа. Мөн тайлбар толь бичгийн талаар “Өнгөрсөн, Одоо, Ирээдүй» сэдэвт хэлэлцүүлгийг банк санхүүгийн салбарын ажилтнууд, их дээд сургуулийн багш, оюутан, сэтгүүлч, судлаачдын хүрээнд зохион байгууллаа.
- Санхүүгийн мэдлэг дутмаг байдлаас иргэд ихээр залиланд өртөж байгаа бөгөөд ЦЕГ-ын тайланд 2025 онд өмнөх онтой харьцуулахад залилах гэмт хэрэг 41,5 хувиар өссөн талаар дурдсан. Иймд Монголбанк, Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ), МБХ, Залилах, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад иргэдийн санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Монголын баримт шалгах төв хамтран “Дансаа бүү ашиглуул” аяныг 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 2 сарын хугацаанд зохион байгуулж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүллээ. Аяны үр дүнд залилах гэмт хэрэг 12.3 хувиар буурсан боловч цаашид анхаарах асуудал хэвээр байхаар байна..Тусаяны хүрээнд залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд сургалт, уулзалт, ярилцлага, нэвтрүүлэгтэх мэтлон арга хэлбэрээр олон нийтэд мэдээ, мэдээлэл түгээв.

Хэвлэмэл бүтээгдэхүүн:

- Тайлант хугацаанд Монголбанкны жилийн тайлан, өрхийн төсөв, халаасны мөнгөний дэвтэр, Эдийн засаг-санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилт, үйл ажиллагааны ерөнхий зөвлөмж” товхимол, “Судалгааны ажил” товхимол, Мөнгөний бодлогын тайлан, Санхүүгийн тогтвортой байдлын тайлан, “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл” зэрэг хэвлэмэл бүтээгдэхүүнийг хэвлүүлж, түгээлтийг гүйцэтгэв.

Цахим хуудсаар санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Цахим орчинд мэдээлэл түгээх ажлын дагуу www.sankhuuginbolovsrol.mn хуудсыг тогтмол идэвхжүүлж, www.facebook.com/sankhuuginbolovsrol пэйж хуудас, twitter.com/SankhBolovsrol твиттер хуудсанд тайлант хугацаанд нийт 51 мэдээ, постер байршуулав. Мөн “Анар Ану 2” цуврал богино хэмжээний 2 анимейшны ээлжит дугаарыг бүтээж, нийгмийн сүлжээнд байршуулав.
- Монголбанканд иргэдээс ирсэн санал, хүсэлтэд тогтмол хариу өгч ажиллалаа.

Олон улсын байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагаа:

- Япон улсын JICA-тай хамтран “Анар, Ану хоёр” анимейшний хоёр дугаарыг бүтээх ажлыг гүйцэтгэж, ажлын даалгавар, зохиолын санааг бичиж, хүүхдүүдийн худалдан авалт болон цахим хэрэглээг харгалзан үзэж, санхүүгийн боловсролын хүрээнд «Анар, Ану хоёр дэлгүүр орсон нь», «Анар, Ану хоёр цахим мөнгөний талаар ярилцсан нь» сэдвээр анимейшн хийлгэж, цахим сувгуудаар түгээв.
- Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ (OECD/INFE)-ний 2025 оны 5 дугаар сарын 6-9 -нд Мексик Улсад болсон

хиймэл оюун ухааныг санхүүгийн боловсролд нэвтрүүлэх нь сургалт, ээлжит техникийн зөвлөлийн хуралд оролцов.

- Ахлах ангийн сурагчдын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Төв банк болон тус улсын ХДК-ийн үйл ажиллагаатай танилцах зорилгоор 6 сарын 28-наас 7 сарын 4-ний өдөр туршлага судлах сургалтад хамрагдав.
- “Aflatoun International” байгууллагын Азийн бүсийн зохицуулагч Монгол Улсад ирж, 2025 оны 8 дугаар сарын 25-30-ны өдөр ажиллалаа. Монгол Улсад ажиллах хугацаандаа нийслэл болон Архангай аймагт сургагч багшийн сургалтыг амжилттай зохион байгуулж, Монголбанкны удирдлагуудтай албан уулзалт хийж, санхүүгийн боловсрол олгох бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх талаар санал солилцлоо.

3.1 МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

Монголбанк тайлант онд 13 газар, 1 хүрээлэн, 1 төв, 4 бие даасан алба, орон нутаг дахь 17 салбар, 2 төлөөлөгчийн газартайгаар үйл ажиллагаа явуулж, төв аппаратад 577, орон нутаг дахь салбарт 124, нийт 701 батлагдсан орон тоотой ажиллав.

Үндэсний мөнгөн тэмдэгт “Төгрөг”-ийг гүйлгээнд гаргасны түүхт 100 жилийн ойн хүрээнд Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгтийн түүхэн ач холбогдол, үнэ цэнийг иргэдэд таниулан сурталчлах, мөнгөн тэмдэгтийг дээдлэх ёс, соёлтой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор сургалт, уралдаан, эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зэрэг олон талт арга хэмжээг зохион байгууллаа. Мөн банк, санхүүгийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулсан ажилтнуудыг шагнаж урамшуулсан бөгөөд 21 ажилтанг “Хүндэт банкир”, 177 ажилтанг “Санхүү банкны тэргүүний ажилтан” цол, 283 ажилтанг Монголбанкны “Хүндэт жуух”, 368 ажилтанд Монголбанкны “Баярын бичиг” -ээр тус тус шагнаж, урамшууллаа.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд 2025 онд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэв. Ажилтнуудын мэргэжлийн болон ур чадварын хөгжлийг тасралтгүй дэмжиж, ажиллах орчны нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүллээ. Тайлант онд нийт 225 ажилтныг гадаад, дотоодын богино хугацааны сургалтад хамруулж, 19 ажилтан гадаадын болон дотоодын их, дээд сургуулиудад тэтгэлгээр суралцуулахаар Монголбанкттай сургалтын гэрээ байгуулан мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна

Хурдацтай өөрчлөгдөж буй орчинд төв банкнуудын хувьд илүү уян хатан бүтэц, хариуцлагатай удирдлага, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт, хүний нөөцийн оновчтой зохион байгуулалт зайлшгүй шаардлагатай болж байна. Энэ нөхцөлд хүний нөөцийн чиг үүрэг улам бүр хурдтайгаар хувьсан өөрчлөгдөж байна. Хүний нөөцийн үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэх нь сонголт бус, стратегийн зайлшгүй шаардлага болжээ. Энэхүү сургалт нь технологийг стратегийн түвшинд ашиглан авьяас чадварын баазыг бэхжүүлэх, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөлтийг оновчтой болгох, ажилтнуудын ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр бодит мэдлэг, арга зүй олгосон ач холбогдолтой арга хэмжээ болов. Мөн Ази, Номхон далайн бүсийн төв банкнуудад тулгамдаж буй ажиллах хүчний шинэ чиг хандлага, түүний стратегийн үр дагавар, байгууллагын зорилго, улс орны мандаттай уялдсан хүний нөөцийн төлөвлөлтийн стратеги, технологи болон хүний нөөцийн дижитал хэрэгслүүдийг ашиглан нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын талаар хэлэлцэж, төв банкнуудын хүний нөөцийн мэргэжилтнүүд харилцан туршлага солилцох, шилдэг практикийг хуваалцах боломжийг бүрдүүлсэн үр дүнтэй сургалт боллоо.

Мөн 2025 онд Монголбанк төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын чиглэлээр 5 жил тутамд хийгддэг улсын үзлэгт хамрагдаж 91.5 оноо буюу “А” үнэлгээтэй шалгагдлаа. Монголбанк нийгмийн хариуцлагын хүрээнд ажилтнуудынхаа санаачилгаар сайн үйлсийн хандивын аяныг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулж, хамтын ажиллагаатай Чингэлтэй дүүргийн 5 дугаар цэцэрлэгийн хүүхдүүдэд ном, дэвтэр, тоглоом хандивлав.

3.2 ДОТООД АУДИТ

Засаглал, хараат бус байдал

Дотоод аудитын газар нь Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкны Дотоод аудитын дүрэм болон Дотоод аудитын олон улсын стандарт (Global Internal Audit Standards)-д нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөг сайжруулахад чиглэсэн хараат бус, бодитой баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд Дотоод аудитын газар нь үйл ажиллагаагаа Монголбанкны Ерөнхийлөгчид шууд тайлагнадаг бөгөөд энэ нь аудитын үйл ажиллагааны хараат бус, бодитой байдлыг хангах үндэс нь болдог.

Дотоод аудитын газар нь Монгол Улсын Их Хурлаас томилогддог Монголбанкны Хяналтын зөвлөлтэй хамтран ажиллаж, аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайланг танилцуулж, үйл ажиллагааны тайланг улирал тутам хүргүүлэн ажиллаж байна.

Мөн Монголбанкны санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитын байгууллагатай нягт хамтран ажиллаж, аудитын үйл ажиллагаанд шаардлагатай тайлан мэдээллийг цаг тухайд нь гарган, холбогдох асуудлаар харилцан мэдээлэл солилцон, тайлбар хүргүүлэн ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээ ба аудитын төлөвлөлт

Дотоод аудитын газар нь Монголбанкны стратегийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, эрсдэлийг харгалзан байгууллагын үйл ажиллагаанд тогтмол эрсдэлийн үнэлгээ хийж байна. Энэхүү эрсдэлийн үнэлгээнд стратеги, үйл ажиллагаа, санхүү, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдал болон нэр хүндийн эрсдэлүүд хамардаг болно.

Дээрх үнэлгээнд үндэслэн эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэн ажиллалаа.

Аудит, мониторингийн үйл ажиллагаа

Дотоод аудит газар нь 2025 онд батлагдсан эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөөний дагуу Монголбанкны үндсэн болон дэмжих чиг үүрэг бүхий үйл ажиллагааны хүрээнд аудит, шалгалт, зайны хяналтын дүгнэлтийг батлуулж ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 24 аудит гүйцэтгэснээс үйл ажиллагааны аудит 9, мэдээллийн технологийн аудит 2, орон нутгийн салбарын аудит 11, санхүүгийн аудит 2 хийж гүйцэтгэв.

Мөн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах зорилгоор тодорхой процесс, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, мониторингийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн, илэрсэн асуудал, сайжруулах боломжийн талаар дүгнэлт гарган, холбогдох нэгжүүдэд зөвлөмжийг хүргүүлэн, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллалаа.

Хүний нөөц ба чадавхжуулалт

Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх зорилгоор Дотоод аудитын олон улсын институцийн Монгол дахь салбарын сургалтад тогтмол хамрагдаж, мөн олон улсын төв банкнууд болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас зохион байгуулагддаг сургалт, семинарт тогтмол оролцож байна.

Тайлант хугацаанд Дотоод аудитын газраас Certified Internal Auditor (CIA) зэргийг нэг аудитор хангаж, газрын мэргэжлийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэрээ орууллаа.

3.3 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монголбанк гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийн удирдлага болон төв банкны зээл, санхүүжилтийн үйл ажиллагаанд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд ГВУН-ийн стратегийн хөрөнгө оруулалтын бүтэц, жишиг багц, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулах хөрөнгийн лимитийг тодорхойлох, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах, төв банкны зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгийн шалгуурыг тодорхойлох, барьцаа хөрөнгийн жагсаалтыг гаргах, эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээг тогтоох, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийг тооцох аргачлалыг боловсруулах, гүйцэтгэлд нь хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа. Түүнчлэн санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын хүрээнд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага болон үйл ажиллагааны тасралтгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэн ажиллав.

Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Гадаад валютын улсын нөөцийн эрсдэлийн удирдлага

Тайлант онд ГВУН эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаад өр төлбөрийн бүтэц, импортын барааны төлбөр тооцооны валютын бүтэц, банкнуудын гадаад гүйлгээний гадагшлах урсгал болон дотоодын валютын захын валютын бүтэц зэрэг макро үзүүлэлтүүдэд үндэслэн хөрвөх чадвартай бөгөөд зах зээлийн эрсдэлийг хамгийн бага байлгах валютын болон активын бүтцийг тодорхойлж, хэрэгжилтийг хянаж ажиллав. Түүнчлэн хүүгийн түвшний өндөр хэлбэлзлийн үед хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн үнэ цэнэ буурах эрсдэлийг хамгийн бага байлгах үүднээс нөөцийн дэд багц тус бүрийн хувьд үргэлжлэх хугацаа болон түүний хазайлтын оновчтой хэмжээг тогтоох замаар хүүгийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй зах зээлийн эрсдэлийг удирдан ажиллалаа.

Дэлхий даяар инфляц буурч байгаа хэдий ч эдийн засгийн өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал улс орнуудын хооронд жигд бус хэвээр байна. Үүнтэй холбоотойгоор төв банкнууд бодлогын хүүгээ үе шаттайгаар бууруулах бодлого хэрэгжүүлэв. АНУ-ын хувьд инфляц саарч, технологийн салбарын хөрөнгө оруулалт болон хөрөнгийн зах зээлийн өсөлт нь нийт эдийн засгийн өсөлтийг дэмжиж, өсөлт харьцангуй өндөр түвшинд хадгалагдлаа. Гэвч технологийн шинэчлэлтэй холбоотойгоор хөдөлмөрийн захын бүтцийн шилжилт эрчимжсэн нь зарим салбарын ажил эрхлэлтэд дарамт үүсгэв. Түүнчлэн 2025 оны 4 дүгээр сард АНУ-ын Засгийн газраас зарим улс оронд өндөр тариф ногдуулсан нь гадаад худалдааны орчинд тодорхой бус байдал үүсгэж, хөрөнгийн зах зээлд савлагаа бий болгосон бөгөөд тус улс худалдааны гол түнш орнуудтайгаа худалдааны хэлэлцээрийг эрчимжүүлсний үр дүнд зах зээлийн тодорхой бус байдал тодорхой хэмжээнд намжиж, хөрөнгийн зах зээлд сэргэлт ажиглагдсан. Түүнчлэн Вэнэсүэль болон Ираны талаар авч хэрэгжүүлсэн бодлогын алхмууд, Гринланд арал болон Канадын талаарх байр суурь нь АНУ-ын гадаад бодлогын чиг хандлагад эрс өөрчлөлт орж байгааг харууллаа. БНХАУ-ын хувьд үл хөдлөх хөрөнгийн зах зээл уналттай хэвээр, хэрэглээ сул байсан тул тус улсын Засгийн газар болон төв банк эдийн засгийг дэмжих бодлогын багц арга хэмжээ хэрэгжүүлж эхэлсэн ч худалдааны зөрчил, геополитикийн тодорхойгүй байдал нь өсөлтийг олон жилийн дундаж өндөр түвшинд хүргэхэд саад болов. Харин Евро бүсийн голлох улсууд ОХУ-Украины дайн үргэлжилж буй нөхцөл байдал болон АНУ-ын зүгээс Гринланд арлыг эзэмших сонирхлоо илээр илэрхийлж байгаагаас үүдэн батлан хамгаалахын зардлаа нэмэгдүүлж эхэлсэн жил байв.

Тайлант онд дээрх гадаад орчны нөхцөл байдалтай уялдуулан гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлагын хүрээнд зээлийн эрсдэл, төлбөр тооцооны эрсдэл, зах зээлийн эрсдэл, түүний дотор ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэлийг голлон анхаарч ГВУН-ийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэв. ГВУН-ийн стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийн тооцооллыг сайжруулах ажлын хүрээнд ОУТТБ-ны тооцоолол, програмчлалын шийдлийг ашиглан бүтцийн тооцооллыг сайжруулах судалгааны ажлыг гүйцэтгэж үйл ажиллагаандаа нэвтрүүлэв.

Улс орнуудын өрийн дарамт, төсвийн санхүүжилтийн хүүгийн дарамт нэмэгдсэн, эдийн засгийн тогтворгүй байдал зэргээс шалтгаалж зээлжих зэрэглэл тогтоогч голлох байгууллагууд 2025 онд АНУ, Франц улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан. Тиймээс эдгээр нөхцөл байдлыг тогтмол хянаж, зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаадын харилцагч банк, санхүүгийн байгууллагуудын санхүүгийн чадавхид шинжилгээ хийж, санхүүгийн гол үзүүлэлтүүд, зээлжих зэрэглэл, хувьцааны үнийн динамик, CDS спред болон тэдгээр байгууллагын талаарх онцгойлох мэдээ, мэдээлэлд мониторинг хийв.

Гадаад валютын нөөцийн хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зорилгоор нийт нөөцийг богино болон урт хугацаат хөрөнгө оруулалтын багцад хуваан удирдав. Нөөцийн хүрэлцээт байдлыг тодорхойлоход түгээмэл ашиглагддаг ОУВС болон бусад төв банкнуудаас гаргасан аргачлалын дагуу хөрвөх чадвар өндөртэй богино хугацаат багцын оновчтой хэмжээг нийт гадаад өр төлбөрийн түүхэн мэдээлэл болон ирэх оны өр төлбөрийн хуваарь, экспорт, импортын ирэх оны төсөөлөл зэрэг макро үзүүлэлтүүдэд үндэслэн тодорхойлж, нөөцийн удирдлагад ашигласан. Түүнчлэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор нөөцийг харилцах, богино хугацаат хадгаламж, гадаадын засгийн газрын болон олон улсын санхүүгийн байгууллагын богино хугацаат үнэт цаас зэрэг хөрвөх чадвар өндөртэй хэрэгслүүдэд байршуулж удирдлаа.

ГВУН-ийн батлагдсан бүтэц болон лимитийн комплаенсийг өдөр тутам хийж, нөөцийн удирдлагын гүйцэтгэлийг олон улсын стандартын дагуу тооцож, тогтмол тайлагнан ажиллав. Цаашилбал ГВУН-ийн удирдлагын журмыг шинэчлэх, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийг шинээр боловсруулах талаар холбогдох судалгааг хийж олон улсын байгууллагуудаас санал, зөвлөмж авч ажиллалаа.

Мөнгөний бодлогын хэрэгжилттэй холбоотой эрсдэлийн удирдлага

Мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдлын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкнаас банканд олгох зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгийн төрлийг тодорхойлох, бодит үнэ цэнийг тооцох аргачлалыг боловсруулах, эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээг тогтоох зэрэг барьцаа хөрөнгийн бодлогоор дамжуулан төв банкны хүлээх зээлийн эрсдэлийг удирдаж, тайлант хугацаанд батлагдсан барьцаа хөрөнгийн бодлогын дагуу Монголбанкнаас банкнуудад олгосон зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгийн үнэлгээг тухай бүр хийж, барьцаа хөрөнгийн хүрэлцээг хангаж ажиллав.

Төв банкны эрсдэлийн хямдруулалт нь барьцаа хөрөнгийн онцлог, эрсдэлийн түвшин, хөрвөх чадвар зэрэг олон хүчин зүйлийг харгалзан ялгаатай тогтоогддог тул төв банкны барьцаалах хэвийн зээлийн эрсдэлийн хямдруулалтыг бусад улсын төв банкнуудын зээлийн эрсдэлийн хямдруулалттай харьцуулан судалж эрсдэлийн хямдруулалтын зохистой хувь хэмжээг тогтоох талаар үндэслэл бүхий тооцооллыг хийсэн нь төв банкны төдийгүй нийт санхүүгийн системийн эрсдэлийг бууруулахад чухал нөлөөтэй ажил боллоо.

Монголбанкны мөнгөний бодлогын хэрэгслийн үр ашгийг нэмэгдүүлэх, төв банкны санхүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд авах зохистой арга хэмжээг тодорхойлох зорилгоор Монголбанкны барьцаа хөрөнгийн жагсаалтыг шаардлагатай үед шинэчлэн баталдаг. Тайлант онд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн үнэт цаасны эрсдэлийн хямдруулалтын тооцооллыг хийж, улмаар “Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаасны жагсаалт”-д нэмж орууллаа.

Санхүүгийн хөрөнгөөс хүлээж болзошгүй алдагдлыг тооцох аргачлалыг сайжруулах талаар судалж, үр дүнг тооцоололд тусгаж Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартад нийцүүлэн гаргасан “Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэлгээний заавар”-ын дагуу Монголбанкны зарим төрлийн санхүүгийн хөрөнгөөс хүлээж болзошгүй алдагдлыг урьдчилан тооцоолж, түүнд тохирсон эрсдэлийн нөөц санг байгуулсан.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн А-236 дугаар тушаалаар “Урт хугацаат своп хэлцлийн журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах зорилгоор дотоодын банкнуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлийн дахин үнэлгээг шинэчлэн баталсан журмын дагуу гүйцэтгэж санхүүгийн тайланд тусгав. Ингэснээр Монголбанкны тайлан тэнцлийг олон нийтэд бодитой, үнэн зөв тайлагнаж, төв банкны хариуцлагатай, найдвартай байдлыг бэхжүүлснээр бодлогын үр нөлөөг сайжруулах юм.

Төв банкнуудын нийт активын өсөлт, тайлан тэнцлийн бүтцийн өөрчлөлттэй уялдан төв банканд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, удирдах асуудал дэлхий нийтийн хүрээнд чухлаар хөндөгдөх болсон. Иймд Монголбанк төв банкны санхүүгийн тайлан тэнцэлд эрсдэлийн төрлөөр шинжилгээ хийж, үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлэх, удирдах арга хэмжээг авах зорилгоор улирал тутам эрсдэлийн шинжилгээний танилцуулгыг бэлтгэн удирдлагын хүрээнд мэдээлэл солилцон ажиллав.

Санхүүгийн бус эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Тайлант онд төв банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах зорилгоор онолын судалгааны ажлууд, бусад улс орны төв банкнуудын тэргүүн туршлагыг судалж, улмаар эрсдэлийн засаглалын тогтолцоог бэхжүүлж, эрсдэлийг үнэлж, тодорхойлох арга хэрэгслүүдийг амжилттайгаар хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад түгээмэл ашиглагддаг үнэлгээний хэрэгсэл болох “Өөрийн үнэлгээ” (Risk Control and Self-Assessment)-г нийт ажилтнуудаар хийлгэж, үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллав. Үүнээс гадна эрсдэлтэй тохиолдол гарах, үүсэх бүрт эрсдэлийн мэдээллийн санд мэдээллийг оруулж баяжуулах, үйл ажиллагааны эрсдэлийн гол үзүүлэлтүүд (KRIs)-ийн гүйцэтгэлийг тухай бүр хянаж, тайлагнав. Энэ нь үйл ажиллагааны эрсдэлийг бодит хэмжүүрээр хэмжиж, эрсдэл үүсгэж буй хүчин зүйлсийн гол шалтгааныг олж тодорхойлон, тохирсон арга хэмжээг авахад чухал хувь нэмэр оруулж байна. Түүнчлэн тайлант онд 1) программ боловсруулах, засвар, өөрчлөлт хийх үйл ажиллагаа болон 2) үнэт цаасны арилжааны процессын бүх шатны үйл ажиллагаанд эрсдэлийн зураглалын үнэлгээг хийж, үр дүнд үндэслэн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллав.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын соёлыг төлөвшүүлэх хүрээнд байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, Монголбанкны газар нэгжүүдийн үйл ажиллагааны эрсдэл хариуцсан ажилтнуудад сургалт, уулзалт зохион байгуулж, нэгж тус бүр хоорондоо нягт уялдаа холбоотой хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэв.

Үйл ажиллагааны тасралтгүй байдлын удирдлага

Монголбанканд хүчин төгөлдөр хэрэгжиж буй үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангах, онцгой нөхцөлд дагаж мөрдөх төлөвлөгөөнүүд болон дүрмийн хэрэгжилтэд Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжээс хяналт тавьж ажиллалаа. Үүнээс гадна Монголбанк үйл ажиллагааны эрсдэл болон тасралтгүй байдлын удирдлагын талаарх ажилтны мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад оролцогч талуудын мэргэжлийн, хариуцлагатай зан чанарыг дэмжих замаар байгууллагын эрсдэлийн соёлыг төлөвшүүлэхийг зорьж байгаа бөгөөд тайлант жилд санхүү, бүртгэл болон мөнгөн тэмдэгттэй холбоотой үйл ажиллагааны тасралтгүй байдлын тусгайлсан төлөвлөгөөг шинээр баталлаа.

3.4 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Мэдээллийн технологийн газар нь 2025 онд байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах, шинэ технологи, программ хангамж нэвтрүүлэх чиглэлээр ажиллалаа. Тайлант хугацаанд хийгдсэн гол ажлуудыг танилцуулж байна.

Дэд бүтэц, аюулгүй байдлыг сайжруулах ажлын хүрээнд:

- Систем болон серверүүдийн доголдлыг илрүүлж, засварлалт, автоматжуулалт хийгдэж, Зээлийн нэгтгэлийн систем (NPL)-ийн үндсэн орчныг үүсгэж, үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүлсэн бөгөөд Oracle өгөгдлийн сангийн хяналтын системийг OEM 13c хувилбараас OEM 24ai (AI суурьтай) хувилбар руу шинэчилж, Зээлийн мэдээллийн сангийн standby серверийг нэмэгдүүлж нөөц төвд байршуулсан нь серверийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагаанд дэмжлэг болохуйц ажил боллоо.
- VxRail орчин болон ЗМС-ийн шинэчилсэн JSON протоколын өгөгдлийн сан, аппликэйшн орчныг үүсгэж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх сүлжээ, серверийн сайжруулалт хийгдсэн бөгөөд RAM системд үйлдлийн систем, сервер, сүлжээний төхөөрөмжүүдийг холбож хандалтын хяналтыг сайжруулах, FortiClient Endpoint Management System-ийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг аюулгүй байдлын оновчтой шийдлүүдийг тусгав. Мөн ТЕГ-аас өгсөн мэдээллийн аюулгүй байдлын зөвлөмжийг хэрэгжүүлж, ISO27001:2022 Мэдээллийн аюулгүй байдлын стандартад нийцүүлсэн холбогдох 10 журам, бодлогын баримт бичгүүдийг боловсруулав.

Программ хангамж хөгжүүлж, нэвтрүүлэх ажлын хүрээнд:

- Цагдаагийн ерөнхий газартай хамтран цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх системийг бүрэн хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд арилжааны банкнууд, ЦЕГ хоорондын хамтын ажиллагааг түргэн шуурхай, хялбар болголоо.
- Зээлийн эрсдэл, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд зээлийн тайлан, нэгтгэлийг хялбаршуулж, чанаргүй зээлийн хяналт, тооцооллыг түргэн шуурхай, найдвартай түвшинд хүргэв.
- Монголбанканд ирүүлж буй олон нийтийн өргөдөл, санал гомдлыг цахимаар хүлээж авах системийг бүрэн хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон.
- Монголбанкнаас олгодог зөвшөөрлүүдийг цахимжуулах ажлын хүрээнд программ хангамжийг хөгжүүлж, олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон бөгөөд Монголбанкнаас олгодог тусгай болон энгийн зөвшөөрлүүдийг цахим болгосон нь олон нийтэд нээлттэй, ил тод, түргэн шуурхай байдлаар процессыг сайжруулах өндөр ач холбогдолтой билээ.

3.5 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлд тусгасны дагуу Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны техник хэрэгжилт, үр дүнтэй байдлын дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэж, шууд хэрэгжилтийн үзүүлэлтийн дагуу өөрийгөө үнэлэх болон үндэсний, салбарын эрсдэлийн үнэлгээг эхлүүлнэ гэж тусгасан. Санхүүгийн мэдээллийн алба (цаашид “СМА” гэх) нь дээр дурдсан үндсэн чиглэл болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр (Үндэсний хөтөлбөр)


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹ дугаар зүйлийн 22^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор үндэсний хэмжээнд хэрэгжих “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр” батлагдсан.

Хөтөлбөрийг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж, Үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилт, Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн болон олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийг үндэслэн боловсруулсан бөгөөд эрсдэлийн нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбогдуулан Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/189 дүгээр тушаалаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ялангуяа хөтөлбөрөөр дэвшүүлсэн зорилтуудад хүрэхэд өндөр түвшний улс төрийн дэмжлэг, хангалттай нөөц бололцоо болон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой. Хөтөлбөрийн дагуу 2022-2030 онд 8 стратеги зорилгын хүрээнд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 тоот тушаалаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 194 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр баталж, батлагдсан төлөвлөгөөг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг жил бүр гарган, танилцуулж байхыг СМА-д даалгасан.

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн 5.5, 5.7 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөөний явц, биелэлтийг байгууллагууд улирал бүр Үндэсний зөвлөл (ҮЗ), Хамтын ажиллагааны зөвлөл (ХАЗ)-ийн хурлаар танилцуулан, үнэлж дүгнэн ажиллалаа.

Зураг 3.1 Биелэлтийг ҮЗ, ХАЗ-ийн хуралд танилцуулсан байдал




Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 195 ажлаас 2025 онд хийж дуусгах 21 ажил, 2025 оноос эхлэн хэрэгжих 5 ажил, жил бүр/тогтмол хэрэгжих 30 ажил байна.

Монгол Улсын Явцын тайлан

Монгол Улс ФАТФ-аас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн талаар жил бүр Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-т тайлагнах үүрэгтэй. Энэ хүрээнд СМА болон ХАЗ-ийн гишүүн байгууллагуудтай хамтран 2025 оны Явцын тайланг үнэлгээ ахиулах хүсэлтгүйгээр 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүргүүлэв.

Зураг 3.2 Явцын тайлан хүргүүлэх явц



АНДМУТБ-ийн 2025 оны жилийн чуулга уулзалт 2025 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс 29-ний өдөр Япон улсын Токио хотноо зохион байгуулагдсан. Тус уулзалтад Монгол Улсыг төлөөлөн ХАЗ-ийн дарга бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны дэд даргаар ахлуулан Монголбанк, СМА, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Терроризмтой тэмцэх зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлөөллүүд оролцов.

Чуулга уулзалтын үеэр зохион байгуулагдсан дэлхий нийтийн 5 дахь шатны харилцан үнэлгээний амжилтын хүчин зүйлс, олон талт байдал, оролцоог хангах тухай панел хэлэлцүүлэгт СМА-ны дарга оролцон, 2019 онд Монгол Улс саарал жагсаалтад орж, богино хугацаанд гарсан туршлагаас хуваалцлаа. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд тавих хяналт: Хүндрэл бэрхшээл ба сургамж” сэдвээр Монгол Улсын зохицуулалтын туршлагаас хуваалцан, панелистаар оролцов.

Түүнчлэн СМА-ны төлөөлөл Вьетнам Улсын 2025 оны явцын тайлангийн үнэлгээчнээр ажиллаж, холбогдох зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэн, тайланг энэ удаагийн жилийн уулзалтаар танилцуулав.

Дотоод, гадаад хамтын ажиллагаа

Дотоод хамтын ажиллагаа

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд дотоодын төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өндөр ач холбогдолтой. Энэ хүрээнд Монгол Улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ҮЗ, ХАЗ-ийн гишүүн 19 төрийн байгууллага тогтмол хамтран ажилладаг бөгөөд СМА нь зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэж, зөвлөлийн хурлыг зохион байгуулдаг.

- АНДМУТБ-ийн жилийн уулзалт, хянагч, үнэлгээчний сургалт, типологийн хурал зэрэг үйл ажиллагааг Монгол Улсад зохион байгуулах талаар холбогдох байгууллагуудад уламжлах талаар арга хэмжээг авах;
- Гишүүн байгууллагууд Харилцан үнэлгээний үеэр өөрийн байгууллагатай хамаарах Шууд хэрэгжилтийн үнэлгээг хамгаалах тул үнэлгээнд оролцох албан хаагчдыг бэлтгэх, үнэлгээчин, хянагч бэлтгэх сургалтуудад албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах;
- Шаардлагатай тохиолдолд Зам тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар болон Далайн захиргааны газрын төлөөллийг ХАЗ-ийн хуралд оролцуулах, сүүлийн үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг өгөх;
- АНДМУТБ-ийн ээлжит чуулга уулзалт 2025 оны 8 дугаар сард Япон улсад зохион байгуулагдах талаарх мэдээллийг ажлын албанаас ХАЗ-ийн гишүүдэд хүргүүлэх, гишүүд өргөн бүрэлдэхүүнтэйгээр чуулга уулзалтад оролцоход анхаарах;
- МУТСТ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа байгууллагуудад албан бичиг хүргүүлэх;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрыг ХАЗ-ийн бүрэлдэхүүнд оруулах талаар албан бичгийг ажлын албанаас хүргүүлэх;
- ҮЭҮ-ний дэд ажлын хэсэгт ажиллаж буй албан хаагчдыг боломжтой бол үндсэн ажлаас чөлөөлөх, эрсдэлийн үнэлгээг хийх боломжоор хангах;
- Үр дүнтэй байдлын 11 шууд хэрэгжилт тус бүр дээр хамаарах байгууллагуудыг тодорхойлох, байгууллага тус бүр дараагийн Харилцан үнэлгээний үеэр өөрийн байгууллагыг төлөөлөн ажиллах хүнийг томилж, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах;
- Монгол Улсын харилцан үнэлгээний хуваарийг 12 сараар хойшлуулахыг дэмжиж, АНДМУТБ-т 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн дотор хариуг хүргүүлэх;

Гадаад хамтын ажиллагаа

Монгол Улс ФАТФ, АНДМУТБ, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Эгмонт бүлэг зэрэг олон улсын байгууллагуудаас зохион байгуулдаг сургалтад хамрагдах, бусад улс орнуудын тайлантай танилцаж, санал өгөх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой ирүүлсэн асуулга бөглөх, сайн туршлага, типологи, бодит жишээг хуваалцах, шаардлагатай бусад мэдээллийг хүргүүлэх зэргээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарал хандуулан ажиллалаа.

Тайлант онд СМА нь гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон холбогдох суурь гэмт хэргийн дүн шинжилгээний мэдээллийг солилцох цар хүрээг өргөжүүлэх зорилгоор 2025 онд Бутан Улсын Санхүүгийн мэдээллийн алба, Бүгд Найрамдах Мальта Улсын Санхүүгийн мэдээллийн дүн шинжилгээний алба болон Канад Улсын Санхүүгийн гүйлгээ, тайлангийн дүн шинжилгээний төвтэй Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ажлыг эхлүүллээ. Энэ хүрээнд СМА-аас дээрх улс орнуудын санхүүгийн мэдээллийн албадтай байгуулах санамж бичгийн төсөлд харилцан санал солилцож ажиллав. Улмаар 2025 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Бүгд Найрамдах Мальта Улсын Санхүүгийн мэдээллийн дүн шинжилгээний албатай “Мөнгө угаах, түүний суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн мэдээлэл солилцон хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулав. Бусад хоёр улстай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ажил үргэлжилж байна.

2025 оны 6 дугаар сард зохион байгуулагдсан ФАТФ-ын чуулга уулзалтад оролцсон бөгөөд уг чуулга уулзалтаар олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой гол асуудлуудын талаарх мэдээлэл авахын зэрэгцээ Монгол Улсын МУТСТ тогтолцоог олон улсын стандарттай нийцүүлэх, эрсдэлийг үнэлэх, хяналт, зохицуулалтын арга хэмжээг боловсронгуй болгох чиглэлээр туршлага судлах, санал солилцох

боломжийг олгосон юм. СМА нь ФАТФ-ын 2025 оны ээлжит чуулга уулзалтаас гарсан шийдвэрүүд, МУТСТ чиглэлээр өргөтгөсөн хяналтад орсон “саарал” жагсаалт, стратегийн ноцтой дутагдалтай, өндөр эрсдэлтэй “хар” жагсаалттай холбоотой өөрчлөлтүүдийг холбогдох эрх бүхий байгууллагуудад болон цахим хуудсаар дамжуулан тухай бүр мэдээлж, хүргүүлэн ажиллалаа.

2025 онд Улсын ерөнхий прокурорын газар, Терроризмтой тэмцэх зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар болон Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчид АНДМУТБ-ийн үнэлгээчин бэлтгэх сургалтад хамрагдлаа. Түүнчлэн СМА-ны ажилтан нь АНДМУТБ-ийн гишүүн Вьетнам Улсын 2025 оны 02 дугаар сарын Явцын тайланд үнэлгээчнээр ажилласан. Эдгээр үнэлгээчин, хянагчаар ажилласан бодит туршлага нь Монгол Улсын дараагийн харилцан үнэлгээний үед үндэсний тайланг олон улсын стандарт, арга зүйд нийцүүлэн бэлтгэх, үнэлгээний явцад үр дүнтэй хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Монгол Улс 2012 оны 5 дугаар сард Евро-Азийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлэгт ажиглагч улсын статустайгаар нэгдсэн билээ. Энэ хүрээнд тус бүлгийн гишүүн болон бусад ажиглагч улс орнуудтай МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх чиглэлээр мэдээлэл солилцоог идэвхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор уялдаа холбоотой, тогтвортой хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Тухайлбал, СМА нь гурав болон аравдугаар сард Монгол Улсын ажиглагчийн үйл ажиллагааны тайланг боловсруулж хүргүүлэв.

Эгмонт бүлгийн 30 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдсан 31 дэх удаагийн чуулга уулзалт нь Люксембург улсад 2025 оны 7 дугаар сарын 06-ны өдрөөс 11-ний өдөр “Эгмонт бүлэг 30 жилд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын зохицуулалтын ирээдүй” сэдвийн дор зохион байгуулагдаж, СМА-ны төлөөллүүд оролцов. Чуулга уулзалтад Эгмонт бүлэг, гишүүн санхүүгийн мэдээллийн албад, олон улсын түншлэгч байгууллагууд, ажиглагч улсуудын нийт 600 гаруй төлөөлөгч оролцож, олон улсын чиг хандлага, сайн туршлагаас хуваалцлаа.

Хяналт шалгалт

СМА нь хяналт шалгалтын зохицуулагч байгууллага болох Монголбанкны Хяналт шалгалтын газар, Санхүүгийн зохицуулах хороо болон мэргэжлийн холбоодтой хяналт шалгалтын статистик, мэдээлэл тогтмол солилцож хамтран ажилладаг. Энэ хүрээнд 2025 онд нийт мэдээлэх үүрэгтэй этгээд /МҮЭ/-д хийсэн хяналт шалгалт болон авсан арга хэмжээний нэгдсэн статистик мэдээллийг дараах Хүснэгт 3.1-д харуулав.

Хүснэгт 3.1 МУТСТ чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа /2023-2025/

Үзүүлэлт	2023	2024	2025
МУТСТ, ҮОХЗДСТ үйл ажиллагаанд хийсэн зайны хяналтын нийт тоо	8,392	5,611	7,463
МУТСТ, ҮОХЗДСТ үйл ажиллагаанд хийсэн зайны хяналтад хамрагдсан МҮЭ-ийн нийт тоо	9,102	6,219	7,463
МУТСТ, ҮОХЗДСТ үйл ажиллагаанд хийсэн газар дээрх хяналт шалгалтын нийт тоо	231	238	83
МУТСТ, ҮОХЗДСТ үйл ажиллагаанд хийсэн нийт газар дээрх хяналт шалгалтад хамрагдсан МҮЭ-ийн нийт тоо	231	242	83
Хяналт тавих эрх бүхий байгууллагаас МУТСТ, ҮОХЗДСТ чиглэлээр гаргасан дутагдлыг арилгах талаар хүргүүлсэн албан шаардлага, сануулга, хугацаат үүрэг даалгаврын нийт тоо	505	617	604
Хяналт тавих эрх бүхий байгууллагаас МУТСТ, ҮОХЗДСТ-тэй холбоотой асуудлаар тогтоосон акт, мэдэгдлийн нийт тоо	71	90	93
Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэсэн МҮЭ-ийн нийт тоо	19	5	19
Зөрчлийн тухай хуулийн дагуу авсан хөрөнгө, орлого хураах, торгох арга хэмжээний нийт тоо	154,500,000	70,000,000	288,500,000

Эх сурвалж: СМА

СМА нь Санхүүгийн зохицуулах хороотой хамтран 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 4 дүгээр сарын 08-ны өдрүүдэд 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, 2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс 4 дүгээр сарын 18-ны өдрүүдэд 52 банк бус санхүүгийн байгууллагад газар дээрх шалгалтыг тус тус хийлээ.

Газар дээрх хяналт шалгалтын явцад дотооддоо мөрдөж буй баримт материалтай танилцах, ярилцлага хийх, түүвэрлэн шалгах, архивын баримт бичгийн үзлэг хийх зэргээр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөв. Шалгалтын үр дүнд үндэслэн хяналт шалгалтад хамрагдсан нийт МҮЭ-д цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг багтаасан хяналт шалгалтын тайлан хүргүүлж, зөрчил гаргасан МҮЭ-үүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллалаа.

Монголын нотариатчидын танхим, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбооноос хуульч, өмгөөлөгч, нотариатч, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийн МУТСТ үйл ажиллагаанд хийж буй хяналт шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажилласан бөгөөд холбоод тус бүрийн хяналт шалгалтын төлөвлөгөө, зайн болон газар дээрх хяналт шалгалтын тайланд хагас жил тутам хяналт тавьж ажиллалаа.

Мэдээлэл хүлээн авах болон дүн шинжилгээ хийх

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь тус хуулийн 7 дугаар зүйлд заасан сэжигтэй гүйлгээний мэдээлэл болон 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ, гадаад төлбөр тооцооны гүйлгээ, виртуал хөрөнгийн гүйлгээний мэдээллийг тус тус СМА-наас д мэдээлэх үүрэг хүлээдэг. СМА-ны 2023-2025 онд хүлээн авсан мэдээллийг Хүснэгт 3.2-т харуулав.

Хүснэгт 3.2 СМА-нд мэдээлсэн гүйлгээний тоо /2023-2025 он/

	2023 он	2024 он	2025 он
Сэжигтэй гүйлгээний тоо	1,799	2,823	5,204
Бэлэн мөнгөний гүйлгээний тоо	315,103	328,667	516,483
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо	284,301	382,266	375,306
Виртуал хөрөнгийн гүйлгээний тоо	7,447	15,141	15,979

Эх сурвалж: СМА

Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгөний гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллагаас хүлээн авдаг (Хүснэгт 3.3).

Хүснэгт 3.3 Гаалийн мэдүүлгийн тоо /2023-2025 он/

	2023 он	2024 он	2025 он
Гаалийн мэдүүлгийн тоо	15,090	9,147	26,045

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

СМА нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.1.1-д заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд 2025 онд мэдээлэх үүрэгтэй этгээдээс нийт 5,204 Сэжигтэй гүйлгээний тайланд мэдээлсэн бөгөөд 2,775 сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийж, нийт 2,657 сэжигтэй гүйлгээг хууль сахиулах байгууллагууд руу шилжүүлсэн (Хүснэгт 3.4).


Хүснэгт 3.4 Мэдээлсэн сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийсэн сэжигтэй гүйлгээний тоо /2023-2025/

	2023	2024	2025	2025 оныг 2024 онтой харьцуулсан өөрчлөлт, хувиар
Хүлээн авсан СГТ-ийн тоо	1,799	2,823	5,204	84%-аар өссөн
Дүн шинжилгээ хийсэн СГТ-ийн тоо	795	680	2,775	308%-аар өссөн
ХСБ-д шилжүүлсэн СГТ-ийн тоо	765	654	2,657	306%-аар өссөн

Эх сурвалж: СМА


Мэдээлэл солилцох**А. Дотоодын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцож хамтарч ажилласан байдал**

СМА нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоодын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажилладаг бөгөөд 2025 онд дотоодын эрх бүхий хууль сахиулах байгууллагуудаас нийт 6,326 этгээдэд холбогдох 425 хүсэлтийг хүлээн авч, нийт 5,833 этгээдэд холбогдох 418 хүсэлтийн хариуг илгээсэн байна (Зураг 3.5).

Зураг 3.5 Дотоодын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцсон байдал /2022-2025 он/

Мөн тайлант хугацаанд хууль сахиулах байгууллагад 2,657 сэжигтэй гүйлгээг шилжүүлсэн бөгөөд энэ нь 2022-2024 оны дундажтай харьцуулахад 4.6 дахин өссөн үзүүлэлт юм.

Зураг 3.6 СМА-наас хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн сэжигтэй гүйлгээний тоо



Б. Гадаад улсын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцож, хамтарч ажилласан байдал

ФАТФ-ын Зөвлөмж 29, Зөвлөмж 40 болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу СМА нь гадаад улсын ижил төстэй чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагуудтай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэдээлэл солилцож хамтран ажилладаг бөгөөд энэ хүрээнд СМА нь 2025 онд дараах байдлаар мэдээлэл солилцон, хамтран ажиллав (Хүснэгт 3.5).

Хүснэгт 3.5 Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцсон байдал

Үзүүлэлт	2023	2024	2025
СМА-аас гадаадын СМА-д явуулсан хүсэлтийн тоо	223	82	220
Гадаадын СМА-д явуулсан хүсэлтийн дагуу ирүүлсэн хариуны тоо	167	116	102
Гадаадын СМА-аас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн тоо	13	33	54
Гадаадын СМА-аас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо	13	3	83
Гадаадын СМА-наас шилжүүлсэн мэдээллийн тоо	14	7	12

Эх сурвалж: СМА

Энэ онд СМА нь нийт 220 этгээдтэй холбоотой хүсэлтийг гадаад улсын СМА-нд хүргүүлсэн бөгөөд Бүгд Найрамдах Солонгос Улс, Сингапур болон Америкийн Нэгдсэн Улс гэх зэрэг улс руу хамгийн их хүсэлтийг хүргүүлсэн байна.

Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцон хамтран ажиллахаас гадна СМА нь 2025 онд шинээр Бүгд Найрамдах Мальта Улсын Санхүүгийн мэдээллийн албатай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан гадаад харилцааг өргөжүүлэн ажиллаж байна.

Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа болон чадавхыг бэхжүүлэх, нөөц бололцоог сайжруулах

СМА-ны ажилтнууд 2025 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дотоод болон гадаадын байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа бэхжүүлэх чиглэлээр анхаарч ажиллалаа. Энэ онд СМА-ны нийт ажилтанд зориулан дотооддоо мэдээлэл солилцон, мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр хамтран ажиллаж буй зарим төрийн эрх бүхий байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд үзүүлдэг хүчин чармайлтын талаар мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан нь хоёр байгууллага хоорондын хамтын ажиллагаанд эергээр нөлөөлөх, солилцож буй мэдээллийн чанарыг сайжруулахад чухал нөлөө үзүүлсэн ажил боллоо.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй төрийн байгууллагууд, мэдээлэл үүрэгтэй этгээдүүдэд зориулсан сургалт, семинарыг СМА тогтмол зохион байгуулдаг. Тайлант

онд СМА нь дангаараа болон бусад байгууллагуудтай хамтран нийт 12 сургалт зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 1012 төлөөллийг хамруулав. Мөн СМА нь Монголбанк, Монголын банкны холбоо, Хаан банктай хамтран 2025 оны 11 дүгээр сарын 27-оос 28-ны өдрүүдэд “МУТСТ Комплаенс-Цахим шилжилт” сэдэвт форум зохион байгуулж, уг арга хэмжээнд Засгийн газар, ҮЗ, ХАЗ-ийн байгууллагууд, банк, санхүүгийн салбарын удирдах түвшний төлөөлөл өргөнөөр оролцлоо.

ХАЗ-ийн дэргэдэх Судалгаа, дүн шинжилгээний ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд СМА-аас оюутнуудын дунд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр “Эрдэм шинжилгээний бага хурал”-ыг дөрөв дэх жилдээ зохион байгууллаа. Тус хурал нь өмнөх жилүүдтэй харьцуулахад судалгааны сэдвийн хүрээг өргөжүүлж, цахим гэмт хэрэг, мөнгө угаах типологийн чиг хандлага, шинэ техник, технологи, санхүүгийн инновац, шинэ төрлийн санхүүгийн хэрэгслүүдэд онцгойлон анхаарав. Энэ удаагийн эрдэм шинжилгээний бага хурлыг анх удаа танхим болон цахим хэлбэрийг хослуулан зохион байгуулж, Монгол Улсын их, дээд сургуулийн оюутнуудаас гадна ОХУ, АНУ-ын оюутнууд оролцож, судалгааны илтгэлээ танилцуулсан нь хамрах хүрээ өргөжиж байгаагийн илрэл юм.

3.6 ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭНГИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн нь эдийн засгийн бодлогын шийдвэрт дэмжлэг үзүүлэх судалгаа, шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх, төв банк болон санхүүгийн салбарын мэргэжилтнд зориулан дунд болон ахисан түвшний сургалт зохион байгуулах, эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд суурь инфляцыг тооцдог аргачлалуудыг харьцуулах зорилгоор “*Суурь инфляцыг эконометрикийн аргаар тооцох нь*”, мөнгөний бодлогын төлөв, тэнцвэрт хүүг тодорхойлох зорилгоор “*Жижиг нээлттэй эдийн засаг дахь нейтраль хүүг тодорхойлох нь*”, үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын ач холбогдол, түүнийг хэрэгжүүлэх санал, дүгнэлтийг боловсруулах зорилгоор “*Үндэсний баялгийн сан: Олон улсын туршилага*” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн стратегийн гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн зах зээлийн шинжилгээ, ирээдүйн үнийн болон эрэлт, нийлүүлэлтийн шинжилгээг хийж гүйцэтгэх зорилгоор гурил, улаан буудай, мах махан бүтээгдэхүүн, ноос, ноолуурын зах зээлийн судалгаа хийв. Мөн макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон эрсдэлийн түвшинг үнэлэх зорилгоор “Монгол Улсын эдийн засгийн гүйцэтгэлийн индекс”, “Монгол Улсын эмзэг байдлын индекс”-ийг 2015 – 2025 оноор тооцлоо.

Түүвэр судалгаа хийх хүрээнд 2025 онд “*Монгол Улсын өрхийн хэрэглээ, санхүүгийн байдлын түүвэр судалгаа*” болон “*Банкнудын эх үүсвэрийн төлөвийн түүвэр судалгаа*”-г хийж гүйцэтгэв. Тухайлбал, “Монгол Улсын өрхийн хэрэглээ, санхүүгийн байдлын түүвэр судалгаа”-ны өгөгдөл, мэдээлэл цуглуулах ажлыг 2025 оны 6 дугаар сарын 16-наас 8 дугаар сарын 16-ны хооронд улс орон даяар зохион байгуулж, нийт 2,557 өрхийг хамрууллаа. Тус судалгаагаар өрхийн орлого, зардал, хөрөнгө, өр төлбөр болон санхүүгийн эмзэг байдлын үзүүлэлт, ажилгүйдлийн шалтгаан, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийг цогцоор тусгахыг зорьсон бөгөөд түүвэр судалгааны үр дүнд үндэслэн холбогдох санал, зөвлөмжийг боловсруулсан болно.

“*Банкнудын эх үүсвэрийн төлөвийн түүвэр судалгаа*”-г Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 11 арилжааны банкыг хамруулан 2025 оны II болон IV улиралд тус тус зохион байгууллаа. Тус судалгаагаар банкнудын нийт эх үүсвэрийн бүтэц, иргэд болон аж ахуйн нэгжийн харилцах, хадгаламж, Засгийн газрын болон гадаад эх үүсвэр, мөн бусад банк, санхүүгийн байгууллага, мөнгөний зах зээлээс татсан эх үүсвэрүүдийн өнөөгийн болон цаашдын төлөвт дүн шинжилгээ хийж, тэдгээрийн өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлов. Мөн Германы Бундесбанктай (Deutsche Bundesbank) хамтран

“Enhancing Central Bank Surveys” сэдэвт онлайн семинарт оролцож төв банкны түүвэр судалгааны арга зүй, түүврийн дизайн, өгөгдөл цуглуулах арга болон дүн шинжилгээний явцад тулгарч буй сорилт, шийдвэрлэх арга замын талаар харилцан туршлага солилцов.

Сургалтын чиг үүргийн хүрээнд төв банкны ажилтнуудын ур чадвар, мэдлэгийг сайжруулах зорилгоор 80 гаруй хянан шалгагч нарт зориулан “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” сэдэвт сургалт, 45 гаруй эдийн засагчдад зориулан “Санхүүгийн машин” сэдэвт 10 цуврал сургалт зохион байгууллаа.

Түүнчлэн банк, санхүүгийн салбарын мэргэжилтнийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 12 арилжааны банкны 1,040 гаруй ажилтныг хамарсан “Банкны ажилтны семинар”-ыг 16 сэдвийн хүрээнд 2025 оны 4 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд зохион байгуулсан болно.

Монголбанкны нийт ажилтнад зориулсан “Тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар туршлага солилцох нь” сэдэвт чөлөөт ярилцлага, эдийн засаг, банк, санхүүгийн салбарын бодлого, тодорхойлогчид, эрдэмтэн, судлаачдад зориулсан “Судлаачдын хэлэлцүүлэг”-ийг явууллаа. Мөн эдийн засгийн судалгааны ач холбогдол, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор эдийн засаг, санхүүгийн банк санхүүгийн чиглэлээр суралцдаг оюутнуудын дунд “Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаан”-ыг 2025 оны 5 дугаар сард 2 шаттайгаар зохион байгуулсан болно. Тус бүтээлийн уралдаанд макро эдийн засаг, мөнгөний бодлого, финтек болон төсвийн ил тод байдал зэрэг чиглэлээр нийт 86 оролцогчийн 29 судалгааны бүтээл хүлээн авсан ба шилдэг 10 бүтээлийг шалгаруулан 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцүүлсэн.

Эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах ажлын хүрээнд 2025 онд эдийн засгийн онол, практикийн дунд гүүр бий болгох, академик болон бодлогын харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх, судалгааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээ, эдийн засгийн нөхцөл байдлыг олон нийтэд түгээх зорилгоор олон улсын стандартад нийцсэн эдийн засгийн эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах бэлтгэл ажлыг бүрэн хийж гүйцэтгэлээ. Тухайлбал, эрдэм шинжилгээний сэтгүүлийн ерөнхий агуулга, бүтэц, загвар, сэтгүүлд ирүүлэх бүтээлүүдэд тавигдах ерөнхий стандарт, сэтгүүл эрхлэн гаргах тухай танилцуулга, төсвийг боловсруулсан болно.

3.7 ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

Монголбанк нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, зээлийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах, санхүүгийн зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, зээлийн мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зээлийн мэдээллийн сан нь банк, банк бус санхүүгийн байгууллага болон зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг төвлөрүүлэн боловсруулах замаар санхүүгийн байгууллагуудын зээлийн шийдвэр гаргалт, эрсдэлийн үнэлгээнд чухал дэмжлэг үзүүлдэг санхүүгийн дэд бүтэц юм. Энэхүү тогтолцоо нь зээлдэгчийн зээл, төлбөрийн мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэх боломжийг бүрдүүлж, мэдээллийн зөрүүг бууруулах, давхар зээлийг хязгаарлах замаар санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл”-д үндэсний төлбөрийн систем болон зээлийн мэдээллийн шинэ үйлчилгээг дэмжих, санхүүгийн зах зээлийн хөгжилтэй уялдсан хяналт, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх зорилтыг тусгасан.

Энэхүү бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкнаас зээлийн мэдээллийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зээлийн мэдээллийн системийн технологийн шийдлийг шинэчлэх, мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах, олон улсын жишигт нийцсэн зээлийн оноонд суурилсан үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

Зээлийн мэдээллийн зохицуулалтыг боловсронгуй болгох

УИХ-аас 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох онооны аргачлал, зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд таван жилээр тусгах хугацааны нөхцөл, шаардлагыг боловсруулан батлахыг Монголбанканд даалгасан.

Энэ хүрээнд Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийн мөрдөх зээлийн онооны загвар, оноо тооцоолох аргачлалыг боловсруулахад баримтлах “Зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох нөхцөл, шаардлага”-ын эрх зүйн баримт бичгийг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу олон нийт болон санхүүгийн салбарын оролцогчдоос санал авах ажиллагааг зохион байгуулан баримт бичгийг баталсан.

Уг баримт бичгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталж, захиргааны хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр хүргүүлсэн бөгөөд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр мөрдөгдөх нөхцөл бүрдэнэ.

Энэхүү зохицуулалт хэрэгжсэнээр зээлдэгчийн зээлжих чадварыг үнэлэх үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн зээлийн оноонд суурилсан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж, зээлийн эрсдэлийг илүү нарийвчлалтай үнэлэх, санхүүгийн байгууллагуудын зээлийн шийдвэр гаргалтын чанарыг сайжруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Мөн зээлийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор иргэн, хуулийн этгээдийн зээлийн ангиллын мэдээллийг зээлийн мэдээллийн лавлагаанд тусгахгүй байх шийдвэрийг гаргаж, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн.

Энэ хүрээнд Монголбанк болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтран E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн портал дахь зээлийн мэдээллийн үйлчилгээний тохиргоог 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр шинэчлэн тохируулсан.

Мөн зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий “Титан Си Ар Эй Зээлийн мэдээллийн сан” ХХК болон “Бүрэн Скор ЗМС” ХХК нь 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн иргэн, хуулийн этгээдийн зээлийн мэдээллийн лавлагаанд зээлийн ангиллын мэдээллийг тусгахгүй байхаар өөрчлөлт хийж, харин зээлийн хугацаа хэтрэлтийн мэдээллийг хураангуй хэлбэрээр харуулдаг болгон шинэчилсэн.

Энэхүү зохицуулалтын өөрчлөлт нь зээлийн мэдээллийн ашиглалтыг илүү бодит эрсдэлийн мэдээлэлд тулгуурлуулах, зээлдэгчийн мэдээллийг буруу ойлгогдохоос сэргийлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, цаашид зээлийн оноонд суурилсан үнэлгээний тогтолцоонд шилжих нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хяналт шалгалт, зохицуулалтын үйл ажиллагаа

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зээлийн мэдээллийн сангийн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг баталгаажуулах зорилгоор мэдээлэл нийлүүлэгч байгууллагууд болон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдийн үйл ажиллагаанд газар дээрх болон зайны хяналт

шалгалтыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

2025 оны байдлаар зээлийн мэдээллийн санд нийт 664 байгууллага мэдээлэл нийлүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд үүнд арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгч, даатгал болон үнэт цаасны зах зээлийн оролцогч байгууллагууд, төрийн байгууллагууд хамрагдаж байна.

Мөн зээлийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудад иж бүрэн шалгалт хийж, мэдээлэл нийлүүлэгч санхүүгийн байгууллагуудад хэсэгчилсэн шалгалт зохион байгуулан илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр зөвлөмж, үүрэг даалгавар хүргүүлэн ажилласан.

Системийн хөгжил, технологийн шинэчлэл

Санхүүгийн технологийн хурдацтай хөгжил, цахим зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өсөлттэй уялдан зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл боловсруулах хүчин чадал, мэдээлэл солилцооны үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх шаардлага нэмэгдэж байна.

Энэ хүрээнд зээлийн мэдээлэл нийлүүлэх дата протоколыг XML технологиос JSON технологид суурилсан шинэ формат руу шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх хүрээнд “Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх протокол”-ыг шинэчлэн баталсан.

Шинэчилсэн протоколыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд хоёр сая гаруй зээлдэгчийн бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулган баталгаажуулах, банк бус санхүүгийн байгууллагуудаас нийлүүлсэн өгөгдөлд хяналт шалгалт хийж 13 мянга гаруй зээлийн давхардлыг илрүүлэн системээс хасах, арилжааны банкнуудын зээлийн мэдээллийг шинэ формат руу хөрвүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн.

JSON формат нь өгөгдөл дамжуулах хурдыг нэмэгдүүлэх, мэдээллийн төрөл, бүтэц, уян хатан байдлыг сайжруулах, системийн ачааллыг бууруулах зэрэг технологийн давуу талтай бөгөөд санхүүгийн байгууллагуудын мэдээлэл солилцоог илүү үр ашигтай болгох нөхцөлийг бүрдүүлж байна.

Зээлийн мэдээллийн сангийн хамрах хүрээ, цаашдын чиглэл

Зээлийн мэдээллийн санд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудаас давхардсан тоогоор 2,428,495 иргэний 5,139,048 ширхэг зээлийн мэдээлэл, 20,149 аж ахуйн нэгжийн 39,397 ширхэг зээлийн мэдээлэл нийлүүлэгдсэн байна.

2024 оны жилийн эцсийн байдалтай харьцуулахад иргэдийн тоо 260,946-аар өсөж, зээлийн мэдээллийн тоо ойролцоогоор 858.4 мянгаар нэмэгдсэн байна. Мөн аж ахуйн нэгжийн тоо 1,725-аар, аж ахуйн нэгжийн зээлийн мэдээллийн тоо 3,242-оор тус тус өссөн байна.

Энэхүү өсөлт нь санхүүгийн байгууллагуудын зээлийн мэдээлэл нийлүүлэх хамрах хүрээ өргөжиж, зээлийн мэдээллийн сангийн ашиглалт нэмэгдэн, зээлийн мэдээллийн бүртгэл илүү бүрэн, нарийвчлалтай болж байгааг илтгэж байна. Улмаар зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл нь санхүүгийн байгууллагуудын зээлийн шийдвэр гаргалт, эрсдэлийн үнэлгээнд ашиглагдах мэдээллийн хамрах хүрээг өргөжүүлж, санхүүгийн салбарын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагын чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой байна.

Цаашид Монголбанкнаас зээлийн мэдээллийн сангийн мэдээллийн чанар, хамрах хүрээг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцооны технологийн шийдлийг боловсронгуй болгох, зээлийн мэдээллийн стандарт болон хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.8 БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ

Монголбанк банк, санхүүгийн салбарын эрх зүйн орчныг үе шаттайгаар шинэчлэх бодлогын санаачилгыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон Улсын Их Хурлын холбогдох шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтыг хангах, санхүүгийн зах зээлийн үр ашиг, ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр цогц шинэчлэлийг санаачлан ажиллаж байна.

Энэхүү шинэчлэл нь олон улсын сайн туршлага, жишиг, олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмжийг харгалзан боловсруулж Монгол Улсын санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой, хариуцлагатай хөгжлийг хангах институцийн суурийг бэхжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд 2025 онд Монголбанк энэ чиглэлээр хэд хэдэн голлох хуулийн төслийг боловсруулан, санаачлуулаад байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зээлийн мэдээллийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, мэдээллийн чанар, хамрах хүрээг өргөжүүлэх, зээлжих чадварыг үнэлэх орчин үеийн аргачлалыг нэвтрүүлэх зорилгоор боловсруулав. Төслийн хүрээнд зээлдэгчийн зээлийн түүх, эргэн төлөлтийн сахилга батад үндэслэсэн кредит скорингийн тогтолцоог хуульчлах, зээлийн мэдээллийн ил тод, шуурхай солилцооны эрх зүйн үндсийг тодорхой болгох, мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээллийн хамгаалалтыг бэхжүүлэх, зээлийн эрсдэлийг бодитой үнэлэх замаар зээлийн хүүг эрсдэлд суурилан тогтоох орчныг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан. Энэхүү шинэчлэлийн үр дүнд эрсдэл багатай зээлдэгчийн зээлийн өртөг буурч, зээлийн зах зээлийн сахилга бат, ил тод байдал нэмэгдэн, зээлийн чанар сайжирч, санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэхээр байна.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монголбанкны үндсэн зорилтыг үнийн тогтвортой байдал болгон тодорхой болгож, инфляцын зорилтот бодлогын эрх зүйн үндсийг баталгаажуулах, мөнгөний бодлогын зорилтыг дунд хугацаагаар тодорхойлох, макро зохистой бодлогын хэрэгслийг тодорхойлон санхүүгийн системийн эрсдэлийг урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төв банкны засаглал, хариуцлагын тогтолцоог олон улсын сайн туршлагад нийцүүлэх агуулгатайгаар боловсруулагдсан. Энэхүү шинэчлэл нь инфляцын хүлээлтийг тогтворжуулах, мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах, төв банкны институцийн бие даасан, хараат бус байдал, хариуцлагын тэнцвэрийг хангах, санхүүгийн системийн тогтвортой байдлыг дэмжих стратегийн ач холбогдолтой юм.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг үе шаттай бууруулах, өмчлөлийн бүтцийг ил тод, тогтвортой болгох, урт хугацааны хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор боловсруулсан. Төсөлд томоохон хувьцаа эзэмшигчийн хязгаарыг оновчтой тогтоох, олон улсын санхүүгийн болон хөгжлийн байгууллагын хөрөнгө оруулалтыг дэмжих, холбогдох этгээдийн тодорхойлолтыг бодит хэрэгжилтэд нийцүүлэх, банкны засаглал, эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх зохицуулалтыг тусгасан. Үүний үр дүнд банкны салбарын өмчлөлийн бүтэц ил тод, тогтвортой болж, дотоод, гадаадын урт хугацааны хөрөнгө оруулалт нэмэгдэн, системийн эрсдэл буурах нөхцөл бүрдэхээр байна.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай анхдагч хуулийн төслийг санхүүгийн үйлчилгээний хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжих, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулсан. Төсөлд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгайлсан хяналт, шалгалтын тогтолцоог бий болгох, маргаан шийдвэрлэх, гомдол барагдуулах ил тод, шуурхай механизмыг бүрдүүлэх, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх бодлогын суурийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан. Энэ нь санхүүгийн салбарт хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлж, зах зээлийн сахилга бат, хүртээмжийг сайжруулахад чиглэнэ.

УИХ-ын 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 79 дүгээр тогтоолын хүрээнд зээлийн хүүгийн бүтэц, эх үүсвэрийн өртгийн нөлөөлөл, зээлийн мэдээллийн ил тод байдал, гадаадын банкны салбар байгуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, бодлогын санал боловсруулан хэрэгжилтийн тайланг УИХ-д хүргүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд банкны эх үүсвэрийн өртөг, хадгаламжийн хүүний нөлөөллийг бууруулах боломж, эрсдэл багатай зээлдэгчийн зээлийн хүүгийн мэдээллийг ил тод болгох зохицуулалт, гадаадын банкны салбар байгуулах шалгуур, нөхцөлийг олон улсын стандарттай нийцүүлэх, барьцаа хөрөнгийн үнэлгээг зээлжих чадвартай уялдуулах асуудлыг судлав. Үүний үр дүнд зээлийн хүүгийн бүтэц ил тод, өрсөлдөөнт болж, санхүүгийн зуучлалын үр ашиг нэмэгдэн, зах зээлийн өрсөлдөөн сайжрах, санхүүгийн системийн тогтвортой байдал бэхжих нөхцөл бүрдэхээр байна.

Ийнхүү банк, санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэчлэл нь Монголбанкны үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилт, санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах чиг үүрэгтэй нягт уялдаж, зах зээлийн сахилга бат, ил тод байдал, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар Монгол Улсын макро эдийн засгийн тогтвортой хөгжил, санхүүгийн салбарын урт хугацааны тогтвортой байдлын суурь нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна.

**МОНГОЛБАНКНААС 2025 ОНД БАТАЛСАН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ
АКТЫН ХУРААНГУЙ**

Д/д	Эрх зүйн баримт бичгийн нэр	Огноо	Дугаар	Тайлбар
1.	Их дүнтэй төлбөрийн системийн дүрэм	2025.10.29	А-229	Энэхүү дүрмээр үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих, шинээр төлбөрийн систем гаргах, төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд болон операторын зохистой засаглал, удирдлага, үйл ажиллагаа, хэрэглэгчтэй холбогдох харилцаа, систем хоорондын хамаарлыг зохицуулахад шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Их дүнтэй төлбөрийн систем буюу “Банксүлжээ систем”-ээр төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой хийгдэх үйл ажиллагаа, оролцогчийн үүрэг хариуцлагыг тодорхойлох, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулна.
2.	Банкны хадгаламжийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөлийг тогтоох журам	2025.11.18	А-263	Энэхүү журмаар Монголбанкнаас хадгаламжийн үйл ажиллагааны зөвшөөрөл авсан банкны эрхлэх мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг нөхцөл, шаардлагыг тодорхойлох, банкны мөнгөн хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээл дээр арилжих, төлбөр тооцоог гүйцэтгэхэд хуульд тусгайлан зааснаас бусад мөнгөн хадгаламжтай холбоотой харилцааг зохицуулна.

3.	Харилцан ойлголцлын үлгэрчилсэн загвар санамж бичиг батлах тухай	2025.12.12	А-300	Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгын хүрээнд гадаадын банкны харьяа улсын хянан шалгах эрх бүхий байгууллагатай хийх харилцан ойлголцлын санамж бичигт хоёр улсын хянан шалгах эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг, хяналт шалгалтын хамрах хүрээ, мэдээлэл солилцох байдал, нууцлалын бодлого зэргийг хос хяналт шалгалтын зарчимд үндэслэн тодорхойлж, цаашид аливаа улсын хянан шалгах байгууллагатай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахад зохицуулагч байгууллагаас тавих доод шаардлага болгон ашиглах зорилгоор энэхүү харилцан ойлголцлын үлгэрчилсэн загвар санамж бичгийг баталсан.
4.	Монголбанкны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт	2025.12.16	А-310	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад тусгагдсан мэдээллийг нууцад хамааруулсан үндэслэл, хэрэгцээ шаардлага, хуульд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд судалгаа хийж, шинэчлэн баталсан.

МОНГОЛБАНК

**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БА
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

2025 ОНЫ 12 САРЫН 31

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

АГУУЛГА

ЗАХИРЛУУДЫН зөвлөлийн хариуцлагын талаарх мэдэгдэл хараат бус аудиторын тайлан

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

Санхүүгийн байдлын тайлан	1
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	2
Өмчийн өөрчлөлтийн тайлан	3
Мөнгөн гүйлгээний тайлан	4
1 Танилцуулга	6
2 Банкны үйл ажиллагааны орчин	7
3 Тайлан бэлтгэх үндэслэл	7
4 Нягтлан бодох бүртгэлд ашигласан ач холбогдол бүхий тооцоолол ба үндэслэл	10
5 Шинэ болон өөрчлөлт орсон стандартуудын тайлбар, хэрэгжилт	17
6 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдэл	17
7 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	18
8 Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	19
9 Дотоодын банкуудад олгосон зээл	23
10 Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	31
11 Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	40
12 Урвуу буцаан худалдан авах хэлцэл	40
13 Мөнгөжсөн алт, үнэт метал	44
14 Эрдэнэсийн сан	45
15 Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	46
16 Засгийн газрын үнэт цаас	47
17 Засгийн газраас авах авлага	49
18 Бусад хөрөнгө	50
19 Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө	55
20 Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	57
21 Төв банкны үнэт цаас	58
22 Засгийн газрын хөрөнгө	58
23 Дотоодын банкуудын хөрөнгө	60
24 Гадаад өр төлбөр	61
25 Бусад өр төлбөр	62
26 Дүрмийн сан болон бусад нөөц сан	63
27 Хүүгийн орлого ба зардал	66
28 Алт, үнэт металын арилжааны олз	67
29 Үйл ажиллагааны бусад орлого	67
30 Захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал	68
31 Санхүүжилтийн үйл ажиллагаатай холбоотой өр төлбөрийн хөдөлгөөн	69
32 Болзошгүй өр төлбөр ба үүрэг	70
33 Холбоотой талуудын ажил гүйлгээ	72
34 Санхүүгийн эрсдэлийн удирдлага	75
35 Бодит үнэ цэнийн тодруулга	96
36 Санхүүгийн хэрэгслийн хэмжилтийн ангиллаарх тодруулга	106
37 Капитал хөрөнгийн удирдлага	107
38 Тайлангийн дараах үйл явдал	108

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Монголбанк (цаашид "Банк")-ны санхүүгийн тайлангуудыг бэлтгэн гаргах нь Монголбанкны Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.

Банкны санхүүгийн тайлангуудыг НББОУСЗ-өөс батлан гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандарт")-ын дагуу бэлтгэн гаргасан. Банкны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг эдгээр санхүүгийн тайлангуудад бодитойгоор илэрхийлэгдсэнийг Захирлуудын зөвлөл баталгаажуулах үүрэгтэй.

Банкны санхүүгийн байдлыг бодитойгоор илэрхийлэх, нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлөхийг Захирлуудын зөвлөл хангах үүрэгтэй бөгөөд энэхүү бүртгэл нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн бодлогод нийцүүлэн бэлтгэснийг баталгаажуулна.

Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг өөрийн эрх мэдлийн хүрээнд авч хэрэгжүүлэх нь Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг болно.

Захирлуудын зөвлөл нь 1-ээс 108 дугаар хуудсанд тусгасан санхүүгийн тайлангууд ба түүний тодруулгуудыг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг тууштай баримталж, үндэслэлтэй бөгөөд оновчтой үнэлэлт, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж үзэж байна.

Захирлуудын зөвлөлийг төлөөлөн гарын үсэг зурсан:



С.Наранцогт
Монголбанкны Ерөнхийлөгч



Хараат бус Аудиторын Тайлан

Монголбанкны Захирлуудын Зөвлөлд

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь Монголбанк ("Банк" гэх)-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Банкны санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Банкны санхүүгийн тайлангууд нь дараах хэсгүүдээс бүрдсэн. Үүнд:

- 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд болон бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан санхүүгийн тайлангуудын тодруулгууд.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэж байна.

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Монгол Улс, Улаанбаатар хот
14200, Сүхбаатар дүүрэг-8, Сүхбаатарын талбай, Сантрал Тауэр,
6 давхарт 601 тоот, Утас: +976 70009089

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Хараат бус байдал

Олон нийтийн ашиг сонирхлын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад хамааралтай Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат бус байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (НБЁЗОУСЗ-ийн Дүрэм)-ийн дагуу Банкнаас бид хараат бус болно. Бид НБЁЗОУСЗ-ийн дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Энэхүү аудиторын тайланг гарсан өдрөөс хойш бид хүлээн авахаар хүлээгдэж буй бусад мэдээлэл гэдэгт 2025 оны Банкны жилийн тайлан (үүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан хамаарахгүй болно) орно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбоотойгоор бидний хүлээх үүрэг хариуцлага нь дээр дурдсан бусад мэдээллийг уншиж танилцах бөгөөд ингэхдээ бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг зөрүүтэй эсвэл ямар нэг байдлаар материаллаг буруу илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж үзэх юм. 2025 оны Жилийн тайланг уншиж танилцах үед хэрэв бид энэхүү бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл засаглах эрх бүхий этгээдэд энэ талаар тайлагнах үүрэгтэй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Банк үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвартай эсэхийг үнэлэх, шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхтэй холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулах, Банкны татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй болсноос бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах, мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаа гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл бүрийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба эдгээр нь тус бүртгээ эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхүйц байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх явцдаа бид мэргэжлийн үнэлэмжүүдийг гаргадаг ба аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас ханддаг. Мөн бид:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэл байх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон эрх мэдлээ ашиглан дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдийг агуулсан байдаг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр нөлөөг дүгнэх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцоолуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой мөрдсөн эсэх, мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн, үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх Банкны чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэсэн үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэдэг. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулгыг хангалтгүй гэж үзвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлага гардаг. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоондоо үндэслэн бид дүгнэлт өгдөг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Банк тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болоход хүргэж болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага
(үргэлжлэл)**

- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг үнэлдэг ба холбогдох ажил гүйлгээ болон үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид төлөвлөсөн аудитын ажлын хамрах хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдол болон бусад асуудлуудыг багтаагаад аудитын томоохон илрүүлэлтийн талаар засаглах эрх бүхий этгээдтэй харилцдаг.

Гарын үсэг зурсан:


Давдаагийн Баярмаа
Гүйдэтгэх захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК
PRICEWATERHOUSECOOPERS AUDIT LLC

Баталсан:



Айгуль Ахметова

Партнер

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот
2026 оны 3 сарын 31-ний өдөр

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК

Санхүүгийн Байдлын Тайлан

Сая тэгрэгээр	Тодруулга	2025 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2024 оны 1 сарын 1 (дахин тайлагнасан)
ХӨРӨНГӨ				
	7	395,506	95,661	309,414
Бэлэн мөнгө				
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	8	9,686,207	6,546,326	7,168,909
Дотоодын банкуудад олгосон зээл	9	179,323	1,421,867	1,662,975
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	10	9,410,889	8,373,945	7,525,303
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	11	6,533	6,533	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	12	10,070,627	8,261,033	4,955,616
Алт ба үнэт металл	3,13	4,432,018	2,403,179	2,077,528
Эрдэнэсийн сан	3,14	61,143	59,051	46,382
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	15	259,852	140,720	126,364
Засгийн газрын үнэт цаас	16	54,633	55,720	42,100
Засгийн газраас авах авлага	17	403,306	477,537	514,942
Бусад хөрөнгө	18	27,289	30,342	58,111
Үндсэн ба биет бус хөрөнгө	19	132,519	133,673	135,404
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		35,017	36,289	29,052
НИЙТ ХӨРӨНГӨ		35,154,862	28,041,876	24,558,633
ӨР ТӨЛБӨР				
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	20	1,244,350	1,222,179	1,151,700
Төв банкны үнэт цаас	21	10,973,332	11,511,780	8,745,075
Засгийн газрын хөрөнгө	22	6,402,201	6,843,279	4,597,302
Дотоод банкуудын хөрөнгө	23	16,537,777	10,704,582	9,526,237
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	15	398,576	227,933	531,770
Гадаад өр төлбөр	24	3,669,062	3,378,085	5,659,491
Бусад өр төлбөр	25	734,338	109,096	600,653
НИЙТ ӨР ТӨЛБӨР		39,959,636	33,996,934	30,812,228
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ				
Дүрмийн сан	26	60,000	60,000	60,000
Хуримтлагдсан алдагдал	26	(6,839,698)	(7,472,493)	(7,429,287)
Бусад нөөц	26	1,974,924	1,457,435	1,115,692
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		(4,804,774)	(5,955,058)	(6,253,595)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		35,154,862	28,041,876	24,558,633

Захирлуудын зөвлөлийг төлөөлж 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр нийтлэхийг зөвшөөрч гарын үсэг зурав.



Б.Батбаяр
Санхүү, Удирдлагын Газрын Захирал

МОНГОЛБАНК

АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

Сая төгрөгөөр	Тодруулга	2025	2024
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	27	756,067	908,268
Бусад адилтгах орлого	27	841	3,600
Хүүгийн зардал	27	(1,476,446)	(1,496,745)
Хүүгийн цэвэр зардал		(719,538)	(584,877)
Эрсдэлийн алдагдлын сан/Эрсдэлийн алдагдалын сангийн буцаалт		(122,535)	83,274
Эрсдэлийн алдагдлын сангийн зардлын дараах хүүгийн цэвэр зардал		(842,073)	(501,603)
Алт ба үнэт металын арилжааны олз	28	1,009,946	336,647
Алт ба үнэт металын ханшийн тэгшитгэлийн олз		738,120	162,373
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний олз		351,999	237,809
Гадаад валютын арилжааны олз/(гарз)		191,439	(48,290)
Засгийн газраас авах авлагын үнэ цэнийн бууралтын гарз	17	(74,231)	(37,405)
Гадаад валютын ханш хөрвүүлэлтийн (гарз)/ олз		(235,044)	187,094
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх өрийн хэрэгслийг борлуулах үеийн гарз		(553)	(39)
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын арилжааны олз		770	5
Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн олз		5,322	12,871
Үйл ажиллагааны бусад орлого	29	108,391	73,233
Захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал	30	(118,218)	(116,440)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ		1,135,868	306,255
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал):			
Ашиг, алдагдалд дахин ангилгдаж болзошгүй зүйлс:			
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх өрийн хэрэгсэл:			
- Тайлант жилийн олз/(гарз)	26	13,863	(7,757)
- Борлуулах үед ашиг, алдагдалд дахин ангилсан гарз	26	553	39
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)		14,416	(7,718)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		1,150,284	298,537

МОНГОЛБАНК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Сая төгрөгөөр	Тодруулга	Дүрмийн сан	Бусад нөөц	Хуримтлагдсан алдагдал	Нийт өөрийн хөрөнгө
2024 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл (өмнө нь тайлагнасан)	26	60,000	2,177,456	(7,429,287)	(5,191,831)
Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний буцаалт	3	-	(1,061,764)	-	(1,061,764)
2024 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл (дахин тайлагнасан)		60,000	1,115,692	(7,429,287)	(6,253,595)
Тайлант жилийн орлого		-	-	306,255	306,255
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	(7,718)	-	(7,718)
2024 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	(7,718)	306,255	298,537
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сангаас хуримтлагдсан алдагдал руу шилжүүлсэн	26	-	(8)	8	-
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөц рүү шилжүүлсэн	26	-	349,469	(349,469)	-
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл (өмнө нь тайлагнасан)		60,000	2,519,199	(7,472,493)	(4,893,294)
Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний буцаалт		-	(1,061,764)	-	(1,061,764)
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл (дахин тайлагнасан)	26	60,000	1,457,435	(7,472,493)	(5,955,058)
Тайлант жилийн орлого		-	-	1,135,868	1,135,868
Бусад дэлгэрэнгүй орлого		-	14,416	-	14,416
2025 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	14,416	1,135,868	1,150,284
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сангаас хуримтлагдсан алдагдал руу шилжүүлсэн	26	-	(3)	3	-
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөц рүү шилжүүлсэн	26	-	503,076	(503,076)	-
2025 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	26	60,000	1,974,924	(6,839,698)	(4,804,774)

Банк нь 2025 онд Эрдэнэсийн Сангийн хэмжилтэд өөрчлөлт оруулж, дахин үнэлгээний загвараас өртгийн загвар луу шилжсэн. Улмаар, Эрдэнэсийн Сангийн дахин үнэлгээний нэмэгдэлийг буцаан, санхүүгийн тайланд дахин тайлагнасан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 3-аас харна уу.

Хуримтлагдсан алдагдлаас 2025 болон 2024 онд бусад нөөцөд шилжүүлсэн дүн нь мөнгөжсөн алт, үнэт металл болон гадаад валютын хөрвүүлэлтийн олзтой холбоотой. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 26-аас харна уу.

2025 онд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сангаас хуримтлагдсан алдагдал руу шилжүүлсэн дүн нь үл хөдлөх хөрөнгийг борлуулсантай холбоотой. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 26-аас харна уу.

МОНГОЛБАНК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Сая төгрөгөөр	Тодруулга	2025	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн ашиг		1,135,868	306,255
Тохируулгууд:			
Эрсдэлийн алдагдлын сан/Эрсдэлийн алдагдалын сангийн буцаалт		122,535	(83,274)
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх өрийн хэрэгслийг борлуулах үеийн гарз		553	39
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын арилжааны олз		(770)	(5)
Алт ба үнэт металын дахин үнэлгээний олз		(738,120)	(162,373)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний цэвэр олз		(351,999)	(237,809)
Гадаад валютын ханш хөрвүүлэлтийн гарз/(олз)		235,044	(187,094)
Засгийн газраас авах авлагын үнэ цэнийн бууралтын гарз	17	74,231	37,405
Үндсэн хөрөнгийн элэгдэл болон биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардал	19,30	13,178	13,139
Данснаас хассан үндсэн хөрөнгө	19	11	12
Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн олз		(5,322)	(12,871)
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	27	(756,067)	(908,268)
Бусад адилтгах орлого	27	(841)	(3,600)
Хүүгийн зардал	27	1,476,446	1,496,745
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		1,204,747	258,301
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:			
Алт, үнэт металын цэвэр (өсөлт)		(1,290,719)	(163,278)
Урвуу буцаан худалдан авах хэлцлийн цэвэр (өсөлт)	12	(1,830,973)	(3,299,793)
Дотоодын банкуудад олгосон зээлийн цэвэр (өсөлт)	9	(55,867)	(254,779)
Бусад хөрөнгийн цэвэр бууралт	18	12,563	29,400
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн цэвэр өсөлт/(бууралт)		398,273	(80,383)
Төв банкны үнэт цаасны цэвэр (бууралт)/өсөлт		(534,000)	2,714,764
Засгийн газрын хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт		(703,689)	2,272,222
Дотоодын банкуудын хөрөнгийн цэвэр өсөлт		5,533,432	1,244,222
Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт)		646,024	(490,077)
Үндсэн үйл ажиллагаанаас олсон хүүгийн өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ		3,379,791	2,230,599
Хүлээн авсан хүү		671,447	980,810
Төлсөн хүү		(1,489,146)	(1,494,920)
Үндсэн үйл ажиллагаанаас олсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ		2,562,092	1,716,489

МОНГОЛБАНК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

Сая төгрөгөөр	Тодруулга	2025	2024
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	19	(14,450)	(12,819)
Үндсэн хөрөнгийн борлуулсны орлого	19	2,415	1,399
Эрдэнэсийн сангийн худалдан авалт	14	(2,092)	(12,669)
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх өрийн хэрэгслийн худалдан авалт	10	(6,500,096)	(6,728,187)
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх өрийн хэрэгслийн борлуулсны орлого	10	6,539,211	5,658,221
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэрэгслийн эргэн төлөлтийн орлого	10	418,433	667,501
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		443,421	(426,554)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний цэвэр өсөлт	20	22,171	70,479
Гадаад өр төлбөрийн эргэн төлөлт	31	-	(2,100,025)
Буцаан худалдан авах хэлцлийн худалдан авалт	31	13,504,814	-
Буцаан худалдан авах хэлцлийн эргэн төлөлт	31	(13,530,708)	-
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		(3,723)	(2,029,546)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		437,924	(96,724)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)		3,439,714	(836,335)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эхний үлдэгдэл	7	6,641,760	7,478,095
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эцсийн үлдэгдэл		10,081,474	6,641,760

Хуудас 103-аас 216-д тусгасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1 ТАНИЛЦУУЛГА

Монголбанк (Цаашид “Банк”)–ны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУЗ)–өөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандарт)–ын дагуу бэлтгэн гаргасан.

Банк нь Монгол Улсын Төв банк бөгөөд Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)–ны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Банк нь Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор анх үүсгэн байгуулагдсан.

Банк нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх үйл ажиллагаагаа явуулдаг. Орон нутагт нийт 17 салбартай бөгөөд Их Британи улсын Лондон хот болон АНУ–ын Нью Йорк хотод тус тус төлөөлөгчийн газартай.

Үндсэн үйл ажиллагаа. Хууль, тогтоомжид зааснаар Банкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээл болон банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн тэнцвэртэй, тогтвортой хөгжлийг дэмжихэд оршино.

Банк нь ашгийн бус байгууллага бөгөөд төрөөс үүсгэн байгуулсан тусгай хуулийн этгээдийн хувьд түүний үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, хөрөнгө, өр төлбөр болон өөрийн хөрөнгийн бүтэц нь Банкны хуульд заасан чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогоор тодорхойлогддог.

Төв банк (Монголбанк)–ны тухай хуулийн дагуу Банк нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах;
- Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Засгийн газар (“Засгийн газар” эсвэл “Төрийн”)–ын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх;
- Банкны салбарын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих;
- Үндэсний төлбөрийн системийг зохицуулах, хяналт тавих болон банк хоорондын төлбөр тооцооны системийн үйл ажиллагааг эрхлэх;
- Гадаад валютын улсын нөөцийг удирдах;
- Банкуудад эцсийн зээлдүүлэгчийн үүргийг гүйцэтгэх болон дахин санхүүжилтийн тогтолцоог зохион байгуулах;
- Монгол Улсыг бусад хамтын ажиллагаа бүхий төв банкууд, олон улсын банк болон санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд төлөөлөх;
- Хуульд заасан эрх хэмжээний хүрээнд санхүү болон зээлийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Хуульд заасны дагуу Банк нь банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор банкуудад зээл олгох, хоёрдогч зах зээл дээр үнэт цаас худалдах, худалдан авах, гадаад валют, үнэт металл худалдах, худалдан авах, дотоод ба гадаадын зах зээл дээр үнэт металл болон бусад металаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Мөн Банк нь Засгийн газар, түүний дотор Сангийн яам (Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага)–ны дансыг хөтлөх, олон улсын байгууллагуудын дансыг байршуулах бөгөөд Банкны хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг явуулдаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1 ТАНИЛЦУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны дүрмийн сангийн хөрөнгийг Монгол Улсын төр эзэмшдэг. Төв банкны тухай хуульд зааснаар Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг нь мөнгөний бодлогын зарчмыг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих юм. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгч нь Банкны санхүүгийн тайланг батлах, ирэх оны орлого, зарлагын төсвийг батлах, түүний гүйцэтгэл болон тайлант жилийн ашгийн хуваарилалтын талаар олон нийтэд мэдээлэх, Монгол Улсын хууль тогтоомжид заасан эрхийн хүрээнд бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Бүртгэгдсэн хаяг ба үйл ажиллагаа явуулж буй байршил. Монголбанкны албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот 46, Бага Тойруу 3, 15160 байна.

Тайлагналын мөнгөн нэгж. Эдгээр санхүүгийн тайлангуудыг Банкны үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн анхдагч орчны мөнгөн тэмдэгт бөгөөд Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “төгрөг”-өөр тайлагнасан. Өөрөөр тусгайлан заагаагүй бол бүх дүнг сая төгрөгөөр нарийвчилсан болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2 БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН

Монгол Улсын эдийн засаг 2025 онд тогтвортой өсөлтөө хадгалж, үүний гол дэмжлэг нь уул уурхайн салбарын хүчтэй өсөлт, ялангуяа зэс болон нүүрсний экспортын өсөлт, түүнчлэн өрхийн хэрэглээ болон төсвийн зарцуулалтын өсөлтөөс шалтгаалан тогтвортой тэлж байна. Гадаад төлбөрийн тэнцэл 2025 онд 1,034 сая ам.долларын ашиг (2024: 622 сая ам.долларын ашиг)-тай гарч, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн нийт экспортын 93%-ийг эзэлж байна.

Гадаад өрийн дахин санхүүжүүлтийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын гадаад эрсдэл буурч, гадаад валютын албан нөөц 2025 онд түүхэн дээд хэмжээ буюу 7,005 сая ам.долларт (2024: 5,510 сая ам.доллар) хүрсэн. Энэхүү санхүүгийн тогтвортой байдал нь улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд эерэгээр нөлөөлж байна. Тухайлбал Монгол Улсын зээлжих зэрэглэлийг Фитч агентлаг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр “B+” буюу тогтвортой төлөвт хэвээр үлдээсэн бол Стандарт энд Пүүрс агентлаг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр мөн “B+” буюу тогтвортой төлөвт хэвээр хадгалсан байна. Харин Мүүдис агентлаг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “B1” болгон ахиулж, тогтвортой төлөвтэй гэж үнэлжээ.

Банк 2025 онд бодлогын хүүг дотоод макро эдийн засгийн орчны нөхцөл байдал, инфляцын цаашдын төлөвийг харгалзан 2025 оны 3 дугаар 7-ны өдөр 2%-аар нэмэгдүүлэн 12% (2024: 10%)-д хүргэсэн. Инфляц 2025 оны эцэст зорилтот түвшинд буюу 7.5%-тай (2024: 9%) байна.

ОХУ болон Украин Улсын хоорондын дайнтай холбоотойгоор Украин дахь цэргийн ажиллагааны улмаас ОХУ-д тавьсан хориг арга хэмжээнүүд болон ОХУ-ын авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний үр дүнд байгалийн хий, цахилгаан эрчим хүчний үнэ өсөж, үнийн хэлбэлзэл нэмэгдсэн. Олон улсын түүхий эдийн үнэ түүхэн дээд түвшинд хүрч, дэлхий даяар инфляцын түвшин өндөр хэвээр байхад нөлөөлсөн боловч ОХУ болон Украины нөхцөл байдал нь Банкны үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлэхгүй. Олон улс даяар инфляц өндөр түвшинд байгаагийн улмаас эцсийн бүтээгдэхүүний үнэ өссөн нь импортын бараа бүтээгдэхүүнээр дамжин Монгол Улсад мөн нөлөөлсөн байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Банк эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандарт)-ын дагуу бэлтгэн гаргасан.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэн гаргахдаа санхүүгийн хэрэгслийг анхлан бодит үнэ цэнээр, үндсэн хөрөнгө, мөнгөжсөн алт болон үнэт металлыг дахин үнэлгээгээр, мөн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ (“ААБҮЦ”) болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (“БДОБҮЦ”)-ээр ангилагдсан санхүүгийн хэрэгслийг дахин үнэлэх замаар өөрчлөгдсөн түүхэн өртгийн зарчимд үндэслэсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг доор толилуулав. Эдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг өөрөөр зааснаас бусад тохиолдолд бүх тайлант жилүүдэд тасралтгүй мөрдөж ирсэн.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэн гаргахдаа тайлантай танилцах үндсэн хэрэглэгчид нь мэдээллийг нарийн хянаж, дүн шинжилгээ хийх бизнесийн болон эдийн засгийн үйл ажиллагааны талаар зохих мэдлэгтэй байна гэж үзсэн. Гэсэн хэдий ч мэдээлэл сайтай, мэдлэгтэй хэрэглэгчид ч эдгээр санхүүгийн тайлангуудад тусгагдсан эдийн засгийн нарийн төвөгтэй үзүүлэлтүүдтэй холбоотой мэдээллийг ойлгохын тулд зарим тохиолдолд мэргэжлийн зөвлөхийн туслалцаа авах шаардлага үүсч болзошгүй байдаг.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь удирдлагын хувьд зөвхөн үндсэн хэрэглэгчдэд чухал гэж үзсэн мэдээллийг тодруулахад чиглэгдсэн. Иймд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад зөвхөн материаллаг нөлөөтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээллийг толилуулсан болно.

Санхүүгийн байдлын тайланг түргэн хөрвөх чадварын эрэмбээр толилуулах. Банк тодорхой үйл ажиллагааны мөчлөггүй тул санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, богино болон урт хугацаат өр төлбөрийг тусад нь ангилан харуулдаггүй. Харин хөрөнгө болон өр төлбөрийг тэдгээрийн түргэн хөрвөх чадвараар нь эрэмбэлж толилуулдаг.

Санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрөөс бусад эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, богино болон урт хугацаат өр төлбөрийн талаарх мэдээллийг Тодруулга 34-т тусгасан. Санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрт үндсэндээ барилга байгууламж, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө болон Эрдэнэсийн сангийн хөрөнгийг бүртгэх ба тэдгээрийг тайлант хугацаанаас хойш 12 сараас дээш хугацаанд буцаан төлөх буюу барагдуулагдах төлөвтэй байна.

Дахин тайлагнал. Банк 2025 онд Эрдэнэсийн Сангийн хөрөнгийн хэмжилтийг дахин үнэлгээний загвараас өртгийн загварт шилжүүлсэн. Үүний үр дүнд, Банк НББОУС 8 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа” стандартын дагуу эдгээр санхүүгийн тайлангуудад дараах үзүүлэлтүүдийг буцаан хэрэгжүүлэх зарчмаар дахин тайлагнасан:

2024 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаарх Санхүүгийн байдлын тайлангийн дахин тайлагналын нөлөөг дараах байдлаар тайлагнасан:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

<i>Сая төгрөгөөр</i>	2024 оны 1 дүгээр сарын 1 (өмнө нь тайлагнасан)	1925 оны зоосны дахин үнэлгээний дахин тайлагнал (a)	Бусад соёлийн өвийн зүйлсийн бодлогын өөрчлөлт (b)	Тодруулга	2024 оны 1 дүгээр сарын 1 (дахин тайлагнасан)
Хөрөнгө					
Эрдэнэсийн сан	1,099,230	(906,788)	(146,060)	14	46,382
Дурсгалын зоос болон бусад үнэт зүйлс	25,539	-	(8,916)	13	16,623
Өөрийн хөрөнгө					
Бусад нөөц	(2,177,456)	906,788	154,976	26	(1,115,692)

2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн байдлын тайлангийн дахин тайлагналын нөлөөг дараах байдлаар тайлагнасан:

<i>Сая төгрөгөөр</i>	2024 оны 12 дугаар сарын 31 (өмнө нь тайлагнасан)	1925 оны зоосны дахин үнэлгээний дахин тайлагнал (a)	Бусад соёлийн өвийн зүйлсийн бодлогын өөрчлөлт (b)	Тодруулга	2024 оны 12 дуга- ар сарын 31 (дахин тайлагнасан)
Хөрөнгө					
Эрдэнэсийн сан	1,111,899	(906,788)	(146,060)	14	59,051
Дурсгалын зоос болон бусад үнэт зүйлс	27,071	-	(8,916)	13	18,155
Өөрийн хөрөнгө					
Бусад нөөц	(2,519,199)	906,788	154,976	26	(1,457,435)

(a) Эрдэнэсийн Сан нь түүх соёлын хосгүй үнэт зүйлс болон 1925 онд Монгол Улсад албан ёсоор гүйлгээнд ашиглагдаж байсан төлбөрийн хэрэгсэл болон зоосон мөнгөнөөс бүрдэнэ. Гүйлгээнд ашиглагдаж байсан 1925 оны зоосыг 1938 онд гүйлгээнээс буцаан татсан бөгөөд Банкныг СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартад шилжих үед гүйлгээнд ашиглагдаагүй хэвээр байсан. Гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөн тэмдэгт нь Тодруулга 20-д дурдсанчлан Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу гүйлгээнд гаргахаас өмнө болон дараа аль ч үед өр төлбөр хэсэгт нэрлэсэн үнээр бүртгэгддэг бөгөөд ямар ч тохиолдолд хөрөнгөөр бүртгэгддэггүй. Одоогоор Банкинд байгаа зооснууд хэсэг эсвэл бүхлээрээ өмнө нь Монгол Улсад гүйлгээнд ашиглагдаж байсан хүчин төгөлдөр зооснууд ба Банкнаас биетээр хэзээ ч гараагүй байж магадгүй юм. Тодруулга 14-т дурдсанчлан 2024 оны 12 дугаар 31-ний өдөр болон 2024 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаар Банк Эрдэнэсийн сангийн эд зүйлсийг үндсэн хөрөнгөтэй адилтган үзэж “НББОУС 16 Үндсэн хөрөнгө” стандартын хүрээнд дахин үнэлсэн. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дахин үнэлсэн дүн нь 906,788 сая төгрөг (2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр 906,788 сая төгрөг) ба дансны үнэ нь 908,476 сая төгрөг (2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр 908,476 сая төгрөг) байсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гүйлгээнээс татагдсанаас хойш урт хугацаа өнгөрсөн тул эдгээр зооснууд нь гуравдагч этгээдийн эзэмшилд байгаад 1938 оноос хойш, өөрөөр хэлбэл зооснууд хууль ёсны төлбөрийн хэрэгсэл байхаа больсны дараа, хууль ёсны эзэмшигч болох гуравдагч этгээдээс эзэмшил шилжүүлэгдэж эсвэл Эрдэнэсийн сан руу хууль ёсны шилжүүлэг хийгдэж ирсэн болохыг нотлох баримт Банкинд хадгалагдаж үлдээгүй. Түүнчлэн, эдгээр зооснуудын бодит үнэ цэнээр бүгдийг нь зарахад ашиглагдах тооцох боломжтой найдвар төрүүлэх үнийн мэдээлэл байхгүй гэх үндэслэлээр эдгээр хөрөнгийн хэмжилтийн суурийг дахин хянаж, өртгийн аргаар хэмжихээр шийдвэрлэсэн ба дансны үнэ болох 1,688 сая төгрөгөөр буюу өртгөөр нь буцаан хэрэгжүүлэх зарчмын дагуу дахин тайлагнасан. Банкны үзэж байгаагаар зооснуудын түүхэн өртөг нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд илүү найдвартай мэдээлэл өгдөг. Үүний үр дүнд Банк нь Эрдэнэсийн сангийн эд зүйлсийн дансны үнийг өртгийн аргаар дахин хэмжиж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаарх дансны үнийг буцаан хэрэгжүүлэх зарчмаар дахин тайлагнасныг дээрх хүснэгтэд тодруулсан.

(б) 2022 онд Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, Эрдэнэсийн сангийн байнгын хэсэгт хамаарах эд зүйлсийг засгийн газрын зөвшөөрөлтэй эсэхээс үл хамааран захиран зарцуулахыг хориглосон. Энэхүү хориг нь Монгол Улсын Эрдэнэсийн санг хамгаалах хууль эрх зүйн арга хэмжээнүүдийн нэг гэж удирдлага үзсэн. Үүний үр дүнд Банк захиран зарцуулах боломжгүй хэдий ч худалдсан тохиолдолд үүсэх ашиг нь хадгалагдан үлдэхээс үнэ цэнийн хувьд харьцангуй бага байгаа учир удирдлага зооснууд болон Эрдэнэсийн санг хууль эрх зүйн үндэслэлийн дагуу өртгийн аргаар бүртгэхийг шийдвэрлэсэн. Үндсэн хөрөнгийн хэмжилтийн суурийг өөрчилсөн нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөд хамаарах тул буцаан хэрэгжүүлэх зарчмыг баримталж дээрх хүснэгтэнд тусган тайлагнасан.

Санхүүгийн тайлан гаргасны дараах өөрчлөлт. Банкны удирдлага санхүүгийн тайлангуудыг нийтэлсний дараа түүнд өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ

Банк санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдсөн дүнд болон дараагийн санхүүгийн тайлант жилийн хөрөнгө болон өр төлбөрийн бүртгэлийн дүнд нөлөө үзүүлэх үнэлэлт болон тооцооллыг ашигладаг. Тооцоолол болон үнэлэлт нь үргэлж хянагддаг бөгөөд удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлсэд суурилдаг. Удирдлага тооцоололд үнэлэлт хийхийн зэрэгцээ нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцыг мөн үнэлж, тодорхой үнэлэлт, дүгнэлтийг гаргадаг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнд хамгийн их мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлт болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд мэдэгдэхүйц их хэмжээний залруулга хийх шаардлага үүсгэж болох тооцоололд дараах зүйлс хамаарна:

(а) Дараагийн санхүүгийн тайлант жилд материаллаг нөлөө үзүүлж болох өндөр эрсдэлтэй тооцооллууд

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын тооцоолол, хэмжилт. ХБЭА-ын хэмжилт нь тодорхой арга зүй, загварчлал, мэдээллийн өгөгдлүүдийг тодорхойлох чухал тооцоолол ба ХБЭА-ын хэмжилтийн арга зүйн дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 34-т тусгасан. Эрсдэлийн алдагдлын сангийн тооцоололд дараах хүчин зүйлс чухал нөлөө үзүүлдэг. Үүнд:

- Банкнаас тогтоосон дефолтын тодорхойлолт;
- Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд;
- Дотоод зээлийн ангиллын загваруудыг боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд эдгээр загварууд нь зээлийн эрсдэлийн ангилал бүрд харгалзах дефолтын болох магадлал (ДМ)-ыг тогтоодог;
- Санхүүгийн хэрэгсэл болон зээлийн үүрэгтэй холбоотой дефолт болох үеийн үлдэгдэл дүн (ДҮД)-г тооцоолоход ашиглагддаг дотоод загваруудыг боловсруулж, хөгжүүлэх;
- Дефолт болох үеийн алдагдлын хэмжээ (ДАХ), барьцаа хөрөнгийн үнэлгээнд баримталсан мэргэжлийн үнэлэлт, дүгнэлтийг хамруулах;
- Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн хэтийн төлөвийн хувилбаруудыг сонгож, тэдгээрийн магадлалыг жинлэх;

Банк хүлээгдэж буй эрсдэлийн тооцоолол болон бодит эрсдэлийн алдагдалын хоорондын зөрүүг багсагах үүднээс загварын ооцоололд ашиглах өгөгдлүүдийг байнга үнэлж, хяналт тавьдаг.

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ). Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд Банк тайлант өдрийн эцсийн байдлаарх санхүүгийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд дефолт үүсэх эрсдэлийг анх хүлээн зөвшөөрсөн өдрийн дефолт үүсэх эрсдэлтэй харьцуулан үнэлдэг. Үнэлгээгээр тайлант хугацааны эцэст тодорхой нэг зээлийн эрсдэлийн түвшинд хүрэхээс илүү зээлийн эрсдэлийн харьцангуй өсөлтийг харгалзан үздэг. Банк ХБЭА-ыг хэмжихдээ ашиглаж болохуйц, үндэслэлтэй ирээдүйд чиглэсэн бүх мэдээллийг, тэр дундаа макро эдийн засгийн таамаглалын загварын үр дүнг авч үздэг. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 34-өөс харна уу.

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ. Банк нийт валютын хүүгийн своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийг үнэлэх зорилгоор үнэлгээний загварыг боловсруулсан. Зах зээлийн бэлэн мэдээлэлд суурилсан таамаглалыг ашиглахад үнэлэгдсэн санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн талаарх мэдээллийг Тодруулга 35-д тусгасан.

4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Барилгын дахин үнэлгээ. Банк нь өөрийн барилга, байгууламжийг дахин үнэлэгдсэн дүнгээр хэмжиж үнэлдэг бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрдөг. Барилга, байгууламжуудыг тайлант жил бүрийн эцэст зах зээлийн нотолгоонд тулгуурлан, хөрөнгийн шинж чанар, байршил болон ашиглалтын байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан тохируулсан ижил төрлийн хөрөнгийн зах зээлийн үнэд тохируулга хийх замаар үнэлдэг. Барилгын үнэлгээг 2018 онд мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэсэн. Удирдлага барилгын бодит үнэ цэнийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дансны үнээс мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй гэж дүгнэсэн. Энэхүү дүгнэлт нь эдгээр хөрөнгийн талаарх удирдлагын туршлага болон Тодруулга 19-т тодорхойлсон бусад таамаглалд тулгуурласан үнэлэлт, дүгнэлтийг шаарддаг. Зах зээлийн үнэ болон өгөгдөлд суурилагагүй, таамаглал ашиглан үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ, мэдрэмтгий байдлын шинжилгээний талаарх мэдээллийг Тодруулга 35-аас харна уу.

(б) Тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн дүнд чухал нөлөө үзүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын үндэслэлүүд

Тасралтгүй байх зарчим. Удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэн гаргасан. Банкны өөрийн хөрөнгө нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар сөрөг утгатай байсан хэдий ч удирдлагын зүгээс Тодруулга 34-т тусгасан төлбөрийн чадварын болон бусад санхүүгийн эрсдэлийг тогтмол хянаж байдаг тул Банкны үйл ажиллагаа ойрын хугацаанд тасалдахгүй, үйл ажиллагаагаа тасралтгүй байх зарчмын дагуу явуулахгүй байх ямар нэгэн эрсдэл байхгүй гэж үзсэн. Төлбөрийн чадварын эрсдэлийн үнэлгээний гол эрсдэл нь Хятадын ардын банкнаас авсан зээлтэй холбоотой байна. Энэхүү зээлийн гэрээний хугацааг 2023 оны 7 дугаар сард хамгийн сүүлд гурван жилийн хугацаагаар 2026 оны 7 дугаар сар хүртэл сунгасан. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар энэ зээлийн үлдэгдэл нь 6,000 сая юань буюу 3,052,680 сая төгрөг (2024: 6,000 сая юань буюу 2,811,420 сая төгрөг) байна. Удирдлага Засгийн газрын дэмжлэгтэйгээр энэхүү зээлийн хугацааг дахин гурван жилээр сунгах хэлцлийг идэвхтэй явуулж байгаа бөгөөд сунгалт 2026 оны дунд үе гэхэд амжилттай хийгдэнэ гэж үзэж байна. Энэхүү зээлийг өмнө нь нийт дөрвөн удаа сунгаж байсан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 32-оос харна уу.

Түүнчлэн, шаардлагатай тохиолдолд Банк нь Монгол Улсын Төв Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу өөрийн хөрөнгийн хасах дүнг буюу алдагдлыг бууруулах зорилгоор Засгийн газрын үнэт цаас гаргах замаар дахин хөрөнгөжүүлэх асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх хүсэлт гаргах боломжтой. Тус хуулийн 38 дугаар зүйлд Төв Банкны алдагдал үүссэн тохиолдолд хуримтлагдсан алдагдлыг бууруулах зорилгоор Засгийн газар үнэт цаас гаргах эсэхийг Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан байдаг. Иймд Засгийн газар Банкны цэвэр алдагдлыг санхүүжүүлэх үүрэг хүлээхгүй. Гэсэн хэдий ч, Банкны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх болон үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулахад шаардлагатай гэж үзвэл, алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газрын бонд гаргах нь Улсын Их Хурлын зүгээс авч хэрэгжүүлэх боломжит арга хэмжээ юм.

Иймд Банкны онцгой үүрэг, эрх зүйн статусыг харгалзан үзвэл, ойрын ирээдүйд Банк тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болох эрсдэл байхгүй гэж удирдлага үзэж байна.

Бизнес загварын үнэлгээ. Банк бизнес загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хөрөнгийг тодорхой шинж чанараар нь багцалж нэгтгэх эсэхийг тодорхойлоход үнэлэлт, дүгнэлтийг ашиглан санхүүгийн хөрөнгийг зохих бизнес загварын түвшинд ангилдаг. Банк бизнесийг хэрхэн удирдаж байгаа байдал болон удирдлагад мэдээлэл хэрхэн тайлагнагдаж байгааг хамгийн сайн тусгасан бизнес загварын зорилгыг тодорхойлдог. Үнэлгээнд дараах мэдээллийг харгалзан үзнэ:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

- Багцын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, удирдлагад тайлагнах байдал;
- Бизнесийн загварын гүйцэтгэлд (мөн тухайн бизнесийн загварт багтсан санхүүгийн хөрөнгүүдэд) нөлөөлөх эрсдэл болон эдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж байгаа байдал;
- Багцыг удирдаж буй зорилго, бодлого болон эдгээр бодлогыг практикт хэрхэн хэрэгжүүлж байгаа байдал;
- Санхүүгийн хөрөнгийн борлуулалтын түүхэн давтамж, хугацаа, дүн, шалтгаан болон ирээдүйн борлуулалтын талаарх хүлээлт.

Зөвхөн эрсдэлийн стрессээс шалтгаалж, эсвэл Банкны удирдаж чадахгүй, урьдчилан таамаглах боломжгүй, онцгой үйл явдлын нөлөөгөөр санхүүгийн хөрөнгийг борлуулсан бол үүнийг тухайн бизнес загварыг өөрчлөхгүй бөгөөд энэ тохиолдолд санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчлөхгүй.

“Хугацааны эцэс хүртэл эзэмших” бизнес загвар гэж санхүүгийн хөрөнгийг зөвхөн гэрээнд заасан мөнгөн урсгалыг хугацааны эцэс хүртэл цуглуулах зорилгоор эзэмшихийг хэлнэ. Энэхүү бизнес загварын хүрээнд санхүүгийн хөрөнгийг борлуулах нь бизнесийн үндсэн стратегийн нэг хэсэг бус, харин дагалдах шинжтэй байна.

“Хугацааны эцэс хүртэл эзэмших ба зарж борлуулах” бизнес загвар гэж санхүүгийн хөрөнгийг гэрээнд заасан мөнгөн урсгалыг цуглуулах, тодорхой зорилгын хүрээнд буюу хөрвөх чадварыг хангах, өгөөж хүртэх, хөрөнгө, өр төлбөрийн хугацааг нийцүүлэх зорилгоор хөрөнгийн зарим хэсгийг зарж борлуулах боломжтой байхыг хэлнэ.

Дээрх 2 бизнес загварт хамаарахгүй санхүүгийн хөрөнгө нь “худалдан борлуулах зорилгоор эзэмших” бизнес загварт хамаарна. Энэ бизнес загварт ихэвчлэн идэвхтэй арилжаалагддаг санхүүгийн хөрөнгө багтах бөгөөд гэрээнд заасан мөнгөн урсгалыг цуглуулах нь энэ бизнес загварын үндсэн зорилго биш юм.

Банк өрийн үнэт цаасны ойролцоогоор 52% (2024: 55%)-ийг хөрвөх чадварын багц гэж тодорхойлон “хугацааны эцэс хүртэл эзэмших ба зарж борлуулах” гэж ангилсан бол үлдсэн өрийн үнэт цаасыг стрессийн нөхцөл байдлын үед борлуулна гэсэн таамаглалд үндэслэн “Хугацааны эцэс хүртэл эзэмших” гэж ангилсан.

Банк Тодруулга 9-т дурдсан дотоодын банкуудад олгосон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ (ААБҮЦ)-ээр ангилагдсан зээлийн хүүгийн хувь хэмжээг дахин тогтоох нөхцөлтэй зээлүүдээс бусад бүх төрлийн зээлүүдийг “хугацааны эцэс хүртэл эзэмших” загварын шалгуурыг хангана гэж үзсэн.

Мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй эсэх үнэлгээ. Санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлт (“ЗХҮТ”)-өөс бүрдэж буй эсэхийг тодорхойлох шаардлагатай байдаг бөгөөд тус үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үздэг. Үүнд:

- Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын дүн болон хугацаанд өөрчлөлт оруулж болзошгүй үйл явдал;
- Хөшүүргийн онцлог шинж;
- Урьдчилан төлөх болон хугацаа сунгах нөхцөл;
- Мөнгөний цаг хугацааны үнэлгээнд нөлөөлж болзошгүй нөхцөл (жишээ нь, хүүгийн хувь хэмжээг тодорхой хугацааны давтамжтай шинэчлэх буюу дахин тохируулах).

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн бүрэлдэхүүн хэсэг нь дараах байдлаар өөрчлөгдөх боломжтой, тухайлбал, гэрээний дагуу хүүгийн хувь хэмжээг тогтмол хугацаанд дахин шинэчилдэг боловч давтамж нь тухайн өрийн хэрэгслийн суурь хүүгийн хугацаатай нийцэхгүй байх тохиолдол үүсч болно. Жишээлбэл, зээл нь гурван сарын банк хоорондын хүүгийн түвшинд суурилсан боловч хүүгийн хувь хэмжээг сар бүр дахин шинэчилдэг байж болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн өөрчлөлтийн нөлөөг тухайн санхүүгийн хэрэгслийн мөнгөн урсгалыг ЗХҮТ-ыг шалгуурыг хангах жишиг өрийн хэрэгслийн мөнгөн урсгалтай харьцуулан, тайлант үед тухайн хэрэгслийн ашиглалтын нийт хугацаанд хуримтлуулан үнэлдэг. Энэхүү үнэлгээг хийхдээ санхүүгийн зах зээлд учирч болзошгүй өсөлт болон хямралын нөхцөл байдлыг хамруулдаг. Хэрэв тухайн санхүүгийн хэрэгслийн мөнгөн урсгал нь жишиг өрийн хэрэгслийн мөнгөн урсгалаас материаллаг хэмжээгээр зөрүүтэй байвал энэхүү мөнгөн урсгалыг ЗХҮТ гэж үзэхгүй бөгөөд тухайн санхүүгийн хэрэгслийг ААБҮЦ-ээр хэмжигдэх ангилалд хамруулна. ЗХҮТ шалгуурыг хангаагүй, ААБҮЦ-ээр хэмжигдэх санхүүгийн хэрэгсэл болон түүнтэй холбоотой дотоодын банкуудад олгосон зээл, өрийн бичгийн дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 9 болон 18-аас харна уу.

Банк гэрээнд заасан мөнгөн урсгалын дүн болон хугацаанд өөрчлөлт оруулж болзошгүй нөхцөлийг үнэлдэг. Хэрэв тухайн зээлийг хугацаанаас өмнө төлөх боломжтой бөгөөд хугацаанаас өмнө төлөх дүн нь үндсэн зээлийн үлдэгдэл болон хуримтлагдсан хүү, түүнчлэн гэрээг хугацаанаас өмнө дуусгасны төлөө төлөх нэмэлт нөхөн төлбөрийг үндсэндээ илэрхийлж байвал энэ зээлийг ЗХҮТ-ийн шалгуурыг хангана гэж үзнэ. Санхүүгийн хөрөнгийн үндсэн төлбөрийн үлдэгдлийг анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнээс төлбөрийн эргэн төлөлт (үр ашигт хүүгийн аргыг ашиглан тодорхойлогдсон хүүг хассан төлбөр)-ийг хассан дүнгээр тодорхойлно.

Энэхүү зарчмын онцгой тохиолдолд СТОУС 9-аар дараах нөхцөлийг хангасан хугацаанаас өмнө төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн хэрэгслийг ЗХҮТ-ийн шалгуурыг хангана гэж үзэхийг зөвшөөрдөг. Үүнд: i) санхүүгийн хэрэгсэл нь анх хүлээн зөвшөөрөгдөх үед хөнгөлөлт, урамшуулалтай ii) урьдчилан төлөх дүн нь гэрээний нэрлэсэн үнэ, хуримтлагдсан хүү болон гэрээг хугацаанаас өмнө цуцалсны нөхөн төлбөрийг багтаасан байх, iii) урьдчилан төлөх нөхцлийн бодит үнэ цэнэ нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үед материаллаг бус байх.

Орон сууцны ипотекийн зээлийн гэрээний дагуу Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд Банк дотоодын банкуудад олгосон орон сууцны ипотекийн зээлийг Монголын Ипотекийн Корпорациас гаргасан давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-оор солилцдог. Давуу эрхтэй ИЗББ-ын гэрээний нөхцөл нь тухайн бондын мөнгөн урсгалын дүнд нөлөөлөхгүй, мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөрөөс бүрдэнэ гэж үзсэн. Монголын Ипотекийн Корпораци нь тусгай зориулалтын компаниар дамжуулан ИЗББ гаргаж, дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлийн багцыг нэрлэсэн үнээр нь худалдан авдаг. Иймд Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон зээлүүд ЗХҮТ-ийн шалгуурыг хангаж байна. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Дотоодын банкуудад олгосон орон сууцны зээлийн анхны хүлээн зөвшөөрөлт” хэсэгт тодруулсан болно.

Дотоодын банкуудад олгосон орон сууцны зээлийн анхны хүлээн зөвшөөрөлт. Банк нь Монгол Улсын Засгийн газартай хамтран Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд ипотекийн зээлийг санхүүжүүлсэн. Энэхүү зээлийг Банк, Монгол Улсын Засгийн газар, Монголын Ипотекийн Корпораци болон дотоодын банкуудын хооронд байгуулсан “Ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулах ерөнхий гэрээ”-ний дагуу санхүүжүүлсэн бөгөөд дотоодын банкууд зээлийн нөхцөлийг тодорхойлох эрхгүй. Банк гэрээний дагуу дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлийн төлбөрт МИК-аас гаргасан давуу эрхтэй ИЗББ-ыг хүлээн авдаг. Энэхүү зээл нь жилийн 2 хувь (2024: 2–6 хувь)-ийн хүүтэй бөгөөд зээлийг анх бүртгэх үед ашиг эсвэл алдагдал үүсэх эсэхийг авч үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Тус хөтөлбөр нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, инфляцийг тогтворжуулах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх Төв банкны үндсэн чиг үүргийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа тул ижил төстэй санхүүгийн хэрэгслийн зах зээл байхгүй буюу энэ нь анхдагч зах зээл байна гэж үзсэн. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон зээлийн үлдэгдэл нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 181,426 сая төгрөг (2024: 1,400,969 сая төгрөг) байна. Дотоодын банкуудад олгосон зээлийн талаар Тодруулга 9-д толилуулсан.

Дотоодын банкуудад олгосон орон сууцны зээлийн анхны хүлээн зөвшөөрөлт. Банк нь Монгол Улсын Засгийн газартай хамтран Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд ипотекийн зээлийг санхүүжүүлсэн. Энэхүү зээлийг Банк, Монгол Улсын Засгийн газар, Монголын Ипотекийн Корпораци болон дотоодын банкуудын хооронд байгуулсан “Ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулах ерөнхий гэрээ”-ний дагуу санхүүжүүлсэн бөгөөд дотоодын банкууд зээлийн нөхцөлийг тодорхойлох эрхгүй. Банк гэрээний дагуу дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлийн төлбөрт МИК-аас гаргасан давуу эрхтэй ИЗББ-ыг хүлээн авдаг. Энэхүү зээл нь жилийн 2 хувь (2024: 2–6 хувь)-ийн хүүтэй бөгөөд зээлийг анх бүртгэх үед ашиг эсвэл алдагдал үүсэх эсэхийг авч үзсэн. Тус хөтөлбөр нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, инфляцийг тогтворжуулах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх Төв банкны үндсэн чиг үүргийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа тул ижил төстэй санхүүгийн хэрэгслийн зах зээл байхгүй буюу энэ нь анхдагч зах зээл байна гэж үзсэн. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон зээлийн үлдэгдэл нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 181,426 сая төгрөг (2024: 1,400,969 сая төгрөг) байна. Дотоодын банкуудад олгосон зээлийн талаар Тодруулга 9-д толилуулсан.

Засгийн газраас авах авлагын анхны хүлээн зөвшөөрөлт болон үнэ цэнийн бууралт. УИХ-ын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Монголросцветмент” ХХК-ийн 49 хувийг “Монголын зэс корпораци” ХХК-аас худалдан авахыг Засгийн газарт даалгасан. УИХ-ын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 258 дугаар, 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 315 дугаар тогтоолуудыг гаргасан. Эдгээр тогтоолуудаар Худалдаа, хөгжлийн банк (ХХБ)-нд олгосон зээл болон ХХБ-наас авсан өрийн бичгийг Эрдэнэт үйлдвэр ХХК болон Монголросцветмет ХХК-ийн 49 хувийн хувьцааг худалдан авах төлбөртэй харилцан суутгах талаар Банкинд чиглэл өгсөн.

Засгийн газрын тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газар, Банк, “Монголын зэс корпораци” ХХК болон Худалдаа, хөгжлийн банк хооронд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр болон 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдөр дөрвөн талт харилцан төлбөр барагдуулах тухай акт үйлдсэн. Харилцан төлбөр барагдуулах акт байгуулах үеийн холбогдох хөрөнгийн дансны үнэ 491,291 сая төгрөг болон 166,467 сая төгрөг байсан бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 17-оос харна уу.

Дээр дурдсан тогтоолууд болон дөрвөн талт харилцан төлбөр барагдуулах актын үр дүнд Банк нь Монгол Улсын Засгийн газраас нийт 657,758 сая төгрөгийн авлагыг нэхэмжлэх эрхтэй болж Засгийн газраас авах авлагыг хүлээн зөвшөөрсөн. “Монголын зэс корпораци” ХХК-д төлөх үлдэгдэл төлбөрийг Засгийн газар бүрэн төлж барагдуулсны дараа Засгийн газар болон Банкны хооронд байгуулах гэрээний нөхцлийг эцэслэн шийдвэрлэх юм.

Засгийн газар болон Банк хооронд байгуулагдах гэрээний нөхцөл, заалт нь Сангийн сайдаас 2026 оны 3 сарын 24-ний өдрийн Банкинд ирүүлсэн албан бичигт дурдсан нөхцөл, заалттай ижил байна гэж удирдлага үзэж байна. Энэхүү албан бичгээр Сангийн яам 657,758 сая төгрөгийн өр төлбөрийг баталгаажуулж, бодлогын хүүтэй тэнцүү хүүтэй, 10 жилийн хугацаатай гэрээ байгуулахаар төлөвлөж байгааг мэдэгдсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Түүнчлэн Аж Үйлдвэр, Эрдэс Баялгийн Яам нь Засгийн газраас авах авлагыг барагдуулах арга хэмжээ авах зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр ажлын хэсэг байгуулж, 2025 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Банкинд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай дурдсан албан бичгийг ирүүлсэн.

Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу Засгийн газраас авах авлагын анхны хүлээн зөвшөөрөлтийн дүн нь 514,942 сая төгрөг байсан бөгөөд Засгийн газраас авах авлагыг анх хүлээн зөвшөөрөх үеийн гарзыг 133,482 сая төгрөг, Засгийн газраас авах авлагын үнэ цэнийн бууралтын гарзыг 9,334 сая төгрөгөөр тус тус хүлээн зөвшөөрсөн. Удирдлага 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх авлагын дансны үнийг 403,306 сая төгрөг (2024: 477,537 сая төгрөг) гэж үнэлсэн бөгөөд Засгийн газартай гэрээ байгуулах үйл явц удааширсантай холбоотойгоор 74,231 сая төгрөг (2024: 37,405 сая төгрөг)-ийн үнэ цэнийн бууралтыг тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн. Үнэ цэнийн бууралтын үнэлгээг хийхдээ болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор гурван хувилбараар тооцоо хийсэн бөгөөд авлага нь Сангийн яамны албан бичигт дурдсаны дагуу тухайн үеийн бодлогын хүүтэй тэнцүү хүүтэй, гэрээ байгуулагдснаас хойш 10 жилийн хугацаанд төлөгдөнө гэж авч үзсэн. Удирдлага нь Засгийн газартай 2027 оны эцсээс 2031 оны хооронд гэрээ байгуулах магадлалтай гэж үзэж байна. Засгийн газраас авах авлагын эргэн төлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 17-оос харна уу.

Эрдэнэс бондын ХБЭА-ын үнэлгээ. Банк нь 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан «Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль»-ийн дагуу дотоодын банкуудаар дамжуулан «Эрдэнэс Монгол» ХХК-ийн гаргасан бондыг худалдан авах үүрэг хүлээсэн. Дотоодын банкууд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх иргэдийн тэтгэврийн зээлийн үлдэгдэл төлбөрт энэхүү бондыг хүлээн авсан. Банк нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 849,807 сая төгрөг (2024: 849,807 сая төгрөг)-ийн дансны нийт дүнтэй Эрдэнэс бондыг эзэмшиж байна. Бонд нь нэгжийн 1 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 6%-ийн хүүтэй, 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр эргэн төлөгдөх нөхцөлтэй байсан. Бондын ихэнх хэсэг нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төлөгдөөгүй, эргэн төлөлтийн хугацаа тодорхойгүй болсон зэргийг үндэслэн Банк тус хөрөнгийг үнэ цэнийн бууралттай гэж үзэн 3-р шатлалд ангилсан. Үүний үр дүнд бондын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сан 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 228,190 сая төгрөг (2024: 84,317 сая төгрөг) байгаа бөгөөд тайлант хугацаанд 143,873 сая төгрөгийн үнэ цэнэ бууралтын санг нэмж байгуулсан байна. Дэлгэрэнгүйг Тодруулга 10-аас харна уу.

“Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”-д зааснаар Эрдэнэс бондыг эзэмшсэнтэй холбоотойгоор Банкны өөрийн хөрөнгө буурсан тохиолдолд Засгийн газар нь энэхүү алдагдлыг үнэт цаасаар нөхөх үүрэгтэй. Үүний хүрээнд Монгол Улсын Засгийн газар нь 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 32 дугаар тогтоолоор Эрдэнэс бондын эргэн төлөлтийг хангах зорилгоор 550,000 сая төгрөгийн Засгийн газрын баталгаа гаргах, эсвэл шаардлагатай бусад арга хэмжээг авах шийдвэрийг гаргасан. Дээрх нөхцөл байдлыг харгалзан Банк дефолт болох магадлал (ДМ)-ыг 100% гэж үзсэн ба дефолт болох үеийн үлдэгдэл (ДҮД)-ийг 3 өөр хувилбараар авч үзсэн. Ингэхдээ Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн дагуу Засгийн газар 2027-2029 оны хооронд үнэт цаас гаргах замаар Эрдэнэс бондын төлбөрийг нөхөн төлнө гэсэн төсөөлөлд үндэслэн алдагдлын хэмжээг тооцсон. ХБЭА-ын хэмжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 34-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д тавих хяналт. Удирдлага Монголбанк болон Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-ийн хоорондын харилцааны мөн чанар нь ХДК-ийг МБ хянаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд үнэлэлт, дүгнэлтийг гаргадаг. Энэхүү дүгнэлтийг гаргахдаа удирдлага дараах хүчин зүйлсийг харгалзан үздэг. Үүнд:

- ХДК-д нөлөөлөх эрх мэдэлтэй эсэх,
- ХДК дахь өөрийн эрх мэдлээ ашиглан Банкны хүртэх ашгийн хэмжээнд нөлөөлөх чадвар. ХДК-д оролцсоноор үүсэх хувьсах өгөөжид өртөх, эсвэл тийм өгөөж авах эрхтэй эсэх; мөн тухайн өгөөжийн хэмжээнд нөлөөлөхийн тулд ХДК-д хамаарах эрх мэдлээ ашиглах боломжтой эсэх.

Банк нь ХДК-ийн үйл ажиллагаанд шууд оролцож, дангаараа удирдан чиглүүлэх эрхтэй нөхцөлд тухайн байгууллагад хяналт тогтоосон гэж үзнэ. ХДК-ийн дүрэмд тус байгууллагын удирдах дээд байгууллага болох Үндэсний хороо нь 7 гишүүнээс бүрдэх ба Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч тус хорооны дарга нь байна гэж заасан. Үндэсний хорооны бусад зургаан гишүүд нь дараах бүрэлдэхүүнтэй. Үүнд:

- Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга;
- ХДК-ийн Гүйцэтгэх захирал;

Гурван гишүүнийг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд болон Монголын Банкны Холбоо (Монголбанкыг гишүүнээрээ багтаадаггүй, дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас бүрдсэн бие даасан, хөндлөнгийн холбоо)-оос тус тус нэр дэвшүүлж, Монголбанкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар томилдог.

ХДК-ийн үйл ажиллагаатай холбоотой бүх шийдвэр нь Үндэсний хорооны 7 гишүүний саналын хураалтаар батлагддаг бөгөөд аль нэг гишүүн дангаар ХДК-ийн үйл ажиллагааг удирдах давуу эрхгүй. Монголбанкны Дэд Ерөнхийлөгч нь Үндэсний хорооны даргын үүргийг гүйцэтгэж байгаа хэдий ч тус албан тушаал нь ХДК-ийн үйл ажиллагаанд дангаараа нөлөөлөх эрхгүй. Түүнчлэн, Банк нь бусад гурван гишүүдийг томилох хязгаарлагдмал эрхтэй байгаа нь ХДК-д хяналт болон нөлөөгүй гэдгийг илэрхийлж байна. Иймд удирдлага нь ХДК-ийн үйл ажиллагааны үр дүнг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлагагүй гэж үзсэн.

Үндэсний баялгийн сан. Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдаж газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Монгол Улсын одоогийн болон ирээдүйн иргэдэд тэгш, шударга хуваарилах зорилгоор (i) Хуримтлалын сан, (ii) Ирээдүйн өв сан, (iii) Хөгжлийн сан гэсэн гурван төрөлжсөн санг Сангийн яам Монголбанкинд эзэмшүүлж байна. Сангийн яам нь 2025 оны 12 дугаар сарын 31 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хуримтлалын сан болон Ирээдүйн өв сангийн дансуудыг Монголбанкинд байршуулж байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хуримтлалын сан. Монголбанк нь Сангийн яамтай Хуримтлалын сангийн хадгаламжийн дансыг удирдах болон өсгөх тухай 2024 оны 5 дугаар сарын 9-ний өдөр гэрээ байгуулсан бөгөөд уг хадгаламж нь нэг жилийн хугацаатай, бодлогын хүүтэй тэнцэх хүүгийн түвшинд байршуулсан. Гэрээний дагуу хуримтлалын сангаар санхүүжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийн үндсэн хөрөнгө оруулалтын шийдвэрийг Монголбанк гаргадаг тул зээлийн эрсдэлийг Монголбанк хүлээдэг байсан. Удирдлагын үзэж байгаагаар (2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар) Монголбанк нь Хуримтлалын сангаар санхүүжүүлсэн ипотекийн зээлийн эрсдэл болон өгөөжийг хүлээж байгаа тул Хуримтлалын санг санхүүгийн тайланд нийт дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэх нь зохистой гэж үзсэн.

Монгол Улсын Засгийн газрын баталсан 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 72 дугаар тогтоолоор Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын журам болон эрх олголтыг тогтоосон, 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 228 дугаар тогтоолоор ипотекийн зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор Хуримтлалын сангийн нийт санхүүжилтийн хэмжээг тогтоосон. Засгийн газрын 72 болон 228 дугаар тогтоолуудын дагуу Банк 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Сангийн яамтай Хуримтлалын сангийн хөрөнгийг үнэ цэнэ болон хөрвөх чадварыг хадгалан сангийн эх үүсвэрээр орон сууцны ипотекийн зээлийг санхүүжүүлж, үлдэгдэл хөрөнгөд бодлогын хүүгээр хүү тооцох, 1 жилийн хугацаатай удирдлагын гэрээ байгуулсан. Тус гэрээний дагуу Хуримтлалын сангийн эх үүсвэрээр олгосон орон сууцны ипотекийн зээлийн хөрөнгө оруулалтын үндсэн шийдвэрийг Сангийн яам гаргах болсон тул Банк уг зээлийн зээлийн эрсдэлийг хүлээхгүй болсон. Банк нь Хуримтлалын сангаар санхүүжүүлсэн ипотекийн зээлийн эрсдэл болон өгөөжийг хүлээхгүй тул Хуримтлалын санг санхүүгийн тайланд цэвэр дүнгээр санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэх нь зохистой гэж үзсэн. Иймд Банк 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр 480,211 сая төгрөгийн дансны үлдэгдэл бүхий өмнө олгогдсон орон сууцны ипотекийн зээлийг Сангийн яаманд шилжүүлсэн (Тодруулга 9-ийг харна уу). Хуримтлалын сангийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 21,923 сая төгрөг байна (2024: 495,647 сая төгрөг). Энэхүү санхүүжилтын данс нь жилийн 12%-ийн хүүтэй (2024: 10%-ийн бодлогын хүү) байна. Тодруулга 22-ыг харна уу.

Ирээдүйн өв сан. Монгол Улсын Засгийн газар 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагын журам болон эрх олголтыг тогтоосон 72 дугаар тогтоол гаргасан. Энэхүү тогтоолын дагуу Банк Сангийн яамтай 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Ирээдүйн өв сангийн гадаад валютын хадгаламжийн гэрээг нэг жилийн хугацаатай байгуулсан. Хадгаламжийн гэрээний дагуу Сангийн яам нь Ирээдүйн өв сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтаас олж буй өгөөжтэй тэнцэх хүүтэй, 90 хоногийн хугацаатай богино хугацааны гадаад валютын хадгаламжийг Банкинд байршуулдаг. Ирээдүйн өв сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын үндсэн шийдвэрийг Банк гаргадаг тул уг хөрөнгө оруулалтын зээлийн эрсдэлийг Банк хүлээдэг. Иймд Банк нь Ирээдүйн өв сангийн эрсдэл болон өгөөжийг хүлээж байгаа гэж үзсэн тул тус санг нийт дүнгээр санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэх нь зохистой гэж үзсэн. Ирээдүйн өв сангийн хадгаламжийн дансны үлдэгдэл 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,336 сая ам.доллар буюу 4,762,664 сая төгрөгтэй тэнцэх (2024 онд 1,162 сая ам.доллар буюу 3,974,519 сая төгрөг) бөгөөд хадгаламж нь жилийн 3.78%-ийн хүүтэй, 90 хоногийн хугацаатай (2024: хүү тооцдоггүй харилцах данс). Тодруулга 22-ыг харна уу.

5 ШИНЭ БОЛОН ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ

Дараах өөрчлөлтүүд 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн:

“НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө” стандартад орсон өөрчлөлт: Валютын үл хөрвөх байдал (2023 оны 8 дугаар сард батлагдан гарсан, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаануудад хүчин төгөлдөр болно). 2023 оны 8 сард НББОУСЗ нь НББОУС 21 стандартад нэмэлт өөрчлөлт оруулж, валют хоорондын солилцооны боломжгүй нөхцөлд байгууллагууд хоёр валютын хоорондын солилцооны боломжийг үнэлэх болон тухайн үеийн спот ханшийг тогтоох аргачлалтай болох боломжийг бүрдүүлсэн. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь тухайн байгууллагад тодорхой зорилгоор хэмжилтийн өдөрт гадаад валютыг өөр валют руу солих боломжгүй гүйлгээ эсвэл үйл ажиллагаа байгаа тохиолдолд хамаарна. НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлт нь тухайн үеийн спот ханшийг хэрхэн тооцоолох талаар нарийвчилсан шаардлагыг тусгаагүй болно. Харин үүний оронд хэмжилтийн өдрийн тухайн үеийн спот ханшийг байгууллага тогтоох боломжтой хүрээг тогтоосон. Шинэ шаардлагыг хэрэгжүүлэхдээ өмнөх харьцуулсан мэдээллийг дахин тооцоолохыг зөвшөөрдөггүй. Харин анх удаа хэрэгжүүлэх өдрийн байдлаар нөлөөлөлд өртсөн дүнг тооцоологдсон тухайн үеийн спот ханшаар хөрвүүлэх шаардлагатай бөгөөд энэ үед зөрүүг хуримтлагдсан ашиг эсвэл хуримтлагдсан хөрвүүлэлтийн зөрүүгийн нөөц санд тохируулан бүртгэнэ.

Шинээр батлагдсан СТОУС болон нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх нь Банкны санхүүгийн тайлангуудад материаллаг хэмжээний нөлөө үзүүлэхгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЭЛ

2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд заавал мөрдөх стандарт болон тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг банк хугацаанаас нь өмнө хэрэгжүүлж эхлээгүй болно.

Шинэ стандарт, нэмэлт өөрчлөлтүүд	Дагаж мөрдөх хугацаа
Санхүүгийн хэрэгслийн ангилал ба хэмжилтэд орсон нэмэлт өөрчлөлтүүд СТОУС 9 болон СТОУС 7-д орсон нэмэлт өөрчлөлтүүд (2024 оны 5-р сарын 30-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2026 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн эсвэл түүнээс хойш хүчинтэй).	2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр
Сэргээгдэх эрчим хүч ашиглах гэрээ СТОУС 9 болон СТОУС 7-д орсон өөрчлөлтүүд (2024 оны 12-р сарын 18-ны өдөр нийтлэгдсэн бөгөөд 2026 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчинтэй).	2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр
СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын жилийн сайжруулалт (2024 оны 7-р сард нийтлэгдсэн бөгөөд 2026 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчинтэй).	2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр
СТОУС 18 Санхүүгийн тайлангийн тодруулга ба толилуулга (2024 оны 4-р сарын 9-ний өдөр нийтлэгдсэн бөгөөд 2027 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн эсвэл түүнээс хойш хүчинтэй).	2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр
СТОУС 19 Олон нийтэд хамааралгүй охин компаниуд (2024 оны 5-р сарын 9-ний өдөр нийтлэгдсэн бөгөөд 2027 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойш хүчинтэй).	2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр
СТОУС 14 Зохицуулалтаар хойшлогдсон дансууд (2014 оны 1-р сарын 30-ны өдөр нийтлэгдсэн)	Тодорхойгүй
Хөрөнгө оруулагч болон түүний холбоотой компани эсвэл хамтарсан компани хоорондын хөрөнгийн борлуулалт эсвэл хувь оролцоо – СТОУС 10 болон СТОУС 28-д оруулсан өөрчлөлтүүд (2014 оны 9-р сарын 11-ний өдөр нийтлэгдсэн бөгөөд НББОУСЗ-өөс тодорхойлогдох өдөр эсвэл түүнээс хойш хүчинтэй).	Тодорхойгүй

Дээр дурдсанаас бусад тохиолдолд Банк эдгээр нэмэлт, өөрчлөлтүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг одоогоор үнэлж байна.

Банк дээрх стандартын өөрчлөлтүүд санхүүгийн тайланд хэрхэн нөлөөлөх талаар судалж байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	Тодруулга	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Бэлэн мөнгө		395,506	95,661
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө:			
- Гадаад валютын богино хугацаат хадгаламж	8	7,600,098	5,159,918
- Хугацаагүй хадгаламж	8	1,772,411	1,077,794
- Зээлжих тусгай эрх	8	314,495	308,666
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан		(1,036)	(279)
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		10,081,474	6,641,760

Дээрх хүснэгтэд мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүнг толилуулсан бөгөөд ХБЭА-ын хэмжилтийн аргын талаар Тодруулга 34-өөс харна уу.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгөнд түргэн хугацаанд хөрвөх боломжтой, үнэ цэнийн өөрчлөлтийн эрсдэл багатай хөрөнгийг хамруулна. Үүнд, бэлэн мөнгө болон шаардлагатай үед татан авах боломжтой, эсвэл гурван сараас бага хугацаатай, богино хугацаанд ашиглах боломжтой санхүүгийн хөрөнгө багтана. Гурван сараас дээш хугацаатай хөрөнгийг санхүүгийн байдлын тайлан болон мөнгөн гүйлгээний тайлан дах мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд хамруулахгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг дараах үндэслэлийн дагуу ХӨ-өөр хэмжин тайлагнасан. Үүнд: (i) хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд тухайн мөнгөн урсгал нь зөвхөн ЗХҮТ-ийн шалгуурыг хангадаг, (ii) хөрөнгө нь ААБҮЦ-ээр бүртгэгддэггүй.

Мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан төлбөр болон орлого нь Банкны мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн шилжүүлгийг илэрхийлдэг. Банкны харилцагч талуудын харилцах дансанд бүртгэсэн дүнг оролцуулан, зээлийн хүүгийн авлага, арилжааны банкнуудын харилцагчдын харилцах данснаас суутгасан үндсэн төлбөр, харилцагчдад олгосон зээл ба зээлийн хүүгийн төлөлт зэргийг оролцуулах ба эдгээр төлөлтүүд нь харилцагчдын мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болно.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлийн эрсдэлийн чанарын үзүүлэлтийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд тайлагнав. Банкны эрсдэлийн үнэлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 34-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2025 оны 12 дугаар сарын 31			2024 оны 12 дугаар сарын 31		
	Нийт дансны дүн	Эрсдэлийн алдагдлын сан	Дансны дүн	Нийт дансны дүн	Эрсдэлийн алдагдлын сан	Дансны дүн
<i>Сая төгрөгөөр</i>						
Онц сайн						
Гадаад валютын богино хугацаат хадгаламж	7,600,098	(1,014)	7,599,084	5,159,918	(276)	5,159,642
Хугацаагүй хадгаламж	1,772,411	(22)	1,772,389	1,077,794	(3)	1,077,791
Зээлжих тусгай эрх	314,495	-	314,495	308,666	-	308,666
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд багтах гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, бэлэн мөнгийг оруулахгүйгээр	9,687,004	(1,036)	9,685,968	6,546,378	(279)	6,546,099

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг ХБЭА-ын үнэлгээний зорилгоор шатлал 1-д ангилсан бөгөөд тухайн хөрөнгө байршиж буй гадаадын төв банк болон санхүүгийн байгууллага нь зээлжих зэрэглэлийн үнэлгээ хийлгэдэггүй (жишээ нь Английн Төв Банк) бол тухайн улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг авч үздэг.

Банк нь бэлэн мөнгө болон ОУВС дээрх зээлийн тусгай эрхтэй холбоотой үүсч болох зээлийн эрсдэлийг бага гэж үнэлсэн. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эрсдэлийн үнэлгээг Тодруулга 34-өөс, холбоотой талуудтай хийсэн гүйлгээ болон үлдэгдлийн талаарх мэдээллийг Тодруулга 33-аас тус тус харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8 ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Гадаад валютын богино хугацаат хадгаламж	7,600,098	5,159,918
Хугацаагүй хадгаламж	1,772,411	1,077,794
Зээлжих тусгай эрх	314,495	308,666
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	224	214
Бусад хувь хөрөнгө	15	13
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(1,036)	(279)
Нийт гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	9,686,207	6,546,326

Банк нь гадаадын санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийн дансандаа мөнгө байршуулсан үед тухайн хөрөнгийг “гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөөр” хүлээн зөвшөөрдөг. Энэхүү хөрөнгийг дараах тохиолдолд ХӨ-өөр бүртгэнэ: (1) хөрөнгийг зөвхөн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилготой байршуулсан бөгөөд мөнгөн урсгал нь ЗХҮТ-өөс бүрдсэн (2) хөрөнгө нь ААБҮЦ-ээр бүртгэгдээгүй.

Банк нь бусад орнуудын төв банкууд болон нэр хүнд бүхий олон улсын байгууллагад харилцах, хадгаламж байршуулдаг бөгөөд зээлийн эрсдэлийн томоохон төвлөрөлтэй ба үүнд: Францын Төв Банкинд 3,735,043 сая төгрөг (2024: 3,395,427 сая төгрөг), Английн Төв Банкинд 2,946,863 сая төгрөг (2024: 393,846 сая төгрөг), бусад орны төв банк болон санхүүгийн байгууллагуудад нийтдээ 2,690,604 сая төгрөг (2024: 2,448,439 сая төгрөг)-ийг тус тус байршуулсан.

Эдгээр санхүүгийн байгууллага нь олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Стандарт энд Пүүрс болон/ эсвэл Фитч ба Мүүдисийн рейтингээр үнэлэхэд Аа3-аас Ааа зэрэглэлтэй буюу онц сайн үнэлгээтэй байна. Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан богино хугацаат хадгаламж болон хугацаагүй хадгаламжийн 9,372,509 сая төгрөг (2024: 6,237,712 сая төгрөг)-ийн үлдэгдэлд эрсдэлийн алдагдлын үнэлгээ хийсэн.

Гадаад валютын богино хугацаат хадгаламж. Гадаадын төв банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан 90 хүртэлх хоногийн хугацаатай (2024: 90 хоног) ам.доллар, евро, фунт стерлинг, юанийн болон бусад валютаар илэрхийлэгдэх хугацаат хадгаламжуудын дүнг илэрхийлнэ.

Хугацаагүй хадгаламж. Гадаадын төв банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах дансдын үлдэгдлийг илэрхийлнэ.

Зээлжих тусгай эрх (ЗТЭ). Монгол Улсын эзэмшиж буй ОУВС-тай холбоотой зээлжих тусгай эрхийн хадгаламжийг илэрхийлнэ. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 64.5 сая ЗТЭ (2024: 69.2 сая ЗТЭ)-ийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 3.26% (2024: 3.44%)-ийн хүүтэй байна.

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө. Дэлхийн банкны гишүүнчлэлийн нөхцөлийн дагуу байршуулсан хөрөнгө. Энэхүү хөрөнгө нь харгалзах өр төлбөрийн дүнтэй тэнцүү ба хүү тооцдоггүй (Тодруулга 24-ийг харна уу). Тус хөрөнгийг Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын төв банк болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагад байршуулсан тул үнэ цэнийн бууралт үүсэхгүй гэж үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8 ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ
(ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад хувь хөрөнгө. Монгол Улс олон улсын гадаад төлбөр тооцооны СВИФТ системд нэгдэн орж гишүүн улс болох үед төлсөн хураамжийн дүнгээс бүрдэнэ.

ХБЭА-ын хэмжилтийн зорилгоор зээлийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн дүн болон зээлийн эрсдэлийн үзүүлэлтийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа. Эдгээр хөрөнгийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын төв банк болон нэр хүнд бүхий олон улсын байгууллагад байршуулсан тул ХБЭА-ын үнэлгээний 1-р шатлалд хамруулдаг. Банкны ашиглаж буй зээлийн эрсдэлийн үнэлгээ болон бусад банкнуудад байршуулсан хөрөнгөд хамаарах хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилтийн аргачлал, үүнд дефолтын тодорхойлолт болон зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ)ийн тодорхойлолтыг багтаасан дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 34-өөс харна уу.

Доорх хүснэгтэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ба 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн дүн болон эдгээр хөрөнгийн эрсдэлд өртөх дээд хэмжээг харууллаа:

	2025 оны 12 дугаар сарын 31			2024 оны 12 дугаар сарын 31		
	Нийт дансны дүн	Эрсдэлийн алдагдлын сан	Дансны дүн	Нийт дансны дүн	Эрсдэлийн алдагдлын сан	Дансны дүн
<i>Сая төгрөгөөр</i>						
Онц сайн						
Гадаад валютын богино хугацаат хадгаламж	7,600,098	(1,014)	7,599,084	5,159,918	(276)	5,159,642
Хугацаагүй хадгаламж	1,772,411	(22)	1,772,389	1,077,794	(3)	1,077,791
Зээлжих тусгай эрх	314,495	-	314,495	308,666	-	308,666
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	224	-	224	214	-	214
Бусад хувь хөрөнгө	15	-	15	13	-	13
Нийт гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	9,687,243	(1,036)	9,686,207	6,546,605	(279)	6,546,326

ОУВС-ийн хувь хөрөнгө, Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө, бусад хувь хөрөнгө нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагад харьяалагддаг орнуудын төв банкинд байршдаг тул зээлийн эрсдэл учруулахгүй гэж үзсэн.

Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө нь барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй. Эдгээр хөрөнгийн бодит үнэ цэнийн үнэлгээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 35, хүүгийн түвшний шинжилгээг Тодруулга 34-т тус тус тусган толилуулав.

Тайлант хугацааны гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн дансны нийт дүн, эрсдэлийн алдагдлын сангийн дүн, тэдгээрийн өөрчлөлт, хөдөлгөөнийг доорх хүснэгтэд толилуулав.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8 ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ
(ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Нийт дансны дүн		
1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл	6,546,605	7,169,453
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	53,664,646	50,788,165
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(50,840,218)	(51,297,097)
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(2,260)	(12,383)
Гадаад валютын хөрвүүлэлт	318,470	(101,533)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	9,687,243	6,546,605
Эрсдэлийн алдагдлын сан		
1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл	279	544
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	815	148
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(58)	(413)
Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт	757	(265)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,036	279
Нийт гадаадын байгууллагад байршуулсан хөрөнгө	9,686,207	6,546,326

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9 ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Орон сууцны үнийг тогтворжуулах хөтөлбөр	181,426	1,400,969
Алт-2 хөтөлбөр	-	5,080
Бусад зээл	502	1,535
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(2,605)	(18,337)
Хорогдуулсан өртгөөрх дотоодын банкуудад олгосон зээл	179,323	1,389,247
ААБҮЦ-ээрх дотоодын банкуудад олгосон зээл	-	32,620
Нийт банкуудад олгосон зээл	179,323	1,421,867

Доорх хүснэгтэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дотоодын банкуудад олгосон зээлийн өөрчлөлт, хөдөлгөөнийг харуулав.

Сая төгрөгөөр	Тодруулга	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Дотоодын банкуудад олгосон зээлийн 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл		1,421,867	1,562,975
Мөнгөн гүйлгээ			
Зээлийн эргэн төлөлт		(29,603)	(1,087,302)
Зээл олголт		566,806	1,342,081
Төлөгдсөн хүү		(20,184)	(133,560)
Мөнгөн бус гүйлгээ			
Давуу эрхтэй ИЗББ-руу шилжсэн	4,10	(1,318,254)	(373,197)
Зээл шилжүүлэлт*		(480,211)	-
Хуримтлуулсан хүү		19,202	86,444
Бусад өөрчлөлт		19,700	24,426
Дотоодын банкуудад олгосон зээлийн 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл		179,323	1,421,867

***Зээл шилжүүлэлт.** 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу Банк орон сууцны ипотекийн зээлийг Хуримтлалын сангийн санхүүжилтээр арилжааны банкуудад олгосон. 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Банк нь Сангийн яамтай Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, аривжуулах гэрээг Засгийн газрын 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 72 тоот болон 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 228 тоот тогтоолын дагуу байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд Банк өмнө олгосон орон сууцны ипотекийн зээлүүдийг 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Сангийн яаманд шилжүүлсэн. Үүнтэй холбоотой удирдлагын дүгнэлтийг Тодруулга 4-өөс, Засгийн газрын хөрөнгөтэй холбоотой бууралтыг Тодруулга 22-оос тус тус харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9 ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн дотоодын банкуудад олгосон зээлийн дүн болон тэдгээрт байгуулсан эрсдэлийн алдагдлын санг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр доорх хүснэгтэд харуулав.

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31			2024 оны 12 дугаар сарын 31		
	Нийт дансны дүн	Эрсдэлийн алдагдлын сан	Дансны дүн	Нийт дансны дүн	Эрсдэлийн алдагдлын сан	Дансны дүн
Орон сууцны ипотекийн зээл	181,426	(2,596)	178,830	1,400,969	(18,323)	1,382,646
Алт-2 хөтөлбөр	-	-	-	5,080	-	5,080
Бусад зээл	502	(9)	493	1,535	(14)	1,521
ХӨ-өөр бүртгэсэн харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны нийт дүн	181,928	(2,605)	179,323	1,407,584	(18,337)	1,389,247

Банк дотоодын банкнаас авсан зээлийг бий болгох эсвэл худалдан авахад урьдчилгаа мөнгийг шилжүүлсэн үед банкуудад олгосон зээлийг хүлээн зөвшөөрөх ба бизнес загвар болон мөнгөн урсгалын онцлог шинжид үндэслэн тухайн зээлийг дараах ангиллын аль нэгээр бүртгэдэг: (i) ХӨ: гэрээнээс үүсэх мөнгөн урсгалыг цуглуулах, мөнгөн урсгал нь ЗХҮТ-өөс бүрдэж байгаа, тухайн хөрөнгийг ААБҮЦ гэж ангилаагүй, (ii) ААБҮЦ: зээл нь ЗХҮТ эсвэл ААБҮЦ-ээр хэмжигдэх ХӨ болон БДОБҮЦ-ийн бусад шалгуурыг хангаагүй.

Зээлийн үнэ цэнийн бууралтын санг байгуулахдаа ирээдүйд чиглэсэн ХБЭА-ын загварт суурилдаг бөгөөд ХБЭА-ын загварын хэмжилтэд ашигласан орц, таамаглал болон тооцоолсон аргачлалын талаарх дэлгэнгүй мэдээллийг Тодруулга 34-өөс харна уу.

Хорогдуулсан өртөг (ХӨ) гэдэг нь санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүнд санхүүгийн хэрэгслийг анхлан хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт болон дуусгавар болох хугацаа хүртэлх үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолсон хөнгөлөлт, урамшууллын дүн багтдаг. Хуримтлагдсан хүүгийн орлого болон хуримтлагдсан хүүгийн зардал нь хуримтлагдсан купон болон хорогдуулсан урамшуулал буюу хөнгөлөлт (хэрэв байгаа бол анх олголтын үед хойшлогдсон шимтгэлийг оролцуулан)-ийг хамрах бөгөөд эдгээрийг тусад нь тусган харуулахгүй, харин санхүүгийн байдлын тайланд холбогдох үзүүлэлтийн дансны үнэд багтаан бүртгэлд тусгадаг.

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг холбогдох хугацааны туршид дансны үнээс тогтмол хувиар (үр ашигт хүүгийн түвшин) тооцож, хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн түвшин гэдэг нь санхүүгийн хэрэгслийн ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн орлого эсвэл мөнгөн төлбөрийг (ирээдүйд гарах эрсдэлийн алдагдлыг хасаж) санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд аль богино хугацаанд хөнгөлөлт тооцож, тухайн санхүүгийн хэрэгслийн нийт дансны дүнтэй тэнцүү байлгах хүүгийн түвшин юм.

9 ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хувьсах хүүтэй хэрэгслийн хувьд мөнгөн урсгалыг дараагийн хүү өөрчлөгдөх хүртэлх хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хорогдуулах бөгөөд ингэхдээ урамшуулал болон хямдруулалтын дүнг өөрчлөхгүй. Учир нь хямдруулалт болон урамшуулал нь тухайн санхүүгийн хэрэгслийн хувьсах хүүг дагаж өөрчлөгддөггүй, харин хөвөгч хүүтэй холбоотой эрсдэлийн тархалт гэх мэт бусад хувьсагчаас хамаардаг. Урамшуулал болон хямдруулалтыг тухайн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулан тооцно. Өнөөгийн үнэ цэнийн тооцооллод тухайн санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой бүх хураамж, шимтгэлийн дүнг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн нэг бүрэлдэхүүн хэсэг болно. Үнэ цэнийн бууралттай хөрөнгө худалдаж авсан тохиолдолд үр ашигт хүү нь тухайн санхүүгийн хэрэгслийн гэрээнд заасан ирээдүйн мөнгөн урсгалд суурилахгүй харин хүлээгдэж буй мөнгөн урсгалд суурилна.

Гүйлгээний зардал нь санхүүгийн хэрэгслийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэгдэл зардал юм. Нэмэгдэл зардал гэдэг нь тухайн гүйлгээ хийгдээгүй бол үүсэхгүй байх байсан зардал байна. Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч (борлуулалтын агентын гүйцэтгэж буй ажилчид), зөвлөх, брокер, дилерт төлсөн хураамж шимтгэл, агент, зохицуулагч байгууллагууд болон хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөр, шилжүүлгэд ногдуулсан татвар хураамж хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт, урамшуулал, хүүгийн зардал, захиргааны болон хадгалалтын зардал хамаарахгүй.

Зээлийн эрсдэлийн сан - ХБЭА. Банк нь ХӨ болон БДОБҮЦ-ээр ангилах санхүүгийн хөрөнгөтэй холбоотой ХБЭА-ыг тооцохдоо ирээдүйн нөхцөл байдалд суурилж үнэлгээг хийдэг бөгөөд ХБЭА-ын Алдагдлын өөрчлөлтийг тайлант хугацаа бүрийн эцэст хүлээн зөвшөөрдөг. ХБЭА нь (i) олон хувилбар бүхий үр дүнг магадлалаар жигнэж тодорхойлсон дүн; (ii) мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; (iii) өнгөрсөн үйл явдал, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хялбар олдохуйц, бэлэн мэдээлэлд үндэслэн тооцоолсон дүн юм.

ХӨ-өөрх өрийн хэрэгслийг санхүүгийн байдлын тайланд ХБЭА-ын дүнг хассан дүнгээр тайлагнана. Санхүүгийн баталгааны хувьд ХБЭА-ыг санхүүгийн байдлын тайланд өр төлбөрөөр тусад нь тайлагнана. БДОБҮЦ-ээрх өрийн хэрэгслийн хорогдуулсан өртгийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх бол бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд олз, гарзаар тайлагнана.

Банк нь тухайн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш ХБЭА-ын 3 шатлал бүхий загварыг ашиглан хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хэмждэг бөгөөд үнэ цэнийн бууралт үүсээгүй хөрөнгө нь «Шатлал 1"-д ангилагдана. Энэ ангилал дах хөрөнгийн ХБЭА-г тооцохдоо тайлант өдрөөс хойш 12 сарын дотор тухайн хөрөнгөтэй холбоотой үүсч болох хүлээгдэж буй алдагдлын дүнг ашиглана.

Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн хөрөнгийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн байвал хөрөнгийг «Шатлал 2"-д ангилах бөгөөд ХБЭА-г тооцохдоо хугацааны эцэс хүртэл хүлээгдэж буй алдагдлын дүнг ашиглана. Зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан эсэхийг Банк хэрхэн хэмждэг талаар Тодруулга 34-өөс харна уу. Хэрэв Банк нь санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзвэл хөрөнгийг «3-р шатлал» руу ангилах ба ХБЭА-ыг хөрөнгийн нийт хугацааны эрсдэлийн алдагдлаар хэмжинэ. Үнэ цэнэ буурсан хөрөнгийн болон дефолтын тодорхойлолтыг Тодруулга 34-өөс харна уу. Үнэ цэнийн бууралттай санхүүгийн хэрэгслийг худалдаж авах үед ХБЭА-ыг тооцохдоо тухайн хөрөнгийн нийт хугацааны эрсдэлийг авч үзнэ. ХБЭА-ын үнэлгээнд ашигласан мэдээллийн дэлгэрэнгүйг Тодруулга 34-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9 ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл

Орон сууцны ипотекийн зээл. Банк, Засгийн газар, Монголын ипотекийн корпораци хамтран байгуулсан “Ипотекийн зээлийг санхүүжүүлэх гэрээ”-ний дагуу эдгээр зээлийг олгодог бөгөөд Банк болон дотоодын банкууд зээлийн нөхцлийг тодорхойлох эрхгүй. Банк нь зээлийн төлбөрт давуу эрхтэй ИЗББ авдаг. Эдгээр зээлийн хүүгийн түвшин 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар жилийн 2 хувь (2024: 2%-6%), хугацаа нь 1-2 жил (2024:1-9 жил) байна. Удирдлага нь эдгээр зээлийн анх хүлээн зөвшөөрсөн дүнд алдагдал тооцох шаардлагагүй гэж үзсэн. Удирдлагын дүгнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 4-өөс харна уу.

Алт - 2 хөтөлбөр. Зээл нь жилийн 10%-12% (2024: 10%-12%) хүүтэй, 2-3 жилийн хугацаатай (2024: 2-3 жил) бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Алт-2 хөтөлбөр бүрэн төлөгдсөн байна (2024: 5,080 сая төгрөг).

Бусад зээл

Төгрөгөөр олгосон зээл. Герман Улсын засгийн газрын (КФВ) дэмжлэгтэйгээр дотоодын банкинд олгосон зээл бөгөөд энэ нь 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр бүрэн төлөгдөж дууссан (2024: 971 сая төгрөг).

Гадаад валютын зээл. Дотоодын банкны мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, банкны системийг сайжруулах хүрээнд АХБ-наас олгосон хөтөлбөрийн зээл бөгөөд 502 сая төгрөг (2024: 564 сая төгрөг)-ийн үлдэгдэлтэй байна.

Энэхүү зээлийг Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан гэрээний дагуу “Ди-Эй-Ай” (Тайланд) Лимитед компанийн зохион байгуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор олгосон бөгөөд 14 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй.

ААБҮЦ-ээрх дотоодын банкуудад олгосон зээл. 13 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай ипотекийн зээлийг дотоодын банкуудад олгосон бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бүрэн төлөгдөж дууссан байна.

Тодруулга 34-т дурдсанчлан дотоодын томоохон банкууд нь олон улсын үнэлгээний агентлагуудаар зээлжих зэрэглэлийн үнэлгээ хийлгэдэг. Үнэлгээ хийгдээгүй банкуудын хувьд Монголбанк нь хөрөнгийн зээлийн чанарыг сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон холбогдох бусад мэдээлэлд үндэслэн үнэлдэг.

Дотоодын банкуудад олгосон зээлд байгуулсан хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санд орсон өөрчлөлт нь хэд хэдэн хүчин зүйлсээс шалтгаалдаг бөгөөд тайлант хугацаанд орсон өөрчлөлтийг доорх хүснэгтэд харууллаа:

- Зээлийн эрсдэлийн зэрэглэл болон үнэ цэнийн бууралтаас шалтгаалж 12 сар болон хугацааны эцэс хүртэлх ХБЭА-ын хооронд «ангилал ахих» (эсвэл «буух») хөдөлгөөн орж 1, 2 болон 3-р шатлал хооронд орсон шилжилт;
- Санхүүгийн хэрэгслүүдэд шинээр байгуулсан сангийн өөрчлөлт болон данснаас хассан санхүүгийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтын буцаалт

Дараах хүснэгтэд банкуудад олгосон ХӨ-өөр бүртгэгдсэн зээлийн дансны үнэ болон эрсдэлийн алдагдлын санд орсон өөрчлөлтийг харуулж тайлант хугацааны эхний болон эцсийн үлдэгдлүүдийг тайлагнав.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9 ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ХӨ-өөр бүртгэгдсэн банкуудад олгосон зээлийн дансны нийт үнэ болон эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлтийг харууллаа:

Сая төгрөгөөр	Шатлал 1			Нийт дүн
	Үнийн тогтворжуулалтын хөтөлбөрийн хүрээнд орон сууцны ипотекийн зээл (Шатлал 1)	АЛТ - 2 Хөтөлбөр (Шатлал 1)	Бусад зээл (Шатлал 1)	
Дансны нийт үнэ				
2025 оны 1 дүгээр сарын 1	1,400,969	5,080	1,535	1,407,584
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн зардлын нөлөөний өөрчлөлт:				
- Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	566,806	-	-	566,806
- Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(1,785,176)	(5,070)	(1,054)	(1,791,300)
- Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(1,173)	(10)	(1)	(1,184)
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн зардлын нөлөөний нийт өөрчлөлт	(1,219,543)	(5,080)	(1,055)	(1,225,678)
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн зардалд нөлөөлөхгүй өөрчлөлт:				
Гадаад валютын ханшийн болон бусад өөрчлөлт	-	-	22	22
2025 оны 12 дугаар сарын 31	181,426	-	502	181,928
Эрсдэлийн алдагдлын сан				
2025 оны 1 дүгээр сарын 1	18,323	-	14	18,337
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн зардлын нөлөөний өөрчлөлт:				
- Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(15,727)	-	(7)	(15,734)
- Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	-	-	2	2
Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн зардлын нөлөөний нийт өөрчлөлт	(15,727)	-	(5)	(15,732)
2025 оны 12 дугаар сарын 31	2,596	-	9	2,605

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9 ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэд 2024 оны ХӨ-өөр бүртгэгдсэн банкуудад олгосон зээлийн дансны нийт үнэ болон эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлтийг харууллаа.

Сая төгрөгөөр	Шатлал 1					Нийт дүн
	Үнийн тогтворжуулалтын хөтөлбөрийн хүрээнд орон сууцны ипотекийн зээл (Шатлал 1)	Барьцаат зээл (Шатлал 1)	Шатахууны үнийг тогтворжуулах хөтөлбөр (Шатлал 1)	АЛТ - 2 Хөтөлбөр (Шатлал 1)	Бусад зээл (Шатлал 1)	
Сая төгрөгөөр						
Дансны үнэ						
2024 оны 1 дүгээр сарын 1	685,641	429,893	338,484	17,693	3,684	1,475,395
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн зардлын нөлөөний өөрчлөлт:						
- Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	1,035,009	225,563	-	-	-	1,260,572
- Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(320,719)	(654,563)	(292,386)	(12,583)	(2,147)	(1,282,398)
- Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(66)	(893)	(46,098)	(30)	(2)	(47,089)
- Бусад өөрчлөлт	1,104	-	-	-	-	1,104
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн зардлын нөлөөний нийт өөрчлөлт	715,328	(429,893)	(338,484)	(12,613)	(2,149)	(67,811)
2024 оны 12 дугаар сарын 31	1,400,969	-	-	5,080	1,535	1,407,584
Эрсдэлийн алдагдлын сан						
2024 оны 1 дүгээр сарын 1	14,674	9,248	6,791	-	101	30,814
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн зардлын нөлөөний өөрчлөлт:						
- Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	13,519	-	-	-	2	13,521
- Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(9,883)	(9,248)	(5,781)	-	(87)	(24,999)
- Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	13	-	(1,010)	-	(2)	(999)
Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн зардлын нөлөөний нийт өөрчлөлт	3,649	(9,248)	(6,791)	-	(87)	(12,477)
2024 оны 12 дугаар сарын 31	18,323	-	-	-	14	18,337

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9 ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХӨ-өөр бүртгэгдсэн дотоодын банкуудад олгосон зээлийн хувьд эрсдэлийн чанар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна:

	Шатлал 1		Нийт дүн
	Орон сууцны ипотекийн зээл (Шатлал 1)	Бусад зээл (Шатлал 1)	
<i>Сая төгрөгөөр</i>			
-Сайн	181,426	502	181,928
Нийт дансны үнэ	181,426	502	181,928
Эрсдэлийн алдагдлын сан	(2,596)	(9)	(2,605)
Дансны дүн	178,830	493	179,323

ХӨ-өөр бүртгэгдсэн дотоодын банкуудад олгосон зээлийн хувьд эрсдэлийн чанар 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна:

	Шатлал 1			Нийт дүн
	Орон сууцны ипотекийн зээл (Шатлал 1)	Алт-2 хөтөлбөр (Шатлал 1)	Бусад зээл (Шатлал 1)	
<i>Сая төгрөгөөр</i>				
-Сайн	1,400,969	5,080	1,535	1,407,584
Нийт дансны үнэ	1,400,969	5,080	1,535	1,407,584
Эрсдэлийн алдагдлын сан	(18,323)	-	(14)	(18,337)
Дансны дүн	1,382,646	5,080	1,521	1,389,247

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9 ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХӨ-өөр бүртгэгдсэн дотоодын банкуудад олгосон зээлийн барьцаа хөрөнгийн дүн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

Сая төгрөгөөр	Орон сууцны ипотекийн зээл	Бусад зээл	Нийт дүн
Барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй	181,426	502	181,928
Дотоодын банкуудад олгосон нийт ХӨ-өөрх зээлийн дүн (дотоодын банкуудад олгосон зээлийн эрсдэлд өртөх ХӨ- өөрх зээлийн дүн)	181,426	502	181,928

ХӨ-өөр бүртгэгдсэн дотоодын банкуудад олгосон зээлийн барьцаа хөрөнгийн дүн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

Сая төгрөгөөр	Орон сууцны ипотекийн зээл	Алт-2 хөтөлбөр	Бусад зээл	Нийт дүн
Зээлийн барьцаа хөрөнгө: -Төв банкны үнэт цаас	-	5,080	-	5,080
Нийт дүн	-	5,080	-	5,080
Барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй	1,400,969	-	1,535	1,402,504
Дотоодын банкуудад олгосон нийт ХӨ-өөрх зээлийн дүн (дотоодын банкуудад олгосон зээлийн эрсдэлд өртөх ХӨ-өөрх зээлийн дүн)	1,400,969	5,080	1,535	1,407,584

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10 ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

<i>Сая төгрөгөөр`</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
БДОБҮЦ-ээрх өрийн үнэт цаас	4,867,855	4,579,412
ХӨ-өөрх өрийн үнэт цаас	4,543,034	3,794,533
Нийт өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	9,410,889	8,373,945

Банк тухайн хөрөнгийг удирдаж буй бизнес загвар болон мөнгөн урсгалын онцлогт үндэслэн өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг ХӨ, БДОБҮЦ эсвэл ААБҮЦ-ээр ангилдаг. Өрийн үнэт цаасыг гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд мөнгөн урсгал нь ЗХҮТ-ийн шалгуурыг хангаж, нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах зорилгоор ААБҮЦ-ээр ангилагдаагүй бол ХӨ-өөр ангилдаг.

Хэрэв өрийн үнэт цаасыг худалдан борлуулах зорилгоор гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж аваад эзэмшсэн бол мөнгөн урсгал нь ЗХҮТ-ийн шалгуурыг хангасан, ААБҮЦ-ээр ангилагдаагүй бол өрийн үнэт цаасыг БДОБҮЦ-ээр бүртгэдэг. Эдгээр хөрөнгийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолж ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. ХБЭА-ын загварын ашиглан тооцоолсон үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх дансны үнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрдөг. Өрийн үнэт цаасыг данснаас хасах үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогоос ашиг, алдагдалд дахин ангилж бүртгэдэг.

Өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтыг ХӨ болон БДОБҮЦ-ээрх ангилалд бүртгээгүй үед ААБҮЦ-ээрх ангилалд бүртгэнэ. Банк анх хүлээн зөвшөөрөх үедээ санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлийн өөр сууриар хүлээн зөвшөөрөх эсвэл хэмжихээс үүсэх нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулж байгаа тохиолдолд өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлж, эргэж буцалтгүйгээр ангилж болно.

Буцаан худалдан авах хэлцэл нь үнэт цаас барьцаалсан санхүүжилтийн нэг хэлбэр бөгөөд үнэт цаас барьцаалан зээл авч буй тал энэхүү үнэт цаасыг данснаас хасдаггүй. Мөн, үнэт цаас барьцаалан зээл олгож буй тал тухайн үнэт цаасыг цааш нь давхар барьцаалах эсхүл зарах эрх үүсээгүй нөхцөлд санхүүжилт авч буй тал барьцааны үнэт цаасны ангилалыг солихгүй. Хэрэв барьцаалагч тал үнэт цаасыг бусдад давхар барьцаалах, эсхүл зарах эрхтэй бол санхүүжилт авч буй тал тухайн үнэт цаасыг «буцаан худалдан авах хэлцлийн авлага» ангилалд бүртгэдэг. Үнэт цаасыг зарах, буцаан худалдан авах үнийн зөрүү нь тухайн санхүүжилтийн хүү болох бөгөөд үүнийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулдаг.

Доорх хүснэгтэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг ангилал тус бүрээр харууллаа:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10 ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөгөөр	БДОБҮЦ-ээрх өрийн үнэт цаас	ХӨ-өөрх өрийн үнэт цаас	Нийт дүн
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт			
АНУ-ын засгийн газрын үнэт цаас	1,876,626	-	1,876,626
Олон улсын төлбөр тооцооны банкны бонд	1,322,675	-	1,322,675
РАМП хөрөнгө оруулалт	1,303,749	-	1,303,749
Олон улсын төлбөр тооцооны банкинд оруулсан хөрөнгө оруулалт	208,034	-	208,034
АХБ-ны бонд	138,652	-	138,652
Европын хөрөнгө оруулалтын банкны бонд	18,119	-	18,119
Давуу эрхтэй ИЗББ	-	3,803,343	3,803,343
Эрдэнэс бонд	-	849,807	849,807
Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд	-	119,072	119,072
Нийт өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	4,867,855	4,772,222	9,640,077
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	-	(229,188)	(229,188)
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх нийт өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (дансны үнэ)	4,867,855	4,543,034	9,410,889

Доорх хүснэгтэд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг ангилал тус бүрээр харууллаа:

Сая төгрөгөөр	БДОБҮЦ-ээрх өрийн үнэт цаас	ХӨ-өөрх өрийн үнэт цаас	Нийт дүн
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт			
Олон улсын төлбөр тооцооны банкны бонд	2,706,858	-	2,706,858
РАМП хөрөнгө оруулалт	1,193,924	-	1,193,924
АНУ-ын засгийн газрын үнэт цаас	451,274	-	451,274
Олон улсын төлбөр тооцооны банкинд оруулсан хөрөнгө оруулалт	190,404	-	190,404
АХБ-ны бонд	20,092	-	20,092
Европын хөрөнгө оруулалтын банкны бонд	16,860	-	16,860
Давуу эрхтэй ИЗББ	-	2,900,604	2,900,604
Эрдэнэс бонд	-	849,807	849,807
Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд	-	129,196	129,196
Нийт өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	4,579,412	3,879,607	8,459,019
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	-	(85,074)	(85,074)
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх нийт өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (дансны үнэ)	4,579,412	3,794,533	8,373,945

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10 ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

БДОБҮЦ-ээр бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

БДОБҮЦ-ээр бүртгэгдэх өрийн үнэт цаас нь ХБЭА-ын шатлал 1-д ангилагдаж байгаа бөгөөд “онц сайн” үнэлгээтэй байна. Банкны ашигладаг зээлийн эрсдэлийн ангиллын систем болон хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжих аргачлал, түүний дотор бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх өрийн үнэт цаасанд хамаарах зээлийн дефолтын тодорхойлолт болон зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ)-ийн тодорхойлолтын талаар дэлгэрэнгүйг Тодруулга 34-өөс харна уу.

АНУ-ын Засгийн газрын үнэт цаас. Санхүүгийн жилийн эцсийн байдлаар бонд нь 527.7 сая ам.доллар буюу 1,876,626 сая төгрөг (2024: 132 сая ам.доллар буюу 451,274 сая төгрөг)-ийн үлдэгдэлтэй, 1-5 жил (2024: 1-5 жил)-ийн хугацаатай, жилийн хүү болон өгөөж нь 0,75%-4.73% (2024: жилийн 2.88% -5%) байна.

Банк 2025 оны 10 дугаар сарын 5-ны өдөр Олон Улсын Төлбөр Тооцооны банк (ОУТТБ)-тай АНУ-ын Засгийн газрын үнэт цаас барьцаалан буцаан худалдан авах гэрээ байгуулсан. Гэрээний хүрээнд 2025 оны туршид нийт 13,669,957 сая төгрөг (2024: байхгүй)-ийн АНУ-ын Засгийн газрын үнэт цаасыг барьцаалсан байна. 2025 оны 12 дугаар сарын 31 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ОУТТБ-ы буцаан худалдах авах гэрээний хувьд АНУ-ын Засгийн газрын үнэт цаасыг барьцаалаагүй байна. Дэлгэрэнгүйг тодруулга 31-ээс харна уу.

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31
Буцаан худалдан авах хэлцлийн авлагын 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл	-
<i>Мөнгөн бус гүйлгээ:</i>	
Буцаан худалдан авах хэлцлийн авлагын – барьцааны амлалт	13,669,957
Буцаан худалдан авах хэлцлийн авлагын – барьцааны буцаалт	(13,696,705)
Гадаад валютын ханшийн тэгшитгэл ба бусад өөрчлөлт	26,748
Буцаан худалдан авах хэлцлийн авлагын 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	-

Олон улсын төлбөр тооцооны банкны (ОУТТБ) гаргасан бондыг зах зээлийн үнэд суурилсан бодит үнэ цэнээр хэмждэг ба хөрөнгийн биржид арилжаалагддаг өрийн үнэт цаасыг илэрхийлдэг. Санхүүгийн жилийн эцсийн байдлаар эдгээр бонд нь 244.5 сая ам.доллар, 890.6 сая юань буюу нийт 1,322,675 сая төгрөг (2024: 689.8 сая ам.доллар, 741.4 сая юань буюу нийт 2,706,858 сая төгрөг)-ийн үлдэгдэлтэй байна. Эдгээр бондын хугацаа нь 91-365 хоног (2024: 147-245 хоног) ба жилийн хүү болон өгөөж нь 0.92%-3.76% (2024: жилийн 1.49-4.82%) хүүтэй. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 34-өөс харна уу.

“Рамп” хөрөнгө оруулалтын данс. Гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулах зорилгоор Банк нь Дэлхийн банкны “Нөөцийн удирдлага болон нөөцийн удирдлагыг сайжруулахад зөвлөгөө өгөх” төслийг 2011 оноос хойш хэрэгжүүлсэн.

Хөрөнгө оруулалт дансны хөрөнгө нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 0.28 сая ам.доллар буюу 1,028 сая төгрөг (2024: 0.26 сая ам.доллар буюу 905 сая төгрөг)-ийн мөнгөн хөрөнгө, 366.3 сая ам.доллар буюу 1,302,721 сая төгрөг (2024: 348.8 сая ам.доллар буюу 1,193,019 сая төгрөг) ийн гадаадын үнэт цааснаас тус тус бүрдэж байна. Хөрөнгө оруулалтын дансны хөрөнгийг АНУ-ын Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан бөгөөд барьцаа хөрөнгөөр баталгаажуулсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10 ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хөрөнгө оруулалтын дансны хөрөнгийн дийлэнх хэсгийг бүрдүүлж буй үнэт цаасанд голчлон АНУ-ын Төрийн сангийн үнэт цаас болон бусад төрийн байгууллагаас гаргасан үнэт цаас багтдаг. Хөрөнгө оруулалтын дансны хөрөнгөнд багтсан өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн зэрэглэл нь онц сайн түвшинд байгаа бөгөөд Мүүдисийн үнэлгээгээр Аа3аас Аа1 хүртэл, эсвэл Стандарт энд Пүүрс болон/эсвэл Фитчийн үнэлгээтэй дүйцэхүйц үнэлгээтэй байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 34-өөс харна уу.

Олон улсын төлбөр тооцооны банкны (ОУТТБ) хөрөнгө оруулалт. Гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулах зорилгоор ОУТТБ-тай “Нөөцийн удирдлагыг сайжруулах зөвлөгөө ба нөөцийн удирдлагын төсөл”-ийг 2019 оноос хэрэгжүүлсэн. Энэхүү хөрөнгө оруулалт нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 58.5 сая ам.доллар буюу 208,034 сая төгрөгтэй тэнцэхүйц (2024: 55.7 сая ам.доллар буюу 190,404 сая төгрөгтэй тэнцэхүйц) үлдэгдэлтэй байна.

Хөрөнгө оруулалтын дансны хөрөнгийн дийлэнх хэсгийг бүрдүүлж буй үнэт цаасанд голчлон АНУ-ын Төрийн сангийн үнэт цаас багтдаг. Хөрөнгө оруулалтын дансны хөрөнгөнд багтсан өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн зэрэглэл нь онц сайн түвшинд байгаа бөгөөд Мүүдисийн үнэлгээгээр Аа3аас Аа1 хүртэл, эсвэл Стандарт энд Пүүрс болон/эсвэл Фитчийн үнэлгээтэй дүйцэхүйц үнэлгээтэй байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 34-өөс харна уу.

Азийн хөгжлийн банкны бонд. Азийн хөгжлийн банкнаас гаргасан бонд бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 39 сая ам.доллар буюу 138,652 сая төгрөг (2024: 5.9 сая ам.доллар буюу 20,092 сая төгрөг)-тэй тэнцэхүйц үлдэгдэлтэй байна.

Европын хөрөнгө оруулалтын банкны бонд. Европын хөрөнгө оруулалтын банкнаас гаргасан бонд бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5.1 сая ам.доллар буюу 18,119 сая төгрөг (2024: 4.9 сая ам.доллар буюу 16,860 сая төгрөг)-тэй тэнцэхүйц үлдэгдэлтэй байна.

БДОБҮЦ-ээрх өрийн үнэт цаас болон эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөнийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харуулав.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10 ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөгөөр	Эрсдэлийн алдагдлын сан		Дансны нийт дүн	
	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Нийт дүн	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Нийт дүн
2025 оны 1 дүгээр сарын 1	172	172	4,579,584	4,579,584
<i>Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын санд нөлөөлсөн өөрчлөлт:</i>				
Шинээр худалдан авсан	322	322	6,500,096	6,500,096
Бүртгэлээс хассан	(116)	(116)	(6,539,211)	(6,539,211)
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	-	94,709	94,709
Бусад өөрчлөлт	-	-	27,081	27,081
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын хасагдуулгын нөлөөг тусгасан нийт өөрчлөлт, хөдөлгөөн	206	206	82,675	82,675
<i>Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын санд нөлөөлөхгүй бусад өөрчлөлт:</i>				
Гадаад валютын ханшийн болон бусад өөрчлөлт	-	-	205,974	205,974
2025 оны 12 дугаар сарын 31	378	378	4,868,233	4,868,233

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10 ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

БДОБҮЦ-ээрх өрийн үнэт цаас болон эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөнийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	Эрсдэлийн алдагдлын сан		Нийт дүн	
	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Нийт дүн	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Нийт дүн
2024 оны 1 дүгээр сарын 1	92	92	3,525,587	3,525,587
<i>Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын санд нөлөөлсөн өөрчлөлт:</i>				
Шинээр худалдан авсан	85	85	6,728,186	6,728,186
Бүртгэлээс хассан	(5)	(5)	(5,658,221)	(5,658,221)
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	-	(13)	(13)
Бусад өөрчлөлт	-	-	(23,616)	(23,616)
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын хасагдуулгын нөлөөг тусгасан нийт өөрчлөлт, хөдөлгөөн	80	80	1,046,336	1,046,336
<i>Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын санд нөлөөлөхгүй бусад өөрчлөлт:</i>				
Гадаад валютын ханшийн болон бусад өөрчлөлт	-	-	7,661	7,661
2024 оны 12 дугаар сарын 31	172	172	4,579,584	4,579,584

(б) Хорогдуулсан өртгөөрх өрийн үнэт цаас

МИК-ийн гаргасан давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд. Банк 2013 оны 6 дугаар сарын 13-ны өдөр МИК болон дотоодын банкуудтай гурван талт “Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г байгуулсан. Банк Тодруулга 9т дурдсан Үнийн тогтворжуулах хөтөлбөрийн орон сууцны ипотекийн дэд хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлийн төлбөрт МИК-аас гаргасан давуу эрхтэй ИЗББ-ыг дотоодын банкуудаас хүлээн авдаг. Бонд нь 30 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 1%, 2.25% болон 4.5 %-ийн хүүтэй. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 4 болон 9-өөс харна уу.

Эрдэнэс бонд. Банк нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 849,807 сая төгрөг (2024: 849,807 сая төгрөг)-ийн тус бүр нь 1 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 6 хувийн хүүтэй, 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дуусах хугацаатай бондыг эзэмшиж байна. Удирдлага Эрдэнэс бондын хугацаа дуусах үед бүрэн төлөлт хийгдээгүйгээс шалтгаалж эргэн төлөлтийн хуваарьт тодорхой бус байдал үүсч, үнэ цэнийн бууралтад орох болсон гэж үзсэн тул бондыг Шатлал 3т ангилсан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 4-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10 ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд. Төрийн болон тусгай албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд “Нийслэлийн орон сууцны корпораци (НОСК)” ХК-аас гаргасан түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг Банк 2020 оны 10 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн худалдан авч эхэлсэн бөгөөд тайлант хугацааны байдлаар 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 6-8 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай 1,123,054 (2024: 1,223,190) ширхэг бондыг эзэмшиж байна. Бонд нь НОСК ХК-ийн эзэмшилд байгаа түрээсийн орон сууц, тэдгээрийн түрээсийн орлогоор баталгаажсан.

Доорх хүснэгтэд ХБЭА-ын үнэлгээний зорилгоор ХӨ-өөр бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг зээлийн чанараар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн эрсдэлийн зэрэглэл болон 3 шатлал бүрээр харууллаа. Банкны ашиглаж байгаа зээлийн эрсдэлийн зэрэглэлийн систем болон хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн аргачлал, ХӨ-өөрх үнэт цаасанд хамаарах зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт, дефолтын тодорхойлолтын талаарх дэлгэрэнгүйг Тодруулга 34-өөс харна уу.

ХӨ-өөр бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын дансны үнэ болон Банкны эдгээр хөрөнгийн зээлийн эрсдэлд хамгийн их өртөх дүнг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа.

Сая төгрөгөөр	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 3 (хугацааны турш дахь ХБЭА, үнэ цэнэ буурсан)	Нийт дүн
Сайн			
Давуу эрхтэй ИЗББ	3,803,343	-	3,803,343
Түрээсийн хөрөнгөөр батаагаажсан бонд	119,072	-	119,072
Дефолт			
Эрдэнэс бонд	-	849,807	849,807
Дансны нийт үнэ	3,922,415	849,807	4,772,222
Эрсдэлийн алдагдлын сан	(998)	(228,190)	(229,188)
Нийт ХӨ-өөрх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт (дансны үнэ)	3,921,417	621,617	4,543,034

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10 ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын зээлийн чанарын хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа.

Сая төгрөгөөр	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 3 (хугацааны турш дахь ХБЭА, үнэ цэнэ буурсан)	Нийт дүн
Сайн			
Давуу эрхтэй ИЗББ	2,900,604	-	2,900,604
Түрээсийн хөрөнгөөр батаагаажсан бонд	129,196	-	129,196
Дефолт			
Эрдэнэс бонд	-	849,807	849,807
Дансны нийт үнэ	3,029,800	849,807	3,879,607
Эрсдэлийн алдагдлын сан	(757)	(84,317)	(85,074)
Нийт ХӨ-өөрх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт (дансны үнэ)	3,029,043	765,490	3,794,533

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хорогдуулсан өртгөөрх дансны үнэ болон эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөнийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харуулав.

Сая төгрөгөөр	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 3 (хугацааны туршид дахь ХБЭА, үнэ цэнэ буурсан)	Нийт дүн	
	Давуу эрхтэй ИЗББ (ипотекийн зээлээр баталгаажсан)	Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд (түрээсийн орон сууцаар баталгаажсан)	Эрдэнэс бонд	
Дансны нийт үнэ				
2025 оны 1 дүгээр сарын 1	2,900,604	129,196	849,807	3,879,607
Шилжүүлэлт:				
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	1,318,254	-	-	1,318,254
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(408,420)	(10,013)	-	(418,433)
Хөнгөлөлтийн бууралт	8,148	-	-	8,148
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(15,244)	(110)	-	(15,354)
2025 оны 12 дугаар сарын 31	3,803,342	119,073	849,807	4,772,222
Эрсдэлийн алдагдлын сан				
2025 оны 1 дүгээр сарын 1	490	267	84,317	85,074
Шилжүүлэлт:				
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	413	64	143,873	144,350
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(62)	(174)	-	(236)
2025 оны 12 дугаар сарын 31	841*	157*	228,190	229,188

*Илүү барьцаа хөрөнгөтэй

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10 ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хорогдуулсан өртгөөрх дансны үнэ болон эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөнийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа.

Сая төгрөгөөр	Шатлал 1 (12 сарын ХБЭА)			Шатлал 3 (хугацааны туршид дахь ХБЭА, үнэ цэнэ буурсан)		
	Давуу эрхтэй ИЗББ (ипотекийн зээлээр баталгаажсан)	Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд (түрээсийн орон сууцаар баталгаажсан)	Эрдэнэс бонд	Эрдэнэс таван толгой бонд	Эрдэнэс бонд	Нийт дүн
Дансны үнэ						
2024 оны 1 дүгээр сарын 1	2,972,103	143,957	877,166	155,301	-	4,148,527
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын санд нөлөөлсөн өөрчлөлт, хөдөлгөөн:						
Шилжүүлэлт:						
Зээлийн чанар буурсан (шатлал1-ээс шатлал 3)	-	-	(849,807)	-	849,807	-
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	373,197	-	-	-	-	373,197
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(423,109)	(14,314)	(80,078)	(150,000)	-	(667,501)
Хөнгөлөлтийн бууралт	7,316	-	52,719	-	-	60,035
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(28,903)	(447)	-	(5,301)	-	(34,651)
2024 оны 12 дугаар сарын 31	2,900,604	129,196	-	-	849,807	3,879,607
Эрсдэлийн алдагдлын сан						
2024 оны 1 дүгээр сарын 1	936	574	135,487	11,722	-	148,719
Шилжүүлэлт:						
Зээлийн чанар буурсан (Шатлал1-ээс шатлал 3)	-	-	(71,410)	-	84,317	12,907
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	-	46	-	-	-	46
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(446)	(353)	(64,077)	(11,722)	-	(76,598)
2024 оны 12 дугаар сарын 31	490*	267*	-	-	84,317	85,074

*Илүү барьцаа хөрөнгөтэй

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

11 ӨМЧИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Өмчийн үнэт цаас	6,533	6,533
Нийт өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	6,533	6,533

Өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ)-ээр хэмжиж бүргэдэг бөгөөд Банк анх хүлээн зөвшөөрөх үедээ өмчийн хөрөнгө оруулалтыг БДОБҮЦ-ээр үнэлэгдэхээр эргэж буцалтгүйгээр сонгодог. Банк өмчийн хөрөнгө оруулалтыг өөрийн бодлогын хүрээнд зөвхөн хөрөнгө оруулалтын ашиг хүртэх зорилгоор бус, стратегийн зорилгоор эзэмшдэг тул өмчийн хэрэгслийг дээрх ангиллаар ангилдаг. БДОБҮЦ-ийн сонголтыг ашигласан тохиолдолд бодит үнэ цэнийн олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх бөгөөд дараа үед тэдгээрийг болон хөрөнгийг худалдан борлуулах үед ч ашиг, алдагдалд дахин ангилж шилжүүлэхгүй. Түүнчлэн, өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт, тэдгээрийн буцаалтыг, хэрэв байгаа бол, бодит үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусдаа бүртгэдэггүй.

БДОБҮЦ-ээр хэмжигдэх өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт. Үүнд Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк болон Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Олон Улсын Банкинд оруулсан хөрөнгө оруулалт багтдаг ба тэдгээрийг бодит үнэ цэнээр бүртгэдэг. Удирдлага бодит үнэ цэнийг хөрөнгө оруулалтын өртөгтэй ойролцоо байна гэж үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

12 УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Нью-Йоркийн Холбооны Нөөцийн банк	6,086,748	5,507,629
Дотоодын банкууд – Богино хугацаатай (овернайт)	3,918,083	2,475,427
Дотоодын банкууд - Урт хугацаатай (ТБҮЦ барьцаалсан)	65,803	232,218
Дотоодын банкууд - Урт хугацаатай (Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаар барьцаалсан)	-	27,470
Дотоодын банкууд - Урт хугацаатай (Орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаасаар барьцаалсан)	-	18,351
Нийт ХӨ-өөрх буцаан худалдан авах хэлцэл (дансны нийт дүн)	10,070,634	8,261,095
Эрсдэлийн алдагдлын сан	(7)	(62)
Нийт ХӨ-өөрх буцаан худалдан авах хэлцэл (дансны дүн)	10,070,627	8,261,033

Буцаан худалдах нөхцөлтэйгээр худалдан авсан үнэт цаас (“урвуу буцаан худалдан авах хэлцэл”) нь Банкинд зээлдүүлэгчийн өгөөжийг бий болгодог тул холбогдох тохиолдолд урвуу буцаан худалдан авах хэлцэл хэлбэрээр бүртгэнэ. Худалдан авах үнэ болон буцаан худалдах үнийн зөрүүт, харилцагч талын цуглуулсан хүү болон ногдол ашгийн орлогоор тохируулан, хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрч, буцаан худалдах хэлцлийн хугацааны туршид үр ашигт хүүгийн аргыг ашиглан хуримтлуулан бүртгэдэг.

Тогтмол шимтгэлийн төлбөртэйгээр харилцагч талд зээлдүүлсэн үнэт цаасыг, хэрэв харилцагч тал тухайн үнэт цаасыг гэрээний дагуу эсвэл зах зээлийн жишгээр зарах эсвэл дахин барьцаалах эрхгүй бол, санхүүгийн байдлын тайланд анхны ангиллаар нь хэвээр бүртгэнэ. Харин харилцагч талд ийм эрх олгогдсон тохиолдолд энэхүү үнэт цаасыг дахин ангилж, тусад нь тайлагнадаг. Тогтмол шимтгэлийн төлбөртэйгээр зээлж авсан үнэт цаасыг санхүүгийн тайланд бүртгэхгүй бөгөөд зөвхөн гуравдагч этгээдэд худалдсан тохиолдолд тухайн худалдан авалт, борлуулалтыг тайлант жилийн ашиг, алдагдалд арилжааны үнэт цааснаас үүсэх олз, гарзын цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрнө. Үнэт цаасыг буцаан олгох үүргийг бусад зээлсэн хөрөнгийн бодит үнэ цэнээр бүртгэдэг.

Банк буцаан худалдан авах хэлцлийн дагуу борлуулсан үнэт цаасны ангилалд үндэслэн урвуу буцаан худалдан авах хэлцлийг ХӨ-р ангилж бүртгэдэг.

Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк. Банк нь Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан хадгаламжийн данстай холбоотойгоор Автомат хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэлцэл байгуулсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан харилцах дансны үлдэгдлийн 250,000 ам.доллараас илүү гарсан дүнгээр Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкны буцаан худалдан авах хэлцэлд хөрөнгө оруулах болно.

Буцаан худалдан авах хэлцэлд оруулсан хөрөнгө оруулалт нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 1,711 сая ам.доллар буюу 6,086,748 сая төгрөг (2024: 1,160 сая ам.доллар буюу 5,507,629 сая төгрөг)-тэй тэнцэхүйц байна. Энэхүү хөрөнгө оруулалт нь 2 хоног (2024: 2 хоног)-ийн хугацаатай бөгөөд жилийн 3.5%-ийн (2024: 4.3%-5.3%) хүүтэй. Холбогдох хөрөнгө оруулалтыг барьцаагаар баталгаажуулдаг боловч хөрөнгө оруулалтын хөтөлбөрт үндэслэн худалдан авах үнэт цаасыг тодорхойлох боломжгүй байдаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

12 УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Богино хугацаатай урвуу буцаан худалдан авах хэлцлүүд (овернайт). Дотоодын банкуудтай байгуулсан төгрөгийн овернайт урвуу буцаан худалдан авах хэлцэл нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3,918,083 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 2 хоногийн хугацаатай, жилийн 14 хувийн хүүтэй (2024: 2,475,427 сая төгрөг, 2 хоногийн хугацаатай, жилийн 12 хувийн хүүтэй) байна. Эдгээр нь Төв банкны үнэт цаасаар бүрэн баталгаажсан.

Урт хугацаатай урвуу буцаан худалдан авах хэлцлүүд. Дотоодын банктай хийсэн урт хугацаат урвуу буцаан худалдан авах хэлцэл нь 1 жилийн хугацаатай, жилийн 14 хувийн хүүтэй (2024: 2-3 жилийн хугацаатай, жилийн 7%-14%) 65,803 сая төгрөг (2024: 232,218 сая төгрөг)-ийн үлдэгдэлтэй. Эдгээр нь Төв банкны үнэт цаасаар баталгаажсан.

Нью-Йоркийн холбооны нөөцийн банктай байгуулсан урвуу буцаан худалдан авах хэлцлийн зээлийн эрсдэлийн чанарын шинжилгээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа.

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31 Шатлал 1 (12 сарын ХБЭА)	2024 оны 12 дугаар сарын 31 Шатлал 1 (12 сарын ХБЭА)
Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк - Онц сайн	6,086,748	5,507,629
Дансны нийт дүн	6,086,748	5,507,629
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(7)	(5)
Дансны дүн	6,086,741	5,507,624

Дотоодын банктай байгуулсан урвуу буцаан худалдан авах хэлцэл нь зээлийн эрсдэлийн чанарын үнэлгээгээр Шатлал 1 буюу “сайн” (2024: Шатлал 1 буюу “сайн”) гэсэн үнэлгээтэй байна. Дотоодын банктай байгуулсан урвуу буцаан худалдан авах хэлцэлтэй холбоотой Банкны ашиглаж байгаа зээлийн эрсдэлийн зэрэглэлийн систем, ХБЭА-ын хэмжилтийн аргачлал, дефолтын тодорхойлолт болон ЗЭМӨ-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 34-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

12 УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэд ХӨ-өөрх урвуу буцаан худалдан авах хэлцлийн дансны нийт дүн болон эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөнийг тайлант жилийн эхэн болон эцсийн хугацааны туршид харууллаа:

	Шатлал 1					Нийт дүн
	Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк	Дотоодын банкууд – Богино хугацаатай (ТБҮЦ барьцаалсан)	Дотоодын банкууд – Урт хугацаатай (ТБҮЦ барьцаалсан)	Урт хугацаатай (Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас барьцаалсан)	Урт хугацаатай (Орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалсан)	
Сая төгрөгөөр						
Дансны нийт үнэ						
2025 оны 1 дүгээр сарын 1	5,507,629	2,475,427	232,218	27,470	18,351	8,261,095
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн нөлөөллийг багтаасан өөрчлөлт:						
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	695,954,082	19,235,227	-	-	-	715,189,309
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(695,369,573)	(17,793,260)	(150,889)	(27,470)	(17,144)	(713,358,336)
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	592	689	(15,526)	-	(1,207)	(15,452)
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын хасагдуулгын нөлөөг тусгасан нийт өөрчлөлт, хөдөлгөөн	585,101	1,442,656	(166,415)	(27,470)	(18,351)	1,815,521
Эрсдэлийн алдагдлын санд нөлөөлөхгүй бусад өөрчлөлт:						
Гадаад валютын ханшийн болон бусад өөрчлөлт	(5,982)	-	-	-	-	(5,982)
2025 оны 12 дугаар сарын 31	6,086,748	3,918,083	65,803	-	-	10,070,634
Эрсдэлийн алдагдлын сан						
2025 оны 1 дүгээр сарын 1	5	-	-	57	-	62
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн нөлөөллийг багтаасан өөрчлөлт:						
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	7	-	-	106	-	113
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(5)	-	-	(163)	-	(168)
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын хасагдуулгын нөлөөг тусгасан өөрчлөлт, хөдөлгөөн	2	-	-	(57)	-	(55)
2025 оны 12 дугаар сарын 31	7	-	-	-	-	7

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

12 УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэд 2024 оны туршид ХӨ-өөрх урвуу буцаан худалдан авах хэлцлийн дансны нийт дүн болон эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөнийг харууллаа:

Сая төгрөгөөр	Шатлал 1					Нийт дүн
	Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк	Дотоодын банкууд – Богино хугацаатай (ТБҮЦ барьцаалсан)	Дотоодын банкууд – Урт хугацаатай (ТБҮЦ барьцаалсан)	Урт хугацаатай (Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас барьцаалсан)	Урт хугацаатай (Орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалсан)	
Дансны нийт үнэ						
2024 оны 1 дүгээр сарын 1	3,960,295	723,660	212,453	41,471	17,846	4,955,725
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн нөлөөллийг багтаасан өөрчлөлт:						
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	1,004,523,220	12,421,951	135,420	-	13,937	1,017,094,528
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(1,002,974,721)	(10,669,889)	(117,862)	(28,263)	(4,000)	(1,013,794,735)
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(1,165)	(295)	2,207	14,262	(9,432)	5,577
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын хасагдуулгын нөлөөг тусгасан нийт өөрчлөлт, хөдөлгөөн	1,547,334	1,751,767	19,765	(14,001)	505	3,305,370
2024 оны 12 дугаар сарын 31	5,507,629	2,475,427	232,218	27,470	18,351	8,261,095
Эрсдэлийн алдагдлын сан						
2024 оны 1 дүгээр сарын 1	5	-	-	104	-	109
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын сангийн нөлөөллийг багтаасан өөрчлөлт:						
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	1	-	-	163	-	164
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(1)	-	-	(210)	-	(211)
Тайлант жилийн эрсдэлийн алдагдлын хасагдуулгын нөлөөг тусгасан нийт өөрчлөлт, хөдөлгөөн	-	-	-	(47)	-	(47)
2024 оны 12 дугаар сарын 31	5	-	-	57*	-*	62

* Илүү барьцаа хөрөнгөтэй

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

13 МӨНГӨЖСӨН АЛТ, ҮНЭТ МЕТАЛ

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31 (дахин тайлагнасан дүн)	2024 оны 1 дүгээр сарын 1 (дахин тайлагнасан дүн)
Бодит үнэ цэнээр			
Мөнгөжсөн алт	3,901,306	2,115,101	1,828,140
Мөнгөжсөн мөнгө	10,185	4,489	20,561
Өртгөөр			
Алт олборлогчдоос худалдан авсан алт, мөнгө	457,987	258,999	196,352
Цэвэршүүлэхээр ачуулсан алт	43,015	6,435	15,852
Дурсгалын зоос, үнэт металл	19,525	18,155	16,623
Нийт мөнгөжсөн алт, үнэт металл	4,432,018	2,403,179	2,077,528

Мөнгөжсөн алт, мөнгө нь гадаадын банкууд болон Банкны сейфэнд хадгалагдаж байгаа олон улсын стандартын алтан гулдмайн нөөцөөс бүрдэнэ. Мөнгөжсөн алт, мөнгө нь олон улсын нөөцийн нэг хэсгийг төлөөлдөг. Мөнгөжсөн алтыг трой унцаар буюу биет жингээр бүртгэдэг бөгөөд Банкны албан ханш болох төгрөгөөр үнэлдэг. Албан ханшийг Лондонгийн Алтны Зах Зээлийн Холбооны оролцогчдын тогтоосон (тогтмол) алтны үнийн талаарх мэдээллийг үндэслэн Банкны албан ханш буюу төгрөг/ам.долларын ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцдог.

Мөнгөжсөн алт, мөнгийг бодит үнэ цэнээр нь өдөр бүр үнэлж, дахин үнэлгээний олз, гарзыг ашиг, алдагдалд бүртгэдэг. Алт, үнэт металлыг худалдсан тохиолдолд жигнэсэн дундаж ханшаар тооцож дахин үнэлгээний олз, гарзын данснаас буцааж, үнэт металлын бодит ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Банк нь жил бүр бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит бус олз, гарзыг хуримтлагдсан алдагдлаас “Гадаад валют, үнэт металын дахин үнэлгээний сан”-д шилжүүлэн бүртгэдэг (Тодруулга 26-г харна уу). Гадаадын банкуудад хадгалагдаж буй болон Банкны сейфэнд хадгалагдаж байгаа олон улсын стандартын мөнгөжсөн алт, мөнгөжсөн мөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр хэмжиж, дахин үнэлгээг өдөр тутам хийдэг. Удирдлага цэвэршүүлсэн алт, мөнгийг валют эсвэл санхүүгийн хөрөнгийг орлох шинжтэй гэж үзэн, эдгээр санхүүгийн тайлангуудын тодруулгын зорилгоор санхүүгийн хэрэгсэл гэж бүртгэдэг. Алт, мөнгөний бодит үнэ цэнийг зах зээлийн үнэд тулгуурлан тодорхойлдог. Дахин үнэлгээний үр дүнд үүсэх олз, гарзыг мөнгөжсөн алт болон үнэт металлын ханшийн зөрүүнээс үүсэх олз, гарз гэж тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Өмнө нь ханшийн зөрүүнээс үүсэх олз, гарзаар хүлээн зөвшөөрөгдсөн дахин үнэлгээний олз, гарзыг тухайн гүйлгээ дуусах үед буцаан залруулж, мөнгөжсөн алт болон үнэт металлын арилжаанаас үүсэх олз, гарз гэж тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Жил бүр бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй олз, гарзыг хуримтлагдсан алдагдлаас өмчийн бусад нөөцийн бүрэлдэхүүнд багтах “Мөнгөжсөн алт болон гадаад валютын дахин үнэлгээний нөөц” дансанд шилжүүлэн бүртгэдэг (Тодруулга 26г харна уу).

Банк мөнгөжсөн алт хэлбэрээр алт эзэмшихээс гадна Монгол Улсын үйлдвэрлэгчид болон аж ахуйн нэгжүүдээс цэвэршүүлээгүй алт, мөнгө худалдан авч, алт, мөнгөний арилжаа эрхэлдэг. Цэвэршүүлээгүй алт, мөнгө болон дурсгалын зоосыг оролцуулсан бусад үнэт металлыг бараа материал гэж хүлээн зөвшөөрч, өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль бага дүнгээр үнэлдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

13 МӨНГӨЖСӨН АЛТ, ҮНЭТ МЕТАЛЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу Эрдэнэсийн сан нь үндсэн болон гүйлгээ сангаас бүрдэнэ. Гүйлгээ сан нь мөнгөжсөн алт болон үнэт металын ангилал дах дурсгалын зоос болон үнэт металл багтдаг. Үндсэн бус буюу гүйлгээ санд цэвэршүүлэхээр хүлээгдэж буй үнэт метал, судалгааны болон дурсгалын журмаар хадгалж буй үнэт метал, үндсэн санд багтаагүй бусад эд зүйлс хамаарна. Банк 2025 онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж Эрдэнэсийн Сангийн эд зүйлсийг дахин үнэлгээний аргаас өртгийн арга руу өөрчилсөн. Энэхүү өөрчлөлт орсонтой холбогдуулан санхүүгийн тайлангийн дурсгалын зоос болон үнэт металлуудыг буцаан хэрэгжүүлэх зарчмын дагуу дахин тайлагнасан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 3-аас харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

14 ЭРДЭНЭСИЙН САН

Сая төгрөгөөр	2024 оны 12 дугаар сарын		
	2025 оны 12 дугаар сарын 31	31 (дахин тайлагнасан дүн)	2024 оны 1 дүгээр сарын 1 (дахин тайлагнасан дүн)
Үндсэн сан - Байнгын бус	60,687	58,595	45,926
Үндсэн сан - Байнгын	456	456	456
Нийт Эрдэнэсийн сан	61,143	59,051	46,382

Эрдэнэсийн сангийн тухай хуулинд “Эрдэнэс” гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн зэрэг ямар ч байдалд байгаа үнэт метал, эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, байгалийн төрц багтана гэж тодорхойлсон. Эрдэнэсийн сан нь үндсэн болон гүйлгээ сангаас бүрдэнэ.

Үндсэн сан нь байнгын болон байнгын бус сангаас бүрдэнэ. Эрдэнэсийн сангийн байнгын сан нь Улсын Их Хурлаар баталсан “Түүх, соёлын болон өв уламжлалын үнэт зүйлс”ийн жагсаалтад багтсан түүх, соёлын дурсгалт зүйл буюу хосгүй үнэт түүхэн эд зүйлсээс бүрддэг. Байнгын бус санд олон улсын жишгээр цэвэршүүлсэн үнэт метал, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт болон бусад металаар хийж нөөцөд авсан зоос багтана.

Банк 2025 онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж Эрдэнэсийн Сангийн эд зүйлсийг дахин үнэлгээний аргаас өртгийн арга руу өөрчилсөн. Энэхүү өөрчлөлт орсонтой холбогдуулан санхүүгийн тайлангийн Эрдэнэсийн Сангийн дахин үнэлгээний сангийн үзүүлэлтийг буцаан хэрэгжүүлэх зарчмын дагуу дахин тайлагнасан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 3-аас харна уу.

Хэмжилт: Удирдлага Эрдэнэсийн сангийн хөрөнгийг үнэт өв хөрөнгө гэж үздэг бөгөөд тодорхойгүй ашиглалтын хугацаатай гэж үздэг. Тиймээс Эрдэнэсийн сангийн эд зүйлсийг элэгдүүлдэггүй.

Эрдэнэсийн сангийн өөрчлөлтийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	Байнгын бус			Нийт дүн
	Байнгын	Зоос	Соёлын үнэт зүйлс	
2024 оны 1 дүгээр сарын 1 (дахин тайлагнасан дүн)	456	3,602	42,324	46,382
Нэмэгдсэн	-	169	12,500	12,669
2024 оны 12 дугаар сарын 31 (дахин тайлагнасан дүн)	456	3,771	54,824	59,051
Нэмэгдсэн	-	1,623	469	2,092
2025 оны 12 дугаар сарын 31-ний дансны дүн	456	5,394	55,293	61,143

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15 САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЭЛ

Банк гадаад валютын урсгалыг дэмжих, хүүгийн түвшин, гадаад валютын зээлийн өсөлтийг хязгаарлах зорилгоор дотоодын банкуудтай санхүүгийн үүсмэл хэрэгслийн гэрээ байгуулдаг. Санхүүгийн үүсмэл хэрэгслийг бодит үнэ цэнээр нь бүртгэж, ашигтай байвал хөрөнгө талд, алдагдалтай бол өр төлбөр талд бүртгэдэг. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн нийт бодит үнэ цэнэ нь хугацааны туршид мэдэгдэхүйц хэлбэлзэлтэй байж болно. Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийг тайлант жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. Банк хэджийн бүртгэлийг ашигладаггүй.

Урт хугацаат своп хэлцэл нь 1-8 жилийн хугацаатай, төгрөг болон ам.долларын ханшийн зөрүүг хүүгийн хамт солилцох нөхцөлтэй. Банк ийм хэлцлүүдийн бодит үнэ цэнийг үнэлэх хорогдуулсан мөнгөн гүйлгээний загварыг ашигладаг ба энэ загвар нь зах зээл дээрх ажиглагдах өгөгдөл мэдээлэлд үндэслэсэн байдаг. Дэлгэрэнгүйг Тодруулга 35-аас харна уу.

Доорх хүснэгт нь хөрөнгө, өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг харуулж байгаа ба тус үүсмэл хэрэгслүүд нь дотоодын банк болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай байгуулсан урт хугацааны нийт валютаар илэрхийлэгдсэн хүүгийн своп хэлцлүүдээс бүрдэж байна:

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Урт хугацааны нийт валютаар илэрхийлэгдсэн хүүгийн своп: тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ		
ААБҮЦ-ээрх санхүүгийн хөрөнгө	259,852	140,720
ААБҮЦ-ээрх санхүүгийн өр төлбөр	(398,576)	(227,933)
ААБҮЦ-ээрх санхүүгийн өр төлбөр, цэвэр дүнгээр	(138,724)	(87,213)

Доорх хүснэгтэд тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаарх Банкны байгуулсан урт хугацааны нийт валютаар илэрхийлэгдсэн хүүгийн своп хэлцлүүдээр үүссэн авлага, өглөгийн бодит үнэ цэнийг харууллаа. Хүснэгтэд харилцагч талын позици (төлбөр)-тэй цэвэршүүлээгүй нийт позицыг харуулсан бөгөөд холбогдох тайлант хугацааны эцсийн өдрөөс хойших хугацаанд төлбөр тооцоо хийгдэх хэлцлүүдийг мөн багтаасан.

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31		2024 оны 12 дугаар сарын 31	
	Бодит үнэ цэнийн эерэг утгатай гэрээ	Бодит үнэ цэнийн сөрөг утгатай гэрээ	Бодит үнэ цэнийн эерэг утгатай гэрээ	Бодит үнэ цэнийн сөрөг утгатай гэрээ
- Ам долларын өглөг (-)	(4,908,484)	(7,905,679)	(3,398,169)	(4,516,464)
-Төгрөгийн авлага (+)	5,168,336	7,507,103	3,538,889	4,288,531
Гадаад валютын ханшийн форвард болон своп хэлцлийн цэвэр бодит үнэ цэнэ	259,852	(398,576)	140,720	(227,933)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

16 ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Засгийн газрын үнэт цаас	54,633	55,720

Зах зээлийн хүүгийн түвшингээс доогуур хүүтэй Засгийн газрын үнэт цаас. Засгийн газрын үнэт цаасны бодит үнэ цэнэ нь анх хүлээн зөвшөөрөх үед 123,668 сая төгрөг байсан. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ болон нэрлэсэн үнийн зөрүү болох 330,044 сая төгрөгийг анхны хүлээн зөвшөөрөлтөөр 2016 онд алдагдлаар хүлээн зөвшөөрсөн. Засгийн газрын үнэт цаас нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 96,600 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1.0 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай (2024: 96,600 сая төгрөг, жилийн 1.0 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай) байсан бөгөөд дансны үнэ нь 54,633 сая төгрөг (2024: 55,720 сая төгрөг) байсан. Бодит үнэ цэнийн мэдээллийг Тодруулга 35-аас харна уу.

Банк БДОБҮЦ-ээр хэмжигдсэн 639 сая төгрөг (2024: 468 сая төгрөг)-ийн Засгийн газрын үнэт цаасны ХБЭА-ын хасагдуулгыг тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын холбогдох өөрчлөлтийн дүнд бүртгэсэн.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх үнэт цаасны үлдэгдлийн зээлийн эрсдэлд өртөх хамгийн их дүнг доорх хүснэгтэд харууллаа. Банкны ашиглаж байгаа зээлийн эрсдэлийн зэрэглэлийн систем болон ХБЭА-ын хэмжилтийн аргачлалын тайлбарыг Тодруулга 34-өөс харна уу.

Дараах хүснэгтэд БДОБҮЦ-ээр хэмжигдсэн Засгийн газрын үнэт цаасны мэдээллийг харууллаа:

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31 Шатлал 1 (12 сарын ХБЭА)	2024 оны 12 дугаар сарын 31 Шатлал (12 сарын ХБЭА)
Засгийн газрын үнэт цаас Сайн	42,257	36,639
Хорогдуулсан өртгөөрх дансны нийт дүн	42,257	36,639
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(639)	(468)
Нэмэх нь: Бодит үнэ цэнийн тохируулга (ХӨ-өөс БҮЦ-рүү)	13,015	19,549
Дансны дүн (бодит үнэ цэнэ)	54,633	55,720

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

16 ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэд тайлант болон харьцуулсан өмнөх хугацааны эхэн ба төгсгөлийн хооронд бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн засгийн газрын үнэт цаасны эрсдэлийн алдагдлын сан болон дансны нийт үнийн өөрчлөлтийг харууллаа:

<i>Сая төгрөгөөр</i>	Эрсдэлийн алдагдлын сан Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Нийт дүн Шатлал 1 (12 сарын ХБЭА)
БДОБҮЦ-ээрх Засгийн газрын үнэт цаас		
2025 оны 1 дүгээр сарын 1	468	36,639
<i>Эрсдэлийн алдагдлын санд нөлөөлсөн хөдөлгөөн:</i>		
ХБЭА-ын хэмжилтийн таамаглалд орсон өөрчлөлт	171	-
Хямдруулалтын хорогдуулалт	-	5,618
2025 оны 12 дугаар сарын 31	639	42,257
БДОБҮЦ-ээрх Засгийн газрын үнэт цаас		
2024 оны 1 дүгээр сарын 1	413	31,884
<i>Эрсдэлийн алдагдлын санд нөлөөлсөн хөдөлгөөн:</i>		
ХБЭА-ын хэмжилтийн таамаглалд орсон өөрчлөлт	55	-
Хямдруулалтын хорогдуулалт	-	4,755
2024 оны 12 дугаар сарын 31	468	36,639

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

17 ЗАСГИЙН ГАЗРААС АВАХ АВЛАГА

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Засгийн газраас авах авлага	403,306	477,537
Нийт засгийн газраас авах авлага	403,306	477,537

Засгийн газраас авах авлага нь Банкны төлбөр тооцооны үндсэн дээр бүртгэсэн худалдан авсан санхүүгийн бус хөрөнгийг илэрхийлнэ. Авлагыг анх хүлээн зөвшөөрөхдөө өртөг буюу тухайн үед хамгийн сайн мэдэгдэж байсан мэдээлэлд тулгуурлан хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар үнэлсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн. Авлагын эргэн төлөгдөх дүнг хорогдуулсан мөнгөн урсгалын аргыг ашиглан тооцохдоо 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 12%-ийн хорогдуулалтын хувиар тооцсон (2024: 10%). Удирдлага 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар авлагын эргэн төлөгдөх дүнг 403,306 сая төгрөг (2024: 477,537 сая төгрөг) гэж үнэлсэн бөгөөд Засгийн газартай гэрээ байгуулах ажил хойшилсонтой холбоотойгоор тайлант жилд 74,231 сая төгрөг (2024: 37,405 сая төгрөг)-ийн үнэ цэнийн бууралтыг нэмж ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн. Удирдлагын дүгнэлтийг Тодруулга 4-өөс харна уу.

Доорх хүснэгтэд тайлант жилийн болон өмнөх харьцуулагдах хугацааны Засгийн газраас авах авлагын өртгийн өөрчлөлтийг тодруулан харууллаа:

Сая төгрөгөөр	2025	2024
1 дүгээр сарын 1-ний нийт дансны үнэ	524,275	524,275
1 дүгээр сарын 1-ний хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарз	(46,738)	(9,333)
1 дүгээр сарын 1-ний дансны үнэ	477,537	514,942
Үнэ цэнийн бууралтын гарз	(74,231)	(37,405)
12 дугаар сарын 31-ний дансны үнэ	403,306	477,537
12 дугаар сарын 31-ний нийт дансны үнэ	524,275	524,275
12 дугаар сарын 31-ний хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарз	(120,969)	(46,738)
12 дугаар сарын 31-ний дансны үнэ	403,306	477,537

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18 БУСАД ХӨРӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
ХӨ-өөрх бусад санхүүгийн хөрөнгө		
Хадгаламжийн Даатгалын Корпорациас авах авлага	85,000	85,000
Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага	67,371	67,371
Татан буугдсан Анод банкнаас хүлээн авсан хөрөнгө	53,765	56,424
Аж ахуйн нэгжээс авах авлага	49,773	71,657
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага	31,094	29,901
Татан буугдсан Капитал банкны өрийн бичиг	5,320	9,896
Бусад санхүүгийн авлага	31,519	18,062
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(302,868)	(329,292)
Хорогдуулсан өртгөөрх нийт бусад санхүүгийн хөрөнгө	20,974	9,019
Бусад санхүүгийн бус хөрөнгө		
Урьдчилж төлсөн зардал	1,849	3,133
Бусад	4,466	3,532
Нийт бусад санхүүгийн бус хөрөнгө	6,315	6,665
Нийт ХӨ-өөрх бусад хөрөнгийн дансны дүн	27,289	5,684
ААБҮЦ-ээрх бусад хөрөнгө		
Өрийн бичгийн авлага	-	14,658
Нийт ААБҮЦ-ээрх бусад хөрөнгийн дансны дүн	-	14,658
Нийт бусад хөрөнгө	27,289	30,342

Бусад хөрөнгө нь авлага, урьдчилгаа санхүүжилт, урьдчилж төлсөн зардлаас бүрдэх бөгөөд өрийн бичгийн авлагаас бусад авлагыг хорогдуулсан өртгөөр тооцож, хуримтлуулан бүртгэдэг. Авлагын гэрээний дагуу бүртгэдэг.

Урьдчилж төлсөн төлбөрийг төлбөр хийгдсэн өдөр бүртгэж, тухайн ажил үйлчилгээг хүлээн авсан үед ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрдөг. Авлагын үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг ирээдүйд чиглэсэн ХБЭА-ын загварт үндэслэн тодорхойлдог. Тодруулга 34-т ХБЭА-ын загварыг хэмжихэд ашигласан мэдээлэл, таамаглал болон тооцооллын аргуудын талаарх мэдээллийг оруулсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18 БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага. Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлагад жилийн тэг хувийн хүүтэй, 85,000 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүртгэдэг бөгөөд энэхүү санхүүгийн дэмжлэгийг 2014 оноос хойш төлөгдөөгүй тул нөөц санг байгуулж, шатлал 3-т ангилсан. Санхүүгийн дэмжлэг нь 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Төрийн банк ХК-ны хувьчлалаас эргэн төлөгдөх нөхцөлтэй боловч тайлант жилийн эцсийн байдлаар төлөгдөөгүй байна. Засгийн газар ойрын хугацаанд хувьчлалын үйл явцыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Санхүүгийн дэмжлэгийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ыг тухайн хөрөнгийн эргэн төлөлтийн хуваарийг харгалзан үнэлсэн. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар энэ авлагын нийт дүнгээр хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг байгуулсан.

Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага. Энэхүү авлагад Капитал банктэй холбоотой үүссэн клирингийн авлагын 5,215 сая төгрөг (2024: 5,215 сая төгрөг), заавал байлгах нөөцийн торгуулийн авлагын 4,602 сая төгрөг (2024: 4,602 сая төгрөг), ХДК-тай холбоотой үүссэн авлагын 44,663 сая төгрөг (2024: 44,663 сая төгрөг), Капитал банкинд олгосон ипотекийн зээлтэй холбоотой авлагын 12,891 сая төгрөг (2024: 12,891 сая төгрөг) багтаж байна. Банк нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлагад чанаргүйдлийн магадлал болон алдагдалд хүргэх чанаргүйдлийн 100%-ийн санг байгуулсан (2024: 100% сан байгуулсан).

Татан буугдсан Анод банкнаас авах авлага. Банк нь 2015 онд Анод банкны эрх хүлээн авагчийн ажиллагаа дуусгавар болсонтой холбогдуулан бусад эргэлтийн бус хөрөнгө болон зээлийн багцыг багтаасан нийт 73,662 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг хүлээн авсан. 2025 онд нийт 2,674 сая төгрөг (2024: 1,192 сая төгрөг)-ийн эргэн төлөлт хийгдсэн. Банк тус авлагад нийт 53,765 сая төгрөг (2024: 56,424 сая төгрөг)-ийн санг байгуулсан. СТОУС 9-ийн дагуу хөрөнгийн чанаргүйдлийн магадлал болон алдагдалд хүргэх чанаргүйдлийн 100%-ийн санг байгуулж, шатлал 3-т ангилсан.

Аж ахуйн нэгжээс авах авлага. Үүнд алт олборлогч компаниудтай байгуулсан алтны опцион гэрээний дагуу 2004 онд хугацаа нь дууссан боловч үүргээ биелүүлээгүй авлага багтсан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 26,360 сая төгрөг (2024: 48,752 сая төгрөг)-ийн үлдэгдэлтэй байна. Үүнээс гадна банк бус байгууллагаас авах авлагын үлдэгдэл 23,413 сая төгрөг (2024: 22,684 сая төгрөг) байна. Банк эдгээр байгууллагын эсрэг ойрын хугацаанд шүүхийн нэхэмжлэх үүсгэхээр төлөвлөж байна. Эдгээр авлагад өнгөрсөн хугацаанд 100%-ийн үнэ цэнийн бууралтын сан байгуулсан бөгөөд чанаргүйдлийн магадлал болон алдагдалд хүргэх чанаргүйдлийн 100%-ийн санг байгуулж, шатлал 3-т ангилсан.

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах авлага. Энэхүү авлага нь Eastern Gates компанитай холбоотой үүссэн авлага бөгөөд тус байгууллага үйл ажиллагаагаа зогсоосон учир банк нь тус авлагыг эргэн төлөгдөхгүй гэж үзэж 100%-ийн санг байгуулсан. Банк тухайн этгээдийн эсрэг шүүхийн нэхэмжлэл гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд хөрөнгийн чанаргүйдлийн магадлал болон алдагдалд хүргэх чанаргүйдлийг 100% гэж үнэлээд хөрөнгийг шатлал 3-т ангилсан.

Капитал банкны эрх хүлээн авагчаас авах өрийн бичгийн авлага. Банк 2020 оны 6 дугаар сард дотоодын нэг компаниас ААБҮЦ-ээр хэмжигдэж байсан өрийн бичгийн эргэн төлөлтөд Капитал банкны эрх хүлээн авагчаас гаргасан өрийн бичгийг хүлээн авсан. Авлагын дүнгээс 2025 онд 4,576 сая төгрөг (2024: 11,810 сая төгрөг) эргэн төлөгдсөн. Өрийн бичгийн үлдэгдэл 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5,320 сая төгрөг (2024: 9,896 сая төгрөг) байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18 БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Өрийн бичгийн авлага. Өрийн бичгийн авлага нь хорогдуулсан өртгийн ангиллын ЗХҮТ-ийн шалгуурыг хангаагүй тул ААБҮЦ-ээр бүртгэгддэг. Өрийн бичгийн гэрээ нь гэрээний анхны хүүгийн түвшин өндөр байхаар заасан бөгөөд хэрэв тодорхой нөхцөл байдал хангагдсан бол зээлийн хүүг зах зээлийн хүүгээс доогуур түвшин хүртэл бууруулах боломжтой. Банк 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 9 жилийн хугацаатай 15,625 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй дотоодын компанийн гаргасан өрийн бичгийг эзэмшиж байсан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өрийн бичиг нь бүрэн төлөгдсөн байна.

Эрсдэлийн алдагдлын сан. ХӨ-өөрх бусад санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийн шинжилгээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

<i>Сая төгрөгөөр</i>	Шатлал 1 (12-сарын ХБЭА)	Шатлал 3 (хугацааны туршид дахь ХБЭА, үнэ цэнэ буурсан)	Нийт дүн
-Сайн	11,513	-	11,513
-Дефолт	-	312,329	312,329
Хорогдуулсан өртгөөрх дансны нийт үнэ	11,513	312,329	323,842
Эрсдэлийн алдагдлын сан	(75)	(302,793)	(302,868)
Хорогдуулсан өртгөөрх дансны нийт үнэ	11,438	9,536	20,974

ХӨ-өөрх бусад санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийн шинжилгээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

<i>Сая төгрөгөөр</i>	Шатлал 1 (12-сарын ХБЭА)	Шатлал 3 (хугацааны туршид дахь ХБЭА, үнэ цэнэ буурсан)	Нийт дүн
<i>Бусад санхүүгийн хөрөнгө</i>			
-Хангалттай	3,985	-	3,985
-Дефолт	-	334,326	334,326
Хорогдуулсан өртгөөрх дансны нийт үнэ	3,985	334,326	338,311
Эрсдэлийн алдагдлын сан	(6)	(329,286)	(329,292)
Хорогдуулсан өртгөөрх дансны нийт үнэ	3,979	5,040	9,019

Бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрчлөлт, хөдөлгөөнийг доорх хүснэгтэд харууллаа:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18 БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөгөөр	Шатлал 1			Шатлал 3							Нийт дүн
	Бусад санхүүгийн хөрөнгө (Шатлал 1)	Бусад ААН-ээс авах авлага (Шатлал 1)	Анод банкнаас авах авлага (Шатлал 3)	Бусад санхүүгийн хөрөнгө (Шатлал 3)	Капитал банкны ЭХА-аас авах өрийн авлага (Шатлал 3)	ХДК-аас авах авлага (Шатлал 3)	Капитал банкны ЭХА-аас авах авлага (Шатлал 3)	Санхүүгийн бус байгууллагаас авах авлага (Шатлал 3)	Бусад ААН-ээс авах авлага (Шатлал 3)		
Дансны нийт үнэ											
2025 оны 1 дүгээр сарын 1	3,764	221	56,424	14,298	9,896	85,000	67,371	29,901	71,436	338,311	
<i>Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөн:</i>											
- Шатлал 1 болон 2-оос Шатлал 3 руу шилжсэн	-	(221)	-	221	-	-	-	-	-	-	
- Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	9,034	-	-	5,700	-	-	-	-	433	15,167	
- Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(1,285)	-	(2,674)	(219)	(4,576)	-	-	-	(1,394)	(10,148)	
Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт	7,749	(221)	(2,674)	5,702	(4,576)	-	-	-	(961)	5,019	
<i>Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангаас бусад өөрчлөлт, хөдөлгөөн:</i>											
- Гадаад валютын ханшийн болон бусад өөрчлөлт	-	-	15	6	-	-	-	1,193	2,549	3,763	
- Данснаас хасалт	-	-	-	-	-	-	-	-	(23,251)	(23,251)	
2025 оны 12 дугаар сарын 31	11,513	-	53,765	20,006	5,320	85,000	67,371	31,094	49,773	323,842	
Эрсдэлийн алдагдлын сан											
2025 оны 1 дүгээр сарын 1	6	-	56,424	11,704	7,450	85,000	67,371	29,901	71,436	329,292	
<i>Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөн:</i>											
- Шатлал 1 болон 2-оос Шатлал 3 руу шилжсэн	-	(4)	-	4	-	-	-	-	-	-	
- Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	75	4	-	2,283	-	-	-	-	-	2,362	
- Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(6)	-	(2,674)	(1,986)	(3,669)	-	-	-	(968)	(9,303)	
Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт	69	-	(2,674)	301	(3,669)	-	-	-	(968)	(6,941)	
<i>Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангаас бусад өөрчлөлт, хөдөлгөөн:</i>											
- Гадаад валютын ханшийн болон бусад өөрчлөлт	-	-	15	4	-	-	-	1,193	2,556	3,768	
- Данснаас хасалт	-	-	-	-	-	-	-	-	(23,251)	(23,251)	
2025 оны 12 дугаар сарын 31	75	-	53,765	12,009	3,781	85,000	67,371	31,094	49,773	302,868	

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18 БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрчлөлт, хөдөлгөөнийг доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	Шатлал 1				Капитал банкны ЭХА-аас авах өрийн бичгийн авлага (Шатлал 3)	Шатлал 3			Бусад ААН-ээс авах авлага (Шатлал 3)	Нийт дүн
	Бусад санхүүгийн хөрөнгө (Шатлал 1)	Бусад ААН-ээс авах авлага (Шатлал 1)	Анод банкнаас авах авлага (Шатлал 3)	Бусад санхүүгийн хөрөнгө (Шатлал 3)		ХДК-аас авах авлага (Шатлал 3)	Капитал банкны ЭХА-аас авах авлага (Шатлал 3)	Санхүүгийн бус байгууллагаас авах авлага (Шатлал 3)		
Дансны нийт үнэ										
2024 оны 1 дүгээр сарын 1	5,065	185	57,616	8,326	21,706	85,000	67,371	29,818	71,249	346,336
<i>Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөн:</i>										
- Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	6	426	1,398	6,000	-	-	-	-	-	7,830
- Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(1,307)	(390)	(2,590)	(28)	(11,810)	-	-	-	-	(16,125)
Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт	(1,301)	36	(1,192)	5,972	(11,810)	-	-	-	-	(8,295)
<i>Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангаас бусад өөрчлөлт, хөдөлгөөн:</i>										
- Гадаад валютын ханшийн болон бусад өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	83	187	270
2024 оны 12 дугаар сарын 31	3,764	221	56,424	14,298	9,896	85,000	67,371	29,901	71,436	338,311
Эрсдэлийн алдагдлын сан										
2024 оны 1 дүгээр сарын 1	336	-	57,616	6,860	17,750	85,000	67,371	29,818	71,249	336,000
<i>Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт, хөдөлгөөн:</i>										
- Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	8	-	1,398	4,849	-	-	-	-	-	6,255
- Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(338)	-	(2,590)	(5)	(10,300)	-	-	-	-	(13,233)
Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт	(330)	-	(1,192)	4,844	(10,300)	-	-	-	-	(6,978)
<i>Тайлант хугацааны эрсдэлийн алдагдлын сангаас бусад өөрчлөлт, хөдөлгөөн:</i>										
Гадаад валютын ханшийн болон бусад өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	83	187	270
2024 оны 12 дугаар сарын 31	6	-	56,424	11,704	7,450	85,000	67,371	29,901	71,436	329,292

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20 ҮНДСЭН ХӨРӨНГӨ БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	Барилга байгууламж	Дуусаагүй барилга	Тавилга, компьютер төхөөрөм	Нийт биет хөрөнгө	Биет бус хөрөнгө	Нийт дүн
2024 оны 1 сарын 1-ний өртөг	140,641	685	36,943	178,269	32,497	210,766
Хуримтлагдсан элэгдэл/ хорогдуулалт	(52,301)	-	(16,320)	(68,621)	(6,741)	(75,362)
2024 оны 1 сарын 1-нээрх дансны дүн	88,340	685	20,623	109,648	25,756	135,404
Нэмэгдсэн	-	7,475	5,344	12,819	-	12,819
Хасагдсан -өртгөөр	(1,567)	-	-	(1,567)	-	(1,567)
Акталсан -өртгөөр	-	-	(59)	(59)	-	(59)
Шилжүүлсэн	518	(518)	-	-	-	-
Элэгдэл/хорогдуулалт	(2,463)	-	(5,528)	(7,991)	(5,148)	(13,139)
Хасагдсан -хуримтлагдсан элэгдэл	168	-	-	168	-	168
Акталсан хуримтлагдсан элэгдэл	-	-	47	47	-	47
2024 оны 12 сарын 31-ний өртөг эсвэл үнэлгээ	139,592	7,642	42,227	189,461	32,497	221,958
Хуримтлагдсан элэгдэл/ хорогдуулалт	(54,596)	-	(21,800)	(76,396)	(11,889)	(88,285)
2024 оны 12 сарын 31-нээрх дансны дүн	84,996	7,642	20,427	113,065	20,608	133,673
Нэмэгдсэн	-	6,953	7,497	14,450	-	14,450
Хасагдсан -өртгөөр	(2,620)	-	(1)	(2,621)	-	(2,621)
Акталсан -өртгөөр	(1)	-	(195)	(196)	(37)	(233)
Шилжүүлсэн	162	(162)	-	-	-	-
Элэгдэл/хорогдуулалт	(2,449)	-	(5,858)	(8,307)	(4,871)	(13,178)
Хасагдсан -хуримтлагдсан элэгдэл	205	-	1	206	-	206
Акталсан -хуримтлагдсан элэгдэл	1	-	184	185	37	222
2025 оны 12 сарын 31-ний өртөг эсвэл үнэлгээ	137,133	14,433	49,528	201,094	32,460	233,554
Хуримтлагдсан элэгдэл/ хорогдуулалт	(56,839)	-	(27,473)	(84,312)	(16,723)	(101,035)
2025 оны 12 сарын 31-нээрх дансны дүн	80,294	14,433	22,055	116,782	15,737	132,519

Барилга байгууламжийг доор тайлбарласны дагуу дахин үнэлсэн дүнгээр, хуримтлагдсан элэгдэл болон шаардлагатай тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэдэг.

Банк барилга байгууламжийг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрдөг ба барилга байгууламжийг тайлант үеийн эцэст тодорхойлогдох бодит үнэ цэнээс бүртгэлийн дүн нь мэдэгдэхүйц зөрүүтэй болохооргүй байлгахын тулд тогтмол бөгөөд хангалттай давтамжтайгаар дахин үнэлгээ хийдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19 ҮНДСЭН ХӨРӨНГӨ БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дансны үнэ дахин үнэлгээгээр нэмэгдсэн тохиолдолд нэмэгдлийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, дөөрийн хөрөнгийн бусад нөөц дансанд холбогдох дахин үнэлгээний санд хүлээн зөвшөөрдөг. Тухайн хөрөнгийн өмнө нь хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний өсөлтийг нөхөж буй бүртгэлийн дүнгийн бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөд өмнө нь бүртгэсэн дахин үнэлгээний илүүдлийг бууруулж бүртгэдэг. Үүнээс бусад бүх бууралтыг тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгөнд бүртгэсэн барилга байгууламжийн дахин үнэлгээний нөөцийг илүүдэл бодитоор хэрэгжих үед хуримтлагдсан алдагдал эсвэл хуримтлагдсан ашиг руу шууд шилжүүлэ бүртгэдэг.

Банк нь эзэмшиж буй эд хогшил, тоног төхөөрөмжийг анхны өртгөөс үнэ цэнийн бууралт болон элэгдлийг хассан дүнгээр бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухай бүрт нь хүлээн зөвшөөрдөг бол барилга байгууламж, тоног төхөөрөмжийн аль нэг бүрэлдэхүүн хэсгийг солих зорилгоор томоохон зардал гаргасан бол тэдгээрийг капиталжуулах буюу хөрөнгийн өртөгт шингээдэг.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тайлант хугацааны эцэст үнэлж, үнэ цэнийн бууралт үүссэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцдог. Нөхөгдөх дүн гэж хөрөнгийн бодит үнэ цэнээс тухайн хөрөнгийг борлуулах зардлыг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр дүнг нь хэлнэ. Өмнөх тайлант жилүүдэд тухайн хөрөнгөд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг, тухайн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл борлуулахтай холбоотой зардлыг хассан бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орсон тохиолдолд буцаан хүлээн зөвшөөрнө.

Банк үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ болон борлуулсан үнийн зөрүүг тайлант жилийн ашиг, алдагдалд буюу үйл ажиллагааны бус орлого, зардалд бүртгэдэг.

Банк барилга байгууламжийг зах зээлийн ханшаар жил бүр дахин үнэлэхдээ жишиг хөрөнгө буюу ижил төстэй барилгатай харьцуулах замаар үнэлдэг ба тухайн жишиг хөрөнгийн үнэд байршил, барилгын бүтэц, хийцлэл, ашиглалтын байдалд тохируулга хийх замаар харьцуулж, үнэлдэг. Хөрөнгийн үнэлгээг хүлээн зөвшөөрөгдсөн, холбогдох мэргэжлийн ур чадварын гэрчилгээтэй хараат бус, гадны үнэлгээчнээр таван жил тутамд нэг удаа хийлгэдэг. Зах зээлээс олж авах боломжгүй мэдээлэлд суурилсан таамаглалаар үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн талаарх мэдээлэл болон мэдрэмтгийн байдлын шинжилгээг Тодруулга 35т тусгасан.

Удирдлага барилга байгууламжийн бодит үнэ цэнэ 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дансны үнээс мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй гэж үзсэн. Өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд барилгын үнэ буурах хандлага ажиглагдахгүй байгаа бөгөөд барилга байгууламжийн боломжит үнийн өсөлт нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн шийдвэр гаргалтад материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19 ҮНДСЭН ХӨРӨНГӨ БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Санхүүгийн байдлын тайланд барилга, байгууламжийн дахин үнэлэгдсэн дүн	80,294	84,996
Өмчийн өөрчлөлтийн тайлан дахь дахин үнэлгээний нөөц	(30,320)	(30,323)
Барилга, байгууламжийн өртгөөс хасах нь хуримтлагдсан элэгдэл	49,974	54,673

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн барьцаанд тавьсан үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө байхгүй болно.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц: Өмчийн өөрчлөлтийн тайлан дахь дахин үнэлгээний нөөцөөс тухайн хөрөнгийг данснаас хасах буюу борлуулах үед дахин үнэлгээний нэмэгдлийг нь хуримтлагдсан алдагдал руу шилжүүлдэг.

Элэгдэл. Банк дуусаагүй барилгад элэгдэл тооцдоггүй бөгөөд харин бусад үндсэн хөрөнгийн хувьд тэдгээрийн өртгийг үлдэх өртөг хүртэл хуваарилан доорх тооцоолсон ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргыг ашиглан элэгдүүлдэг:

	Ашиглалтын хугацаа, жилээр
Барилга байгууламж	6 – 60 жил
Оффис, конторын тавилга болон компьютер, тоног төхөөрөмж	3 – 20 жил

Биет бус хөрөнгө. Биет бус хөрөнгөд программ хангамжийн лицензүүд багтдаг ба эдгээр нь тодорхой ашиглалтын хугацаатай. Худалдан авсан компьютерийн программ хангамжийн лицензийг тухайн программ хангамжийг худалдан авч, ашиглахад бэлэн болгоход гарсан зардлын дүнгээр капиталжуулна. Биет бус хөрөнгийн өртгийг үлдэх өртөг хүртэл бууруулан 48 жилийн тооцоолсон ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулдаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20 ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Гүйлгээнд гаргасан мөнгөн тэмдэгт	1,244,350	1,222,179
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,244,350	1,222,179

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө нь Монголбанкнаас 1993 оны 9 дүгээр сараас хойш гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөн тэмдэгтээс бүрдэнэ. Банк нь дотоодын банкуудын бэлэн мөнгийг зузаатгах, бусад шаардлагаар харилцагчдад олгох үед гүйлгээнд гаргасан мөнгөн тэмдэгтийг нэрлэсэн үнээр өр төлбөрт бүртгэдэг ба Банкинд буцаан татагдах үед бүртгэлээс хасдаг.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

<i>Сая төгрөгөөр</i>	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Гүйлгээнд гаргасан мөнгөн тэмдэгт	1,222,179	1,293,829	(1,271,658)	1,244,350
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,222,179	1,293,829	(1,271,658)	1,244,350

20 ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

<i>Сая төгрөгөөр</i>	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Гүйлгээнд гаргасан мөнгөн тэмдэгт	1,151,700	1,524,335	(1,453,856)	1,222,179
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,151,700	1,524,335	(1,453,856)	1,222,179

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

21 ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Төв банкны үнэт цаас	10,973,332	11,511,780
Нийт төв банкны үнэт цаас	10,973,332	11,511,780

Банк нь өөрийн гаргасан үнэт цаасыг анхлан бодит үнэ цэнээр бүртгэж, дараа нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулалтын өртгөөр тооцож бүртгэдэг. Хорогдуулсан өртгийг тооцохдоо үр ашиг хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох зардал болон үнэт цаасыг гаргах үеийн хөнгөлөлт эсвэл урамшууллыг харгалзан тооцоолдог. Төв банкны үнэт цаас нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 28 хоног (2024: 28 хоног)-ийн хугацаатай, жилийн 12 хувь (2024: жилийн 10 хувь)-ийн хүүтэй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

22 ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Сангийн яамны хадгаламжийн данс	4,784,587	495,647
Сангийн яамны харилцах данс	1,295,047	5,926,667
Сангийн яаманд төлөх зээлийн өр төлбөр:		
- Олон Улсын Валютын Сан (ОУВС)	286,545	379,948
- Азийн Хөгжлийн Банк (АХБ)	36,022	40,127
- Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)	-	890
Нийт засгийн газрын хөрөнгө	6,402,201	6,843,279

Засгийн газар болон засгийн газрын агентлагуудын дансууд нь Засгийн газарт болон бусад харилцагчдад төлөх санхүүгийн үүсмэл бус өр төлбөр бөгөөд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Засгийн газрын хөрөнгөд Сангийн Яамны харилцах, хадгаламж, Олон Улсын Валютын Сан (ОУВС), Азийн Хөгжлийн Банк (АХБ), болон Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-ийн санхүүжилттэй хөтөлбөрийн хүрээнд Сангийн яамнаас авсан урт хугацаат зээл багтдаг.

Сангийн яамны хадгаламжийн данс. Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсанаар Банк 2024 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Сангийн яамтай 1 жилийн хугацаатай, бодлогын хүүтэй тэнцүү хүүтэй Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг арвижуулах хадгаламжийн гэрээг байгуулсан. Гэрээний дагуу Банк Хуримтлалын сангийн санхүүжилтээр арилжааны банкуудад ипотекийн зээл олгосон. Тус дансны үлдэгдэл 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар жилийн 10%-ийн хүүтэй 495,647 сая төгрөг байсан. Тодруулга 4-өөс удирдлагын дэлгэрэнгүй дүгнэлтийг харна уу.

Банк 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Хуримтлалын сангийн үнэ цэнийг хадгалж, хөрвөх чадварыг алдагдуулахгүйгээр өсгөн нэмэгдүүлэх зорилгоор бодлогын хүүтэй тэнцэх хүүгийн нөхцөлтэй, 1 жилийн хугацаатайгаар Хуримтлалын сангийн хөрөнгийг удирдан зарцуулах гэрээг Сангийн яамтай байгуулсан. 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын гэрээний дагуу Банк өмнө олгосон орон сууцны ипотекийн зээлүүдтэй холбоотой гэрээний дагуух мөнгөн гүйлгээний эрхийг 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Сангийн яаманд шилжүүлсэн. Үүний үр дүнд Хуримтлалын сангийн хадгаламжийн дансны үлдэгдэл 480,211 сая төгрөгөөр буурсан. Тус дансны үлдэгдэл нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 21,923 сая төгрөг (2024: 495,647 сая төгрөг), жилийн 12% хүүтэй (2024: бодлын хүү 10%) байна. Тодруулга 4-өөс удирдлагын дэлгэрэнгүй дүгнэлтийг болон Тодруулга 9-өөс олгосон орон сууцны ипотекийн зээлийн дэлгэрэнгүйг харна уу.

Банк 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Сангийн яамтай Ирээдүйн өв сангийн гадаад валютаарх хадгаламжийн гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан. Ирээдүйн өв сангийн хадгаламж данс нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,336 сая ам.доллар буюу 4,762,664 сая төгрөг үлдэгдэлтэй (2024: 1,162 сая ам.доллар буюу 3,974,519 сая төгрөг)-ийн үлдэгдэлтэй бөгөөд жилийн 3.78%-ийн хүүтэй, 90 хоногийн хугацаатай байна (2024: хүү хуримтлуулдаггүй харилцах данс). Тодруулга 4-өөс харна уу.

Сангийн яамны харилцах данс. Монголбанкинд байршуулсан Сангийн яамны нэлээд олон харилцах дансдууд багтдаг. Ихэнх харилцах дансдууд нь хугацаагүй бөгөөд хүү тооцогддоггүй. Нэг харилцах дансны үлдэгдэл 204,049 сая төгрөг (2024: 650,782 сая төгрөг) байгаа ба энэхүү харилцах дансны үлдэгдэлд жилийн 3 хувийн хүү тооцдог.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

22 ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сангийн яаманд төлөх ОУ-ын байгууллагуудын зээлийн өр төлбөр. Эдгээр өр төлбөр нь Монгол Улсын Засгийн газрын Олон Улсын Валютын Сан (ОУВС), Азийн Хөгжлийн Банк (АХБ), болон Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-аас авсан зээл бөгөөд эдгээр гэрээнүүдэд Сангийн Яам санхүүгийн зуучлагчаар, Монголбанк нь төслийн хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

Олон Улсын Валютын Сан (ОУВС). Монгол Улсын эдийн засгийн реформыг дэмжих зорилгоор ОУВС-аас Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ)-ийг 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 3 жилийн хугацаатай баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд ОУВС-аас Монгол Улсын Засгийн газарт 314,5 сая ЗТЭ-ийн дүн бүхий зээл олгосон бөгөөд энэ нь жилийн 1.53%-1.59%-ийн хүүтэй. Монголбанк болон Сангийн Яамны хооронд 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэн санхүүжилтийг Банкин дахь Сангийн Яамны холбогдох дансанд шилжүүлсэн. Эдгээр зээл нь Сангийн яамны үүрэг хариуцлагад хамаарна. Сангийн яам нь Монгол Улсын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг тул Олон улсын валютын сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор ОУВС-д өрийн бичиг гаргаж, гарын үсэг зурж баталгаажуулсан. Иймд ОУВСийн зээлүүдтэй холбогдох үүрэг хариуцлага нь Сангийн яаманд хамаарна. Зээлийн эргэн төлөлт нь ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн бөгөөд Банк Сангийн яамны өмнөөс ОУВС-д 2026 оны эцэс гэхэд төлж дуусгана. ӨСХ-ийн хүрээнд Сангийн яаманд төлөх өр төлбөрийн хэмжээ 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 59 сая ЗТЭ буюу 286,545 сая төгрөг (2024: 85 сая ЗТЭ буюу 379,948 сая төгрөг)-тэй тэнцэхүйц байна.

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны зээл. Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд АХБ-аас авсан зээл бөгөөд энэ нь жилийн 2,5 хувийн хүүтэй, 16 жилийн анхны тохиролцсон хугацаатай болно. Банк нь ОУВС болон АХБ-ны өмнө төлбөрийн үүрэг хүлээхгүй бөгөөд Сангийн Яам нь Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг тул Сангийн Яаманд төлөх үүрэгтэй. Банк төсөл хэрэгжүүлэгчийн хувьд энэхүү санхүүжилтээс дотоодын банкуудад дамжуулан олгох, үлдэгдлийг гадаад валютын нөөц хэлбэрээр хадгалах үүрэгтэй. Сангийн яам болон Монголбанкны хооронд байгуулсан зохицуулалтын гэрээний дагуу Монголбанк нь Сангийн Яамнаас, Сангийн Яамны Олон улсын валютын сан болон Азийн хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээтэй ижил нөхцөлөөр холбогдох санхүүжилтийг зээлж авсан. Мөн Монголбанк нь хадгаламжийн үүрэг гүйцэтгэж, ОУВС болон АХБтай холбоотойгоор Сангийн Яамны данснуудаас хийх төлбөр тооцоог гүйцэтгэх үүрэгтэй. Тус эх үүсвэрээс банкуудад олгосон зээлийн талаарх мэдээллийг Тодруулга 9-өөс харна уу.

Олон улсын хөгжлийн ассоциациаас авсан зээл. Хувийн хэвшлийг дэмжих төсөл болон Санхүүгийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор Олон улсын хөгжлийн ассоциациаас Сангийн Яамны авсан зээл бөгөөд жилийн 1-3 хувийн хүүтэй, 14-15 жилийн анхны тохиролцсон хугацаатай. Энэхүү зээл нь 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр бүрэн төлөгдөж дууссан.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн холбогдох гэрээний нөхцөлүүдийг бүрэн мөрдөж ажилласан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

23 ДОТООДЫН БАНКУУДЫН ХӨРӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Харилцах дансууд:		
- төгрөгөөр	9,566,805	6,335,095
- валютаар	4,522,956	3,511,587
Гадаад валютын хугацаатай хадгаламж	2,277,970	857,900
Төгрөгийн овернайт хадгаламж	170,046	-
Нийт дотоодын банкуудын хөрөнгө	16,537,777	10,704,582

Харилцагч банкуудаас Монголбанкинд мөнгө шилжин орж ирэхэд дотоодын банкуудын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг. Монголбанк нь үүсмэл бус өр төлбөрийг ХӨ-өөр ангилж, бүртгэдэг.

Харилцах данс. Банкинд байршуулсан дотоодын банкуудын заавал байлгах нөөцийн үлдэгдэл болон бусад төрлийн харилцах дансаас бүрдэх бөгөөд хадгаламж эзэмшигчдэд хамаарах эрх бүхий өр төлбөрийн тодорхой хувиар тооцож бүртгэдэг. Банкуудын харилцах данс дах заавал байлгах нөөцийн үлдэгдэл нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 7,429,675 сая төгрөг (2024: 5,416,920 сая төгрөг) байна.

Гадаад валютын хугацаатай хадгаламж. Дотоодын банкуудын байршуулсан валютын хугацаатай хадгаламж нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 640 сая ам.доллар буюу 2,277,970 сая төгрөгийн үлдэгдэлтэй, жилийн 3.7%-3.83%-ийн хүүтэй, 7-30 хоног (2024: 251 сая ам.доллар буюу 857,900 сая төгрөгийн үлдэгдэлтэй, жилийн 4.4%-4.7%-ийн хүүтэй, 7-90 хоног)-ийн хугацаатай байна.

Овернайт хадгаламж. Овернайт хадгаламж нь дотоодын банкуудын байршуулсан жилийн 10 хувийн хүүтэй 3 өдрийн хугацаатай төгрөгийн овернайт хадгаламж байна (2024: үлдэгдэл байхгүй).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

24 ГАДААД ӨР ТӨЛБӨР

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
ХАБ-аас авсан санхүүжилт	3,091,014	2,849,601
ОУВС-ийн ЗТЭ-ийн хуваарилалт	575,794	526,574
Дэлхийн банкны харилцах данс	1,931	1,596
Дэлхийн банкинд оруулсан хөрөнгө	223	214
АХБ-ны харилцах данс	61	61
ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	39	39
Нийт гадаад өр төлбөр	3,669,062	3,378,085

Гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өр төлбөрийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэж, дараа нь үр ашигт хүүгийн аргыг ашиглаж хорогдуулсан өртгөөр хэмжиж бүртгэдэг. Банк нь БНХАУ-ын Ардын банктай холбоотой зээлийн эрсдэлийн өндөр төвлөрөлтэй байна.

Хятадын Ардын банкнаас авсан санхүүжилт. Энэхүү үлдэгдэл нь Банкнаас дотоодын банкуудад БНХАУ-ын юаниар санхүүжилт олгоход ашигласан, БНХАУ-ын Ардын банкнаас авсан юаниар илэрхийлэгдсэн санхүүжилт юм. Хүүгийн түвшин нь Шанхайн банк хоорондын захын хүүгийн түвшин дээр 175 суурь нэгж нэмсэнтэй тэнцүү (2024: Шанхайн банк хоорондын захын хүүгийн түвшин дээр 175 суурь нэгж нэмсэнтэй тэнцүү) хүү байна. Санхүүжилтийн гэрээг 2023 оны 7 дугаар сард 3 жилийн хугацаагаар сунгасан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6,000 сая юань буюу 3,052,680 сая төгрөг (2024: 6,000 сая юань буюу 2,811,420 сая төгрөг)-ийн үлдэгдэлтэй байна. Тодруулга 4-өөс харна уу.

Зээлжих тусгай эрхийн хуваарилалт. ОУВС-ийн гишүүн орнуудад ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээтэй хувь тэнцүүлэн хуваарилсан ЗТЭ-ээр илэрхийлэгдэх хөрөнгө бөгөөд эдгээр хуваарилалт нь Банкны хувьд ОУВС-ийн өмнө хүлээсэн идэвхгүй шинжтэй өр төлбөрийг илэрхийлэх бөгөөд үүний эсрэгээр ОУВС-ээс хүлээн авсан хөрөнгө нь ЗТЭ-ийн дансанд бүртгэгддэг (Тодруулга 8-ыг харна уу). 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 575,794 сая төгрөг буюу 118,053 сая ЗТЭ (2024: 526,574 сая төгрөг буюу 118,053 сая ЗТЭ)-ийн үлдэгдэлтэй байна.

Олон Улсын Валютын Сантай холбоотой гүйлгээ. Монгол Улс болон Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн хоорондын харилцаан дахь Банкны үндсэн үүргээс шалтгаалж Банк нь ОУВС-тай холбоотой үйл ажиллагаанд оролцдог. Банк нь санхүүгийн тайландаа СТОУС-ийн хүрээнд хөрөнгө ба өр төлбөрийн тодорхойлолтын нөхцөлийг хангасан ОУВС-тай холбоотой тооцоог хүлээн зөвшөөрсөн байдаг. Банк нь СТОУС-ын хүрээнд хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтод нийцэхгүй ОУВС-д хамаарал бүхий тооцоог санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

Банкны ОУВС-тай холбоотой хөрөнгө ба өр төлбөр. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ОУВС-тай холбоотой өр төлбөрт ЗТЭ-ийн хуваарилалт бүхий өр төлбөр багтдаг (Тодруулга 8-ыг харна уу). ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн өр төлбөрийг тайлант өдрийн ЗТЭ-ийн төгрөгтэй харьцах Монголбанкны албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг. Төгрөг, ЗТЭ-ийн албан ханшийг ОУВС-ийн тогтоосон ЗТЭ-ийн ам.доллартай харьцах ханшийн мэдээлэл болон тайлант өдрийн Монголбанкны ам.долларын төгрөгтэй харьцах албан ханшид үндэслэн тооцсон.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

24 ГАДААД ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Монгол Улсын Засгийн газрын ОУВС-тай холбоотой хөрөнгө болон өр төлбөр. ОУВС-аас худалдан авалттай холбоотой гэрээт эрх, үүрэг Монголбанкинд байхгүй тул ОУВС-тай холбоотой хөрөнгүүд СТОУС-д заасан хөрөнгө ба өр төлбөрийн тодорхойлолтод нийцдэггүй. Эдгээр хөрөнгөд ОУВС-д хувь нийлүүлсэн хөрөнгө болон ОУВС-аас Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд авсан зээл багтана. ОУВС-тай холбоотой Монгол Улсын Засгийн газрын данс нь Монголбанкинд байршдаг. Сангийн яам нь Монгол Улсын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Иймд, Монгол Улсын ОУВС-аас авах авлага болон (ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө зэрэг) ОУВС-д төлөх өр төлбөр нь Сангийн яамны хөрөнгө, өр төлбөр болох учир Монголбанкны санхүүгийн тайланд тусгаагүй.

ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө. Энэхүү хувь хөрөнгө нь Монгол Улсын ОУВС-д гишүүн орноор нэгдсэнтэй холбоотойгоор төлсөн тусгай төрлийн хөрөнгө бөгөөд улс орон тус бүрийн хувьд эдийн засгийн хэмжээ, цар хүрээнд тулгуурлан ОУВС-гийн Удирдах Зөвлөлөөс тогтоодог. Квот нь гишүүн байгууллагын саналын эрх, тусгай сангаас хүртэх санхүүгийн нөөцийн хязгаар болон зээлжих тусгай эрх (оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн)-д үндэслэн оролцогчийн хүртэх хувь хязгаарыг тодорхойлдог. Монгол Улсын хувь нийлүүлсэн хөрөнгийн дийлэнх хэсэг нь Сангийн яамны зүгээс баталгаажуулсан үнэт цааснаас бүрдэх ба энэхүү үнэт цаас нь хүүгүй. Мөн үлдэх хэсэг нь ОУВС-д өгөх төлбөрөөс бүрдэх ба данс №1, №2 –ын талаар тодруулсан болно. Зээлжих тусгай эрхийн хуваарилалтын хувьд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 72.3 сая ЗТЭ (2024: 72.3 сая ЗТЭ) байна. Сангийн яам нь өрийн бичиг гаргаж энэхүү нийлүүлсэн хувь хөрөнгийн төлбөрийг хийдэг тул Сангийн яамны хөрөнгөд бүртгэгдэнэ.

ОУВС-д гаргасан үнэт цаас. Энэхүү үнэт цаас нь ОУВС-ийн зүгээс Монгол Улсын үндэсний валютад хуваарилагдах хувийг төлөөлөх ба дээр дурдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн тооцоонд үндэслэн баталгаажуулсан өрийн бичиг юм. Сангийн яам нь ОУВС-тай зээлийн эрхийн ашиглалтын талаар гэрээ хийх тохиолдолд өрийн бичгээр баталгаажуулдаг.

ОУВС-ийн данс №1 болон №2. ОУВС-ийн санхүүжилт авах, эргүүлэн төлөх болон хувь нийлүүлсэн хөрөнгийн ажил гүйлгээ гүйцэтгэхэд данс №1-г ашигладаг. Монгол төгрөгөөр гүйцэтгэх ажил гүйлгээнд данс №2-г ашигладаг. Данс №1 болон №2 нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 174,438 сая төгрөг (2024: 112,319 сая төгрөг)-ийн үлдэгдэлтэй байна.

Дэлхийн банк ба Олон улсын хөгжлийн агентлагт оруулсан хувь хөрөнгө. Энэ нь Банкны зүгээс Дэлхийн банк болон Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-г оруулсан хувь хөрөнгө юм.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар БНХАУ-ын Ардын Банкнаас авсан санхүүжилттэй холбоотой зээлийн гэрээний нөхцөлүүдийг зөрчөөгүй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

25 БУСАД ӨР ТӨЛБӨР

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Бусад санхүүгийн өр төлбөр		
Банкнаас бусад санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	629,219	25,853
Банкны тогтворжуулалтын сан	57,799	38,299
Бусад өглөг	46,715	42,976
Бусад санхүүгийн бус өр төлбөр		
Нийгмийн хөгжлийн сан	606	1,968
Нийт бусад өр төлбөр	734,338	109,096

Банкнаас бусад санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж. Хадгаламжийн даатгалын корпорацийн харилцах, хадгаламж, Үнэт цаасны төлбөр тооцооны төв болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн харилцах дансууд хамаардаг. 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Хадгаламжийн даатгалын корпораци 143 сая ам.доллар буюу 508,744 сая төгрөгийг, жилийн 3%-ийн хүүтэй 90 хоногийн хугацаатай хадгаламж байршуулсан.

Банкны тогтворжуулалтын сан. Банкны тухай хуулийн дагуу дотоодын банкуудын бүтцийн өөрчлөлт хийх зардлыг санхүүжүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг авах зорилгоор байгуулсан сан юм. Монголбанкны шийдвэрийн дагуу дотоодын банкуудын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлдэг бөгөөд санхүүжилт нь сангийн нийт хэмжээнээс хэтрэхгүй. Сангийн хөрөнгийг Монгол Улсад системийн хэмжээнд нөлөө бүхий дотоодын банкуудаас төлдөг жил бүрийн хураамжаас бүрдүүлдэг. Энэ санд 2025 онд нийт 57,799 сая төгрөг (2024: 38,299 сая төгрөг)-ийн жилийн хураамжийг төвлөрүүлсэн.

Нийгмийн хөгжлийн сан. Банкны дотоод дүрэм, журмын зохицуулалтыг үндэслэн ажилтнуудын ажлын нөхцөл, амьдралын чанарыг сайжруулах буюу нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор тодорхой хэмжээний хөрөнгийг Нийгмийн хөгжлийн санд зардлаар хуваарилдаг. Энэхүү сан нь ажилтанд тэтгэмж, тусламж олгох, орон сууц худалдан авахад болон шаардлагатай бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулсан. Удирдлага нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгө нь тухайн санхүүгийн жилийн хүлээгдэж буй санхүүжилтуудыг хангахад хүрэлцээтэй гэж үздэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26 ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САН

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Дүрмийн сан	60,000	60,000

Банк нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд бөгөөд Төв банкны тухай хуулийн дагуу дүрмийн сан нь Банкин дах төрийн эзэмшлийг илтгэх хөрөнгө юм.

Ерөнхий нөөцийн сан. Төв банкны тухай хуулийн дагуу цэвэр орлогын 40%-аас багагүй хувийг Банк нь Ерөнхий нөөцийн санд хуваарилах үүрэгтэй бөгөөд Монголбанкны үйл ажиллагаанаас үүсэх алдагдлыг хаахад ашигладаг. Үлдсэн 60 хүртэлх хувийг улсын төсвийн данс руу шилжүүлдэг. Ерөнхий нөөцийн санд зөвхөн цэвэр орлогын тодорхой хувийг хуримтлуулдаг бөгөөд Банк нь зарцуулах бүрэн эрхтэй байдаг.

2025 болон 2024 онд Банк хуримтлагдсан алдагдалтай байсан тул улсын төсөвт орлого шилжүүлээгүй болно.

Бусад нөөц. Бусад нөөц нь БДОБҮЦ-ээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгө, эрдэнэсийн сан, гадаад валют болон мөнгөжсөн алт, үнэт металл дахин үнэлгээний сангаас бүрддэг. Банк нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ашиг, алдагдлын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрөгдсөн мөнгөжсөн алт болон үнэт металлын дахин үнэлгээнээс үүссэн олз, гарз мөн гадаад валютын ханшийн зөрүүнээс үүссэн олз, гарзыг тайлант жилийн эцэст бусад нөөц дансанд шилжүүлдэг. Мөнгөжсөн алт болон гадаад валюттай холбоотой ханшийн зөрүүнээс үүссэн гарзын хувьд тухайн нөөцийг зөвхөн дахин үнэлгээний нөөцөд байгаа үлдэгдлийн хэмжээгээр бууруулна.

Банк нь 2025 онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж Эрдэнэсийн Сангийн эд зүйлсийг дахин үнэлгээний аргаар бус өртгийн аргаар үнэлж бүртгэх болсон. Энэхүү өөрчлөлт орсонтой холбогдуулан санхүүгийн тайлангийн Эрдэнэсийн Сангийн дахин үнэлгээний сангийн үзүүлэлтийг буцаан хэрэгжүүлэх зарчмын дагуу дахин тайлагнасан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 3-аас харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26 ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад нөөц сангийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	БДОБҮЦ-ээрх ангиллын үнэт цаасны дахин үнэлгээний сан	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан	Үнэт металын дахин үнэлгээний сан	Гадаад валютын дахин үнэлгээний сан	Нийт дүн
2024 оны 1 дүгээр сарын 1 (дахин тайлагнасан дүн)	22,957	30,331	944,898	117,506	1,115,692
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн гарз	(7,892)	-	-	-	(7,892)
БҮЦ-ийн өөрчлөлтөөс үүссэн ХБЭА-ын хэмжилт	135	-	-	-	135
Борлуулах үед ашиг алдагдал руу шилжүүлсэн	39	-	-	-	39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сангийн буцаалт	-	(8)	-	-	(8)
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөц рүү шилжүүлсэн	-	-	162,373	187,096	349,469
2024 оны 12 дугаар сарын 31 (дахин тайлагнасан дүн)	15,239	30,323	1,107,271	304,602	1,457,435
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз	13,828	-	-	-	13,828
БҮЦ-ийн өөрчлөлтөөс үүссэн ХБЭА-ын хэмжилт	35	-	-	-	35
Борлуулах үед ашиг алдагдал руу шилжүүлсэн	553	-	-	-	553
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сангийн буцаалт	-	(3)	-	-	(3)
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөц рүү шилжүүлсэн/(бусад нөөцөөс хуримтлагдсан алдагдал руу шилжүүлсэн)	-	-	738,120	(235,044)	503,076
2025 оны 12 дугаар сарын 31-ний дүн	29,655	30,320	1,845,391	69,558	1,974,924

БДОБҮЦ-ээр ангилах өрийн үнэт цаасны дахин үнэлгээний сан. БДОБҮЦ-ээр ангилах өрийн үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг энэхүү санд бүртгэнэ. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын өөрчлөлтөд бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигддэг засгийн газрын үнэт цаас болон өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтад хүлээн зөвшөөрсөн ХБЭА-ыг бүртгэдэг.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан. Банкны барилгын дахин үнэлгээнээс үүссэн нэмэгдлийг үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц санд бүртгэдэг. Дэлгэрэнгүйг Тодруулга 19-өөс харна уу.

Мөнгөжсөн алт, үнэт металын дахин үнэлгээний сан. Энэхүү санд мөнгөжсөн алт, үнэт металын ханшийн тэгшитгэлээс үүссэн бодит бус олзыг бүртгэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Гадаад валютын хөрвүүлэлт. Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт нь үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндэсний мөнгөн тэмдэгт байна. Үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “Монгол төгрөг” юм.

Гадаад валютын дахин үнэлгээний сан. Банк нь гадаад валютаар илэрхийлэгдэх хөрөнгө, өр төлбөрийг тухайн тайлант жилийн эцсийн валютын албан ханшаар хөрвүүлж бүртгэх үед үүсэх ханшийн зөрүүний олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Мөнгөөр илэрхийлэгдэх хөрөнгө, өр төлбөрийг тайлант жилийн эцсийн байдлаарх үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгийн албан ханшид хөрвүүлэхээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзыг тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзад хүлээн зөвшөөрнө.

Банк нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзыг дахин үнэлгээний нөөцөд шилжүүлдэг. Ханшийн зөрүүгийн гарз үүссэн тохиолдолд гарзыг дахин үнэлгээний нэмэгдэл дүнтэй дүйцүүлэн хасна. Хэрэв ханшийн зөрүүгийн гарз нь дахин үнэлгээний нэмэгдэл дүнгээс илүү гарсан, эсвэл дахин үнэлгээний нэмэгдэл байхгүй тохиолдолд илүү гэрсэн дүнг ашиг, алдагдлын тайланд гадаад валютын ханшийн зөрүүгийн гарзаар хүлээн зөвшөөрдөг.

Түүхэн өртгөөр хэмжигддэг мөнгөн бус зүйлсэд жилийн эцсийн хөрвүүлэлтийн ханш нөлөөлөхгүй. Өмчөөрх хөрөнгө оруулалт зэрэг гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигддэг мөнгөн бус зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тогтоосон өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хөрвүүлэхэд ашигласан ханш:

	2025 оны 12 дугаар сарын 31 (Төгрөг)	2024 оны 12 дугаар сарын 31 (Төгрөг)
Ам.доллар	3,556.66	3,420.25
Зээлжих тусгай эрх	4,877.40	4,460.47
Евро	4,186.72	3,566.98
Юань	508.78	468.57
Иен	22.81	21.67

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

27 ХҮҮГИЙН ОРЛОГО БА ЗАРДАЛ

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого		
ХӨ-өөр ангилсан гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	272,917	232,435
БДОБҮЦ-ээр ангилсан өрийн үнэт цаас	159,450	168,768
ХӨ-өөр ангилсан буцаан худалдан авах хэлцэл	151,476	244,849
ХӨ-өөр ангилсан өрийн үнэт цаас	110,211	171,913
Буцаан худалдан авах хэлцлийн авлага	36,436	-
ХӨ-өөр ангилсан дотоодын банкуудад олгосон зээл	18,996	84,579
БДОБҮЦ-ээр ангилсан Засгийн газрын үнэт цаас	6,581	5,724
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон нийт хүүгийн орлого	756,067	908,268
Бусад адилтгах орлого		
ААБҮЦ-ээр ангилсан банкуудад олгосон зээл	206	1,865
ААБҮЦ-ээр аангилсан бусад хөрөнгө	635	1,735
Нийт бусад адилтгах орлого	841	3,600
Нийт хүүгийн орлого	756,908	911,868
Хүүгийн зардал		
Төв банкны үнэт цаас	(995,068)	(1,078,920)
Засгийн газарт төлөх өр төлбөр	(235,532)	(128,986)
Гадаад өр төлбөр	(107,181)	(146,076)
Дотоодын банкуудын хөрөнгө	(92,473)	(99,987)
Буцаан худалдан авах хэлцэл	(40,683)	-
Бусад хүүгийн зардал	(5,509)	(4,880)
Дотоодын банкуудын заавал байлгах нөөцийн биелэлтэд олгосон урамшуулал	-	(37,896)
Нийт хүүгийн зардал	(1,476,446)	(1,496,745)
Цэвэр хүүгийн зардал	(719,538)	(584,877)

Хүүгийн орлого, зардлыг ААБҮЦ-ээр илэрхийлдэгээс бусад өрийн хэрэгслийн аккруэл суурьд үндэслэн үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолж бүртгэнэ. Энэ арга нь талуудын хооронд гэрээний дагуу төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардал болгон бүртгэдэг. ААБҮЦ-ээр илэрхийлдэг өрийн хэрэгслийн (өрийн бичиг) хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээр тооцоолж ашиг, алдагдлын тайланд “Бусад адилтгах орлого” хэсэгт харуулна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

27 ХҮҮГИЙН ОРЛОГО БА ЗАРДАЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Худалдан авах эсвэл шинээр гаргах үед үнэ цэнийн бууралттай “ХАШГҮЦБ” байсан санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүү нь (анхны ХБЭА-ыг багтаасан) ирээдүйн мөнгөн урсгалыг тухайн хөрөнгийн (анх хүлээн зөвшөөрөлтийн үеийн) бодит үнэ цэнэд хямдруулсан хувь болно. Ингэснээр үр ашигт хүүд эрсдэлийн алдагдлын тохируулга хийгдэнэ.

Хүүгийн орлогыг санхүүгийн хөрөнгийн нийт дүнгээс үр ашигт хүүгээр тооцон гаргана. Харин (i) үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд (шатлал 3) хүүгийн орлогыг хорогдуулсан өртгөөс (ХБЭА-ын хасагдуулгыг хасаад) үр ашигт хүүгийн хувиар тооцдог бөгөөд (ii) ХАШГҮЦБ-тай байсан санхүүгийн хөрөнгийн хувьд анхны эрсдэлийн алдагдлаар тохируулсан үр ашигт хүүг хорогдуулсан өртгөөр үржүүлэн тооцно.

Шатлал 3-т ангилсан байсан санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн алдагдал нь багагүй буурч, чанаргүй гэсэн ангиллаас гарсан тохиолдолд (мөн энэ үйл явдал нь тус ангилалд орсны дараа болсон тохиолдолд) хөрөнгийг шатлал 3-аас гарган дахин ангилах бөгөөд хүүгийн орлогыг нийт дансны үнээс үр ашигт хүүгийн хувиар тооцно. Өмнө нь шатлал 3-т ангилагдсан учраас ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгддөггүй байсан нэмэлт хүүгийн орлого нь хөрөнгийн чанар сайжирснаас хойш үнэ цэнэ бууралтын буцаалт гэж бүртгэгдэнэ.

28 АЛТ, ҮНЭТ МЕТАЛЫН АРИЛЖААНЫ ОЛЗ

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Мөнгөжсөн алт, үнэт металл борлуулсны олз	793,864	258,339
Мөнгөжсөн алт, үнэт металл цэвэршүүлэлтийн зөрүүнээс үүссэн олз	216,082	78,308
Алт, үнэт металын арилжааны олз	1,009,946	336,647

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

29 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО

Сая төгрөгөөр	2025	2024
Шимтгэлийн орлого	56,350	50,377
Хуримтлалын сангийн хүүгийн зөрүүнээс үүссэн орлого	21,681	-
Дотоодын банкуудын торгуулийн орлого	4,951	5,560
Үндсэн хөрөнгийн түрээсийн орлого	2,180	1,174
Үйл ажиллагааны бусад орлого	23,228	16,122
Нийт үйл ажиллагааны бусад орлого	108,391	73,233

Банк шимтгэлийн орлогыг гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн үед, ихэвчлэн тухайн гүйлгээг хэрэгжүүлсэн үед тухайн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Хүлээн авсан буюу авах шимтгэлийн дүн нь бие даасан гүйцэтгэлийн үүрэг гэж тодорхойлогдсон үйлчилгээний гүйлгээний үнийг илэрхийлнэ. Энэ төрлийн орлогод банкны авч буй бэлэн бус гүйлгээний шимтгэл болон бэлэн мөнгөний гүйлгээний шимтгэл багтдаг.

Үүнээс гадна банк хоорондын их болон бага дүнтэй гүйлгээ, картын болон гадаад валютын гүйлгээнээс авч буй шимтгэлийн орлого багтдаг.

Үндэсний Баялгийн Сангийн тухай хууль 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдаж Банк Хуримтлалын сангийн эх үүсвэрээр дотоодын банкуудад орон сууцны ипотекийн зээл олгосон. Банк нь 2024 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Сангийн яамтай Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг арвижуулах хадгаламжийн гэрээг нэг жилийн хугацаатай, бодлогын хүүтэй тэнцүү хүүтэй байгуулсан. Гэрээний дагуу (i) Хуримтлалын сангийн эх үүсвэрээр дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлээс хүлээн авах Банкны хүүгийн орлого болон (ii) Сангийн яамнаас байршуулсан Хуримтлалын сангийн хадгаламжид төлөх Банкны хүүгийн зардлын зөрүүг Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамнаас төлсөн. Удирдлагын дүгнэлтийг тодруулга 4-өөс харна уу.

Банк нь банкны салбарын зохицуулагч байгууллагын хувьд өөрийн тогтоосон зохицуулалтын шаардлагын дагуу дотоодын банкуудаас заавал байлгах нөөцийг төвлөрүүлдэг. Банк нь дотоодын банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг 14 хоногоор тооцдог (Тодруулга 23-ыг харна уу) бөгөөд заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаагүй банкуудаас торгууль авдаг. Нөөц хангаагүй банкуудаас авсан торгуулийн орлогын дүн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4,951 сая төгрөг (2024: 5,560 сая төгрөг) байна.

Үйл ажиллагааны бусад орлогыг ерөнхийдөө тодорхой гүйлгээг гүйцэтгэсэн байдлаар, нийт үзүүлэх үйлчилгээтэй харьцуулахад бодитоор үзүүлсэн үйлчилгээний хувь хэмжээнд үндэслэн хуримтлуулан бүртгэж хүлээн зөвшөөрдөг. Үйл ажиллагааны бусад орлогод мөнгөн тэмдэгт болон зоос борлуулсны орлогыг бүртгэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30 ЗАХИРГААНЫ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Цалингийн зардал	55,763	52,075
Мөнгөн тэмдэгт хэвлүүлэх зардал	19,202	15,255
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл/хорогдуулалт	13,178	13,139
Харилцаа холбоо, ашиглалтын зардал	5,185	4,739
Лиценз ба техник хангамжийн зардал	4,369	7,547
Харуул хамгаалалтын зардал	3,440	3,230
Алт цэвэршүүлэх, тээвэрлэх, хүргүүлэхтэй холбоотой зардал	3,094	4,396
Тээврийн болон албан томилолтын зардал	2,776	2,503
Байгууламж, зохион байгуулалтын төлбөр	1,944	1,883
Үндсэн хөрөнгийн засварын зардал	1,570	1,124
Гишүүнчлэл болон мэргэжлийн үйлчилгээний зардал	1,341	1,414
Зар сурталчилгааны зардал	1,147	1,200
Сургалтын зардал	212	146
Бусад зардал	4,997	7,788
Нийт захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал	118,218	116,440

Цалин хөлс болон түүнтэй адитгах бусад зардлуудыг (ээлжийн амралт, өвчтэй байх үеийн нөхөн олговор, нэмэгдэл хөлс болон мөнгөн бус тэтгэмж гэх мэт) ажилтнуудын холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд харгалзуулан зардал гэж хүлээн зөвшөөрдөг. Ээлжийн амралт зэрэг богино хугацаанд хуримтлагдах нөхөн олговрыг ажилтнуудад ирээдүйд авах амралтын эрхийг үүсгэх буюу үйлчилгээг үзүүлсэн үед зардал болгон хүлээн зөвшөөрнө.

Монголбанк нь Монгол Улсын цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосон мөнгийг гүйлгээнд гаргадаг. Цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосыг хэвлүүлэхтэй холбоотой урьдчилж гарсан зардал нь “Бусад хөрөнгө” хэсэгт бүртгэгдэх ба тэдгээрийг үйлдвэрлэлээс бэлтгэл санд шилжих үед зардлаар хүлээн зөвшөөрч “Захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал”-д толилуулдаг.

Аудитын төлбөр 2025 оны санхүүгийн жилд 527 сая төгрөг (2024: 614 сая төгрөг) байсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

31 САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ӨР ТӨЛБӨРИЙН ХӨДӨЛГӨӨН

Доорх хүснэгтэд тайлант хугацаа тус бүрийн хувьд Банкны санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлтийг харуулсан. Эдгээр өр төлбөрийн зүйлс нь мөнгөн гүйлгээний тайланд санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгалд тусгагдсан.

Сая төгрөгөөр	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өр төлбөр		
	Гадаад байгууллагуудтай холбоотой өр төлбөр	Буцаан худалдан авах хэлцэл	Нийт дүн
2024 оны 1 сарын 1-нээрх санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өр төлбөр	5,659,491	-	5,669,491
<i>Мөнгөн гүйлгээ:</i>			
Мөнгөн гүйлгээний гарах урсгал	(2,100,025)	-	(2,100,025)
Төлсөн хүү	(184,445)	-	(184,445)
<i>Мөнгөн бус гүйлгээ:</i>			
Хуримтлуулсан хүү	147,002	-	147,002
Гадаад валютын ханшийн тэгшитгэл	(143,938)	-	(143,938)
2024 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өр төлбөр	3,378,085	-	3,378,085
<i>Мөнгөн гүйлгээ:</i>			
Мөнгөн гүйлгээний орох урсгал	-	13,504,814	14,504,814
Мөнгөн гүйлгээний гарах урсгал	-	(13,530,708)	(13,530,708)
Төлсөн хүү	(111,946)	(40,699)	(152,645)
<i>Мөнгөн бус гүйлгээ:</i>			
Хуримтлуулсан хүү	107,181	40,699	147,880
Гадаад валютын ханшийн тэгшитгэл	295,742	25,894	321,636
2025 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өр төлбөр	3,669,062	-*	3,669,062

***Буцаан худалдан авах хэлцэл.** Банк 2021 оын 10 дугаар сарын 5-ны өдөр АНУ-ын Засгийн газрын үнэт цаас барьцаалан буцаан худалдан авах хэлцэл хийх гэрээг ОУТТБ-тай байгуулсан (Тодруулга 10-аас харна уу). Энэхүү гэрээний хүрээнд Банк 2025 оны туршид нийт 13,549,338 сая төгрөгийн (2024: байхгүй) буцаан худалдан авах хэлцлийг 30 хоногоос бага хугацаатайгаар байгуулсан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бүрэн төлөгдсөн байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

32 БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ

Шийдэгдээгүй хэрэг. Банк нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар болзошгүй үүрэг хүлээгээгүй ба материаллаг хэмжээний гарз учруулах аливаа шүүн таслах ажиллагаанд оролцогчоор дуудагдаагүй байна. Удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудад нөөц санг байгуулах шаардлагагүй гэж үзсэн.

Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг. Банк зээлийн шинжтэй үүргүүдэд хамаарах гэрээнүүдийг байгуулдаг ба үүнд аккредитив болон БНХАУ-ын Ардын Банк (БНХАУ-ын төв банк, “ХАБ”)–тай байгуулсан гэрээний зохицуулалтууд багтана. Эдгээр зохицуулалтууд нь чанарын хувьд ХАБ-аас Монголбанк (“МБ”)–д юаниар олгосон зээлийн шугам болон Монголбанкаас ХАБ-д төгрөгөөр олгосон зээлийн шугамыг тус тус илэрхийлнэ.

Тайлант жилийн эцэст төлбөрийн үүрэг хариуцлага нь 1) хорогдуулаагүй төлбөрийн үлдэгдэл дээр нэмээд 2) хүлээгдэж буй алдагдлын загвараар тодорхойлсон ХБЭА-ын сангийн дүнгээр хэмжигддэг. Хэрэв ашиглаагүй үүрэг хариуцлагын дүнд хураамж авдаг бол энэ хураамж нь тухайн үүргийн хүчинтэй хугацаанд орлого гэж хүлээн зөвшөөрөгддөг.

Банк нь Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол Улсын хувьд чухал ач холбогдол бүхий салбарт (бараа үйлчилгээ экспортлох гэх мэт) санхүүжилтийн баталгаа гаргаж, төлбөрийн үүрэг хүлээдэг. Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь Засгийн газар болон холбогдох бусад талуудыг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино.

Гаргасан аккредитивүүд нь зээл болж гараагүй буюу ашиглагдаагүй үлдсэн үүргээс бүрдэнэ. Банк ийм зээлтэй холбоотой төлбөрийн үүргийн хувьд тухайн зээлээс ашиглагдаагүй үлдсэн хэмжээгээр алдагдал хүлээх эрсдэлтэй юм.

Гэвч ихэнх зээл нь эрсдэл багатай харилцагчдад олгогддог тул энэхүү болзошгүй алдагдлын хэмжээ нь нийт ашиглагдаагүй байгаа төлбөрийн үүргийн хэмжээнээс бага байна. Зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хэмжээг дор харууллаа:

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31 Шатлал 1 (12 сарын ХБЭА)	2024 оны 12 дугаар сарын 31 Шатлал 1 (12 сарын ХБЭА)
Болзошгүй өр төлбөр		
Импортын аккредитив	15,768	14,227
Төлбөрийн үүрэг хариуцлага		
Ашиглаагүй зээлийн шугам	7,547,220	7,103,140
Нийт зээлтэй холбоотой үүрэг хариуцлага	7,562,988	7,117,367

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

32 БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлтэй холбоотой үүрэг хариуцлагын зээлийн эрсдэлийн үнэлгээ нь дараах байдалтай байна:

	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
<i>Сая төгрөгөөр</i>	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 1 (12 сарын ХБЭА)
Импортын аккредитив		
- Хангалттай	15,768	14,227
Хүлээн зөвшөөрөөгүй нийт дүн	15,768	14,227
Төлбөрийн үүрэг хариуцлага		
- Онц сайн	7,547,220	7,103,140
Хүлээн зөвшөөрөөгүй нийт дүн	7,562,988	7,117,367

ХБЭА-ыг тооцох зорилгоор болзошгүй өр төлбөр болон үүрэг хариуцлагыг шатлал 1-д ангилсан бөгөөд ХБЭА-ыг тооцсон дүн нь нөлөө бүхий дүн биш байсан тул 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХБЭА-ыг байгуулаагүй. Удирдлага нь аккредитивийн гэрээ болон зээлийн шугамтай холбоотой өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь материаллаг бус гэж үзсэн. Эдгээр ашиглагдаагүй зээлийн шугам болон аккредитивын нийт гэрээт үлдэгдэл дүн нь эдгээр санхүүгийн хэрэгслүүд санхүүжилт хийгдэлгүйгээр хугацаа дуусах эсвэл цуцлагдах боломжтой тул ирээдүйн мөнгөн гүйлгээний хэрэгцээг заавал илэрхийлэхгүй.

ХБЭА-ын хэмжилтийг зээлийн хөрвүүлгийн факторын аргыг ашиглан үнэлсэн бөгөөд эдгээр үлдэгдлийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь материаллаг бус дүнг илтгэнэ. Иймд Банк зээлийн үүрэг хариуцлагын болон санхүүгийн баталгааны хувьд эрсдэлийн алдагдлын санг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

Импортын аккредитив. Импортын аккредитивыг голчлон Монгол Улсын Засгийн газарт импортын зохицуулалттай холбоотойгоор гаргадаг. Гаргасан аккредитивын хүрээнд Банк нь Засгийн газар, түүний харьяа байгууллагуудын өмнөөс Засгийн газрын хүсэлтээр Засгийн газар, түүний харьяа байгууллага эсвэл бусад этгээдэд үйлчилгээ үзүүлсэн, эсвэл бараа нийлүүлсэн гадаадын хуулийн этгээдэд төлбөр хийх үүрэг хүлээдэг.

Хятадын Ардын банкттай байгуулсан своп хэлцэл. Хятадын юань болон Монгол төгрөг солилцох своп хэлцлийг анх 2011 оны 5 дугаар сард байгуулж, 2014 оны 8 дугаар сар, 2017 оны 7 дугаар сар, 2020 оны 7 дугаар сар, 2023 оны 7 сард тус тус сунгасан. ХАБ-тай байгуулсан энэхүү гэрээг хамгийн сүүлд 2023 оны 7 дугаар сард шинэчлэн гурван жилийн хугацаатайгаар сунгасан. Хоёр улсын төв банкууд тухайн своп хэлцлийн санхүүжилтийг хоёр улс хоорондын худалдааг дэмжих, санхүүгийн зах зээлийг тогтворжуулах, богино хугацаанд хөрвөх чадварыг хангах зорилгоор ашигладаг.

Гэрээний дагуу Хятадын Ардын банк болон Банк нь хятадын юаниар төгрөг, монгол төгрөгөөр юань худалдан авах, худалдах хэлцлийг цаашид тодорхой хугацаанд хийх боломжтой. Гэрээний дагуу аль нэг банк нь нөгөө банкны зөвшөөрлийн үндсэн дээр сангийн хөрөнгийг ашиглах хүсэлт гаргах боломжтой. Хөрөнгө ашиглах хүсэлтийн дээд хэмжээ нь Банкны хувьд 15,000 сая юань (2024: 15,000 сая юань), Хятадын Ардын банкны хувьд 7,547,220 сая төгрөг (2024: 7,103,140 сая төгрөг)-өөр хязгаарлагдана.

Зээлийн шугамаас Банкны ашигласан дүн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6,000 сая юань буюу 3,052,680 сая төгрөг (2024: 6,000 сая юань буюу 2,811,620 сая төгрөг) ба ашиглаагүй дүн 9,000 сая юань буюу 4,579,020 сая төгрөг (2024: 9,000 сая юань буюу 4,217,130 сая төгрөг) байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33 ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Холбоотой талууд гэдэг нь хэрэв талууд нэг төвлөрсөн удирдлагатай, эсвэл талуудын аль нэг нь нөгөө байгууллагынхаа санхүү болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, хянах чадвартай байхыг хамруулан ойлгоно. Холбоотой талуудын хамаарлыг авч үзэхдээ зөвхөн хуулийн хэлбэрийг бус хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарна.

Банк нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх холбоотой талуудыг тодруулсан:

- Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд – Монгол улсын Сангийн Яам, удирдлагыг Монгол Улсын Засгийн газраас томилон ажиллуулдаг.
- Төрийн Банк – УИХ-аас удирдлагыг томилох бөгөөд хувьцааны 94.3 хувийг Монгол Улсын Сангийн Яам, 5.7 хувийг олон нийт эзэмшдэг.
- Хөгжлийн Банк – Монгол Улсын Засгийн газраас удирдлагыг томилох бөгөөд Засгийн газрын бүрэн эзэмшлийн төрийн өмчит байгууллага.
- Хадгаламжийн Даатгалын Корпораци (ХДК) нь Монгол Улсын Засгийн газрын 100 хувийн өмчит байгууллага юм. ХДК-ийн үйл ажиллагаатай холбоотой бүх шийдвэрийг Банкны Тэргүүн дэд ерөнхийлөгч даргалдаг Үндэсний хорооны долоон гишүүний саналаар баталдаг. ХДК-д хяналт тогтоож байгаа эсэхтэй холбоотой удирдлагын дүгнэлтийг Тодруулга 4-өөс харна уу.
- Эрдэнэс Монгол ХХК нь Засгийн газрын 100 хувийн өмчит байгууллага.
- Нийслэлийн Орон Сууцны Корпораци нь Засгийн газрын 100 хувийн өмчит байгууллага.

Банк нь НББОУС 24-ийн дагуу Засгийн газартай хамаарал бүхий байгууллагуудын хувьд тодруулгын шаардлагаас хасах чөлөөлөлтийг ашигласан. Үүний үр дүнд, Засгийн газартай хамаарал бүхий байгууллагуудтай хийсэн материаллаг бус гүйлгээг энэхүү санхүүгийн тайланд толилуулаагүй болно.

Холбоотой талуудын орлого, зардлын үзүүлэлтийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харууллаа:

Сая төгрөгөөр	Засгийн Газар	Төрийн Банк	Монгол Улсын		НЗДТГ	НОСК	Нийт дүн
			Хөгжлийн Банк	Эрдэнэс Монгол			
Хүүгийн орлого	6,581	22,403	13,457		8,827	9,112	60,380
Хүүгийн зардал	(202,858)	(115,118)	(22,179)		(3,116)	-	(343,271)
Хураамж шимтгэлийн орлого	2,398	5,773	-		-	-	8,171
Эрсдэлийн алдагдлын сан/ сангийн буцаалт	(171)	-	-	(143,873)	-	110	(143,934)
Засгийн газрын авлагад тооцсон үнэ цэнийн бууралтын гарз	(74,231)	-	-	-	-	-	(74,231)
Нийт дүн	(268,281)	(86,942)	(8,722)	(143,873)	5,711	9.222	(492,885)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33 ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний үр дүнд үүссэн хөрөнгө, өр төлбөрийн дансны үлдэгдлийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

	Тодруулга	Засгийн газар	Төрийн Банк	Монгол Улсын Хөгжлийн Банк	ХДК	Эрдэнэс Монгол ХХК	НЗДТГ	НОСК	Нийт дүн
<i>Сая төгрөгөөр</i>									
Засгийн газрын үнэт цаас	16	55,272	-	-	-	-	-	-	55,272
Засгийн газраас авах авлага	17	403,306	-	-	-	-	-	-	403,306
Санхүүгийн бус байгууллагуудад олгосон зээл	18	-	-	-	85,000	-	-	-	85,000
Эрдэнэс Бонд	10	-	-	-	-	849,807	-	-	849,807
Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд	10	-	-	-	-	-	-	119,072	119,072
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	15	-	1,401	(2,677)	-	-	(8,586)	-	(9,862)
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн алдагдлын сангийн зардал		(639)	-	-	(85,000)	(228,190)	-	(157)	(313,986)
Төв банкны үнэт цаас	21	-	(1,130,000)	-	-	-	-	-	(1,130,000)
Дотоодын банкуудын хөрөнгө	23	-	(695,536)	(376,537)	-	-	-	-	(1,072,073)
Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгө	25	-	-	-	(613,931)	-	-	-	(613,931)
Засгийн газарт төлөх өр төлбөр	22	(6,402,201)	-	-	-	-	-	-	(6,402,201)
Нийт дүн		(5,944,262)	(1,824,135)	(379,214)	(613,931)	621,617	(8,586)	118,915	(8,029,596)

Холбоотой талуудын орлого, зардлын дүнг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

	Засгийн Газар	Төрийн Банк	Монгол Улсын Хөгжлийн Банк	Эрдэнэс Монгол ХХК	Эрдэнэс Таван Толгой ХК	НОСК	Нийт дүн
<i>Сая төгрөгөөр</i>							
Хүүгийн орлого	5,724	2,694	28,510	52,719	9,699	12,019	111,365
Хүүгийн зардал	(80,837)	(134,580)	(8,731)	-	-	-	(224,148)
Хураамж шимтгэлийн орлого	2,563	5,310	-	-	-	-	7,873
Эрсдлийн алдагдлын сан/сангийн буцаалт	(55)	(704)	-	51,171	11,722	306	62,440
Засгийн газраас авах авлагад тооцсон үнэ цэнийн бууралтын гарз	(37,405)	-	-	-	-	-	(37,405)
Нийт дүн	(110,010)	(127,280)	19,779	103,890	21,421	12,325	(79,875)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33 ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний үр дүнд үүссэн хөрөнгө, өр төлбөрийн дансны үлдэгдлийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

	Тодруулга	Засгийн газар	Төрийн Банк	Монгол Улсын Хөгжлийн Банк	ХДК	Эрдэнэс Монгол ХХК	НОСК	Нийт дүн
Сая төгрөгөөр								
Засгийн газрын үнэт цаас	16	56,187	-	-	-	-	-	56,187
Засгийн газраас авах авлага	17	477,537	-	-	-	-	-	477,537
Дотоодын банкуудад олгосон зээл	9	-	154,024	-	-	-	-	154,024
Санхүүгийн бус байгууллагуудад олгосон зээл	18	-	-	-	85,000	-	-	85,000
Эрдэнэс Бонд	10	-	-	-	-	849,807	-	849,807
Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд	10	-	-	-	-	-	129,196	129,196
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	15	-	275	(2,230)	-	-	-	(1,955)
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн алдагдлын сангийн зардал		(468)	(1,975)	-	(85,000)	(84,317)	(268)	(172,028)
Төв банкны үнэт цаас	21	-	(1,350,000)	-	-	-	-	(1,350,000)
Дотоодын банкуудын хөрөнгө	23	-	(552,203)	(89,252)	-	-	-	(641,455)
Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгө	25	-	-	-	(14,646)	-	-	(14,646)
Засгийн газарт төлөх өр төлбөр	22	(6,843,279)	-	-	-	-	-	(6,843,279)
Нийт дүн		(6,310,023)	(1,749,879)	(91,482)	(14,646)	765,490	128,928	(7,271,612)

Дээр дурдсан үлдэгдэл дүн нь Банкны үндсэн үйл ажиллагааны үр дүнд үүссэн болно. Удирдлага холбоотой талуудын ажил гүйлгээнд анх хүлээн зөвшөөрөлтийн олз/гарз бүртгэх шаардлагатай эсхийг үнэлдэг бөгөөд дээрх ажил гүйлгээ нь анхдагч зах зээлд хийгдсэн эсхийг шалгадаг. Дэлгэрэнгүйг Тодруулга 4-өөс харна уу.

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудтай байгуулсан Эрдэнэс бонд, Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондоос бусад хөрөнгө нь барьцаагүй. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол улсын Хөгжлийн Банк нь Эрдэнэс бондтой холбоотойгоор 550,000 сая төгрөгийн баталгаа гаргасан байна. Бусад холбоотой талуудын өглөг эсвэл авлагад зориулж ямар нэгэн хүлээн авсан эсвэл гаргасан баталгаа байхгүй.

Импортын аккредитивүүд. Холбоотой талуудад 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 15,768 сая төгрөг (2024: 14,227 сая төгрөг)-ийн импортын аккредитив гарган өгч үүрэг хүлээсэн. Тодруулга 32-оос дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33 ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны Захирлуудын зөвлөлийн гишүүдийн цалин хөлс болон бусад тэтгэмжийн талаарх мэдээллийг дор харууллаа:

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Цалин хөлс	1,548	1,526
<i>Нийгмийн болон тэтгэврийн санд төлсөн шимтгэл</i>	193	191
Тэтгэмжүүд	20	10
Нийт дүн	1,761	1,727

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, гадаад валютын улсын нөөцийг удирдах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ санхүүгийн эрсдэлд өртөж болзошгүй байдаг. Эрсдэлийг зөв тодорхойлон хэмжиж, хянаснаар эрсдэлийг хязгаарлаж, удирдах боломжтой. Эрсдэлийг үр дүнтэй удирдсанаар төв банк нь мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлж (инфляцын зорилтыг хангах), санхүүгийн тогтвортой байдлыг хангаж ажилладаг. Зарим тохиолдолд Банк эрсдэлд хэт өртөмтгий болох, үндсэн зорилгоо биелүүлэхэд хүндрэл үүсэх боломжтой. Энэ нь санхүүгийн гэнэтийн алдагдал хүлээх, тухайлбал гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгөөс ханшийн хөрвүүлгийн алдагдал хүлээх магадлалтай байдаг. Ийм төрлийн алдагдал нь бүх төрлийн санхүүгийн эрсдэлтэй холбоотойгоор үүсч болзошгүй.

Банк нь олон төрлийн эрсдэлд өртөх боломжтой ба үүнд зээлийн, төлбөрийн чадварын, зах зээлийн, үйл ажиллагааны, нэр хүндийн болон хууль, эрх зүйн эрсдэлүүд хамаарна.

Одоогоор Банк эрсдэлийн удирдлагын төвлөрсөн бус тогтолцоотой үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын төв банк болохын хувьд Банкинд онцгойлон хамаарах эрсдэлийг Банкны стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, удирддаг. Банк “*Гурван шатлалт хамгаалалтын загвар*”-ыг ашиглан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

1. Нэгдүгээр шугамд - газар нэгж тус бүр эрсдэлийн бие даасан хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд эрсдэлийг хянах үүрэгтэй.
2. Хоёрдугаар шугамд - банкны эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтыг боловсруулан гаргах, зөвлөмж чиглэл өгөх, эрсдэлийн мониторинг хийх үйл ажиллагааг хариуцдаг газар нэгжүүдээс тавьж буй хяналт хамаардаг.
3. Гуравдугаар шугамд - нэгдүгээр болон хоёрдугаар шугамын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаа хамаарна.

Эрсдэлийн удирдлагын бүтэц. Эрсдэлийг хянах, удирдах үйл ажиллагааг бие даасан зохион байгуулалтын нэгжүүд хийж гүйцэтгэдэг боловч эцсийн үүрэг хариуцлагыг Захирлуудын зөвлөл хүлээдэг.

Захирлуудын зөвлөл. Эрсдэлийн удирдлагын ерөнхий шийдвэрийг гаргаж, эрсдэлтэй холбоотой асуудлаар Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчтэй зөвлөлддөг.

Хяналтын Зөвлөл. Банкны дотоод бүтэц, зохион байгуулалтад харьяалагддаггүй, хараат бус хөндлөнгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг бөгөөд Банкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, Банкны бусад үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй ажилладаг.

Хөрөнгө оруулалтын хороо. Монголбанкны гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах үйл ажиллагаанд үүсч болох санхүүгийн эрсдлээс сэргийлэх, удирдах, зах зээлийн өөрчлөлттэй уялдуулан шаардлагатай арга хэмжээг авах талаар шийдвэр гаргахад Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөх чиг үүрэгтэй ажилладаг. Хөрөнгө оруулалтын хороо нь 5 гишүүнтэй бөгөөд үүнд Тэргүүн дэд Ерөнхийлөгч, Эрсдэлийн удирдлагын албаны дарга, Санхүү бүртгэлийн газрын захирал, Судалгаа, статистикийн газрын захирал, Санхүүгийн зах зээлийн газрын Нөөцийн удирдлагын хэлтсийн захирал багтдаг.

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хөрөнгө оруулалтын хороо нь нөөцийн удирдлагын хүрээнд хөрөнгө оруулалтын бүтэц, бенчмарк, харилцагч байгууллагын жагсаалт, тэдгээрт олгох лимит тогтоож, идэвхитэйгээр удирдах хөрөнгө оруулалтын багцын хэмжээ, гарч болох аливаа эрсдэлийг тодорхойлж, хөрөнгө оруулалтын бүтцийн гүйцэтгэл, лимитийн хэрэгжилтэд хяналт тавьж, цаашид авах арга хэмжээний саналыг хэлэлцэж Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулдаг. Нөөцийн бүтэц нь хөрөнгө оруулалтын гадаад валютаарх бүтэц, хөрөнгө оруулалтын хуваарилалтын харьцаа, бүтээгдэхүүний төрөл, эдгээрийн өөрчлөлт хөдөлгөөний боломжит хязгаар, хөрөнгө оруулалтын хугацаа, тухайн нэг харилцагч байгууллагад байршуулах хөрөнгийн лимит зэргийг тусгасан байдаг.

Гадаад валютын нөөцийг байршуулахад баримтлах лимитийг Ерөнхийлөгчийн тушаалаар улирал тутам шинэчлэн батлуулдаг ба зээлийн, хөрвөх чадварын, хүүгийн эрсдэлийг харгалзан үздэг.

Банкны нийт хөрөнгийн дийлэнх хувийг гадаад валютаарх хөрөнгө эзэлдэг тул гадаад валютын нөөцтэй холбоотой эрсдэл хамгийн гол анхаарах асуудал байдаг. Гиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон Эрсдэлийн удирдлагын чиг үүрэг хариуцсан нэгжийн үйл ажиллагаа нь гадаад валютаарх хөрөнгө оруулалтын эрсдэлийг удирдахад төвлөрдөг. Хөрөнгө оруулалтын хороо нь Банкны санхүүгийн актив, пассивтай холбоотой санхүүгийн эрсдэлийг улирдаж буй Эрсдэлийн удирдлагын алба болон холбогдох бусад газар нэгж нь үйл ажиллагаандаа банкны хөрөнгө оруулалтын бодлогыг бүхэлд нь мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй. Санхүүгийн эрсдэлийг удирдах аргачлалыг доор дэлгэрэнгүй тайлбарлав.

Эрсдэлийн удирдлагын алба. Эрсдэлийн удирдлагын алба (ЭУА) нь гадаад валютын нөөцийн удирдлага батлагдсан бенчмарк, бүтэц, лимиттэй нийцтэй байгаа, эрсдэлийн удирдлагын бодлого, зарчмын дагуу хэрэгжиж байгаа эсэхэд өдөр тутам хяналт тавьж, гадаад валютын улсын нөөцийн эрсдэлийн удирдлагын тайлагналыг хариуцдаг.

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журамд зааснаар нөөцийн удирдлагын үндсэн зорилго нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж буй зорилго нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих;
- Валютын зах зээлийн ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах;
- Засгийн газрын гадаад өр төлбөрийг барагдуулах;
- Төлбөрийн тэнцлийн алдагдлыг хямралын үед санхүүжүүлэхэд оршино.

Гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлага нь санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлд өртөх байдлыг стратегийн түвшинд удирдан хянах замаар эдгээр зорилтуудыг хангахад хувь нэмэр оруулдаг. Банк гадаад эрсдэлд өртөх байдлыг удирдах зорилгоор хөрөнгийн сонголт болон хөрөнгийн хуваарилалтын стратегийг тодорхойлдог. Үүнд хөрвөх чадвартай валютын бэлэн байдлыг хангах зорилгоор валютын эзэмшил, бүтэцтэй холбоотой шалгуурыг тогтоох, хөрвөх чадвар болон аюулгүй байдлын шаардлагыг хангасан хөрөнгө оруулалтын хэрэгслийн зөвшөөрөгдөх хүрээг тодорхойлох, мөн хүүгийн эрсдэлд өртөх байдлыг хязгаарлах зорилгоор хугацааны хязгаарыг тогтоох зэрэг орно.

Санхүүгийн зах зээлийн газар. Санхүүгийн зах зээлийн газар нь хөрөнгө оруулалтын бодлого, стратегийг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд тус газрын захирал нь хөрөнгө оруулалтын багцын бүтэц буюу хөрөнгө оруулалтын бүрдэл, хэрэгслүүд, харилцагч талууд, дуусгавар болох хугацаа, гадаад валютын нөөцөд тавигдах лимит зэргийг удирдах, хянах үүрэгтэй ажилладаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоод аудитын газар. Банк бодлогоо хэрэгжүүлэхэд дотоод хяналтын тогтолцоо зохистой, үр ашигтай байгаа эсэхийг шалгаж, үнэлэх нь дотоод аудитын зорилго юм. Дотоод аудитын газар (ДАГ) нь Банкны бүх шатны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байгаа, Банкны үйл ажиллагаа холбогдох хууль, журам зааврын дагуу явагдаж байгаа эсэхийг үнэлж, дүгнэх үүрэгтэй. ДАГ нь эрсдэлийн ерөнхий болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Эрсдэлийн ерөнхий үнэлгээг аудитын урт хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулах явцад хийж байгаа нь аудитын нөөц бололцоог эрсдэлийн зэрэглэлд нийцүүлэн зөв хуваарилах ач холбогдолтой. Харин тодорхой салбар, асуудалд нарийвчилсан хяналт тавих зорилгоор тусгайлсан үнэлгээ хийдэг. Банкны Дотоод аудитын газар нь 2025 болон 2024 оны санхүүгийн жилүүдэд батлагдсан аудитын хөтөлбөр болон жилийн аудитын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн.

ДАГ-ын үйл ажиллагааны зорилго нь газар, нэгжүүдэд гарч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлох юм. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, ач холбогдлоос нь шалтгаалан тухайн шалгуур үзүүлэлтүүдийг жинлэж оноо өгдөг. Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн жинлэсэн дундаж онооноос шалтгаалан эрсдэлийн зэргийг тодорхойлдог бөгөөд эрсдэлийн зэргээр нь өндөр, дунд, бага гэж ангилна.

Дотоод хяналтын тогтолцоог үнэлэх ажил нь дотоод аудитын ажлын чухал хэсэг юм. Энэхүү үнэлгээний зорилго нь үйл ажиллагааны зохистой горим байгаа эсэх, ажилчдын чадвар, газар нэгжүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль журамд нийцтэй байгаа эсэх, санхүүгийн тайлагналын системийн найдвартай байдал зэргийг үнэлж дүгнэхэд оршино. ДАГ нь аудитын үр дүн, зөвлөмжийг Ерөнхийлөгч, Хяналтын зөвлөлд тайлагнадаг. Үнэлгээ бүрийн эцэст ДАГ удирдлагуудтай аудитын үр дүнг хэлэлцэж, хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтэд эргэн хяналт тавьдаг.

Зээлийн эрсдэл. Зээлийн эрсдэл нь гэрээний нөгөө тал үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс шалтгаалж Банк алдагдал хүлээх эрсдэл юм. Банк харилцагч талуудад зээл олгох болон бусад гүйлгээ хийх, санхүүгийн хөрөнгө, тэнцлийн гадуурх зээлийн шинжтэй үүрэг амлалтаас шалтгаалж зээлийн эрсдэл бий болдог.

Хөрөнгийн зээлийн эрсдэлийн дээд лимит нь тухайн хөрөнгийн дансны үнээр хязгаарлагдана. Харин банкны бусдын өмнө гаргасан санхүүгийн баталгаа, ашиглаагүй зээлийн шугам, импортын аккредитивын хувьд зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээ нь тухайн баталгаа, үүрэг хариуцлагын дүнгээр хязгаарлагдана.

Зээлийн эрсдэлийн удирдлага. Зээлийн эрсдэлийг тухайн хөрөнгө оруулж буй санхүүгийн хэрэгслийн төрөл, хөрөнгийн хэмжээг зөв сонгож тодорхойлох, хөрөнгө оруулалтын зээлийн чанарыг хянах замаар удирддаг. Хөрөнгө оруулалтын төрөл, оролцогч талуудын зээлийн эрсдэлд лимит тогтоохдоо удирдлагаас зөвшөөрөл авдаг. Эдгээр лимитийг байнгын хяналтад байлгаж, жилд нэг удаа эсвэл шаардлагатай тохиолдолд илүү давтамжтайгаар үнэлдэг.

Гадаад валютын нөөцийн зээлийн эрсдэлийг бууруулахын тулд нөөцийг олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагаас “Ааа”-аас “Аа3” үнэлгээ авсан гадаад улсын Засгийн газар, Төв банкууд, “Ааа” үнэлгээтэй олон улсын санхүүгийн байгууллагын үнэт цаасанд, “А3” үнэлгээ бүхий олон улсын санхүүгийн байгууллагын мөнгөний захын хэрэгсэлд хөрөнгө оруулдаг. Хамтран оролцогч тал нь нэгээс олон байгууллагаар зэрэглэл тогтоолгосон тохиолдолд хамгийн бага үнэлгээг ашигладаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх явцад үүсч болох зээлийн эрсдэлийг бууруулахын тулд барьцаа хөрөнгийн бодлогыг тодорхойлдог. Монголбанкны дахин санхүүжилтийн журмын дагуу дотоодын банкинд зээл, санхүүжилт олгохдоо дараах санхүүгийн хөрөнгийг барьцаалдаг. Үүнд:

1. Төв банкны үнэт цаас (ТБҮЦ);
2. Хэвийн зээлээр баталгаажсан давуу эрхтэй үнэт цаас;
3. Орон сууцны зээлээр баталгаажсан давуу эрхтэй бонд;

Зээлдэгдэгч нь Банкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах үүрэгтэй.

Зээлийн лимит. Гадаад валютын нөөцийн зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Банк нь гадаад улсын харилцагч банк, санхүүгийн байгууллагад зээлийн лимит тогтоодог бөгөөд лимитийн хэмжээ нь харилцагчийн зээлжих зэрэглэл, хөрөнгийн хэмжээ, бусад хүчин зүйлсээс хамаардаг. Лимитийг улирал бүр Ерөнхийлөгчийн тушаалаар батлах бөгөөд тухайн банк, санхүүгийн байгууллагад байршуулах гадаад валютын нөөцийн хэмжээ баталсан лимитийн хүрээнд байгаа эсэхэд ЭУА өдөр бүр хяналт тавьдаг.

Тодруулга 32-г толилуулснаар Банк нь Монгол Улсын хувьд чухал ач холбогдол бүхий арга хэмжээнд зориулан (бараа бүтээгдэхүүн экспортлох эсвэл үйлчилгээ авах), эсвэл Монгол Улсын засгийн газар, эсвэл түүний харьяа байгууллагуудын хүсэлтээр холбогдох талуудад төлбөрийн баталгаа гаргадаг ба энэ нь төлбөр хүлээн авагч талд төлбөр найдвартай төлөгдөх баталгаа болж өгдөг. Төлбөрийн баталгааны гол зорилго нь шаардлагатай бол эдгээр зохицуулалтын хүрээнд Засгийн газар болон бусад холбогдох талуудад санхүүжилт бэлэн байгаа гэдгийг батлахад оршино. Гаргасан аккредитивууд нь энэхүү зохицуулалтыг хүссэн тал нь гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй, мөн ижил хяналтын явц, бодлогоор бууруулж байгаа зээлийн ижил төстэй эрсдэлд Банк учирч болзошгүй тохиолдолд Банк төлбөр хийнэ гэсэн эргэлт буцалтгүй баталгааг илэрхийлдэг.

Банкны зээлийн шугамын үүрэг амлалт нь ХАБ-тай байгуулсан своп хэлцлийн хүрээнд (Тодруулга 32-оос харна уу) ХАБ-ны ашиглаагүй зээлийн үлдэгдлээс бүрдэж буй ба удирдлагын зүгээс харилцагч талын эрсдэл бага гэж үзсэн.

Банкны зээлийн эрсдэлд өртөх боломжит позицын дээд хэмжээ нь санхүүгийн байдлын тайланд туссан мөнгөн хөрөнгийн дансны дүнгээр хязгаарлагддаг. Урвуу буцаан худалдан авах хэлцлийн хувьд зээлийн эрсдэл нь Тодруулга 12-д заасан барьцаа хөрөнгөөр буурч тооцогддог. Аккредитив болон зээлийн шугамын үүрэг амлалтын хувьд зээлийн эрсдэл нь нийт хүлээгдэж буй үүргийн нийт дүнгээр хязгаарлагддаг (Тодруулга 32-оос харна уу).

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын хэмжилт. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь ирээдүйд учирч болзошгүй алдагдал (өгөгдсөн хугацаанд дефолт болох магадлалаар жинлэгдсэн алдагдлын дундаж)-ын магадлалаар жинлэсэн ирээдүйн мөнгөн урсгалын тасалдлын өнөөгийн үнэ цэнийн тооцоолол юм. Олон хувилбар бүхий нөхцөл байдлыг таамаглаж, үнэлсний үр дүнд ХБЭА-ын хэмжээг дөрвөн төрлийн хувьсагчийг ашиглан тооцдог. Үүнд дефолт болох магадлал (“ДМ”), дефолт болох үеийн дүн (“ДҮД”), дефолтын алдагдлын хэмжээ (“ДАХ”), хямдруулалтын хувь хамаарна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

ДҮД гэдэг нь тухайн тайлант хугацаанаас хойш эрсдэлд өртөх боломжтой санхүүгийн хөрөнгийн дансны үлдэгдэл, түүнд хуримтлуулсан хүүгийн нийлбэр дүн юм. Төлбөрийн үүргийн хувьд зээлийн үүргийн биелэлт бодитой болох магадлалыг харуулсан коэффициент болох “зээлийн хувиргалтын фактор” (“ЗХФ”)-ыг ашиглан ДҮД-г тооцдог. ДМ нь зээлдэгч өгөгдсөн хугацаанд дефолт болох магадлалыг харуулсан коэффициентийг, ДАХ нь дефолт болох үед хүлээх алдагдлыг хэлнэ. ДАХ нь зээлдэгчийн төлөх боломжтой дүн болон барьцаа хөрөнгийн үүргийг хэрэгжүүлэх замаар орж ирэх мөнгөн дүнгийн нийлбэрийг гэрээний нийт мөнгөн урсгалын дүнгээс хасч, ДҮД-д эзлэх хувиар тодорхойлогдоно. Хүлээгдэж буй алдагдлыг тухайн санхүүгийн хэрэгслийн бодит хүүгийн хувь эсвэл түүнтэй ойролцоо хувиар хямдруулж, өнөөгийн үнэ цэнэд шилжүүлэн тооцдог. Энэ үед ашиглагдах хямдруулалтын хувь нь тухайн санхүүгийн хэрэгслийн бодит хүүгийн хувь эсвэл түүнтэй ойролцоо хувь байна.

Банкны удирдлага тухайн санхүүгийн хөрөнгийн нийт хугацааны ХБЭА-ыг загварчлан ашигладаг ба тухайн санхүүгийн хэрэгслийн үлдэгдэл ашиглалтын хугацааны туршид үүсэх боломжтой бүх дефолтын үйл явдлаас шалтгаалан бий болох алдагдал гэж тооцоолдог. 12 сарын ХБЭА нь тайлагналын өдрөөс хойших 12 сарын хугацаанд, эсвэл хэрэв санхүүгийн хэрэгслийн үлдэгдэл ашиглалтын хугацаа 12 сараас богино бол тухайн үлдэгдэл хугацаанд үүсэх боломжтой дефолтын үйл явдлаас шалтгаалан бий болох хугацааны туршид дахь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тодорхой хэсгийг илэрхийлнэ.

Эдгээр санхүүгийн тайлангийн зорилгоор удирдлагын тооцоолсон хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь тухайн хугацааны үнэлгээ бөгөөд зохицуулалтын зорилгоор түгээмэл ашиглагддаг мөчлөгийн туршид суурилсан үнэлгээ биш юм. ХБЭА-ыг тооцохдоо ирээдүйд суурилсан өгөгдлийг ашигладаг. Эдгээр өгөгдөл нь магадлалаар жинлэсэн, зээлийн эрсдэлд нөлөөлөх боломжтой макро эдийн засгийн гол хувьсах хүчин зүйлс байдаг. Худалдан авах эсвэл шинээр гаргах үед үнэ цэнийн бууралт (“ХАШГҮЦБ”)-тай байсан санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА-ын тооцоолол нь дээрхтэй ижил зарчмаар хийгдэх боловч: (а) нийт дансны үнэ болон хямдруулалтын хувь нь хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед нөхөгдөх боломжтой байсан мөнгөн урсгалд суурилдаг, (б) ХБЭА нь үргэлж хөрөнгийн нийт хугацааны ХБЭА байна. ХАШГҮЦБ-тай санхүүгийн хөрөнгө нь өнгөрсөн бизнесийн нэгдэлд худалдан авсан үнэ цэнийн бууралттай зээл зэрэг анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгө юм.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем. Банк зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд санхүүгийн хэрэгслийг зээлийн эрсдэлийн дүнгээр үнэлэх зорилгоор олон улсын зээлжих зэрэглэл тооцох байгууллага (Мүүдис, Стандарт энд Пүүрс, Фитч)-аас тооцоолон гаргасан үнэлгээг ашигладаг бөгөөд доорх хүснэгтэд тухайн байгууллагаас гаргадаг зээлжих зэрэглэлийн үнэлгээг харууллаа:

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр	Хөндлөнгийн үнэлгээний агентлагийн өгсөн тохирох үнэлгээ	
	C&P	Мүүдис
Онц сайн	AAA -аас A-	AAA -аас A3
Сайн	BBB+ -аас B-	Baa1 -аас B3
Хангалттай	CCC+ -аас CCC-	Saa1 -аас Saa3
Тусгайлан хянах	CC -аас C	Ca -аас C
Дефолт	Дефолт	Дефолт

Эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг тодорхойлох:

- *Онц сайн* – зээлийн чанар маш сайн, хүлээгдэж буй эрсдэлийн эрсдэл бага;
- *Сайн* – зээлийн чанар сайн, зээлийн эрсдэл дунд зэрэг;
- *Хангалттай* – зээлийн чанар дунд зэрэг, зээлийн эрсдэл хангалттай;
- *Тусгайлан хянах* – удирдлагын менежментийг сайжруулж, нарийн хянах шаардлагатай;
- *Дефолт* – дефолт болсон хэрэгсэл.

Монгол Улсын томоохон арилжааны банкууд олон улсын үнэлгээний байгууллагаар зээлжих зэрэглэл тогтоолгодог учир дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээнд тулгуурлан үнэлдэг. Үнэлгээ хийлгээгүй арилжааны банкуудын хувьд тэдгээртэй ижил хэмжээтэй, үнэлгээ хийлгэдэг банкуудтай харьцуулах замаар эрсдэлийн үнэлгээг хийдэг. Ингэхдээ тэдгээрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, сүүлийн үеийн санхүүгийн мэдээллийг Хяналт шалгалтын газар болон бусад газар нэгжээс авч харьцуулалт хийдэг.

Санхүүгийн хөрөнгийн дефолтын тодорхойлолт, санхүүгийн хөрөнгийг хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын шатлалаар ангилах зарчим. Банк нь дараах шалгуур үзүүлэлтийн аль нэг нь биелэгдсэн тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгө дефолт болсон гэж тодорхойлдог:

- Зээлдэгч тал гэрээгээр хүлээсэн санхүүгийн үүргээ хугацаанд нь биелүүлэлгүй 90-с дээш хоног хэтэрсэн.
- Арилжааны банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг зээлдэгч банк нь хангах боломжгүй болсон.
- Зээлдэгч тал дампуурсан, эсвэл бүрэн эрхт төлөөлөгч томилогдож гэрээгээр хүлээсэн төлбөр төлөх магадлал маш бага эсвэл төлж чадахгүй болсон нь тогтоогдсон.

Банк нь санхүүгийн хөрөнгийг хүлээгдэж буй эрсдэлийн зэрэглэлээр доорх 3 шатлалд холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу ангилдаг:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

№	Шалгуур үзүүлэлт	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3
1	Гэрээгээр хүлээсэн төлбөрийн хоцролтын хоног	30 хоногоос доош	30-90 хоног	90 хоногоос дээш
2	Гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлт хийгдэж буй байдал	Эргэн төлөлт нь хуваарийн дагуу хийгдэж байгаа	Эргэн төлөлт нь хуваарийн дагуу хийгдээгүй саадсан боловч талууд эргэн төлөлт хийх дээр тохиролцсон	Эргэн төлөлт нь хуваарийн дагуу хийгдээгүй бөгөөд хэзээ хийгдэх нь тодорхой бус
3	Арилжааны банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж буй байдал	Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа	Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй болсон	Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй болсоноос гадна дампуурах нь тодорхой болсон

Дээрх шалгуур үзүүлэлтээс гадна Банк нь харилцагч талын төлбөрийн чадваргүй болох магадлал, харилцагчийн зээлжих зэрэглэл, эргэн төлөлтийн хуваарь, барьцаа хөрөнгийн үнэлгээ, харилцагчийн гаргасан бусад өрийн болон өмчийн хэрэгслийн зах зээлийн үнэ цэнийн өөрчлөлт, зээл-үнэлгээний харьцаа, зээлийн спрэйд, зээлдэгчийн гаргасан CDS (Credit default swap)-ийн үнийн өөрчлөлт, үйл ажиллагаа явуулж буй салбарын нөхцөл байдал, дотоод үнэлгээний аргачлалаар тооцсон үнэлгээ, эдийн засаг, санхүү, бизнесийн орчинд гарч буй өөрчлөлт, хууль эрх зүй, технологийн өөрчлөлтийг хянаж, шаардлагатай тохиолдолд эрсдэлийн алдагдлын тооцоололд тусгадаг.

ХБЭА-ын тооцоолол нь зээлдэгчийн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхэд суурилсан бөгөөд санхүүгийн хөрөнгийг дээрх 3 шатлалаар ангилсан. Тухайн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнийн бууралтгүй, зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ) байхгүй бол ойрын 12 сард харгалзах ХБЭА-ыг (шатлал 1) тооцож эрсдэлийн алдагдлын санг байгуулна. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ЗЭМӨ мэдэгдсэн бол санхүүгийн хөрөнгийг шатлал 2-т дахин ангилдаг бөгөөд хараахан үнэ цэнэ буурсан хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөггүй боловч хөрөнгийн нийт хугацаанд харгалзах ХБЭА-ыг тооцдог. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзсэн үед Шатлал 3-т ангилах бөгөөд хөрөнгийн нийт хугацаанд ХБЭА-ыг тооцдог. Үнэ цэнэ буурч шатлал 3-т ангилсан хөрөнгөд хүүгийн орлого тооцохдоо ХБЭА-ын дүнг хассан дүнгээс тооцдог.

Банк нь улс орнуудын засгийн газар, төв банкуудын зээлийн эрсдэлд өөрчлөлт гарсан эсэхийг тооцохдоо эдийн засгийн өсөлтийн таамаг, инфляц, гадаад цэвэр нөөцийн хэмжээ, улс төрийн эрсдэл, гадаад өр төлбөр зэргийг нэмэлтээр харгалзан үздэг бол банкуудын эрсдэлийн өөрчлөлтийг тооцохдоо эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааны үзүүлэлт, хөрвөх чадвар, найдваргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ зэргийг үндэслэдэг. Банкнаас бусад компаниудын зээлийн эрсдэлийг үнэлэх үед төлбөрийн чадварын харьцаа, хөрвөх чадвар, ашигт ажиллагааны харьцааны үзүүлэлт, үйл ажиллагааны харьцааны үзүүлэлт, ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөлөл, компанийн засаглалын индекс зэргийг харгалзан үздэг.

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хөрөнгөд ЗЭМӨ гарахаа больсон гэх баримт, мэдээлэл байгаа үед хөрөнгийг буцаан Шатлал 1-д ангилна. Хөрөнгийг чанарын үзүүлэлт ашиглан үнэлж, шатлал 2-т ангилсан бол Банк тухайн чанарын үзүүлэлт хангагдаж байгаа эсэхийг дахин хянана.

Худалдан авах эсвэл шинээр гаргах үед үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд нийт хугацаанд харгалзах ХБЭА-ыг тооцох тул банк нийт хугацаанд харгалзах ХБЭА-д орсон хуримтлагдсан өөрчлөлтийг хүлээн зөвшөөрдөг.

ХБЭА нь дээр дурдсан ДҮД, ДАХ, ДМ зэрэг эрсдэлийн параметруудийн үржвэрийг хөрөнгийн үр ашигт хүүгийн аргаар хямдруулж өнөөгийн үнэ цэнээр үнэлсэн дүн юм. Эдгээр гурван үзүүлэлтийн үржвэрт эргэн төлөгдөх магадлалын тохируулга хийдэг (жишээ нь, өмнөх сард эргэн төлөгдсөн, эсвэл дефолт болсон). Энэхүү аргаар ирээдүйн тайлант үед ХБЭА-ыг тооцон гаргадаг бөгөөд дараа нь тайлагналын өдөр хүртэл хямдруулалтыг тооцож, нэгтгэдэг. ХБЭА-ын тооцоололд ашиглаж байгаа хямдруулалтын хувь нь анхны үр ашигт хүү, эсвэл түүнтэй ойролцоо утга авах тооцоолсон хүү байна.

Дефолт болох үеийн дүн. Дефолт болох үеийн дүнг ирээдүйд орж ирэх төлөлт болон бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцдог. ДҮД нь зээлдэгчийн 12 сарын хугацаанд эргэн төлөх дүн, эсвэл санхүүгийн хөрөнгийн гэрээнд заасан хугацаа дуусах хүртэлх эргэн төлөлтийн дүнгээр тодорхойлогддог ба зээлдэгч хугацаанаасаа өмнө төлөлт хийвэл дахин тооцоолол хийгдэнэ. Тооцоололд эргэн төлөлт болон дахин санхүүжилтийн таамаглалыг ДҮД-ийн тооцоонд оруулдаг.

Шатлал 1-д буй зээлийн ДҮД-г тооцоолохын тулд тухайн зээлийг ойрын 12 сарын хугацаанд чанаргүй болоход хүргэх хүчин зүйлсийг үнэлж 12 сарын ХБЭА тооцдог. Бусад шатлал буюу 2 болон 3-р шатлалуудад буй хөрөнгийн ДҮД-г тодорхойлохдоо нийт хугацааны туршид тухайн зээлийг чанаргүй болоход хүргэх хүчин зүйлсийг авч үзнэ.

Дефолтын магадлал. ХБЭА-ыг тооцоход хоёр төрлийн ДМ-ыг ашигладаг. Үүнд 12 сарын болон нийт хугацааны ДМ орно. 12 сарын ДМ-ыг хамгийн сүүлийн байдлаар мэдэгдэж байгаа түүхэн өгөгдөл ашиглан гаргадаг бол нийт хугацааны ДМ-ын тооцоолол нь санхүүгийн хөрөнгийн үлдэх хугацаанд дефолт болох магадлалыг илэрхийлэх бөгөөд энэ нь санхүүгийн хэрэгслийн нийт хугацаанд гарч болох 12 сарын ДМ-ын нийлбэр юм.

Дефолтын алдагдлын хэмжээ. ЭУА нь дефолтын алдагдлын хэмжээ (ДАХ)-г санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд улирал бүр үнэлдэг. ДАХ нь санхүүгийн хөрөнгө чанаргүй болох үеийн алдагдлын түвшинг илтгэдэг. ДАХ нь харилцагч буюу зээлдэгч тал, нэхэмжлэлийн төрөл болон зэрэглэл, барьцаа хөрөнгө зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. ДАХ нь чанаргүй болох үеийн өртгийн нэгж тутамд гарах алдагдлын хувиар илэрхийлэгддэг. ДАХ-г 12 сар, эсвэл нийт хугацааны туршид тооцдог бөгөөд 12 сарын ДАХ-г дараагийн 12 сард чанаргүй болох тохиолдолд гарах алдагдлын хувиар тооцдог. Нийт хугацааны турш дахь ДАХ-г үлдэж буй нийт хугацаанд гарах алдагдлын хувиар тооцдог.

Санхүүгийн хэрэгсэлд барьцаа хөрөнгө байхгүй, чанаргүйдлийн түүхэн өгөгдөл хангалтгүй байгаа тохиолдолд шинжээчдийн дүгнэлтийг ашигладаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

ДАХ-г тоон мэдээллийн хүрэлцээтэй байдлаас хамаарч дараах байдлаар тооцдог. Үүнд:

- Төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгөөс ДАХ-г тооцох урт хугацааны түүхэн тоон мэдээлэл байгаа тохиолдолд эконометрик, машин сургалт, бусад санхүүгийн болон статистик загвар ашиглаж ДАХ-г тооцно.
- ДАХ-ний урт хугацааны түүхэн тоон мэдээлэл байхгүй тохиолдолд зээлжих зэрэглэлтэй харилцагч байгууллагын барьцаагүй санхүүгийн хөрөнгийн хувьд Moody's, Standard & Poor's болон Fitch зэрэг байгууллагаас тогтоосон зээлжих зэрэглэлд харгалзах Thomson Reuters-ийн хамгийн сүүлийн боломжит ДАХ-гээр төлөөлүүлэн тооцно.
- Зээлжих зэрэглэлгүй харилцагч байгууллагад байршуулсан барьцаагүй санхүүгийн хөрөнгийн ДАХ-г тооцохдоо ижил төстэй байгууллагын зээлжих зэрэглэлээр төлөөлүүлэн тооцно. Хэрэв ижил төстэй байгууллагын мэдээлэл байхгүй тохиолдолд улсын зэрэглэлийг 1-2 шатлалаар бууруулж зээлжих зэрэглэлийг тодорхойлно.

Түүхэн мэдээллийн хязгаарлагдмал байдлаас Банк нь ДАХ-г тооцоолохдоо Thomson Reuters мэдээллийн сангаас гаргасан, байгууллага болон компанийн зээлийн зэрэглэл болон үлдэгдэл хугацаанд тохирох эргэн төлөлтийн хувь хэмжээг ашигладаг.

Доорх хүснэгтэд санхүүгийн хөрөнгийн ангилал бүрээрх ДАХ-ний хувийг харууллаа.

	Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө Тодруулга (8)	Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт Тодруулга (10)	Урвуу буцаан худалдан авах хэлцэл Тодруулга (12)	Засгийн газрын үнэт цаас Тодруулга (16)	Дотоодын банкуудад олгосон зээл Тодруулга (9)	Бусад санхүүгийн хөрөнгө Тодруулга (18)
2025	60.0%-60.4%	60%-60.8%	0%-60.4%	64.1%	64.1%	0%-100%
2024	59.9%-60.0%	59.9%-60.0%	0%-60.0%	65.0%	0%-65.0%	65.0%-100%

Зээлжих зэрэглэл тогтоолгоогүй харилцагч байгууллагад байршуулсан барьцаагүй санхүүгийн хөрөнгийн хувьд ДАХ-г тооцохдоо дараах аргачлалаас эрэмбийн дагуу сонгож ашиглана. Үүнд:

- Ижил төстэй буюу тухайн байгууллагыг төлөөлж чадахуйц байгууллагын зээлжих зэрэглэлээр төлөөлүүлэн тооцох.
- Ижил төстэй байгууллагын мэдээлэл байхгүй тохиолдолд тухайн улсын зэрэглэлийг 1-2 шатлалаар бууруулж зээлжих зэрэглэлийг тодорхойлох.

ДАХ-г 10%-аар өсгөж 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт ХБЭА-ыг тооцоход 23,061 сая төгрөгөөр өсөхөөр байна (2024: 14,857 сая төгрөгөөр өсөх).

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ). Банк нь шаардлагатай бүх санхүүгийн хөрөнгөд ХБЭА үүссэн эсэхийг тасралтгүй хянадаг бөгөөд тухайн хөрөнгөд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт үүссэн эсэхэд үндэслэн тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг 12 сарын ХБЭА эсвэл нийт хугацааны ХБЭА-аар тодорхойлдог.

Банк хөрөнгийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохдоо чанарын шинжилгээ хийдэг ба зарим тохиолдолд “дефолтын тодорхойлолт” хэсэгт дурдагдсан хүчин зүйлсийг ЗЭМӨ-ийг бий болох үндэслэл гэж үздэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХБЭА-ын загварын ирээдүйн мэдээллийн тохируулга. Банк макро эдийн засгийн хувьсагчуудын ирээдүйн өөрчлөлтийн нөлөөллийг ДМ-д тохируулга хийх замаар ХБЭА-ын тооцоололд оруулдаг. Ингэснээр ХБЭА-ын загварт ирээдүйн макро эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн нөлөөлж болохыг тусгадаг. Банк нь ДМ-ыг санхүүгийн хөрөнгийн шинж чанар, онцлогоос хамаарч хөрөнгө тус бүрийн хувьд тооцоолж, үүнд ашиглагдах макро эдийн засгийн хувьсагчуудыг урьдчилж сонгохдоо хамаарлын шинжилгээ буюу корреляцийн шинжилгээг хийсэн. Улмаар энгийн регрессийн шинжилгээний аргаар коэффициентуудын утгыг тодорхойлсон. Тодорхойлогдсон коэффициентуудын утгад үндэслэн ДМ-ын төсөөлсөн дүнг тооцдог ба үүнийг дефолтын дундаж түүхэн дүнтэй хувьчлах замаар макро эдийн засгийн хүчин зүйлсийн ДМ-д нөлөөлөх нөлөөллийн тохируулгыг тооцсон. ДМ тооцоход Банкны ашигласан өгөгдөл, мэдээллийг доор харуулав.

- Дотоодын банкуудад олгосон зээл

Банк нь олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллага (Стандарт энд Пүүрс)-ын нийтлэн гаргадаг хөрөнгө оруулалтын бус зэрэглэлтэй хөрөнгийн ДМ-ын түүхэн мэдээлэл болон доорх макро эдийн засгийн үзүүлэлтэд үндэслэн банкинд олгосон зээлийн ДМ-ыг тооцсон.

- Жилийн ДНБ
- Зээлийн хүүгийн түвшин (1 улирлын хоцрогдолтой)
- Ажилгүйдлийн түвшин (1 улирлын хоцрогдолтой)

Банк сүүлийн 24 жилийн хугацаан дах макро эдийн засгийн хувьсагчдын тоон өгөгдөл болон ДМ-ын түүхэн өгөгдөлд шугаман регрессийн шинжилгээ хийсэн бөгөөд энэхүү шинжилгээгээр эдгээр хувьсагчид нь статистикийн хувьд чухал ач холбогдолтой болох нь нотлогдсон.

- Дотоодын банкуудад олгосон барьцаатай зээл

Банк олон улсын зээлийн зэрэглэл тогтоогч байгууллагаас (Стандарт энд Пүүрс) нийтэлсэн “хамгийн сул холбоос”-ын түүхэн дефолтын түвшинг ашиглаж, холбогдох макро эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан ирээдүйг тусгасан, магадлалаар жинлэсэн дефолтын магадлалыг тооцоолдог. Үүнд дараах гол макро эдийн засгийн үзүүлэлтийг авч үздэг:

- Жилийн ДНБ

Банк сүүлийн 26 жилийн хугацаан дах макро эдийн засгийн хувьсагчдын тоон өгөгдөл болон ДМ-ын түүхэн өгөгдөлд шугаман регрессийн шинжилгээ хийсэн бөгөөд энэхүү шинжилгээгээр эдгээр хувьсагчид нь статистикийн хувьд чухал ач холбогдолтой болох нь нотлогдсон.

- ИЗББ болон Түрээсийн Орлогоор Баталгаажсан бонд

Банк өөрийн сайтаар олон нийтэд нийтэлдэг нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь болон доорх макро эдийн засгийн үзүүлэлтэд үндэслэн ирээдүйд учирч болох ДМ-ыг тооцсон.

- Улирлын ДНБ (2 улирлын хоцрогдолтой)
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь (1 улирлын хоцрогдолтой)
- Ажилгүйдлийн түвшин (1 улирлын хоцрогдолтой)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк дээрх макро эдийн засгийн хувьсагчид болон нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн сүүлийн 15 жилийн хугацаан дах улирлын түүхэн тоон үзүүлэлтэд шугаман регрессийн шинжилгээ хийсэн бөгөөд энэхүү шинжилгээгээр эдгээр хувьсагчид нь статистикийн хувьд чухал ач холбогдолтой болох нь нотлогдсон.

- Эрдэнэс бонд

Эрдэнэс бондын хувьд 2024 оноос эхлэн шатлал 3-т ангилагдсан тул Банк дефолтын магадлалыг 100 хувь гэж тооцсон. ДАХ-ийг суурь хувилбар 60%, муу хувилбар 30%, өөдрөг хувилбар 10% гэсэн жинлэлтэй гурван өөр хувилбарын дагуу тооцоолсон бөгөөд эдгээр нь эрсдэлийн илүү өргөн тархалт, уул уурхайн салбарын тогтвортой байдал болон улсын төсвийн орлогын өсөлтийг харгалзан ирээдүйг тусгасан таамаглалд суурилсан болно. Эрдэнэс бондын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 4-өөс харна уу.

Эдгээр тохируулгын хүчин зүйлс болон тохируулагдсан ДМ-ын хувь нь ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаар сайн төсөөлөл өгч чадах тул түүнийг ХБЭА-ын загварын суурь төсөөлөл гэж үзсэн. Дефолтын түүхэн тоон үзүүлэлтийг макро эдийн засгийн түүхэн тоон үзүүлэлттэй харьцуулах замаар ДМ-ыг тохируулдаг ба эдийн засгийн нөхцөл байдал хамгийн сайн болон муу байх үеийн тохируулагдсан ДМ-ын түүхэн тоон үзүүлэлтийн өгөгдлөөс сонгож хамгийн сайн болон муу байх үеийн ДМ-ыг тодорхойлдог.

Банк нь хөрөнгөд ХБЭА-ыг тооцохдоо эдийн засгийн ирээдүйн нөхцөл байдлын хувилбар тус бүрийг авч үздэг бөгөөд эдгээр 3 хувилбарын жинлэсэн дунджаар ХБЭА-ыг тодорхойлдог. Энэхүү 3 хувилбарын жинг тооцохдоо ДНБ-ий өсөлтийн сүүлийн 15 жилийн бодит болон таамагласан утгын зөрүүг ашиглан тооцсон. Ингэснээр эдийн засагт эерэг болон сөрөг шок орж ирэх магадлалыг илэрхийлнэ гэсэн таамаглалыг дэвшүүлсэн. Түүхэн мэдээлэлд үндэслэн дараах магадлалыг оноосон. Үүнд: суурь хувилбар – 60%, муу хувилбар – 30%, өөдрөг хувилбар – 10%. Хувилбар тус бүрийн эрсдэлийн алдагдлыг тухайн хувилбарын дагуу тооцоолсон дефолтын магадлалд үндэслэн тодорхойлдог. Үүний үр дүнд 2024 оны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын бодит дүн нь гурван хувилбарын жинлэсэн дунджаар тооцогдож, суурь хувилбар – 55%, муу хувилбар – 36%, өөдрөг хувилбар – 9%-тай байна.

Доорх хүснэгтэд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцоололд ашигласан хувилбар тус бүрийн ирээдүйг тусгасан макро эдийн засгийн таамагалуудыг харуулсан. Бусад хувьсагч үзүүлэлтүүдийг хоцрогдолтой үзүүлэлт гэж үздэг тул тухайн тохиолдолд бодит түүхэн статистик мэдээллийг ашигласан:

Түлхүүр үзүүлэлтүүд	ХБЭА-ын хувилбар	2025 оны 12 сарын 31		2024 оны 12 сарын 31	
		Жин	2025 оны таамаглал	Жин	2024 оны таамаглал
ДНБ-ий өсөлтийн %	Өөдрөг	10%	7.0%	9%	7.5%
	Суурь	60%	6.5%	55%	7.3%
	Муу	30%	3.8%	36%	6.4%
Ажилгүйдлийн түвшин	Өөдрөг	10%	3.6%	9%	4.1%
	Суурь	60%	7.4%	55%	7.9%
	Муу	30%	11.0%	36%	11.3%
Орон сууцны зээлд эзлэх чанаргүй зээлийн %	Өөдрөг	10%	0.8%	9%	0.9%
	Суурь	60%	1.2%	55%	1.1%
	Муу	30%	1.8%	36%	1.3%

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дээрх макро эдийн засгийн суурь төсөөллийг 10%-аар бууруулж тооцоход ХБЭА-ын дүн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 7,125 сая төгрөг (2024: 10,499 сая төгрөгөөр нэмэгдэх байсан)-өөр нэмэгдэж тусгагдахаар байна.

Дараах хүснэгтэд зээлдэгчийн зээлжих зэрэглэлд суурилагүй санхүүгийн хөрөнгө тус бүрийн ДМ-ыг харууллаа:

Санхүүгийн хөрөнгө	ДМ-ын суурь
Засгийн газрын үнэт цаас	С&П өгөгдмөл суурь
Дотоодын банкуудад олгосон зээл	С&П өгөгдмөл суурь
Дотоодын банкуудтай хийсэн урвуу буцаан худалдан авах хэлцэл	С&П өгөгдмөл суурь
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	
Давуу эрхтэй ИЗББ	Ипотекийн зээлд эзлэх муу зээлийн %
Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд	Орон сууцны зээлд эзлэх муу зээлийн %

Хүснэгтэд харуулсан үржүүлэгч нь макро эдийн засгийн ирээдүйн нөхцөл байдлыг тухайн хөрөнгийн ДМ-ын хувь хэмжээнд өөрчлөлт оруулах замаар ХБЭА-ын дүнд шингээсэн тохируулгын дүн юм. Үржүүлэгчийг тооцохдоо жил бүрийн түүхэн ДМ-ын дүн болон дээр дурдсан макро эдийн засгийн хувьсагч хооронд регрессийн шинжилгээ хийсэн. Дараах хүснэгтэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ХБЭА-ын загварт ашигласан үржүүлэгч болон ДМ тус бүрийг тусган харуулав.

Хувилбар	Дотоодын банкуудад олгосон зээл		Давуу эрхтэй ИЗББ		ТХББ	
	Үржүүлэгч	ДМ	Үржүүлэгч	ДМ	Үржүүлэгч	ДМ
Өөдрөг	0.94	1.54%-4.85%	0.96	0.07%	0.96	0.78%
Суурь	1.02	1.67%-5.26%	1.33	0.09%	1.33	1.08%
Муу	1.36	2.23%-7.02%	1.87	0.13%	1.87	1.51%

Доорх хүснэгтэд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ХБЭА-ын загварт ашигласан үржүүлэгч болон ДМ тус бүрийг тусган харуулав.

Хувилбар	Дотоодын банкуудад олгосон зээл		Давуу эрхтэй ИЗББ		ТХББ	
	Үржүүлэгч	ДМ	Үржүүлэгч	ДМ	Үржүүлэгч	ДМ
Өөдрөг	0.75	2.05%-4.00%	0.78	0.08%	0.78	0.83%
Суурь	0.77	2.10%-4.10%	1.00	0.11%	1.00	1.07%
Муу	0.87	2.38%-4.64%	1.23	0.13%	1.23	1.31%

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан санхүүгийн хөрөнгө, өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт зэрэгт ХБЭА-ыг тооцохдоо Блуумберг терминалын Чанаргүйдэх Магадлалын Үнэлгээний Судалгааг ашигласан ба үүнд зээлдэгч талын зээлийн үнэлгээ нь ирээдүйн мэдээллээр тохируулагдсан гэж таамагласан. Тус хөрөнгүүдэд ойрын 12 сарын ХБЭА-ыг тооцсон бөгөөд дээрхтэй ижил зарчмаар буюу эдийн засгийн ирээдүйн нөхцөл байдлын хувилбар бүрийн хувьд чанаргүйдэх магадлалд тодорхой жин өгч тооцсон.

Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн ДМ-ыг 10%-аар өснө гэж үзвэл 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус хөрөнгөд нийт 566 сая төгрөг (2024: 2,400 сая төгрөг нэмэгдэх байсан)-ийн ХБЭА-ын сан нэмж байгуулахаар байна.

Зах зээлийн эрсдэл. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь хүүгийн түвшин, валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан хэлбэлзэх эрсдэлийг зах зээлийн эрсдэл гэнэ. Зах зээлийн болон төлбөрийн чадварын эрсдэлийг үнэлэхдээ гадаад валютын захад хийх интервенцийн хэмжээ, гадаадын байгууллагад төлөх богино хугацаат өр төлбөрийн эргэн төлөлтийг анхаарч үздэг. Банк нь гадаад өрийн эргэн төлөлтийг биелүүлэх хангалттай нөөц байгаа эсэхийг хянаж, мэдрэмтгий байдлын шинжилгээг хийдэг. Банк нь гадаад валютын төвлөрөл, алт болон ЗТЭ-ээс бусад зах зээлийн өндөр эрсдэл байхгүй гэж үзсэн. Удирдлага нь мөнгөжсөн алт болон мөнгөжсөн мөнгийг валют эсвэл санхүүгийн хөрөнгийн орлох шинж чанартай гэж үздэг. Иймд эдгээр хөрөнгийг энэхүү санхүүгийн тайланд валютын ханшийн эрсдэлийн удирдлагын тодруулгын хүрээнд тусган харуулсан. Банк бусад үнийн эрсдэлд мэдэгдэхүйц хэмжээнд өртөөгүй байна.

Ханшийн эрсдэл. Ханшийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалж өөрчлөгдөх эрсдэлийг хэлнэ. Ханшийн эрсдэлийг гадаад валютын багцыг төрөлжүүлэх замаар удирдаж болох ба дараах параметрээр тодорхойлно:

- Гадаад валютын нөөцийн удирдлага
- Гадаад валютын нөөц болон гадаад валютаар илэрхийлэгдэх урт ба богино хугацаат хөрөнгө оруулалтын багцад эзлэх тухайн гадаад валютын хамгийн их байх хэмжээ

Гадаад валютын нөөцийг бүрдүүлэх валютын бүтцийг Хөрөнгө оруулалтын хорооноос жил бүр баталдаг. Доорх хүснэгтэд тайлагналын өдрийн байдлаар Банкны бүртгэлийн валюттай харьцуулахад гадаад валют, алт болон ТЗЭ-ийн ханшид гарч болох боломжит өөрчлөлтийн нөлөөг, бусад бүх хувьсагч тогтмол байна гэж үзэн, ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөнд хэрхэн нөлөөлөхийг харуулсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хүснэгтэд үзүүлсэн сөрөг дүн нь ашиг, алдагдлын цэвэр бууралтыг, харин эерэг дүн нь цэвэр өсөлтийг илэрхийлнэ:

<i>Сая төгрөгөөр</i>	2025 оны 12 сарын 31-нээрх ашиг/(алдагдал) болон өрийн хөрөнгө дэх нөлөө	2024 оны 12 сарын 31-нээрх ашиг/(алдагдал) болон өөрийн хөрөнгө дэх нөлөө
Ам.доллар 10%-аар чангарахад (10%-аар чангарахад)	(684,291)	206,011
Ам.доллар 10%-аар сулрахад (10%-аар сулрахад)	684,291	(206,011)
Юань 10%-аар чангарахад (10%-аар чангарахад)	(164,301)	(171,433)
Юань 10%-аар сулрахад (10%-аар сулрахад)	164,301	171,433
Евро 10%-аар чангарахад (10%-аар чангарахад)	6,960	31,314
Евро 10%-аар сулрахад (10%-аар сулрахад)	(6,960)	(31,314)
ЗТЭ 10%-аар чангарахад (10%-аар чангарахад)	(54,784)	(59,786)
ЗТЭ 10%-аар сулрахад (10%-аар сулрахад)	54,784	59,786
Алт 10%-аар чангарахад (10%-аар чангарахад)	390,131	211,510
Алт 10%-аар сулрахад (10%-аар сулрахад)	(390,131)	(211,510)
Бусад валют 10%-аар чангарахад (10%-аар чангарахад)	11,218	10,237
Бусад валют 10%-аар сулрахад (10%-аар сулрахад)	(11,218)	(10,237)

Дээрх дүнг Банкны бүртгэлийн валютаас өөр валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс, түүнчлэн ТЗЭ болон алт хэлбэрээр илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд үндэслэн тооцоолсон.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк нь мөнгөөр илэрхийлэгдэх хөрөнгө (үүнд мөнгөжсөн алт болон үнэт металлыг багтаасан) болон мөнгөөр илэрхийлэгдсэн өр төлбөрийн хүрээнд валют, алт болон ЗТЭ-ийн мэдэгдэхүйц өртөлттэй байх дүнг харуулсан:

Сая төгрөгөөр	Монгол төгрөг	Ам.доллар	Юань	Евро	ЗТЭ	Алт	Бусад	Нийт дүн
Бэлэн мөнгө	-	310,841	60,799	8,818	-	-	15,048	395,506
Гадаадын санхүүгийн байгууллага дахь хөрөнгө	-	7,055,951	1,360,509	382,173	314,495	-	573,079	9,686,207
Дотоодын банкуудад олгосон зээл	178,820	503	-	-	-	-	-	179,323
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	4,514,906	4,438,128	457,855	-	-	-	-	9,410,889
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	-	-	6,533	-	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	3,983,879	6,086,748	-	-	-	-	-	10,070,627
Мөнгөжсөн алт ба үнэт металл	-	-	-	-	-	3,901,306	10,185	3,911,491
Засгийн газрын үнэт цаас	54,633	-	-	-	-	-	-	54,633
Бусад санхүүгийн хөрөнгө	16,879	4,095	-	-	-	-	-	20,974
Нийт санхүүгийн хөрөнгө	8,749,117	17,896,266	1,879,163	397,524	314,495	3,901,306	598,312	33,736,183
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(1,244,350)	-	-	-	-	-	-	(1,244,350)
Төв банкны үнэт цаас	(10,973,332)	-	-	-	-	-	-	(10,973,332)
Засгийн газрын хөрөнгө	(255,274)	(5,697,840)	-	(162,542)	(286,545)	-	-	(6,402,201)
Дотоодын банкуудын хөрөнгө	(9,736,851)	(5,718,252)	(431,156)	(165,382)	-	-	(486,136)	(16,537,777)
Гадаад өр төлбөр	(2,031)	(223)	(3,091,014)	-	(575,794)	-	-	(3,669,062)
Бусад санхүүгийн өр төлбөр	(224,983)	(508,749)	-	-	-	-	-	(733,732)
Нийт санхүүгийн өр төлбөр	(22,436,821)	(11,925,064)	(3,522,170)	(327,924)	(862,339)	-	(486,136)	(39,560,454)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	12,675,439	(12,814,163)	-	-	-	-	-	(138,724)
Цэвэр позиц	(1,012,265)	(6,842,961)	(1,643,007)	69,600	(547,844)	3,901,306	112,176	(5,962,995)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк нь мөнгөөр илэрхийлэгдэх хөрөнгө (үүнд мөнгөжсөн алт болон үнэт металлыг багтаасан) болон мөнгөөр илэрхийлэгдсэн өр төлбөрийн хүрээнд валют, алт болон ЗТЭ-ийн мэдэгдэхүйц өртөлттэй байх дүнг харуулсан:

Сая төгрөгөөр	Монгол төгрөг	Ам.доллар	Юань	Евро	ЗТЭ	Алт	Бусад	Нийт дүн
Бэлэн мөнгө	-	8,056	67,708	11,258	-	-	8,639	95,661
Гадаадын санхүүгийн байгууллага дахь хөрөнгө	-	4,240,751	1,186,757	535,256	308,666	-	274,896	6,546,326
Дотоодын банкуудад олгосон зээл	1,421,303	564	-	-	-	-	-	1,421,867
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	3,794,532	4,229,015	350,398	-	-	-	-	8,373,945
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	-	-	6,533	-	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	2,753,404	5,507,629	-	-	-	-	-	8,261,033
Мөнгөжсөн алт ба үнэт металл	-	-	-	-	-	2,115,101	4,489	2,119,590
Засгийн газрын үнэт цаас	55,720	-	-	-	-	-	-	55,720
Бусад санхүүгийн хөрөнгө	23,677	-	-	-	-	-	-	23,677
Нийт санхүүгийн хөрөнгө	8,048,636	13,986,015	1,604,863	553,047	308,666	2,115,101	288,024	26,904,352
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(1,222,179)	-	-	-	-	-	-	(1,222,179)
Төв банкны үнэт цаас	(11,511,780)	-	-	-	-	-	-	(11,511,780)
Засгийн газрын хөрөнгө	(5,926,668)	(536,663)	-	-	(379,947)	-	(1)	(6,843,279)
Дотоодын банкуудын хөрөнгө	(6,335,095)	(3,474,344)	(469,588)	(239,906)	-	-	(185,649)	(10,704,582)
Гадаад өр төлбөр	(1,695)	(215)	(2,849,601)	-	(526,574)	-	-	(3,378,085)
Бусад санхүүгийн өр төлбөр	(107,077)	(51)	-	-	-	-	-	(107,128)
Нийт санхүүгийн өр төлбөр	(25,104,494)	(4,011,273)	(3,319,189)	(239,906)	(906,521)	-	(185,650)	(33,767,033)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	7,827,420	(7,914,633)	-	-	-	-	-	(87,213)
Цэвэр позиц	(9,228,438)	2,060,109	(1,714,326)	313,141	(597,855)	2,115,101	102,374	(6,949,894)

Хуугийн түвшний эрсдэл. Хуугийн түвшний хэлбэлзлээс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгал эсвэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдэлийг хуугийн түвшний эрсдэл гэнэ. Хуугийн түвшний эрсдэлийг удирдаж буй гол зорилго нь эрсдэлийг холбогдох бодлогод заасан түвшнээс хэтрүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтын өгөөжийг тогтвортой түвшинд хадгалахад оршино.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны эзэмшиж буй хөрөнгө, өр төлбөрийн дийлэнх нь тогтмол хүүгийн түвшинтэй эсвэл хүүгүй байгаа нь хүүгийн түвшний эрсдэлийг их хэмжээгээр буруулдаг. Банк хүүгийн түвшний эрсдэлийг хязгаарлах зорилгоор гадаад валютын нөөцийн багцын дуусах хугацааны шаардлагыг бэнчмаркийн бодлогодоо тусгаж, хэрэгжилтийг өдөр бүр хянадаг. Хөрөнгө оруулалтын хугацааг хэвтээ шинжилгээний аргаар үнэлдэг ба нэг жилийн хөрөнгө оруулалтын хугацааг ашигладаг. Энэ хүрээнд сөрөг өгөөжийг хамгийн бага өгөөж гэж тодорхойлж, зөвшөөрөгдөх хэлбэлзэл 5% хүртэл байхаар тооцдог.

Доорх хүснэгтэд банкны хүүгийн эрсдэлд өртөх позицыг үзүүлэв. Нийт санхүүгийн хөрөнгө (мөнгөжсөн алт болон үнэт металыг багтаасан), өр төлбөрийн дансны үлдэгдлийг тухайн санхүүгийн хэрэгслийн дуусах хугацаагаар ангилсан ба санхүүгийн хэрэгслийн гэрээнд заасан хүү шинэчлэх хугацаа нь хөрөнгийн дуусах хугацааны өмнө байвал хүү шинэчлэх хугацааг дуусах хугацаагаар сонгоно:

Сая төгрөгөөр	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт хүүтэй	Хүүгийн өөрчлөлтөд мэдрэг бус	Нийт дүн
2025 оны 12 сарын 31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	14,025,982	7,048,254	1,866,296	4,671,211	27,611,743	6,384,292	33,996,035
Нийт санхүүгийн өр төлбөр	(29,213,414)	(5,303,333)	(3,118,398)	(221,890)	(37,857,035)	(2,101,995)	(39,959,030)
2025 оны 12 сарын 31-нээрх цэвэр хүүгийн мэдрэмтгий байдлын зааг							
	(15,187,432)	1,744,921	(1,252,102)	4,449,321	(10,245,292)	4,282,297	(5,962,995)
2024 оны 12 сарын 31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	13,328,001	2,495,091	938,432	3,423,958	20,185,482	6,859,592	27,045,074
Нийт санхүүгийн өр төлбөр	(24,472,613)	(851,475)	(24,018)	(3,295,569)	(28,643,675)	(5,351,291)	(33,994,966)
2024 оны 12 сарын 31-нээрх цэвэр хүүгийн мэдрэмтгий байдлын зааг							
	(11,144,612)	1,643,616	914,414	128,389	(8,458,193)	1,508,301	(6,949,892)

Банк дараах хөрөнгө болон өр төлбөрт хувьсах хүү тооцож хуримтлуулдаг: ЗТЭ (Тодруулга 8), ЗТЭ-ийн хуваарилалт, Хятадын Ардын банкнаас авсан зээл (Тодруулга 24).

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тайлагналын өдрийн хүүгийн түвшин бусад бүх хувьсагч тогтмол байна гэж үзвэл 100 суурь нэгжээр буурсан эсвэл өссөн тохиолдолд тухайн тайлант жилийн ашиг MNT 148,426 сая төгрөгөөр өсөх эсвэл буурах байсан (2024: 123,082 сая төгрөг), энэ нь үндсэндээ Хятадын Ардын Банкнаас авсан санхүүжилтийн хүүгийн зардал буурах эсвэл өсөхтэй холбоотой. Өөрийн хөрөнгийн бусад бүрэлдэхүүн хэсэг 45,973 сая төгрөгөөр буурах эсвэл өсөх байсан (2024: 38,500 сая төгрөг) бөгөөд энэ нь үндсэндээ бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ буурах эсвэл өсөхөөс шалтгаална.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк санхүүгийн хэрэгслийн хүүгийн түвшинг тогтмол хянадаг. Доорх хүснэгтэд тайлант өдрөөрх удирдлагын эрх бүхий албан тушаалтны шалгасан тайланд үндэслэн хүүгийн түвшинг тухайн валютаар илэрхийлэгдэх хөрөнгийн ангилал бүрээр нэгтгэж харууллаа. Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны хувьд хүүгийн түвшин нь тайлант өдрийн байдлаарх зах зээл дээрх өгөөжийн түвшинг илэрхийлнэ.

Жилийн хүү	2025				2024			
	Төгрөг	Ам. доллар	Юань	Бусад	Төгрөг	Ам. доллар	Юань	Бусад
Хөрөнгө								
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	-	3.89%	1.51%	2.99%	-	3.25%	1.84%	1.98%
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	4.03%	4.02%	1.42%	-	3.96%	4.23%	2.05%	-
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	14.00%	3.75%	-	-	11.23%	4.25%	-	-
Засгийн газрын үнэт цаас	1.00%	-	-	-	1.00%	-	-	-
Дотоодын банкуудад олгосон зээл	2.00%	1.00%	-	-	2.98%	1.00%	-	-
Өр төлбөр								
Төв банкны үнэт цаас	12.00%	-	-	-	10.00%	-	-	-
Засгийн газрын хөрөнгө	7.5%	3.51%	-	3.26%	2.00%	2.50%	-	-
Дотоодын банкуудын хөрөнгө	10.00%	3.77%	-	-	8.00%	4.58%	-	-
Гадаад өр төлбөр	-	-	3.40%	-	-	-	3.96%	-
Бусад өр төлбөр	3.00%	-	-	-	-	-	-	-

Хүснэгт дэх “-” тэмдэг нь тухайн валютад харгалзах хөрөнгө, өр төлбөргүйг илтгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Газар зүйн эрсдэлийн төвлөрөл. Санхүүгийн хөрөнгө (мөнгөжсөн алт ба үнэт металлыг багтаасан), өр төлбөрийн газар зүйн төвлөрлийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх доорх хүснэгтээр харууллаа:

Сая төгрөгөөр	Монгол	ЭЗХАХБ-ын орнууд	ОУВС	ЭЗХАХБ-ын бус орнууд	Нийт дүн
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	395,506	-	-	-	395,506
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	-	7,748,783	314,495	1,622,929	9,686,207
Дотоодын банкуудад олгосон зээл	179,323	-	-	-	179,323
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	4,543,034	4,867,855	-	-	9,410,889
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	6,533	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	3,983,879	6,086,748	-	-	10,070,627
Мөнгөжсөн алт ба үнэт металл	1,945,844	1,965,647	-	-	3,911,491
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	259,852	-	-	-	259,852
Засгийн газрын үнэт цаас	54,633	-	-	-	54,633
Бусад санхүүгийн хөрөнгө	20,974	-	-	-	20,974
Нийт санхүүгийн хөрөнгө	11,383,045	20,675,566	314,495	1,622,929	33,996,035
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(1,244,350)	-	-	-	(1,244,350)
Төв банкны үнэт цаас	(10,973,332)	-	-	-	(10,973,332)
Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр	(6,402,201)	-	-	-	(6,402,201)
Банкуудын хөрөнгө	(16,537,777)	-	-	-	(16,537,777)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(398,576)	-	-	-	(398,576)
Гадаад өр төлбөр	-	(2,254)	(575,794)	(3,091,014)	(3,669,062)
Бусад санхүүгийн өр төлбөр	(733,732)	-	-	-	(733,732)
Нийт санхүүгийн өр төлбөр	(36,289,968)	(2,254)	(575,794)	(3,091,014)	(39,959,030)
2025 оны 12 сарын 31-нээрх цэвэр позиц	(24,906,923)	20,673,312	(261,299)	(1,468,085)	(5,962,995)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга 32)	15,768	-	-	7,547,220	7,562,988

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгө (мөнгөжсөн алт ба үнэт металлыг багтаасан, өр төлбөрийн газар зүйн төвлөрлийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтээр харууллаа:

Сая төгрөгөөр	Монгол	ЭЗХАХБ-ын орнууд	ОУВС	ЭЗХАХБ-ын бус орнууд	Нийт дүн
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	95,661	-	-	-	95,661
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	-	5,728,371	308,666	509,289	6,546,326
Дотоодын банкуудад олгосон зээл	1,421,867	-	-	-	1,421,867
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	3,794,533	4,579,412	-	-	8,373,945
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	6,533	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	2,753,404	5,507,629	-	-	8,261,033
Мөнгөжсөн алт ба үнэт металл	-	2,119,590	-	-	2,119,590
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	140,720	-	-	-	140,720
Засгийн газрын үнэт цаас	55,720	-	-	-	55,720
Бусад санхүүгийн хөрөнгө	23,677	-	-	-	23,677
Нийт санхүүгийн хөрөнгө	8,285,582	17,941,535	308,666	509,289	27,045,072
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(1,222,179)	-	-	-	(1,222,179)
Төв банкны үнэт цаас	(11,511,780)	-	-	-	(11,511,780)
Засгийн газрын хөрөнгө Төрийн байгууллагуудад төлөх өр төлбөр	(6,843,279)	-	-	-	(6,843,279)
Банкуудын хөрөнгө	(10,704,582)	-	-	-	(10,704,582)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(227,933)	-	-	-	(227,933)
Гадаад өр төлбөр	-	(1,910)	(526,574)	(2,849,601)	(3,378,085)
Бусад санхүүгийн өр төлбөр	(107,128)	-	-	-	(107,128)
Нийт санхүүгийн өр төлбөр	(30,616,881)	(1,910)	(526,574)	(2,849,601)	(33,994,966)
2024 оны 12 сарын 31-нээрх цэвэр позиц	(22,331,299)	17,939,625	(217,908)	(2,340,312)	(6,949,894)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга 32)	(14,227)	-	-	(7,103,140)	(7,117,367)

Бусад эрсдэлийн төвлөрөл. Удирдлага харилцагч талуудын батлагдсан лимитийн хүрээнд зээлдэгчдэд ногдох эрсдэлд өртөлтийг тусгасан тайлангуудыг ашиглан зээлийн эрсдэлийн төвлөрлийг хянаж, дээр дурдсанчлан тодруулж тайлагнадаг. Банк бусад санхүүгийн байгууллагуудтай холбоотой зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өндөр төвлөрөлтэй байна. Дэлгэрэнгүйг Тодруулга 8, 10 болон 24-өөс харна уу

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төлбөрийн чадварын эрсдэл. Банк нь төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байх эрсдэлийг төлбөрийн чадварын эрсдэл гэнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөрөө төлж барагдуулахтай холбоотой төлбөрийн чадварын эрсдэл нь банкны хувьд гол эрсдэлийн нэг юм. Банкны хөрөнгө оруулалтын бодлого нь өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэгддэг хэдий ч энэ нь зөвхөн төлбөрийн чадварын болон хөрөнгө оруулалтын аюулгүй байдлын шаардлага хангагдсан үед хэрэгждэг. Импортын өндөр хамаарал, Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний тасралтгүй хэрэгцээ, дотоодын зах зээл дэх гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн хэлбэлзэл зэргээс шалтгаалан гадаад валютын нөөцийн удирдлагад төлбөрийн чадвар нь хамгийн чухал анхаарах асуудал болдог. Төлбөрийн чадварын эрсдэлийг удирдахдаа гадаад валютын нөөцийг хоёр багцад хуваадаг. Үүнд:

- Богино хугацаат хөрөнгө оруулалтын багц (бэлэн мөнгөний удирдлага эсвэл хөрвөх чадварын багц орно): Энэ багцыг зээл төлөх, валютын зах зээлийн үйл ажиллагааг тогтвортой байлгах зорилгоор ашигладаг бөгөөд энэ нь бэлэн мөнгө, овернайт ба хугацаагүй хадгаламжаас гадна хугацаат хадгаламж, хөрвөх чадвар сайтай мөнгөний захын хэрэгсэл, долоо хоногоос 12 сар хүртэлх дуусах хугацаа бүхий үнэт цаас болон мөнгөжсөн алтнаас бүрддэг.
- Урт хугацаат хөрөнгө оруулалтын багц: Энэ багц нь дунд болон урт хугацаатай, хөрвөх чадвар бүхий Засгийн газрын бонд, үнэт цаас зэргээс бүрддэг.

Хөрөнгө оруулалтын хороо нь гадаад валютын багцын лимитийг санал болгодог. Банк төлбөрийн хөрвөх эрсдэлийг бууруулахдаа гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журмын дагуу дараах хөрөнгийн бүтцийг дагаж мөрддөг:

- Нийт хөрөнгийн тодорхой хувиас багагүй хэсгийг богино хугацаат (1 жил хүртэлх) хөрөнгө оруулалт буюу харилцах данс, бэлэн мөнгө хэлбэрээр байршуулах;
- Нийт хөрөнгийн тодорхой хувиас багагүй хэсгийг богино хугацаат (1 жил хүртэлх) хөрөнгө оруулалт буюу 6 сар хүртэлх хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулах.

Гадаад валютын арилжаанд тогтоосон лимит нь хөрвөх чадварын эрсдэлийг бууруулахад чиглэгдэх бөгөөд гадаад арилжааны алдагдлын дээд лимит 400,000 ам.доллар, арилжааны нэгжийн дээд лимит 100,000 ам.доллар байх бөгөөд нэг удаагийн арилжааны лимит 50,000 ам.доллар байна.

Доорх хүснэгтэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өр төлбөрийг үлдсэн гэрээний дуусгавар болох хугацаагаар ангилан харуулсан. Хугацааны ангиллын хүснэгтэд тусгасан дүн нь зээлийн нийт үүрэг болон санхүүгийн баталгааг багтаасан, гэрээний дагуу хорогдуулалт тооцоогүй мөнгөн гүйлгээг илэрхийлнэ. Эдгээр хорогдуулалт тооцоогүй мөнгөн гүйлгээ нь санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дүнгээс ялгаатай бөгөөд санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дүн нь хорогдуулалт тооцсон мөнгөн гүйлгээнд суурилсан байдаг. Санхүүгийн үүсмэл бус хэрэгслийг гэрээний дагуу төлөгдөх эсвэл хүлээн авах дүнгээр, өөрөөр хэлбэл нийт дүнгээр тооцогдох форвард болон своп хэлцлийн төлбөрийг холбогдох мөнгөн орлоготой хамтад нь тусгасан.

Олгосон аккредитивын дагуу шаардагдах төлбөрийн чадварын хэрэгцээ нь хугацааны ангиллын шинжилгээнд тусгасан гэрээний дүнгээс нэлээд бага байдаг бөгөөд Банк нь гуравдагч талуудад эдгээр хэлцлийн хүрээнд санхүүжилт татах магадлал багатай гэж ерөнхийдөө үздэг. Доорх хүснэгтэд тусгасан зээл олголтын гэрээнүүдийн нийт үлдэгдэл дүн нь заавал ирээдүйн мөнгөн гүйлгээний хэрэгцээг илэрхийлэхгүй бөгөөд эдгээр гэрээнүүд санхүүжилт хийгдэхгүйгээр дуусгавар болох эсвэл хүчингүй болох боломжтой.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төлөх дүн нь тогтмол биш тохиолдолд тодруулсан дүнг тайлант жилийн эцэст хүчин төгөлдөр байсан нөхцөлд тулгуурлан тодорхойлно. Гадаад валютаар хийгдэх төлбөрийг тайлант жилийн эцсийн спот ханшаар хөрвүүлсэн болно.

Санхүүгийн өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	1 сараас бага сар	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт дүн
Өр төлбөр					
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө	1,244,350	-	-	-	1,244,350
Төв банкны үнэт цаас	11,029,000	-	-	-	11,029,000
Засгийн газарт өгөх өр төлбөр	1,592,730	4,811,097	3,295	30,261	6,437,383
Дотоодын банкуудын хадгаламж	16,543,227	-	-	-	16,543,227
Гадаад өр төлбөр	578,048	-	3,157,250	-	3,735,298
Бусад санхүүгийн өр төлбөр	272,036	465,796	-	-	737,832
<i>Нийт своп хэлцэл:</i>					
- Орох мөнгөн урсгал	(173,518)	(1,383,524)	(1,769,277)	(5,551,296)	(8,877,615)
- Гаргах мөнгөн урсгал	169,363	1,247,710	1,577,538	5,412,314	8,406,925
<i>Зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг:</i>					
- Хятадын Ардын Банкны ашиглаагүй зээлийн шугамын үлдэгдэл	7,547,220	-	-	-	7,547,220
-Бусад болзошгүй өр төлбөр	15,768	-	-	-	15,768
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөр	38,818,224	5,141,079	2,968,806	(108,721)	46,819,388

Санхүүгийн өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	1 сараас бага сар	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт дүн
Өр төлбөр					
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө	1,222,179	-	-	-	1,222,179
Төв банкны үнэт цаас	11,566,084	-	-	-	11,566,084
Засгийн газарт өгөх өр төлбөр	5,936,384	498,909	3,256	412,666	6,851,215
Дотоодын банкуудын хадгаламж	10,430,965	273,636	-	-	10,704,601
Гадаад өр төлбөр	528,484	-	102,607	2,922,868	3,553,959
Бусад санхүүгийн өр төлбөр	107,128	-	-	-	107,128
<i>Нийт биелсэн своп болон форвард хэлцэлүүд:</i>					
- Орох мөнгөн урсгал	(12,651)	(809,240)	(685,368)	(3,642,053)	(5,149,312)
- Гаргах мөнгөн урсгал	10,250	815,103	609,701	3,504,706	4,939,760
<i>Зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг:</i>					
- Хятадын Ардын Банкны ашиглаагүй зээлийн шугамын үлдэгдэл	7,103,140	-	-	-	7,103,140
-Бусад болзошгүй өр төлбөр	14,227	-	-	-	14,227
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөр	36,906,190	778,408	30,196	3,198,187	40,912,981

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоодын банкуудаас татсан хадгаламж болон төрийн байгууллагад хамаарах өр төлбөрийн мэдэгдэхүйц их хэмжээний хэсэг нь үндсэн хадгаламжийг бүрдүүлдэг. Үүнтэй адил, гүйлгээнд буй мөнгө нь төлбөрийг хойшлуулах болзолгүй гэрээт эрх Банкинд байхгүй хэдий ч тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрт тооцогддог. Иймд доор хүлээгдэж буй хугацаанд суурилсан хугацааны шинжилгээг харна уу.

Банк төлбөрийн чадварыг удирдахад өр төлбөрийн хөнгөлөлт хийгдээгүй гэрээт хугацаанд суурилсан дээрх хугацааны шинжилгээг ашигладаггүй. Үүний оронд Банк мөнгөжсөн алт болон үнэт металлыг багтаасан санхүүгийн хөрөнгийн дансны үнийн хүлээгдэж буй хугацаа, түүнчлэн санхүүгийн өр төлбөрийн хүлээгдэж буй хугацааг хянаж, үүнээс үүсэх хүлээгдэж буй хөрвөх чадварын зөрүүг үнэлдэг. Доорх хүснэгтэд санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хүлээгдэж буй хугацаанд суурилан ангилсан хугацааны шинжилгээг харуулсан.

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	Хугацаагүй болон 1 сараас бага сар	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт дүн
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	395,506	-	-	-	395,506
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	3,842,744	5,843,463	-	-	9,686,207
Дотоодын банкуудад олгосон зээл	5	-	178,825	493	179,323
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	2,025,510	1,149,586	1,684,045	4,551,748	9,410,889
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	-	-	6,533	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	10,016,427	54,200	-	-	10,070,627
Мөнгөжсөн алт ба үнэт металл *	3,911,491	-	-	-	3,911,491
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-	190,997	4,039	64,816	259,852
Засгийн газрын үнэт цаас	479	-	-	54,154	54,633
Бусад санхүүгийн хөрөнгө	20,974	-	-	-	20,974
Нийт санхүүгийн хөрөнгө	20,213,136	7,238,246	1,866,909	4,677,744	33,996,035
Өр төлбөр					
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө	(1,244,350)	-	-	-	(1,244,350)
Төв банкны үнэт цаас	(10,973,332)	-	-	-	(10,973,332)
Засгийн газрын хөрөнгө	(1,592,636)	(4,776,459)	(2,845)	(30,261)	(6,402,201)
Банкуудын хөрөнгө	(16,537,777)	-	-	-	(16,537,777)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(4,198)	(139,665)	(63,084)	(191,629)	(398,576)
Гадаад өр төлбөр	(616,382)	-	(3,052,680)	-	(3,669,062)
Бусад санхүүгийн өр төлбөр	(271,366)	(462,366)	-	-	(733,732)
Нийт санхүүгийн өр төлбөр	(31,240,041)	(5,378,490)	(3,118,609)	(221,890)	(39,959,030)
Хөрвөх чадварын цэвэр зөрүү	(11,026,905)	1,859,756	(1,251,700)	4,455,854	(5,962,995)

* Энд дурдсан мөнгөжсөн алт болон үнэт металл нь зөвхөн бодит үнэ цэнээр хэмжигдэж буй хөрөнгийг хамарна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34 САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	Хугацаагүй болон 1 сараас бага сар	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт дүн
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	95,661	-	-	-	95,661
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	5,234,697	1,311,629	-	-	6,546,326
Дотоодын банкуудад олгосон зээл	998,795	362,052	1,241	59,779	1,421,867
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	2,300,967	1,929,837	867,193	3,275,948	8,373,945
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	-	-	6,533	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	8,011,330	190,948	58,755	-	8,261,033
Мөнгөжсөн алт ба үнэт металл *	2,119,590	-	-	-	2,119,590
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	2,454	99,844	5,674	32,748	140,720
Засгийн газрын үнэт цаас	476	-	-	55,244	55,720
Бусад санхүүгийн хөрөнгө	9,202	8,903	5,572	-	23,677
Нийт санхүүгийн хөрөнгө	18,773,172	3,903,213	938,435	3,430,252	27,045,072
Өр төлбөр					
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө	(1,222,179)	-	-	-	(1,222,179)
Төв банкны үнэт цаас	(11,511,780)	-	-	-	(11,511,780)
Засгийн газрын хөрөнгө	(5,929,377)	(498,828)	(3,181)	(411,893)	(6,843,279)
Банкуудын хөрөнгө	(10,430,962)	(273,620)	-	-	(10,704,582)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(26)	(134,791)	(20,840)	(72,276)	(227,933)
Гадаад өр төлбөр	(566,665)	-	-	(2,811,420)	(3,378,085)
Бусад санхүүгийн өр төлбөр	(107,128)	-	-	-	(107,128)
Нийт санхүүгийн өр төлбөр	(29,768,117)	(907,239)	(24,021)	(3,295,589)	(33,994,966)
Хөрвөх чадварын цэвэр зөрүү	(10,994,945)	2,995,974	914,414	134,663	(6,949,894)

* Энд дурдсан мөнгөжсөн алт болон үнэт металл нь зөвхөн бодит үнэ цэнээр хэмжигдэж буй хөрөнгийг хамарна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилтийн өдрийн байдлаар зах зээлийн оролцогчдын хооронд хэвийн нөхцөлд хийгдсэн гүйлгээний хүрээнд хөрөнгийг борлуулснаар хүлээн авах үнэ, эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлөх үнийн дүн юм. Идэвхитэй зах зээл дээр арилжаалагдаж буй үнэ нь хөрөнгийн бодит үнэ цэнийг хамгийн сайн илэрхийлдэг. Идэвхитэй зах зээл гэдэг нь тухайн хөрөнгө эсвэл өр төлбөртэй холбоотой хэлцлүүд идэвхитэй арилжаалагддаг, гүйлгээний давтамж болон хэмжээ нь хангалттай, үнийн мэдээллийг хялбар олж авч болохуйц зах зээлийг хэлнэ. Идэвхтэй зах зээлд арилжаалагддаг санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тухайн хөрөнгө эсвэл өр төлбөрийн нэгжид ногдох арилжаалагдах үнэ болон аж ахуйн нэгжийн эзэмшиж буй тоо хэмжээг үржүүлсэн дүнгээр тодорхойлно. Зах зээлийн өдөр тутмын хэвийн арилжааны хэмжээ нь эзэмшиж буй нийт хэмжээг бүрэн шингээхэд хүрэлцэхгүй, эсвэл түүнийг нэг удаагийн хэлцлээр борлуулах нь арилжаалах үнэд нөлөөлөх боломжтой байсан ч дээрх хэмжилтийн арга хэрэглэгдэнэ.

Банк идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй хөрөнгийн багцыг эзэмшиж байх тохиолдолд эдгээрийн бодит үнэ цэнэ нь санхүүгийн хэрэгсэл тус бүрээр бус харин хэмжилт хийх өдрөөрх тухайн багцын цэвэршүүлсэн дүнд суурилж хэмжигддэг. Банк нь хөрөнгийн бодит үнэ цэнийг багцын цэвэршүүлсэн дүнд суурилж хэмжихэд дараах тохиолдлууд хамаарна: Үүнд, а) Хөрөнгө оруулалтын бодлого болон эрсдэлийн удирдлагын баримт бичигт банк нь хөрөнгө, өр төлбөрийг багцалж, тухайн багц дах хөрөнгө өр, төлбөрийн цэвэршүүлсэн дүнд суурилах замаар эрсдэлийг удирдахаар заасан байх, б) Тухайн багц дах хөрөнгө, өр төлбөрийн цэвэр позицгийн эрсдэлийн талаар удирдлагад мэдээлэл өгдөг байх, в) тухайн багц дах санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн эрсдэлд өртөх хугацаа нь ижил байх.

Удирдлага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан үнэлгээний аргууд нь бодит үнэ цэнийг зохистой бөгөөд найдвартайгаар илэрхийлж байна гэж үзэж байна.

Идэвхитэй зах зээл дээрх үнийн мэдээлэл байхгүй санхүүгийн хэрэгслийн хувьд банк нь бодит үнэ цэнийг хорогдуулсан мөнгөн урсгалын загвар, хамгийн сүүлийн үеийн мэдэгдэж буй хэлцлийн үнэ, зээлдэгч талын санхүүгийн чадварын үнэлгээ гэм мэт аргуудын аль тохиромжтойг сонгон тооцдог.

Хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж хэмжихдээ тухайн үнэлгээнд ашиглагдсан мэдээллийн ялгаатай байдлаас нь хамаарч тухайн хэмжилтийг гурван түвшинд ангилдаг. “Түвшин нэг” дэх хэмжилтийн суурь нь идэвхитэй зах зээл дээр арилжаалагдаж буй ижил төрлийн хөрөнгийн зах зээлийн үнэ байдаг бол “түвшин хоёр” дах хэмжилтийн суурь нь түвшин нэгд заасан үнэлгээний сууриас бусад хялбар олдох боломжтой, үнэлгээнд шууд болон шууд бусаар ашиглагдах материаллаг мэдээллийг агуулдаг. Харин “гуравдугаар түвшин”-д хамаарах хэмжилтийн суурь нь шууд олж авах боломжгүй, дотоод мэдээлэл болон үнэлгээ хийж буй этгээдийн мэргэжлийн дүгнэлтээс бүрдэнэ. Мөн тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашиглагдах хангалттай мэдээлэл байгаа хэдий ч энэ нь их хэмжээний тохируулга хийгдсэний дараа үнэлгээнд ашиглагдахаар байвал үүнийг “шатлал гурав”-т хамаарах үнэлгээний суурь гэж үздэг. Үнэлгээнд ашиглагдаж буй хувьсагч нь тухайн үнэлгээнд ач холбогдолтой эсэхийг тухайн хувьсагчийн бага зэргийн өөрчлөлт нь үнэлгээний дүнд хэрхэн нөлөөлж байгааг шалгадаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

(a) Давтагдах бодит үнэ цэнийн хэмжилт

Давтагдах бодит үнэ цэнийн хэмжилт гэдэг нь тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөхийг нягтлан бодох бүртгэлийн стандартаар шаарддаг эсвэл зөвшөөрдөг хэмжилтийг хэлнэ. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давтагдах бодит үнэ цэнийн хэмжилтийг ангилсан бодит үнэ цэнийн шатлалын түвшнийг доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31			Нийт дүн
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДСЭН ХӨРӨНГӨ				
Бодит үнэ цэнээр хэмжигдэж буй санхүүгийн хөрөнгө болон мөнгөжсөн алт болон үнэт металл				
- АНУ-ын Засгийн газрын бонд	1,876,626	-	-	1,876,626
- Олон улсын төлбөр тооцооны банкны гаргасан бонд	1,322,675	-	-	1,322,675
- РАМП хөрөнгө оруулалтын дансны хөрөнгүүд	1,303,749	-	-	1,303,749
- ОУ-ын төлбөр тооцооны банкны хөрөнгө оруулалт	208,034	-	-	208,034
- АХБ-ны бонд	138,652	-	-	138,652
- Европын хөрөнгө оруулалтын банкны бонд	18,119	-	-	18,119
- Бусад өмчийн хөрөнгө оруулалт	-	-	6,533	6,533
- Бодит үнэ цэнээр хэмжигдэж буй мөнгөжсөн алт болон үнэт метал	3,911,491	-	-	3,911,491
- Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-	259,852	-	259,852
- ЗГҮЦ	-	54,633	-	54,633
Санхүүгийн бус хөрөнгө				
- Үндсэн хөрөнгө	-	-	80,294	80,294
Хөрөнгийн давтагдах бодит үнэ цэнийн нийт хэмжилтийн дүн	8,779,346	314,485	86,827	9,180,658
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДСЭН ӨР ТӨЛБӨР				
Санхүүгийн өр төлбөр				
- Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	-	(398,576)	-	(398,576)
Өр төлбөрийн давтагдах бодит үнэ цэнийн нийт хэмжилтийн дүн	-	(398,576)	-	(398,576)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давтагдах бодит үнэ цэнийн хэмжилтийг ангилсан бодит үнэ цэнийн шатлалын түвшнийг доорх хүснэгтэд харууллаа:

2024 оны 12 дугаар сарын 31 (дахин тайлагнасан)

Сая төгрөгөөр	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт дүн
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДСЭН ХӨРӨНГӨ				
Бодит үнэ цэнээр хэмжигдэж буй санхүүгийн хөрөнгө болон мөнгөжсан алт болон үнэт металл				
- Олон улсын төлбөр тооцооны банкны гаргасан бонд	2,706,858	-	-	2,706,858
- РАМП хөрөнгө оруулалтын дансны хөрөнгүүд	1,193,924	-	-	1,193,924
- АНУ-ын Засгийн газрын бонд	451,274	-	-	451,274
- ОУ-ын төлбөр тооцооны банкны хөрөнгө оруулалт	190,404	-	-	190,404
- АХБ-ны бонд	20,092	-	-	20,092
- Европын хөрөнгө оруулалтын банкны бонд	16,860	-	-	16,860
- Бусад өмчийн хөрөнгө оруулалт	-	-	6,533	6,533
- Бодит үнэ цэнээр хэмжигдэж буй мөнгөжсөн алт болон үнэт металл	2,119,590	-	-	2,119,590
- Дотоодын банкуудад олгосон зээл	-	32,620	-	32,620
- Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-	140,720	-	140,720
- Өрийн бичгээрх авлагууд	-	-	14,658	14,658
- ЗГҮЦ	-	55,720	-	55,720
Санхүүгийн бус хөрөнгө				
- Үндсэн хөрөнгө	-	-	84,996	84,996
Хөрөнгийн давтагдах бодит үнэ цэнийн нийт хэмжилтийн дүн	6,699,002	229,060	106,187	7,034,249
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДСЭН ӨР ТӨЛБӨР				
Санхүүгийн өр төлбөр				
- Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	-	(227,933)	-	(227,933)
Өр төлбөрийн давтагдах бодит үнэ цэнийн нийт хэмжилтийн дүн	-	(227,933)	-	(227,933)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар давтагдах бодит үнэ цэнийн хэмжилтийг ангилсан бодит үнэ цэнийн шатлалын түвшнийг доорх хүснэгтэд харууллаа:

	2024 оны 1 дүгээр сарын 1 (дахин тайлагнасан)			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт дүн
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДСЭН ХӨРӨНГӨ				
Бодит үнэ цэнээр хэмжигдэж буй санхүүгийн хөрөнгө болон хөрөнгөжсөн алт болон үнэт металл				
- Олон улсын төлбөр тооцооны банкны гаргасан бонд	1,936,811	-	-	1,936,811
- РАМП хөрөнгө оруулалтын дансны хөрөнгүүд	1,138,551	-	-	1,138,551
- АНУ-ын Засгийн газрын бонд	263,268	-	-	263,268
- ОУ-ын төлбөр тооцооны банкны хөрөнгө оруулалт	180,521	-	-	180,521
- АХБ-ны бонд	6,344	-	-	6,344
- Бусад өмчийн хөрөнгө оруулалт	-	-	6,533	6,533
- Бодит үнэ цэнээр хэмжигдэж буй хөрөнгөжсөн алт болон үнэт металл	1,848,701	-	-	1,848,701
- Дотоодын банкуудад олгосон зээл	-	118,394	-	118,394
- Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-	126,364	-	126,364
- Өрийн бичгээрх авлагууд	-	-	28,438	28,438
- ЗГҮЦ	-	42,100	-	42,100
Санхүүгийн бус хөрөнгө				
- Үндсэн хөрөнгө	-	-	88,340	88,340
Хөрөнгийн давтагдах бодит үнэ цэнийн нийт хэмжилтийн дүн	5,374,196	286,858	123,311	5,784,365
БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДСЭН ӨР ТӨЛБӨР				
Санхүүгийн өр төлбөр				
- Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	-	(531,770)	-	(531,770)
Өр төлбөрийн давтагдах бодит үнэ цэнийн нийт хэмжилтийн дүн	-	(531,770)	-	(531,770)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Түвшин 2-т хамаарах бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан өгөгдлийн тайлбар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

Сая төгрөгөөр	Бодит үнэ цэнэ 2025	Бодит үнэ цэнэ 2024	Үнэлгээний аргачлал	Ашигласан өгөгдөл
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн хөрөнгө				
-Засгийн газрын үнэт цаас	54,633	55,720	Хорогдуулсан мөнгөн урсгал	Бодлогын хүүнд суурилсан хямдруулалтын түвшин болон эргэн төлөлтийн хуваариарх мөнгөн урсгал. Ам.долларт бодох хүүг СОФР, Z-спрэйд, СОФР болон бусад спрэйдэд суурилж тооцсон. Төгрөгт бодох хүүг Бодлогын хүү, 28 хоногтой төв банкны үнэт цаас болон репо хүүнд суурилж тооцсон.
- Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	259,852	140,720	Хорогдуулсан мөнгөн урсгал	Ам.долларын хямдруулалтын хувь ам.долларын хүүгийн түшинд нийцүүлж Төгрөгийн хямдруулалтын хувь репо санхүүжилтийн хүүнд суурилж тооцсон.
- Дотоодын банкуудад олгосон зээл	-	32,620	Хорогдуулсан мөнгөн урсгал	Гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу орж ирэх мөнгөн урсгалын таамаглал, хямдруулалтын хувийг банкуудад олгосон ипотекийн зээлийн хүүгийн дундажаар авсан.
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн өр төлбөр				
- Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(398,576)	(227,933)	Хорогдуулсан мөнгөн урсгал	Ам.долларт бодох хүүг СОФР, Z-спрэйд, СОФР болон бусад спрэйдэд суурилж тооцсон. Төгрөгт бодох хүүг бодлогын хүү, 28 хоногтой төв банкны үнэт цаас болон репо хүүнд суурилж тооцсон. Ам.долларын хямдруулалтын хувь ам.долларын хүүгийн түшинд нийцүүлж Төгрөгийн хямдруулалтын хувь репо санхүүжилтийн хүүнд суурилж тооцсон.
2-р түвшин дэх давтагдах бодит үнэ цэнийн нийт дансны үнэ	(84,091)	1,127		

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Түвшин 3-т хамаарах бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан өгөгдлийн тайлбар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

Сая төгрөгөөр	Бодит үнэ цэнэ 2025 12 сарын 31	Бодит үнэ цэнэ 2024.12 сарын 31 (дахин тайлагнасан)	Бодит үнэ цэнэ 2024 1 сарын 1 (дахин тайлагнасан)	Үнэлгээний аргачлал	Ашигласан өгөгдөл
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн хөрөнгө					
Санхүүгийн хөрөнгө					
- Өрийн бичиг	-	14,658	28,438	Хорогдуулсан мөнгөн урсгал	Өрийн бичиг гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан, бодлогын хүүнд суурилсан дискаунт хүү болон холбогдох талын зээлийн эрсдэлд суурилсан зээлийн эрсдэлийн хүү, эргэн төлөлтийн хуваариарх мөнгөн урсгал
Санхүүгийн бус хөрөнгө					
- Үндсэн хөрөнгө	80,294	84,996	88,340	Зах зээлийн, Орлогын, болон Өртгийн арга	Тохируулсан/ хорогдуулсан/ залруулга хийгдсэн зах зээлийн үнэ, зах зээл дээрх түрээсийн орлогийн дискаунтчилсан мөнгөн урсгал болон ижил шинж чанар, хэрэглээ, борлуулах чадвартай хөрөнгийг дахин барих одоогийн өртөг
3-р түвшин дэх давтагдах бодит үнэ цэнийн дансны үнэ	80,294	99,654	116,778		

Доорх хүснэгтэд “түвшин 3”-т ангилагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн мэдрэмтгий байдлыг харууллаа. Өөрөөр хэлбэл, бодит үнэ цэнийн үнэлгээнд ашиглагдаж буй өгөгдөлд бага хэмжээний өөрчлөлт ороход хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэд гарах өөрчлөлт нь ашиг/алдагдал, нийт хөрөнгө, өр төлбөрийн хэмжээтэй харьцуулахад их хэмжээтэй байвал, эсвэл энэхүү бодит үнэ цэнийг бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэхээр байвал тухайн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тухайн өгөгдөлд мэдрэг байна гэж үзнэ.

Удирдлага нь “түвшин 3”-т хамаарах үнэлгээний сууриар бодит үнэ цэнэ нь тодорхойлогдох хөрөнгө буюу банкны эзэмшиж буй өмчийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ өөрчлөгдөхөд энэ нь банкны өөрийн хөрөнгөөс бусад санхүүгийн үзүүлэлтэд нөлөө үзүүлэхгүй гэж үзсэн. Тухайлбал, өмчийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ 10%-аар өсөх/(буурах)-д тухайн хөрөнгө оруулалтын дүн 653 сая төгрөг (2024: 653 сая төгрөг)-өөр өсөх/(буурах)-өөр байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

“Түвшин 3”-т ангилагдах хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоход ашигласан өгөгдлийн өөрчлөлтөд тухайн хөрөнгийн үнэ цэнийн мэдрэг байдлыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дор харууллаа:

Сая төгрөгөөр	Бодит үнэ цэнэ 2025 12 сарын 31	Ашигласан өгөгдөл	Өгөгдлийн хязгаар	Боломжит өөрчлөлт	Бодит үнэ цэнийн мэдрэг байдал
Бодит үнэ цэнээрх хөрөнгө					
Санхүүгийн бус хөрөнгө					
-Үндсэн хөрөнгө	80,294	Тохируулсан/хорогдуулсан/ залруулга хийгдсэн зах зээлийн үнэ	0.5 - 5.0 сая төгрөг/мкв	± 10 %	±8,029

“Түвшин 3”-т ангилагдах хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоход ашигласан өгөгдлийн өөрчлөлтөд тухайн хөрөнгийн үнэ цэнийн мэдрэг байдлыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дор харууллаа:

Сая төгрөг	Бодит Үнэ Цэнэ 2024 12 сарын 31 (дахин тайлагнасан)	Ашигласан өгөгдөл	Өгөгдлийн хязгаар	Боломжит өөрчлөлт	Бодит үнэ цэнийн мэдрэг байдал
Бодит үнэ цэнээрх хөрөнгө					
Санхүүгийн хөрөнгө					
- Өрийн бичиг	14,658	Өрчийн бичиг гаргагчийн санхүүгийн тайлан, зах зээлийн хүү (бодлогын хүү+5%) болон төлбөрийн эргэн төлөлтийн дагуу мөнгөн урсгалын таамагласан дүн	Бодлогын хүү 10% + зээлийн эрсдэлийн нэмэгдэл 5%	± 10 %	±67
Санхүүгийн бус хөрөнгө					
-Үндсэн хөрөнгө	84,996	Тохируулсан/хорогдуулсан/ залруулга хийгдсэн зах зээлийн үнэ	0.5 - 3.2 сая төгрөг/мкв	± 10 %	±8,499

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

“Түвшин 3”-т ангилагдах хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоход ашигласан өгөгдлийн өөрчлөлтөд тухайн хөрөнгийн үнэ цэнийн мэдрэг байдлыг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар дор харууллаа:

Сая төгрөг	Бодит Үнэ Цэнэ 2024 1 сарын 1 (дахин тайлагнасан)	Ашигласан өгөгдөл	Өгөгдлийн хязгаар	Боломжит өөрчлөлт	Бодит үнэ цэнийн мэдрэг байдал
Бодит үнэ цэнээрх хөрөнгө					
Санхүүгийн хөрөнгө					
- Өрийн бичиг	28,438	Өрчийн бичиг гаргагчийн санхүүгийн тайлан, зах зээлийн хүү (бодлогын хүү+5%) болон төлбөрийн эргэн төлөлтийн дагуу мөнгөн урсгалын таамагласан дүн	Бодлогын хүү 10% + зээлийн эрсдэлийн нэмэгдэл 5%	± 10 %	±466
Санхүүгийн бус хөрөнгө					
-Үндсэн хөрөнгө	88,340	Тохируулсан/хорогдуулсан/ залруулга хийгдсэн зах зээлийн үнэ	0.5 - 3.2 сая төгрөг/мкв	± 10 %	±8,834

Бодит үнэ цэнийн шатлалын 3-р түвшинд хамаарах хэмжилтийн тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийн тохируулгыг санхүүгийн хэрэгслийн ангиллаар 2025 оны 12 сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болох тайлант жилийн байдлаар доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	2025	2024
Өрийн бичиг		
1 сарын 1-ний өдрийн бодит үнэ цэнэ	14,658	28,438
Тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдсөн дүн	1,150	2,027
Төлөлт	(15,808)	(15,807)
12 сарын 31-ний өдрийн бодит үнэ цэнэ	-	14,658

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

(б) Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй боловч бодит үнэ цэнэ нь тодруулагдсан хөрөнгө ба өр төлбөр

Бодит үнэ цэнээр бүртгэгддэггүй хөрөнгүүдийг 2025 оны 12 дугаар сарын 31 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дээрх хэмжилтийн шатлалаар болон дансны үнээр доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31					2024 оны 12 дугаар сарын 31				
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ
Санхүүгийн хөрөнгө										
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	395,506	-	-	395,506	395,506	95,661	-	-	95,661	95,661
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	9,686,207	-	9,686,207	9,686,207	-	6,546,326	-	6,546,326	6,546,326
Дотоодын банкинд олгосон зээл	-	-	165,664	165,664	179,323	-	-	1,389,247	1,389,247	1,384,167
Өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалт	-	4,431,967	-	4,431,967	4,543,034	-	3,687,095	-	3,687,095	3,794,533
Урвуу буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл	-	10,070,550	-	10,070,550	10,070,627	-	8,262,548	-	8,262,548	8,261,033
Бусад санхүүгийн хөрөнгө	-	20,974	-	20,974	20,974	-	9,021	-	9,021	9,019
Нийт дүн	395,506	24,209,698	165,664	24,770,868	24,895,671	95,661	18,504,990	1,389,247	19,989,898	20,090,739

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35 БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бодит үнэ цэнээр бүртгэгддэггүй өр төлбөрийг 2025 оны 12 дугаар сарын 31 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дээрх хэмжилтийн шатлалаар болон дансны үнээр доорх хүснэгтэд харууллаа:

Сая төгрөгөөр	2025 оны 12 дугаар сарын 31					2024 оны 12 дугаар сарын 31				
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ
Санхүүгийн өр төлбөр										
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,244,350	-	-	1,244,350	1,244,350	1,222,179	-	-	1,222,179	1,222,179
Төв банкны үнэт цаас	-	10,973,332	-	10,973,332	10,973,332	-	11,511,780	-	11,511,780	11,511,780
Засгийн газарт өгөх өр төлбөр	-	6,402,201	-	6,402,201	6,402,201	-	6,843,279	-	6,843,279	6,843,279
Дотоодын банкуудын хадгаламж	-	16,537,777	-	16,537,777	16,537,777	-	10,704,582	-	10,704,582	10,704,582
Гадаад өр төлбөр	-	3,576,465	-	3,576,465	3,669,062	-	3,396,078	-	3,396,078	3,378,085
Бусад санхүүгийн өр төлбөр	-	733,732	-	733,732	733,732	-	107,128	-	107,128	107,128
Нийт дүн	1,244,350	38,223,507	-	39,467,857	39,560,454	1,222,179	32,562,847	-	33,785,026	33,767,033

Дээрх хүснэгтийн “Түвшин 2” болон “Түвшин 3” баганад харгалзах хөрөнгө, өр төлбөрийн дүнг хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргыг ашиглан тооцож гаргасан бөгөөд идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй, хөвөгч хүүтэй хэрэгслүүдийн хувьд бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ижил байна гэж үзсэн. Идэвхтэй зах зээлд үнэлгээ тогтоогдоогүй тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг, ижил төстэй зээлийн эрсдэл болон үлдсэн хугацаатай шинэ санхүүгийн хэрэгслүүдэд хамаарах одоогийн зах зээлийн хүүгийн түвшинг ашиглан, ирээдүйд хүлээн авах хүлээгдэж буй мөнгөн урсгалыг хорогдуулах замаар тооцсон.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

36 САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЭМЖИЛТИЙН АНГИЛЛААРХ ТОДРУУЛГА

Банк нь санхүүгийн хөрөнгийг эзэмшиж буй зорилгоос хамаарч дараах ангиллаар ангилдаг: (а) ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ (ААБҮЦ)-ээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө, (б) бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ)-ээр хэмжигдэх өрийн бичиг, (в) бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ)-ээр хэмжигдэх өмчийн хэрэгсэл, (г) хорогдуулсан өртөг (ХӨ)-өөр бүртгэх санхүүгийн хөрөнгө. ААБҮЦ-ээр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийг 2 дэд ангилалд хуваадаг: (1) Зайлшгүй ААБҮЦ-ээр хэмжих, (2) анх хүлээн зөвшөөрөхөд эсвэл анх хүлээн зөвшөөрсний дараа ААБҮЦ-ээр хүлээн зөвшөөрөх хөрөнгө.

Доорх хүснэгтэд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мөнгөжсөн алт болон үнэт металлыг багтаасан санхүүгийн хөрөнгийг хэмжилтийн ангиллаар харууллаа:

Сая төгрөгөөр	ХӨ	БДОБҮЦ- ээрх өрийн хэрэгсэл	БДОБҮЦ- ээрх өмчийн хэрэгсэл	ААБҮЦ (зайлшгүй)	ААБҮЦ (тодорхойлох)	Нийт дүн
Бодит үнэ цэнээрх санхүүгийн хөрөнгө, мөнгөжсөн алт болон үнэт металл						
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	395,506	-	-	-	-	395,506
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	9,686,207	-	-	-	-	9,686,207
Дотоодын банкинд олгосон зээл	179,323	-	-	-	-	179,323
Бодит үнэ цэнээрх мөнгөжсөн алт болон үнэт металл	-	-	-	-	3,911,491	3,911,491
Өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалт	4,543,034	4,867,855	-	-	-	9,410,889
Өмчийн хэрэгслээрх хөрөнгө оруулалт	-	-	6,533	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	10,070,627	-	-	-	-	10,070,627
Засгийн газрын үнэт цаас	-	54,633	-	-	-	54,633
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-	-	-	259,852	-	259,852
Бусад санхүүгийн хөрөнгө	20,974	-	-	-	-	20,974
Нийт БҮЦ-ээр хэмжигдэж буй санхүүгийн хөрөнгө, мөнгөжсөн алт болон үнэт металл	24,895,671	4,922,488	6,533	259,852	3,911,491	33,996,035

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

36 САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЭМЖИЛТИЙН АНГИЛЛААРХ ТОДРУУЛГА
(ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэнд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мөнгөжсөн алт болон үнэт металлыг багтаасан санхүүгийн хөрөнгийг хэмжилтийн ангиллаар харууллаа:

Сая төгрөгөөр	ХӨ	БДОБҮЦ- ээрх өрийн хэрэгсэл	БДОБҮЦ- ээрх өмчийн хэрэгсэл	ААБҮЦ (зайлшгүй)	ААБҮЦ (тодорхойлох)	Нийт дүн
Бодит үнэ цэнээрх санхүүгийн хөрөнгө, мөнгөжсөн алт болон үнэт металл						
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	95,661	-	-	-	-	95,661
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	6,546,326	-	-	-	-	6,546,326
Дотоодын банкинд олгосон зээл	1,389,247	-	-	32,620	-	1,421,867
Мөнгөжсөн алт болон үнэт металл	-	-	-	-	2,119,590	2,119,590
Өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалт	3,794,533	4,579,412	-	-	-	8,373,945
Өмчийн хэрэгслээрх хөрөнгө оруулалт	-	-	6,533	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	8,261,033	-	-	-	-	8,261,033
Засгийн газрын үнэт цаас	-	55,720	-	-	-	55,720
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-	-	-	140,720	-	140,720
Бусад санхүүгийн хөрөнгө	9,021	-	-	14,656	-	23,677
Нийт БҮЦ-ээр хэмжигдэж буй санхүүгийн хөрөнгө, мөнгөжсөн алт болон үнэт металл	20,095,821	4,635,132	6,533	187,996	2,119,590	27,045,072

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх ангилалд хамаарах үүсмэл хэрэгслээс бусад бүх санхүүгийн өр төлбөр хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37 КАПИТАЛ ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

Банкны өөрийн хөрөнгийн дүн нь нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хассаны дараа үлдэх дүнгээр тодорхойлогдоно. Банк нь эдийн засгийн хувьд хараат бус байж, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд өөрийн хөрөнгийн хэмжээг зохих түвшинд хадгалахыг зорьдог бөгөөд энэ нь санхүүгийн байдлын тайлангийн өөрийн хөрөнгийн дүнтэй тэнцүү байна.

Төв банкны хувьд Банк нь гадны тогтоосон капитал хөрөнгийн шаардлагад хамаарахгүй. Монгол Улсын Төв банкны тухай хууль (Монголбанк)-д Банкны дүрмийн сангийн доод хэмжээ болон жилийн цэвэр орлогоос өөрийн хөрөнгөнд заавал хуваарилах доод хувийг тус тус тодорхойлсон байдаг.

Банкны дүрмийн сан нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 60,000 сая төгрөг (2024: 60,000 сая төгрөг) байгаа нь хуульд заасан хамгийн бага дүн болох 5,000 сая төгрөгөөс их байна. Хуулинд зааснаар банк нь цэвэр орлогын 40%-аас доошгүй хувийг Ерөнхий нөөцийн санд хуваарилж болох бөгөөд үлдэх хувийг улсын төсөвт шилжүүлэх үүрэг хүлээдэг. 2025 болон 2024 оны тайлант жилийн хугацаанд Ерөнхий нөөц санд ямар нэгэн шилжүүлэлт хийгдээгүй.

Монголбанк нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,135,868 сая төгрөгийн ашигтай ажилласан (2024: 306,255 сая төгрөгийн ашигтай) ба өөрийн хөрөнгө нийт 4,804,774 сая төгрөг (2024: 5,955,058 сая төгрөг)-ийн сөрөг дүнтэй байна. Төв банкны тухай хуулийн 38-р зүйлд зааснаар Монголбанк нь өөрийн хөрөнгийн дутагдалд орвол алдагдлыг Засгийн газар үнэт цаас гаргаж хаах эсэх дээр УИХ шийдвэр гаргах үүрэг хүлээсэн байдаг. Иймд, Засгийн газраас Банкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх үүрэг хүлээхгүй ч Банк үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүйд хүрч, үндсэн чиг үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон гэж үзвэл, УИХ-аас дээр дурдсан байдлаар нөхөх боломжтой юм.

Энэхүү хуулийн 37-р зүйлд Монголбанкны дахин үнэлгээний сан нь дараах хэсгүүдээс бүрдэнэ хэмээн заажээ. Үүнд:

- Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан алт болон гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд гарсан өөрчлөлтийн зөрүү;
- Үндсэн хөрөнгө (байшин, барилга гэх мэт) болон эрдэнэсийн сангийн дахин үнэлгээнээс үүдэлтэй зөрүү.

Энэхүү хуулийн 37-р зүйлд гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө ба өр төлбөр болон алтны ханшийн зөрүүнээс үүсэх дахин үнэлгээний цэвэр зөрүүг цэвэр орлогын тооцоонд хамааруулахгүй гэж заасан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

38 ТАЙЛАНГИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Тайлант хугацаа дууссаны дараа эдгээр санхүүгийн тайлангуудыг гаргахаар батлагдсан өдрийг хүртэл гарсан эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэхүйц үйл явдлын талаарх мэдээлэл удирдлагад байхгүй байна.